



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

МЭДЭЭЛЭЛТЭЙ ИРГЭН - ХАРИУЦЛАГАТАЙ ТӨР – ХӨГЖИЛ ДЭВШИЛ

**“ТӨРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ:
НИЙГМИЙН БАЯЛАГ ХУВААРИЛАЛТ”
ФОРУМЫН ЭМХТГЭЛ**

Улаанбаатар хот 2006.12.07



DDC
303.38
T-594

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,
Монгол Улс
Утас: 976-11-313207
Факс: 976-11-314857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@soros.org.mn

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл
ННФ-ын хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

ISBN 978-99929-0-189-6

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

“ТӨРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ: НИЙГМИЙН БАЯЛАГ ХУВААРИЛАЛТ” ФОРУМ

**2006 оны 12 дугаар сарын 7
Чингис зочид буудал**

Ил тод байдал нь ардчиллын гол тулгуур зарчим бөгөөд сайн засаглалыг бэхжүүлэх, авилгалаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үр нөлөөтэй хэрэгсэл юм. Ил тод байдлыг хангах нь ардчилсан төрийн нэн тэргүүний үүрэг хэдий ч нийгэмд ил тод байдлыг бодитойгоор хэрэгжүүлэх нь иргэний нийгмийн хүчин зүтгэлээс ихээхэн хамаарч байдаг. Ил тод байдлын ойлголт нь мэдээллийн хүртээмж, үйл ажиллагааны нээлттэй байдал, иргэдийн зүгээс төрийн хэрэгт оролцох боломж зэргийг хамардаг.

Манай улсад төрийн ил тод байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн цөөнгүй алхмууд хийгдэж, олон хөтөлбөр, баримт бичиг, хууль тогтоомж баталсан боловч ил тод байдал нь төрийн үйл ажиллагааны бүхий л салбарт тууштай баримтлах нэгдсэн зарчим болж хараахан чадаагүй, хэрэгжүүлэлтийн түвшинд бодитой үр дүн төдийлөн гараагүй байна. Иймээс ил тод байдлыг хангах чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааг үнэлэн дүгнэж, оршиж буй бэрхшээл хүндрэлийг тодорхойлж, даван туулах арга замыг талууд хамтран хэлэлцэх нь ил тод байдлыг улам гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж Нээлттэй Нийгэм Форум “Төрийн ил тод байдал: Нийгмийн баялаг хуваарилалт” сэдэвт форумыг зохион байгууллаа.

Форум 2006 оны 12 дугаар сарын 7-ны өдөр болсон бөгөөд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн 200 гаруй хүн оролцохоос гуравны нэг орчим хувь нь орон нутгийн төлөөлөл байлаа.

Форум дор дурдсан таван тусдаа хэлэлцүүлгээс бүрдэнэ. Үүнд:

- Төрийн ил тод байдлыг хангах хууль, эрхзүйн орчин, түүний хэрэгжилт
- Улсын төсвийн ил тод байдал / төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо, төрийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах үйл явц, тусгай сангууд гэх мэт /
- Газар олголтын ил тод байдал
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал / лиценз, гэрээ, төлбөр/
- Цаашид авах арга хэмжээ

Цаашид энэхүү форумыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж төрийн ил тод байдлыг бусад салбар, чиглэлээр авч хэлэлцэхээс гадна бизнесийн болоод иргэний нийгмийн ил тод байдлын талаар ч ярилцах болно.

“ТӨРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ: НИЙГМИЙН БАЯЛАГ ХУВААРИЛАЛТ” ФОРУМЫН ХӨТӨЛБӨР

- 09.00-9.30 Оролцогчдыг бүртгэх
- 9.30-9.35 Форумыг нээх
П.Эрдэнэжаргал, Нээлттэй Нийгэм Форумын гүйцэтгэх захирал

*“Төрийн ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчин, хэрэгжилт” хуралдаан.
Даргалагч: Д.Ганбат, Улс төрийн Боловсролын Академийн гүйцэтгэх захирал,
ННФ-ын удирдах зөвлөлийн гишүүн*

- 09.35-09.50 “Төрийн ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчин”
үндсэн илтгэл, Д.Лүндээжанцан, УИХ-ын дэд дарга
- 09.50-10.00 “Мэдээллээр үйлчлэх төрийн үүрэг”
Х.Наранжаргал, Глоб Интернэшнл ТББ-ын ерөнхийлөгч
- 10.00-10.10 “Хууль тогтоох үйл ажиллагааны ил тод байдал”
Р.Бурмаа, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөний гүйцэтгэх
захирал
- 10.10-11.10 Хэлэлцүүлэг

*“Улсын төсвийн ил тод байдал” хуралдаан
Даргалагч: Ж.Уртнасан, Татвар төлөгчдийн холбооны дарга*

- 11.30-11.45 “Улсын төсвийн ил тод байдал”
Б.Батжаргал, Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын
газрын дарга
- 11.45-11.55 “Нээлттэй төсөв-Хариуцлагатай төр”
Н.Дорждарь, Нээлттэй Нийгэм Форумын менежер
- 11.55-12.05 “Төрийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагааны
ил тод байдал”
Ж.Мөнхбат, МУИС-ийн Нийгмийн Судалгааны Хүрээлэнгийн
захирал
- 12.05-13.00 Хэлэлцүүлэг

*“Газар олголтын ил тод байдал” салбар хуралдаан**Даргалагч: П.Очирбат, Очирбат сангийн тэргүүн*

- 14.30-14.45 “Газар олголтын ил тод байдал”
Б. Төмөрхуяг, Нийслэлийн Газрын албаны дарга
- 14.45-14.55 “Газар олголтын ил тод байдалтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт”
Х.Оюунцэцэг, Хуульч эмэгтэйчүүдийн холбооны гүйцэтгэх захирал
- 14.55-15.05 “Газар олголтын асуудлыг иргэд хянах боломж”
О. Эрдэнэ-Өлзий, “Үндэсний Соёмбо” хөдөлгөөний төлөөлөгч
- 15.05-16.30 Хэлэлцүүлэг

*“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал” салбар хуралдаан**Даргалагч: Г. Цогтсайхан, Азийн санаачилга институт*

- 14.30-14.45 “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал”
Я.Содбаатар, Үйлдвэр, худалдааны дэд сайд
- 14.45-14.55 “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС) ба Монгол улс”
Д.Батбаяр, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн ахлагч
- 14.55-15.05 “Төлсөн авснаа ил тодоор нийтлэх цаг боллоо”
Ц.Ганболд, Олборлох салбарын ил тод байдлын төлөө ТББ-уудын эвслийн зохицуулагч
- 15.05-15.15 “ОУИТБС-ын талаарх компанийн хандлага”
Айвенхоу Майнз компани
- 15.15-16.30 Хэлэлцүүлэг

“Ил тод байдлыг хангах” хаалтын хуралдаан

- 16.50-17.20 Хэлэлцүүлгээр дэвшүүлсэн асуудлуудын тойм
Хуралдаан даргалагчид
- 17.20-17.55 Хэлэлцүүлэг
- 17.55-18.00 Форумыг хаах

“ТӨРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ: НИЙГМИЙН БАЯЛАГ ХУВААРИЛАЛТ” ФОРУМЫГ НЭЭЖ ХЭЛСЭН ҮГ

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ П. ЭРДЭНЭЖАРГАЛ

Төр, иргэний нийгэм, бизнесийн төлөөлөл Та бүхнийг өнөөдөр энэ танхимд урьсны учир нь улс орны хөгжлийн эрх ашигтай салшгүй холбоотой **ТӨРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**-ын талаар ярилцаж, санал солилцон тулгамдсан асуудлуудыг дэвшүүлэн тавихад оршино.

Монгол оронд өрнөсөн ардчилал, хөгжлийнхөө эгзэгтэй үедээ тулж ирлээ гэж дүгнэж болохоор байна. Ардчилал, зах зээлийн эдийн засаг оршин тогтноход шийдвэрлэх үүрэгтэй төрийн ардчилсан институцүүдийг төлөвшүүлэх нь өнөөгийн тулгамдсан зорилт болж байна. Энэ нь ардчилал, зах зээлийн эдийн засгийн суурийг тавьсан, сүүлийн 15 жил үргэлжилсэн шилжилтийн чанартай шинэтгэлээс хавьгүй түвэгтэй, хүн бүрийн оролцоо, хүчин зүтгэл шаардсан үйл явц болох нь тодорхой байна. Хэдийгээр Монгол Улс ардчилсан хөгжлийн замыг сонгоод багагүй хугацаа өнгөрсөн боловч эдүгээ төрийн институцүүд нь өмнөх тогтолцооны сэтгэлгээнээс бүрэн ангижраагүй, нүсэр бүтэцтэй хэвээр байгаагийн зэрэгцээ, улс төр-бизнесийн бүлэглэлүүдийн нөлөөнд гүнзгий автах болсон зэрэг нь тэдгээрт ардчиллын үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлэх, зарим тохиолдолд нэвтрүүлэх энэхүү үйл явцыг улам бүр амаргүй болгож байна.

Төр ил тод буюу тунгалаг байх нь ардчилсан засаглалын тулгуур зарчим билээ. Хэрэв төр нь хаалттай, ил тод бус байвал ард иргэд нь төрөө хянах боломжгүй болж, улмаар төрийн хариуцлагагүй байдал ердийн үзэгдэл болж, авилгал газар авч, улс орны хөгжлийг урт удаан хугацаагаар хойш татах гүн уршигтай болох талаар маргах хүн үгүй биз ээ.

Төрийн ил тод байдлыг хангах буюу тунгалаг төрийн зарчимд юуны өмнө төр иргэндээ нээлттэй байж, эрх ашигт нь хамаарах аливаа мэдээллийг цаг тухайд нь хүргэж, иргэд нийтлэг эрх ашгаа хамгаалж, нөлөөлж оролцох боломжийг олгох явдал хамаарч байгаа юм.

Ардчилсан, зах зээлийн нийгэмд иргэд нь засаг төрөө сонгож, сонгосон засаг төрөө төлсөн татвараараа санхүүжүүлж, эрхээ хамгаалуулж, нийтлэг эрх ашгаа хангуулдаг. Сонгосон засаг төр нь улс орноо хаа хүргэх, ямар бодлого явуулж, төлсөн татварыг нь юунд, хэрхэн зарцуулж буйг иргэд мэдэх, хянах эрхтэй. Иргэд сонгосон их хурлын гишүүд, тэдний томилсон төрийн өндөр албан тушаалтнууд, төрийн албан хаагчид тэдэнд итгэж хариуцуулсан нийгмийн баялгийг, олгосон эрх мэдлийг улс нийгмийн төлөө бус хувийн эрх ашигтаа ашиглаагүй гэдэгт

итгэлтэй байхыг хүсэх нь зүй ёсны хэрэг. Тийм ч учраас тэднийг хөрөнгө, орлогоо нийтэд мэдээлээч, ашиг сонирхлын зөрчилд орсон бол түүнийгээ ил тод мэдэгдэж, хувьдаа ашигтай шийдвэр битгий гаргаач, битгий гаргалцаач гэдэг. Энэ бол ардчилсан нийгмийн төрийн зүтгэлтний сахих наад захын ёс зүйн хэм хэмжээ билээ.

Манай улсад төрийн ил тод байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн цөөнгүй алхмууд хийгдэж, олон хөтөлбөр, баримт бичиг, хууль тогтоомж баталсан хэдий ч ил тод байдал нь төрийн үйл ажиллагааны бүхий л салбарт тууштай баримтлах нэгдсэн зарчим, ердийн хэм хэмжээ болж хараахан чадаагүй, хэрэгжүүлэлтийн түвшинд бодитой үр дүн төдийлөн гараагүй байна. Иймээс ил тод байдлыг хангах чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааг үнэлэн дүгнэж, оршиж буй бэрхшээл хүндрэлийг тодорхойлж, даван туулах арга замыг талууд хамтран хэлэлцэх нь ил тод байдлыг улам гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж Нээлттэй Нийгэм Форум “Төрийн ил тод байдал: Нийгмийн баялаг хуваарилалт” сэдэвт энэхүү форумыг зохион байгуулж байна. Форумд төр, иргэний нийгэм, хувийн салбарын 200 гаруй хүн оролцож байгаагийн гуравны нэг орчим нь орон нутгаас ирснийг тэмдэглэхэд таатай байна.

Бид өнөөдрийн форумар ил тод байдлын эрх зүйн орчин, улсын төсөв, газар олголт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын асуудлаар тусгайлан ярилцана. Улсын төсөв сүүлийн 5 жилд гурав дахин нэмэгдсэн, манай улс түүхэндээ анх удаа газраа хувьчилж, иргэндээ өмчлүүлж эхэлсэн, Улаанбаатар хотод газрын эрэлт хэрэгцээ эрс нэмэгдсэн, уул уурхайн салбар хөрөнгө оруулалтыг эрчимтэй татаж, олборлолт өсч, улс орны хөгжилд нөлөөтэй томоохон ордууд ашиглалтад бэлтгэгдэж байгаа зэрэг нь эдгээр салбарын ил тод байдлыг онцгойлон авч үзэхэд хүргэж байна. Улс орны нөөц баялгийг ашиглахад нийгмийн гишүүд ижил боломжоор хангагдаж байж эцсийн дүндээ ядуурал буурна.

Төр, иргэний нийгэм, бизнесийнхэн ил тод байдлын асуудлаар уулзаж ярилцах нэг талбар болгож энэхүү форумыг цаашид жил бүр тогтмол зохион байгуулж байх болно. Нээлттэй Нийгэм Форумар зохион байгуулж буй энэ арга хэмжээ Монгол улсад ардчиллыг чанаржуулахад өөрийн хувь нэмрээ оруулах байх хэмээн найдаж байна.

2006 оны 12 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

“ТӨРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХЭРЭГЖИЛТ” ХУРАЛДААН

“Төрийн ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчин, хэрэгжилт” салбар хуралдааныг УТБА-ийн гүйцэтгэх захирал, ННФ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Д.Ганбат даргалан явууллаа. Үүнд УИХ-ын дэд дарга Д.Лүндээжанцан “Төрийн ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчин”, “Глоб интернэшнл” ТББ-ын ерөнхийлөгч Х.Наранжаргал “Мэдээллээр үйлчлэх төрийн үүрэг”, НДЭХ-ий гүйцэтгэх захирал Р.Бурмаа “Хууль тогтоох үйл ажиллагааны ил тод байдал” илтгэлийг тус тус тавьж, дараа нь хэлэлцүүлэг өрнөлөө.

ТӨРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

УИХ-ЫН ДЭД ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

Төрийн ил тод байдал: нийгмийн баялаг хуваарилалт форумд оролцож байгаа Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Форумыг зохион байгуулагчид, “Нээлттэй Нийгмийн Хүрээлэн“-д талархалаа илэрхийлье.

Миний бие энэ форумд тавьж буй товчхон илтгэлээрээ төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах эрх зүйн орчин ямар хэмжээнд бүрдсэн, түүнийг боловсронгуй болгох ямар чиглэл, ямар боломж байгаа талаар цөөн хэдэн санаа дэвшүүлж Та бүхэнтэй санал солилцох гэсэн юм.

Илтгэлийнхээ үндсэн сэдвийг ярихын өмнө энэ асуудлыг судлахын чухлыг онцолж цөөн хэдэн үг хэлье гэж бодлоо.

Ардчилал өнөөдөр улс төрийн үйл явц даяаршиж буйн илрэл төдийгүй өөрөө даяаршмал үзэгдэл боллоо. Ардчиллын хэрэгжих хэлбэр, механизмуудын дотор төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд сонгогчдын өмнө тайлагнах явдал чухал байр суурь эзэлдэгийг судлаачид¹ онцлон тэмдэглэж байна.

¹ Ардчилал болон сонгуульд туслах олон улсын хүрээлэн |IDEA|-ээс боловсруулсан арга зүй, аргачлалын дагуу 1999-2000 онд проф. Девид Бийтхэм, Стюарт Вейр нартай хамтран Бангладеш, Итали, Кени, Малави, Шинэ Зеланд, Өмнөд Солонгос зэрэг орнуудад ардчиллын үнэлгээ хийжээ.

Эрх зүйт төр, ардчиллыг судалдаг эрдэмтэн судлаачид², энэ чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагууд³, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдал, иргэдийн оролцоо, иргэний нийгэм, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эрх чөлөө, эргэж тайлагнах байдлыг төрийн ардчилсан шинжийг харуулах үндсэн шалгуур үзүүлэлтүүд гэж үзэх боллоо.

Монгол дахь ардчиллын хөгжлийн зарим үзүүлэлтийн талаар олон улсын байгууллагуудын үнэлгээ дүгнэлт гарч байна. Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын 5 дугаар хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх төслийн хүрээнд манай үндэсний судлаачдын баг ардчилсан засаглалын үнэлгээний талаар судалгааны томоохон илтгэл гаргаад байгааг Та бүхэн мэдэж байгаа.

Сүүлийн жилүүдэд Монгол дахь ардчилсан үйл явцыг дэмжих зорилготой “Төвлөрлийг сааруулах, нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх”, “Сайн засаглал”, “Ардчилсан парламентын чадавхийг бэхжүүлэх нь” зэрэг олон тооны хөтөлбөр төслүүд хэрэгжсэн. Эдгээрт төрийн байгууллагуудын ил тод байдлын тухай асуудал ямар нэг байдлаар тусгагдсаар ирсэн боловч үр өгөөж нь ямар байв гээд эргээд харахад тоймтой хэлчих зүйл харагдахгүй байна.

Төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй байдлын талаарх судалгаа мэдээлэл тойм шинжтэй, эхлэлийн төдий байна. Философи, эрх зүй, улс төрийн шинжлэх ухааны ерөнхий онолын хүрээнд их төлөв академик шинжтэй зарим нэг ажил хийгдсэн байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Бодлогын прагматик шинжтэй судалгаа гол төлөв “Нээлттэй Нийгмийн Хүрээлэн”, НҮБХХ-ийн болон бусад хөтөлбөр, төслийн дэмжлэгтэйгээр хэд хэдэн удаа хийгдэж⁴, мэдээллийн анхны сан бүрдүүлэх, иргэний нийгмийн хөгжил дэх зарим тулгамдсан асуудлыг дэвшүүлэн тавих зорилтын хүрээнд эхлэлийн гэхээр байдалтай байна.

Энэ бүхнээс үндэслэн манайд төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй байдлын талаар иж бүрэн судалгааны ажил шаардлагатай байгааг би энд зориуд онцлон тэмдэглэж байна.

Одоо би үндсэн асуудалдаа орж ярья.

² О’ Доннелл Г. Делегативная демократия., Девид Истон. Категории системного анализа политики., Карл Т. Л., Шмиттер Ф. Что есть демократия? \ www.psc.eu.tt\ Paul Hilder. Open parties? A map of 21 century democracy. www. open Democracy.net

³ Тухайлбал, Ардчилал болон сонгуульд туслах олон нийтийн хүрээлэн [IDEA], АНУ-ын Олон улсын хөгжлийн байгууллага [USAID], НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр [UNDP], Дэлхийн банк зэрэг газрууд ардчиллын үнэлгээний жишиг болох шалгуур үзүүлэлт, аргачлалыг гаргаад байна. Иргэний оролцоог дэмжих дэлхийн холбоо [СИВИКУС]-ноос иргэний нийгмийн индекс боловсруулах арга зүйг боловсруулжээ

⁴ Монголын Төрийн бус байгууллагуудын хүний тогтвортой хөгжлийг дэмжих чадавхийн судалгаа-НҮБХХ, нийгмийн хөгжлийн төвийн зөвлөх нэгж 1997, Төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх нь. Ардчиллын боловсролын Төв. 2003, “ТББ-ын үйл ажиллагааг боловсронгуй болгох нь” АСЛИС холбоо. –ТББ МННХ, Төрийн бус байгууллагын судлал. –“Зотол” МСК, МННХ, “Нээлттэй мэдээлэл төвийн үйл ажиллагааг өргөтгөн сайжруулах үйл ажиллаганы хэгийн төлөв болон ТББ-уудын эрэлт хэрэгцээг тодорхойлох” маркетингийн судалгаа.- Интернет ба Мэдээлэл төв ТББ, “Монголын нийгмийн салбарт ТББ-уудын оруулсан хувь нэмэр”-НҮБХХ, “ТББ-уудын ажилтнуудыг сургах хэрэгцээ, шаардлага”.-ТББ-ын Сургууль ТББ, “ТББ-ын хэрэгцээг судлах санал асуулга”-МННХ, “ТББ-ын онлайн мэдээллийн хэрэгцээ”-Нээлттэй мэдээлэл төв /НМТ/ www.owc.org.mn

Нэгдүгээрт, нээлттэй, ил тод байх нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн зарчим байх ёстой. Энэ бол ардчилсан, эрх зүйт төрийн нийтлэг шаардлага мөн. Монгол Улсын Үндсэн хуульд “Ардчилсан ёсны зарчим ... төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим” болохыг тунхагласан байдгийг Та бид сайн мэднэ. Тиймээс төрийн ил тод байдлыг хангах асуудал бол манай Парламентын хууль тогтоох бодлогын талаар баримталдаг нэгэн чухал зарчим болж байдаг юм. Тухайлбал, Улсын Их Хурлын 2002 оны 22 тогтоолоор баталсан Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөнд “Улсын Их Хурал нь ардчилсан зарчимд тулгуурлан үйл ажиллагааныхаа ил тод, нээлттэй байдлыг бүх талаар хангах” гэж гол таван зорилтынхоо нэг болгож тодорхойлсон. Энэ зорилтоо хэрхэн яаж хэрэгжүүлэх арга замын талаар ч уг төлөвлөгөөнд тодорхой зааж өгсөн зүйлүүд бий.

Энд юуны түрүүнд төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар хууль эрх зүйн тодорхой орчныг бүрдүүлэхэд анхаарлаа чиглүүлж ирснийг тэмдэглэх хэрэгтэй. Эдүгээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын 30 шахам хууль тогтоомжид төрийн үйл ажиллагааны ил тод байдлын эрх зүйн үндсийг тодорхойлсон нийтлэг болон нарийвчилсан зохицуулалтын хэм хэмжээ зохих тусгалаа олсон гэж хэлж болно. Эдгээрээс шинээр батлагдсан Авилгалын эсрэг Монгол Улсын хуульд төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар нэлээд олон зүйл орсныг зориуд цохон тэмдэглэхийг хүсч байна.

Тухайлбал, авилгалын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зохих мэдлэг эзэмшүүлж, авилгалыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх үүднээс уг хуулийн Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа гэсэн 5 дугаар зүйлд: “Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах” тухай заасан нь төрийн ил тод байдлыг хангахад зарчимын ач холбогдолтой юм. Үүнээс гадна Авилгалын эсрэг хуульд ил тод байдлын талаар дараах тодорхой заалтууд орсон байгаа. Үүнд:

- төрийн байгууллага авилгалын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах
- тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх,
- төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах,
- тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгах, түүнтэй танилцах боломжоор хангах,
- төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын

оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх,

- төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх

зэрэг тодорхой заалтын зэрэгцээ мөн хуулийн 14 дүгээр зүйлд төрийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг олон нийтэд нээлттэй байх талаар, түүнийг “Төрийн мэдээлэл” эмхтгэл болон цахим сүлжээнд байрлуулж нийтэд мэдээлэх талаар заасан байгаа.

Цаашид уг хуулийг хэрэгжүүлэх талаар Засгийн газар, авилгалтай тэмцэх байгууллага болон холбогдох яам, агентлагуудын хэмжээнд эрх зүйн цоо шинэ орчинд ил тод, нээлттэй байдлаар хэрхэн ажиллах, хуулийн хэрэгжилтийг яаж зохион байгуулах талаар хуульд нийцүүлэн тодорхой журам гаргаж шуурхай ажиллах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, хууль, төрийн байгууллагын бусад шийдвэрийг олон нийтэд сурталчлан мэдээлэх, хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй зохион байгуулах нь төрийн байгууллагуудын ил тод байдлын нэг үзүүлэлт мөн. Энэ талаар эрх зүйн тодорхой зохицуулалтууд хийгдсэн байгаа.

Үндсэн хуульд Монгол Улсын хуулийг албан ёсоор нийтлэх, мөн Улсын Их Хурлын чуулганы шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхээр, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43.5-д заасны дагуу “Төрийн мэдээлэл” эмхтгэлд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаарх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, яам, агентлагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг бүрэн эхээр нь нийтэлж байгаа бөгөөд уг эмтхгэл нь долоо хоног тутам гарч байна.

Хуулийн эдгээр заалтыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг ашиглаж, хууль, бусад шийдвэрийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах талаар төрийн байгууллагууд санаачилгатай ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Гуравдугаарт, хууль болон төрийн байгууллагуудын шийдвэрийг нийгэм, олон нийтэд сурталчлан мэдээлэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд онцгой үүрэгтэй. Үндсэн хуулиас эхлээд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Олон нийтийн радио телевизийн тухай хуулиудаар хэвлэлийн эрх чөлөөний эрх зүйн суурь үндэс бүрдсэн. Харин энэ хуулийг хэрэгжүүлэх явц төдийлэн сайн байгаа гэж дүгнэхээргүй байна.

Хэрэгжилтийн явц сайнгүй гэсэн дүгнэлтийг хэлэхдээ би хоёр зүйлийг үндэс болгож байна. *Нэгд*, хэдийгээр төр, түүний байгууллагууд харьяандаа хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй байх, төрийн байгууллага, албан тушаалтнууд хэвлэл, мэдээллийн байгууллагуудын нийтлэл, нэвтрүүлэгт хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглосон боловч янз бүрийн аргаар хэвлэлийнхнийг нөлөөндөө байлгах, өөрсдийгөө сурталчлуулах, эсвэл хамгаалуулахын төлөө ажилладаг явдал нийтлэг байдаг. *Хоёрт*, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд хуулиар олгогдсон эрх

чөлөөгөө зохих ёсоор хэрэгжүүлэхийг чухалчлахаасаа илүү ямар нэг улс төрийн хүчин, эсхүл хөрөнгө мөнгөтэй хүн, тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийнхээ эзний нөлөөнд автах тохиолдол цөөн биш байдаг. Энэ хоёр хүчин зүйлийг иш үндэс болгож би дээрх дүгнэлтийг хийж байгаагаа хэлэх байна.

Дөрөвдүгээрт, төрийн бодлого, үйл ажиллагааны талаар иргэд хүссэн мэдээллээ олж авах ямар бололцоогоор хангагдсан байх нь төрийн нээлттэй ил тод байдлын чухал үзүүлэлт болно.

Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Төрийн нууцын жагсаалтыг батлах тухай хуульд хуулиар хамгаалагдсанаас бусад мэдээлэл олон нийтэд нээлттэй байхаар хуульчилсан гэж ойлгож болно. Эдгээр хуулийг хэрэгжүүлэх явцад зарим нэг доголдол гарч байгаагаас иргэд хүссэн мэдээллээ хөнгөн шуурхай авч чадахгүй байх тохиолдол цөөнгүй гардагийг бид сайн мэднэ. Ялангуяа байгууллага нууцдаа хамаарах асуудлын жагсаалтыг өөрөө гаргадаг, төрийн байгууллагуудын хэвлэлийн алба, хэвлэлийн төлөөлөгчид нь байгууллагынхаа талаар олон нийтэд мэдээлэл өгөх гол үүргээ хэрэгжүүлэхийн оронд дарга, албан тушаалтныг сурталчилж, тэднийг хамгаалсан үйл ажиллагаа явуулдаг, олон нийтэд хүргэх шаардлагатай зарим мэдээллийг байгууллагын нууц нэрээр иргэд, хэвлэл, мэдээллийн байгууллагад өгөхгүй байх зэрэг дутагдал архагших шинжтэй болж байна. Иймд дээр дурдсан хуулиудын хэрэгжилтийн байдалд мониторинг, үнэлгээ хийж, өөрчлөн боловсронгуй болгох талаар Засгийн газар санаачилга гаргах ёстой гэж үзэж байна.

Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцэхээр Улсын Их Хурлын жил жилийн ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулж байдаг ч одоогоор хэлэлцүүлэхээр өргөн баригдсан болон бэлэн болсон хуулийн төсөл хараахан байхгүй байна. Энэ хуулийг цаг алдалгүй боловсруулж гаргахгүй бол иргэдийн мэдээлэл олж авах, эрж хайх эрхийг хэрэгжүүлэх, төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй байдлыг хангахад учирч буй бэрхшээлийг даван туулах боломжгүй гэдгийг онцлон хэлмээр байна.

Тавдугаарт, иргэдийн идэвхтэй оролцоо нь нэг талаас, төрийн үйл ажиллагааны ил тод байдлын илэрхийлэл, нөгөө талаас иргэдийн улс төрийн идэвхийг хөхүүлэн дэмжих нэг гол хөшүүрэг болдог. Тиймээс хэлэлцэж буй хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн саналыг аль болох өргөн тусгах, төслийн талаарх нээлттэй хэлэлцүүлгийг өргөн зохион байгуулж байх нь хуулийн төсөл нийтийн эрх ашигт илүү ойр дөт болж, ингэснээр амьдрал практикт хэрэгжих үндэслэл сайтай болдог. Манай парламент хууль тогтоох үйл явцын боломжтой бүх шатанд олон нийтийн оролцоог хангах талаар сүүлийн жилүүдэд нэлээд анхаарч ажиллаж байгаа. Эхний үр дүн ч ямар нэг хэмжээгээр гарч байна. Жишээлбэл, сүүлийн үед олон нийтийн анхаарлыг татсаар ирсэн Сонгуулийн тухай, Ашигт малтмалын тухай хууль, Татварын хуулиуд, Авилгалын эсрэг хуулийн төслийн талаар хурал, семинар зохион байгуулах, төслийг интернэтийн сүлжээнд тавих, олон нийтийн санал асуулга явуулах, иргэд, иргэний нийгмийн төлөөллийг ажлын хэсэгт оруулан хамтран ажиллах зэрэг олон янзын арга хэлбэрээр олон нийтийн саналыг тусгаж ажилласан.

Иргэдийн оролцооны бас нэгэн нөлөөтэй суваг нь Парламентад захидлаар болон электрон хэлбэрээр санал хүсэлт ирүүлдэг иргэдийн захидал юм. Иргэдийн захидлын тооны өсөлт, бууралтын статистик үзүүлэлтийг харахад нэгэн бүрэн эрхийн хугацаагаа эхэлж буй Парламентад хандах иргэдийн хандлага эхэндээ эрс нэмэгддэг байдал харагдаж байна. Жишээ нь: 2000 онд 1899 захидал авч байсан бол 2001 онд энэ тоо 3420 болж, 2004 онд 3313 захидал авч байсан бол 2005 онд 6113 болжээ. Энэ нь иргэд шинэ Парламентад илүү итгэл найдвар тавьж өөрсдийн санал бодлоо илэрхийлж байдгийн нэг жишээ юм. Энэ 2006 оны эхний 10 сарын байдлаар нийт 3154 захидал хүлээн авснаас төр, засгийн бодлого шийдвэрт тусгах, хуулийн төсөлд өгөх саналын байдал сар бүрд харилцан адилгүй боловч ихэнхдээ 4-10 гаруйхан хувьтай байдаг. Харин аль нэг гишүүнд хандсан захидлын тоо нийт захидлын 80-90 гаруй хувийг эзэлж байгааг анхаарахгүй өнгөрч боломгүй байна. Мөн оны эхний 10 сарын байдлаар Иргэдийн хүлээн авах байраар өөрийн биеэр ирж санал хүсэлтээ илэрхийлсэн 661 хүн байна.

Энд нэг зүйлийг анхаарах хэрэгтэй. Улсын Их Хурлын гишүүд, төрийн байгууллагад иргэдээс ирж буй өргөдөл, захидлын дийлэнх нь хаягласан Улсын Их Хурлын гишүүд болон төрийн байгууллага, албан тушаалтнуудын эрх мэдэл, чиг үүрэгт нь хамаарахгүй хувь хүмүүс өөрсдийнхээ хувийн амьдралын аар саар асуудлаа шийдвэрлүүлэх агуулгатай байгаа юм. Энэ бол иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, эрх зүйн соёлд сургах асуудал хойшлуулашгүй зорилт болоод байгааг харуулж байна.

“Ардчилсан парламентын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Монгол Улсын ихэнх аймаг, нийслэлийн дүүргүүдэд Парламентын мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг байгуулж, төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлахын зэрэгцээ бас хэлэлцэх гэж буй хуулийн төсөл, батлагдсан хуулийн хэрэгжилтийн талаар иргэдийн санаа бодлыг авч эхэлж байгаа нь цаашдаа үр дүнгээ өгнө гэж бодож байна.

Эцэст нь, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах эрх зүйн суурь орчин бүрдсэн боловч тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн зэрэгцээ зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, зарим шаардлагатай хуулийг шинээр батлах зэргээр эрх зүйн орчинг цаашид боловсронгуй болгох шаардлага байна.

Энэ шаардлагыг үндэс болгон хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгохын тулд төр болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэд бүх талаар хамтран ажиллахыг уриалж байна. Энэхүү форумын зорилго ч үүнд чиглэгдсэн гэж би ойлгож байгаа. Форумд төрийн ил тод байдал хэрхэн хангагдаж буй бусад асуудлын талаар тухайлбал, улсын төсвийн, газар олголтын, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал зэрэг олон нийтийн анхаарлыг татсан асуудлуудаар тусдаа илтгэл тавигдах учраас энд би зөвхөн эрх зүйн ерөнхий орчинтой холбогдсон цөөн асуудлаар санаа бодлоо товч илэрхийллээ.

Форумын цаашдын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

МЭДЭЭЛЛЭЭР ҮЙЛЧЛЭХ ТӨРИЙН ҮҮРЭГ

“ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ-ЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Х. НАРАНЖАРГАЛ

*Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд...НҮБ-аас
эрхэмлэдэг хүний бусад эрхийн үндсэн хэмжүүр мөн.
НҮБ-ын Ерөнхий ассемблейн анхдугаар чуулга
уулзалтын 59-р тогтоолоос*

Мэдээллийг ардчиллын хүчилтөрөгч гэдэг. Хүний эрхийг дээдэлдэг нийгмийн амин сүнс нь нээлттэй мэдээлэл юм. Нээлттэй мэдээлэл нь мөн ардчилал, эрх чөлөө, шударга ёс, хөгжил дэвшлийн баталгаа юм.

Энэ илтгэлийг “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас 2001-2006 онд хийсэн янз бүрийн судалгаанд түшиглэн бэлтгэв.

2002-2003 оны “Олон нийтийн мэдэх эрх” судалгаанд 18-аас дээш насны 100 иргэн оролцсон юм.

Мэдээлэлтэй байх нь танд ямар хэрэгтэй вэ?	тоо	хувь
1. Олон нийт төрийн байгууллагыг хянах ёстой учраас	42	25.92%
2. Төрийн байгууллагыг шүүмжлэх боломж бий болно	28	17.28%
3. Төрийн байгууллага олон нийтийн татварын мөнгөөр үйл ажиллагаа явуулдаг учраас	25	15.4%
4. Төрөөс явуулж байгаа үйл ажиллагааг дэмжихэд хэрэгтэй	22	13.58%
5. Иргэд сонгодог учраас	17	10.49%
6. Авилгалаас урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой	12	7.4%
7. Бид төрдөө үйлчилдэг	8	4.94%
8. Төрийн байгууллагад ажилд ороход хэрэгтэй	8	4.9%

Манай улс иргэдийнхээ мэдээлэлтэй байх эрх, мэдээллийн эрх чөлөөг Үндсэн хуулиараа баталгаажуулсан.

Иргэддээ мэдээллээр үйлчлэх нь төрийн үндсэн үүргийн нэг юм. Тэгвэл энэ үүргээ манай төр засаг аль хэр хариуцлагатай биелүүлж байна вэ?

*Нийтийн мэдээлэлгүй, эсвэл түүнийг олж эзэмших арга хэрэгсэлгүй хэмээн алдаршсан төр засаг нэг талаар эмгэнэлтэй, нөгөө талаар инээдэмтэй, эс бөгөөс хоёулаа юм.
Жеймс Мадисон*

Тэгвэл манайд байдал эмгэнэлтэй юү, эсвэл инээдэмтэй юү?

Мэдээллээр үйлчлэх нь ардчиллын мөн чанар, зарчим, соёлын салшгүй хэсэг юм. Ардчилсан нийгмийн зарчмыг манай өнөөгийн байдалтай харьцуулж үзье.

Ардчилсан нийгэмд	Монголын нийгэмд
1. Бүх мэдээлэл иргэдэд ил, нээлттэй байна.	Мэдээллийг нууцлах, хязгаарлах уламжлал, сэтгэхүйгээс салаагүй
2. Зарим хязгаарлалт хийж болно Үүнд: -Бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх -Үндэсний аюулгүй байдал -Нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зайлшгүй шаардлага бол мэдээллийг хязгаарлаж болно.	Мэдээлэл нээлттэй байж болно Эрүүл мэн, байгаль орчин, гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл ил байж болно. Төрийн байгууллагын зарим бичиг баримт, зарим мэдээлэл нээлттэй
3. Нууцыг заавал хуулиар тогтооно	Төрийн нууцыг заавал хуулиар тогтооно Байгууллага өөрөө нууцаа тогтооно Тодорхой хуулиудад байгууллагын нууцыг хамгаална.

Дээрх зарчмаас үүдэн Монголын өнөөгийн байдалд дараах дүгнэлтийг хийж байгаа юм.

1. Эрх зүйн орчин таагүй байна

Монголын хууль тогтоомжид эерэг заалтууд байгаа боловч гол төлөв зарчмын шинжтэй, тунхаглалын чанартай, зохицуулалт механизм нь сул, бүдэг учир хэрэгжих боломжгүй юм.

Манай хуулиудад дараах зарчмыг тунхагласан байна.

- Төрийн үйл ажиллагаа ил тод байна.
- Зарим мэдээллийг ил, нээлттэй байлгах үүрэг ногдуулсан.

- Заавал нийтлэх зарим мэдээлэл, бичиг баримтыг хуульчилсан.

Манай хуулиудад *мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалт нь түлхүү байдаг*

2001-2002 онд “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага, Лондон хот дахь “Арван есдүгээр зүйл” байгууллагатай хамтран “Монгол улс шилжилтийн үед: Үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ” хийсэн юм. Тайлангаас үзэхэд 232 хуулийн 51 нь илүүц хязгаарлалттай байв. Ийм хуулийн тоо нэмэгдсээр байгаа юм. Жишээ нь, 2003 онд батлагдсан СӨХ-ны тухай хуулиар Хяналтын зөвлөлийн гишүүн шалгасан баримт бичиг, тайлан, тэнцлийн нууцыг хадгалах үүрэгтэй (11.4).

Мэдээллийг хязгаарлаж буй Монгол Улсын хуулиуд

Төрийн нууц

Монгол Улсад төрийн нууцыг Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар хамгаалдаг. Төрийн нууцын тухай хууль 1995 онд батлагдаж, хамгийн сүүлд 2004 оны 1-р сарын 2-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Төрийн нууцын тухай хуульд: “Төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томьёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

Хуулийн 11-р зүйлд зааснаар “Төрийн нууцыг задруулснаас Монгол Улсын ашиг сонирхол, аюулгүй байдалд учирч болох хор уршгийн хэмжээнээс хамааран төрийн нууцын зэрэглэлийг тогтооно” гэсэн бөгөөд төрийн нууц нь онц чухал-маш нууц, маш нууц, нууц гэсэн гурван зэрэглэлтэй байна.

Төрийн нууцын тухай хуулиар төрийн нууцыг үндсэн 5 төрөлд ангилдаг. Нууцалсан зэрэглэлээр нь авч үзвэл онц чухал-маш нууц мэдээлэл 6, маш нууц мэдээлэл 24, нууц мэдээлэл 7 байна. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд зэрэглэлийг шууд зааж өгөөгүй, нууцалсан зэрэглэлээр гэж ангилсан 25 мэдээлэл байгаа юм.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар 59 төрлийн мэдээллийг, тухайлбал үндэсний аюулгүй байдлын хүрээнд 19, батлан хамгаалах хүрээнд 14, эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд 5, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд 15, бусад хүрээнд 6 зүйлийн мэдээллийг нууцлахаар тогтоожээ. Нийт 59 зүйлээр тогтоосон мэдээллийн 69.5 хувийг 40-60 жилээр, эсвэл байнгын хугацаагаар нууцалсан байна.

Байгууллагын нууц

1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан Байгууллагын нууцын тухай хуулиар нууц мэдээлэл тухайн байгууллагын хамгаалалтад байхаар тогтоосон. Мөн тухайн байгууллага нууцаа хамгаалах журмыг өөрөө тогтоож мөрдөхийг

үүрэг болгосон /5.1/. Энэ хатуу заалтыг 6 дугаар зүйлээр зөөлрүүлэх оролдлого хийж, нууцлахыг хориглох мэдээллийн жагсаалтыг баталсан байна. Үүнд: тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл бол, мөн тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээллийг нууцлахыг хоригложээ. Мөн гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээллийг байгууллага нууцалж болохгүй ажээ.

Хувийн нууц

Үндсэн хуулийн 16.17-д мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг бусдын “нэр төр, алдар хүндийг хамгаалах” үүднээс хязгаарлаж болно гэж заасан. Үүнийг олон улсын хэм хэмжээгээр ч хүлээн зөвшөөрдөг. Манай улсын Хувь хүний нууцын тухай хуульд хувийн нууцыг хүчтэй хамгаалсан. Үүнд нь сонгогдсон улс төрч, төрийн өндөр албан тушаалтан, албан хаагчид ч хамрагддаг.

Бусад хязгаарлалт

Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Аудит, Геодези, зураг зүй, Арбитрийн гэх мэт бараг бүх хуульд нууц хамгаалсан заалтууд байдаг.

Нууц задруулсан иргэнд ногдуулах шийтгэл өндөр

Нууц хамгаалах үүрэгтэй байгууллага, хариуцсан ажилтантай хэрнээ жирийн иргэнд нууц мэдээллийг задруулахгүй байх хатуу үүрэг ноогдуулсан. Төрийн, байгууллагын, хувийн нууц задруулсан иргэн санаандгүй байдлаар үүнийг үйлдсэн ч доод тал нь 3, дээд тал нь 8 жил хоригдох ял хүлээнэ.

Хуулиар нууцлах хугацаа дууссан ч мэдээлэл ил болдоггүй

Төрийн нууцын жагсаалтын тухай хуульд нууцын хугацаа дууссан байлаа ч гэсэн мэдээллийг заавал УИХ-ын шийдвэрээр ил болгоно.

Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиас болгоомжилж байна

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас 2002 онд Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн (одоогийн ННФ), АНУ-ын Элчин Сайдын Яам, Австралийн Олон улсын Хөгжлийн Агентлагийн санхүүгийн дэмжлэгээр мэдээллийн эрх чөлөөний мөн чанар, үзэл баримтлал, зарчмуудыг түгээн дэлгэрүүлэх, ойлгуулах чиглэлээр өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж, 2004 онд Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн анхны төслийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд танилцуулсан юм. Энэ хуулийг хэлэлцэж батлахаар УИХ-аас 2005 оны 11-р сард чуулганы хэлэлцэх асуудлын дэгд оруулсан байсан ч өнөө хэр хэлэлцэгдээгүй байна. 2006 оны 10-р сард Засгийн газрын хуралдаанаар энэ хуулийг УИХ-д өргөн барих асуудлыг хэлэлцсэн боловч мэдээлэл түгээх, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, хэвлэл мэдээллийн эрх зүйн зохицуулалттай уялдуулан багцлан хэлэлцэхээр шийдвэрлэж, хойшлуулсан байна.

2. Төрийн байгууллага мэдээллээр шаардлагын түвшинд үйлчилж чадахгүй байна

Олон улсын хэм хэмжээгээр төрийн байгууллагад доорх мэдээлэл олон нийтэд зайлшгүй ил байх ёстой ажээ. Үүнд:

1. Төрийн байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааны тухай мэдээлэл
2. Төрийн байгууллагад хадгалагдаж буй олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, тэдний сэтгэл санааг зовоож буй мэдээлэл
3. Төрийн байгууллагуудад хадгалагдаж буй албан ёсны бичиг баримтууд
4. Төрийн байгууллагын албан хаагч, ажилтнуудын ажил үүрэгтэй холбоотой мэдээлэл

Дээрх зарчмын үүднээс авч үзвэл төрийн байгууллагууд иргэдийг мэдээллээр шаардлагын түвшинд үйлчилж чадахгүй байна гэсэн дүгнэлт хийж болно. Энэ нь доор дурдсан судалгаагаар нотлогдож байгаа юм.

2002-2003 онд хийсэн “Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал” судалгаанд төрийн 47 байгууллага хамрагдсан. Үүнээс 29 байгууллага зорилго, зорилтоо “үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлах”, 23 байгууллага “олон нийтийг мэдээллээр хангах” гэж тодорхойлсон байна. Харамсалтай нь, бодит байдал үүнтэй зөрчилдөж байгаа юм.

Хуулиар хориглосноос бусад мэдээллийг иргэн хүн чөлөөтэй авах боломжгүй

Судалгаанд хамрагдсан нийт байгууллагаас дор дурдсан 6 байгууллага иргэд мэдээллийг чөлөөтэй авах боломжгүй гэжээ.

1. Тагнуулын төв газар
2. Сүхбаатар дүүргийн ИТХ
3. Иргэний нисэхийн ерөнхий газар
4. Төр засгийн үйлчилгээ, аж ахуй эрхлэх газар
5. Сүхбаатар дүүргийн шүүх
6. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар

Төрийн байгууллага, түүний ажилтан жирийн иргэнээс давуу эрхтэй

Төрийн байгууллагаас мэдээлэл олж авах эрхээ хэн илүү эдэлж байгааг авч үзвэл (нийт 47 байгууллагаас):

Төрийн байгууллага	39
Төрийн албан хаагч албан шугамаар	35
ТББ, хувийн байгууллага албан ёсоор хүсэлт гаргасан тохиолдолд	35
Гэхдээ иргэн зорилгоо тайлбарлавал	32
Иргэнд зөвхөн удирдах албан тушаалтны зөвшөөрлөөр	13
Иргэн татвар төлөгчийн хувьд	11

Өнөөгийн бодит байдал нь ардчилсан нийгэмд тавигддаг шаардлагад хэрхэн нийцэж буй нь дараах хүснэгтээс харагдаж байна.

Шаардлага	Бодит байдал
Төрийн байгууллага мэдээлэл түгээх дүрэм журамтай байх	Байгууллага нууц мэдээллийн жагсаалттай, хамгаалах дүрэм журамтай байх ёстой. Судалгаанд хамрагдсан 45 байгууллагын 12 нь нууцын жагсаалт, хамгаалах журамгүй байв. 23 байгууллагын нууцын жагсаалт, 26 байгууллагын нууц хамгаалах журам нь байгууллагын нууцад хамаардаг.
Төрийн байгууллага мэдээлэл түгээх үйлчилээг хариуцсан алба, хэсэг, хэлтэс гэх мэт тодорхой ойлгомжтой бүтэцтэй, хариуцсан ажилтантай байх	36 байгууллага олон нийттэй харилцах алба, хэвлэлийн алба, хэвлэлийн төлөөлөгчтэй. Тэд байгууллагаа сурталчлах үүрэгтэй. Иргэдэд мэдээллээр үйлчлэх чиг үүрэг бүхий тусгай ажилтан байхгүй.
Төрийн байгууллага хуримтлуулсан, цуглуулсан мэдээллээ шаардлагатай түвшинд ангилсан, кодолсон мэдээллийн сан, архивтай байх	29 байгууллага “мэдээлэл нь цэгцтэй, системтэй, кодлогдсон” гэж хариулсан байна.
Иргэнд хүссэн мэдээллийг нь өгөөгүй албан тушаалтан, албан хаагч хариуцлага хүлээдэг байх	Албан хаагч заавал даргаасаа зөвшөөрөл авах ёстой.

2006 онд хийсэн “Иргэний мэдээлэл олж авах нөхцөл боломж” судалгаа

Судалгаанд УИХ, Засгийн газар, түүний харьяа агентлаг, газар, яам, архив, шүүх, прокурор зэрэг 13 байгууллагаас иргэд 15 төрлийн мэдээлэл олж авахаар хүсэлт тавьсан. Үүнээс 11 нь ил тод байх ёстой мэдээлэл байв. Харин 3 мэдээлэл нь төрийн нууцад хамаардаг, 1 нь, хуулиар нууцлах хугацаа нь дуусч, ил болох ёстой мэдээлэл байв.

Энэ судалгаанаас дараах дүгнэлтийг хийж болно.

Төрийн байгууллага жирийн иргэнд мэдээлэл өгөхөөс татгалздаг

Судалгааны явцад төрийн нууцад үл хамрах 12 мэдээллээс ердөө 3-ыг олж авсан. Хүссэн мэдээллийн 3 нь хуулиар хамгаалагдсан төрийн нууц байсан боловч 1 нь нээлттэй болсон байв. Төрийн байгууллагууд нууц бус 9 мэдээллийг өгөхөөс татгалзаж, 3 мэдээллийг өгөхөөс татгалзаагүй боловч судлаачид олж авч чадаагүй байна.

Мэдээлэл өгөхөөс татгалзсан шалтгаан (9 мэдээллээс):

Төрийн нууц	6
Байгууллагын нууц	1
Иргэд танилцаж байсан практик байхгүй	1
Шалтгаангүйгээр татгалзсан	1
Татгалзаагүй боловч олж авч чадаагүй мэдээлэл:	1
Вэб сайтад байгаа гэсэн боловч байхгүй	1
Судлаачдад төлбөртэй өгч болох, өндөр үнэтэй	1
Шалтгаангүй	1

Үүнтэй адил төстэй боловч өөр аргаар 100 хүнийг хамран хийсэн 2002 оны судалгааны дүнг харъя.

Мэдээлэл өгөхөөс татгалзсан үндэслэл	тоо	хувь
1. Ямар ч шалтгаангүй	13	19.7%
2. Тухайн мэдээлэл байхгүй	12	18.19%
3. Албан хэргийн бичиг баримтыг жирийн иргэнд өгөхгүй	11	16.6%
4. Удирдлага нь зөвшөөрөөгүй	10	15.15%
5. Мэдээллийг ашиглах зорилгоо хэлсэн боловч өгөөгүй	7	10.6%
6. Төрийн нууц	5	7.6%
7. Байгууллагын нууц	5	7.6%
8. Завгүй байна	1	1.5%
9. Дутуу дулимаг хариулт өгсөн	1	1.5%
10. Төлбөр шаардсан	1	1.5%

Иргэн мэдээлэл авахын тулд байнга хүндрэл бэрхшээлтэй тулгардаг

- Төрийн албан хаагч, ажилтан ямар зорилгоор тухайн мэдээллийг хүсч буйг заавал асууна
- Төрийн байгууллагаас мэдээлэл авахад маш их хүнд сурталтай тулгарч байна. Заавал албан бичиг, ямар нэг баримт бичиг шаарддаг. Эсвэл анкет бөглөх хэрэгтэй.
- Төрийн байгууллагад нэвтрэх туйлын хэцүү учир мэдээлэл хариуцсан

хүнтэй нүүр тулж уулзах боломж үгүй. Иргэд жижүүр, харуулаар дамжуулан хэрэгтэй хүнтэйгээ холбогдоно. Эсвэл хэрэгтэй хүнээ олох гэж ихээхэн цаг зарцуулна. Зарим тохиолдолд холбогдох хүнтэй нь жижүүр, харуулаар дамжуулан ярих хэрэг гардаг.

- Төрийн байгууллагууд хэвлэн нийтлэх үүргээ төдийлөн сайн ойлгодоггүй. Бэлэн мэдээллийг худалдаж орлого олох сонирхолтой.
- Төрийн албан хаагчид вэб сайтад бий гэж хэлэх нь моод болсон. Гэвч тэр мэдээлэл нь байддаггүй.
- Зарим албан хаагч ажил үүргээ мэддэггүй бололтой. Бие бие рүүгээ түлхдэг.
- Иргэн ийм мэдээлэл ерөөсөө хүсдэггүй гэж гайхшрах байдал тохиолдож байсан
- Мэдээлэл өндөр үнэтэй. Мэдээлэл олж авах нь иргэн бүрт адил тэгш бус. Судлаач бол албан бичиг авчирч төлбөрийг төлөөд авч болно.

Төрийн байгууллага, албан тушаалтан, сэтгүүлчдэд ч мэдээлэл өгөхөөс татгалздаг.

Иргэний эрх ашигт нийцсэн мэдээлэл түгээх нь сэтгүүлчийн эн тэргүүний эрхэм үүрэг байдаг. Сэтгүүлчид мэдээлэл өгөхөөс татгалзах нь иргэний эрхийг хүндэтгээгүй хэрэг юм. Амьдрал дээр сэтгүүлчдэд байнга тохиолддог энэ хүндрэл бэрхшээлээс зөвхөн гурван жишээг дурдав. Бүрэн мэдээллийг “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас эрхлэн гаргасан “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө Монголын өнөөгийн байдал” тайлангаас үзэж болно. Вэб сайтын хаяг: www.globeinter.org.mn, www.monitoring.mn

Жишээ 1. Эх сурвалж: “Өнөөдөр” сонин 2006.01.11 № 008

Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр хадгаламжийн банкны хувьчлалын талаар янз бүрийн мэдээлэл цацагдаж буй. Түүнчлэн тус банкны улсын төсөвт төлсөн татварын хэмжээ буурсан гэх болсон билээ.

Эдгээр мэдээллийн үнэн бодитой эсэхийг тодруулахаар Үндэсний татварын ерөнхий газрын мэдээлэл боловсруулалт, автоматжуулалтын хэлтсийн байцаагч Б.Батгэрэлтэй уулзаж хадгаламжийн банкны 2003-2005 онд улсад төлсөн татварын талаарх мэдээлэл авахыг хүссэн боловч татгалзсан хариу сонслоо. Хүсэлтээ албан бичгээр гаргах лүндэн буулгасныг ёсоор болговол “Манай даргаар гарын үсэг зуруулаад ир. Тэгвэл мэдээлэл өгнө” гэв. Улсын нууцад үл хамаарах хамгийн энгийн баримтыг журмын дагуу хүсээд тусыг эс олов. ҮТЕГ-ын удирдлага байгуулагадаа ийм хатуу дэг тогтоосон хэрэг үү, эсвэл байцаагч Б.Батгэрэл хүнд суртал гаргаж байна уу?

Жишээ 2

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Даштүдэв Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийнхөө үйл

ажиллагаатай танилцаж, 2006 оны 6-р сарын 12-нд шалгалтын дүнгийн хурал хийж байхдаа аймгийн радио, телевизийн хоёр сурвалжлагчийг танхимаас гарахыг шаарджээ.

Г.Даштүдэв шалгалтын дүнгийн зарим мэдээллийг нийтэд мэдээлэхгүй, нууц гэсэн нэрийдлээр Өвөрхангай аймгийн “Ноён-Уул” FM радиогийн сурвалжлагч С.Мөнхдалайн диктафоныг хоёр ч удаа унтрааж, хурлын явцыг сурвалжилж байсан Өвөрхангай аймгийн телевизийн сурвалжлагч Г.Пунцагсүрэнг бичлэг хийлгүйгээр хуралд суух, эсвэл тэндээс гарахыг шаардсан байна. “Малын хулгайчдын нэрийг хэлэхэд бэлэн байгаа тухай, мөн энэ хүмүүсийг илрүүлж хуулийн дагуу арга хэмжээ авах, Аймгийн цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн цаг хугацаандаа ирэхгүй хүлээлгэсэн” зэрэг мэдээллийг Г.Даштүдэв нууц хэмээн тодорхойлжээ.

Жишээ 3

Өмнөговь аймгийн засаг дарга М.Ядмаа 2006 оны 7-р сарын 27-нд “Алтан говь” телевизийн зураглаач М.Шинэхүү Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга нарын хурлыг сурвалжилж байх үеэр цаашид энэ телевизэд мэдээлэл өгөхгүй байх үүргийг газар, хэлтсийн дарга нартаа өгчээ.

“Алтан говь” телевиз 2006 оны 7 сарын 26-ны өдөр тус аймагт махны үнэ хэт өсч байгаа тухай мэдээлэхдээ махны худалдагч Долгорын “Аймгийн засаг дарга өөрийн ах дүү нартаа мөнгө гарган өгч, өөр аймгуудаас мах авчирч заруулсан” гэсэн утгатай ярилцлагыг оруулсан байна. Энэ мэдээллийг ТВ-ээр дамжуулсны маргааш ноён М.Ядмаа махны худалдагч Долгорыг өрөөндөө дуудан, “ярьсан зүйлдээ залруулга хийхгүй бол шүүхэд өгнө” хэмээн хэлтсийн дарга нарынхаа хамтаар сүрдүүлжээ.

Засгийн газар, төрийн байгууллага өөрийгөө магтуулах мэдээлэлд хөрөнгө мөнгө хайрладаггүй

2000-2004 онд Засгийн газрын нөөц хөрөнгөөс нийт 223.9 сая төгрөгийг Засгийн газрын үйл ажиллагааг сурталчлахад зарцуулсан байна. Үүнээс “Үнэн”, “Зууны мэдээ” сонины захиалга, бусад дэмжлэгээр дамжуулан 138.9 сая төгрөг зарцуулжээ. Хэвлэн нийтлэгч, сэтгүүлчдийн байгууллагад мөн ийм зорилгоор 45 сая төгрөг өгсөн байна.

Улсын Аудитын газрын тайлангаас харахад зөвхөн 2000 онд төрийн 80 байгууллага хэвлэл мэдээллээр өөрийгөө сурталчлахад зориулан хоёр сонинд 20 гаруй сая төгрөг зарцуулжээ.

3. Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлдэггүй

- Манай улс Үндсэн хуулиа ч мөн Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пактын үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулсан 19-р зүйлийг бүдүүлгээр зөрчдөг

- НҮБ-ын гишүүн боловч баталсан гэрээ, конвенци, бусад баримт бичиг, тунхаг, тунхагийн зарчмыг зөрчдөг, зөвлөмжийг хүлээн авдаггүй

НҮБ-ын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх тусгай илтгэгч 1998 оны илтгэлдээ “мэдээллийн эрх чөлөөнд төрийн байгууллагаас мэдээлэл олж авах эрх багтана” гэж заасан. “Мэдээллийг хайх, хүлээж авах, түгээх эрх нь төрд мэдээллийг иргэдэд хүртээмжтэй болгох эерэг үүргийг төрд ногдуулдаг, ялангуяа Засгийн газрын эзэмшилд байгаа бүх төрлийн архив, мэдээллийг нөхөн сэргээх байгууллагын мэдээлэл ил тод байх тухай”¹ саналыг НҮБ-ын Хүний эрхийн комисс дэмжсэн.²

Тусгай илтгэгч 2000 оны илтгэлдээ “Төрийн мэдээлэл хүртээмжтэй байх нь ардчилал, эрх чөлөөг хөгжүүлэхэд ач холбогдолтойн дээр хүний хөгжих эрхийг хэрэгжүүлэх, төрийн үйл ажиллагаанд оролцох эрхийг эдлүүлэхэд нэн чухал” болохыг дэлгэрүүлэн тайлбарласан юм. Ингэхдээ төрийн байгууллагад байгаа албан ёсны баримтыг шаардсан үед нь хүн бүрт үзүүлэх эрхийг баталгаажуулах ёстой. Энэ зарчмыг хэрэглэхдээ яс үндэс хийгээд бусад ямар нэг үндэслэлээр ялгаварлан гадуурхах ёсгүй³ гэдгийг тайлбарласан байна.

Лондон хот дахь “Арван есдүгээр зүйл” байгууллага (ARTICLE 19) олон улсын хэм хэмжээг тогтоосон “Олон нийтийн мэдэх эрх: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хууль тогтоомжийн зарчим”⁴ боловсруулжээ. НҮБ-ын Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний тусгай илтгэгч эдгээрийг бусад зарчмын адил 2000 онд тавьсан илтгэлдээ дэмжсэн.⁵ Эдгээр зарчмыг дараах байдлаар дүгнэн хэлж болно:

1. *Мэдээлэл аль болох нээлттэй байна:* Хууль тогтоомжид мэдээллийг боломжийн хэрээр, дээд зэргээр нээлттэй болгох тухай заалт оруулах.
2. *Нийтлэх үүрэг:* Төрийн байгууллага нь өөрийн санаачилгаар үндсэн мэдээллээ нийтлэх үүрэгтэй.
3. *Нээлттэй төрд дэмжлэг үзүүлэх:* Төрийн байгууллага нь нээлттэй төрд идэвхтэй дэмжлэг үзүүлнэ.
4. *Хамаарахгүй зүйлийн хүрээг хязгаарлах:* Үл хамаарах зарчмыг явцуу хүрээнд, төрийн “ашиг сонирхол”-д “хохирол” үл учруулах үүднээс тодорхойлох
5. *Мэдээлэл олж авах үйл явцад дэмжлэг үзүүлэх:* Мэдээлэл авах хүсэлт шаардлагыг аль болох шуурхай, шударга биелүүлэх, мэдээлэл олгохоос татгалзсан тохиолдолд энэ шийдвэрийн эсрэг хараат бус байгууллагад хандан давж заалдах эрхээр хангах.

¹ Өөрийн гэсэн үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг дэмжих болон хамгаалах тухай Тусгай илтгэгчийн илтгэл DOC. E/CN.4/1998/40, 1998 оны 1-р сарын 28, параграф 14

² Шийдвэр 1998/42, 1998 оны 4-р сарын 17, параграф 2

³ Зөвлөмж 2002/2, 2002 оны 2-р сарын 21-ний өдөр

⁴ Лондон 1999, 6-р сар

⁵ Өөрийн гэсэн үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг дэмжих болон хамгаалах тухай Тусгай илтгэгчийн илтгэл DOC. E/CN.4/2000/63, 2000 оны 1-р сарын 18, параграф 43

6. *Зардал*: Хувь хүний мэдээлэл хүсэх эрхийг хэт өндөр үнэ тогтоон хязгаарлах ёсгүй.
7. *Нээлттэй хурал*: Төрийн байгууллагын хурал нийтэд нээлттэй байх ёстой.
8. *Мэдээллийг нээлттэй болгох жишиг тогтоох*: Мэдээлэл боломжийн хирээр дээд зэргээр нээлттэй байх зарчимд үл нийцэх хууль тогтоомжийг өөрчлөх.
9. *Шүгэлдэгчийг хамгаалах*: Шүгэлдэгч буюу болж бүтэхгүй зүйлийн талаар мэдээлсэн этгээдийг хамгаалах ёстой.

Дүгнэлт

Иргэддээ мэдээллээр үйлчлэх үүргээ манай төр засаг хөсөрдүүлж байна. Энэ нь Үндсэн хуулийн Оршил хэсэгт тунхагласан Монголын ард түмний эрхэм зорилго, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимтай харшилж байна.

ЭНЭ НЬ ИНЭЭДЭМ ҮҮ, ЭСВЭЛ ЭМГЭНЭЛ ҮҮ?

ЦААШИД ЯАХ ВЭ?

- Эрх зүйн шинэтгэл хийх. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг яаравчлан баталж, Нууцын хууль, бусад хууль тогтоомжийг мэдээллийн эрх чөлөөний олон улсын хэмжээ, үзэл баримтлалд нийцүүлэн өөрчлөх
- Төрийн өндөр албан тушаалтан, албан хаагчийн аливаа мэдээллийг нууцлах, иргэнээс зорилгыг нь шалгаах зэрэг хуучин сэтгэлгээг өөрчлөх
- Төрийн байгууллагын бүтцэд нээлттэй мэдээллийг дэмжсэн өөрчлөлт хийх, мэдээллийн сан, ангиллыг шинэчлэх
- Төрийн байгууллагын төсөвт мэдээллийн үйлчилгээг чанаржуулах хөрөнгө суулгаж өгөх, мэдээллийн үйлчилгээнд зохистой, боломжийн үнэ тариф мөрдөх
- Мэдээллийн үйлчилгээг иргэнд ойртуулах, тэдэнд адил тэгш үйлчлэх, үүний тулд хүнд суртал, чирэгдүүлэлтийг арилгах, шаардлагатай эрх зүйн акт, дүрэм журмыг боловсронгуй болгох

Засгийн газар нь ил тод бус, улс төрийн хариуцлага сул, иргэдийнхээ улс төрийн бүх эрхийг адил тэгш хангаагүй нөхцөлд эдийн засгийн хөгжил тогтвортой байж чадахгүй.

Ухамсрын хөгжлийн Сан, Лондон

ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ ЯВЦЫН ИЛ ТОД БАЙДАЛ

НИЙГМИЙН ДЭВШИЛ ЭМЭГТЭЙҮҮД
ХӨДӨЛГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р. БУРМАА

Хууль тогтоогчдын гол үүрэг болох хууль тогтоох болон төсөв батлах, мөн ард иргэд сонгогчдоо төлөөлж тэрхүү төсөв хэрхэн зөв зарцуулагдаж байгаа эсэх дээр хяналт тавихаас хэтэрч Африк болон Латин Америкийн зарим орнуудад хууль тогтоогч нар нь гэрээ контрактыг хэнтэй байгуулах вэ зэргээр төсвийн хөрөнгийг захиран зарцуулахад өөрсдөө идэвхтэй оролцдог нь эрх үүргээсээ хальж байгаагийн тодорхой жишээ юм. Ийнхүү “хоточ нохой” буюу хяналтын үүргээ төсвийн мөнгө рүү “гараа дүрэх” хулгайчийн үүрэгтэй андуурч мэдэн будилснаар авилгал цэцэглэж олон түмний төр засагтаа итгэх итгэл нь алдардаг” /Авилгалын эсрэг сурвалж бичиг. НҮБХХ/. Манай улс үүний нэг жишээ орон болжээ. Монгол улс 1998 онд Авилгалын индексээрээ 43-р байранд орж байсан бол 2006 онд 99-р байранд орж ухарсан “амжилт”-тай байна.

УИХ-аас 2007 оны төсвийг хэлэлцэн батлахдаа 250 сая төгрөгийг тойргуудад хуваарилж, УИХ-ын гишүүд энэхүү төсвийн хөрөнгийг захиран зарцуулахад идэвхтэй оролцохоор болжээ. Мөн улс төрийн намуудын улсын төсвөөс авч байгаа санхүүжилтийн хэмжээ улам бүр нэмэгдэж, харин эсрэгээр ард түмэн нь ядууралдаа туйлдаж гүйцээд байна. Хууль тогтоох үйл явц ямагт хаалттай, ил тод бус байгаагаас нийтийн биш өөрсдийн болон бүлэглэлийн эрх ашгийг хангасан шийдвэрийг гаргадаг болжээ.

Үүний үр дүнд:

- УИХ нь Засгийн газарт хяналт тавих чиг үүргээсээ урваж, Засгийн газартайгаа холилдсон байна.
- Хуулиас дээгүүр “намуудын зөвшилцөл” гэсэн ойлголт бий болж Үндсэн хуулиа дээдлэх, ардчилал, шударга ёсны зарчим алдагдлаа.
- Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх, төрийг удирдах хэрэгт төлөөллийн байгууллагаараа уламжлан оролцох Үндсэн хуулиар олгогдсон эрхийг УИХ-аас хангахгүй байна.
- Хаалттай хууль тогтоох үйл явцын үрдүнд чанаргүй, амьдралд хэрэгжихгүй хууль гарч байна. /366 хууль хүчин төгөлдөр үйлчилж, 1992 оноос хойш 930 гаруй нэмэлт өөрчлөлт оржээ./

Орчин үеийн парламент хууль тогтоох /төсөв батлах, хянах, ард түмнийг төлөөлөх/ гэсэн гурван гол чиг үүргийн хүрээнд ажиллахдаа төлөөлж буй

иргэддээ мэдээллийн хүртээмж, оролцох боломжийг хангаж, үйл ажиллагаагаа нээлттэй явуулах учиртай. Хууль тогтоох үйл явцыг нээлттэй, ил тод байх үндсэн зарчмуудыг Үндсэн хуульдаа тунхагласан хэдий ч бусад хууль, дэг, журам, бодит үйлдэл дээр энэхүү зарчим алдагджээ.

Угтаа хууль тогтоох байгууллага нь өөрсдийг нь сонгож байгуулсан иргэдтэйгээ хэр зэрэг харилцаатай хамтран ажиллаж байгаагаар ардчиллын гол шинж хэмжигдэнэ. Иргэдийн оролцох боломж нь мэдээлэлтэй байх тухай асуудал, мэдээлэлтэй байснаар мэдлэгтэй болж, иргэдийн оролцоо бодитой, идэвхтэй байх болно. Энэ байдал манай улсад хангалтгүй явж ирснийг хууль тогтоох үйл явцын тодорхой жишээн дээрээс харж болно.

Хууль тогтоох үйл явц нь:

- Хуулийн төсөл боловсруулах
- Хууль санаачлах
- Хуулийн төсөл хэлэлцэх
- Хуулийн төслийг батлах
- Нийтлэх, мэдээлэх зэрэг үе шатнаас бүрддэг байна.

Эдгээр үе шатуудад мэдээллийн хүртээмж, нээлттэй байдал, иргэдийн оролцоо бодит байдал дээр ямар байна вэ?

Хууль тогтоох үйл ажиллагааны тухай мэдээлэл нь батлагдсаны дараа “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлэгдэн гаргахаас өмнөх үе шатуудад тун хүртээмжгүй байна /“Төрийн мэдээлэл” сэтгүүлийн хүртээмжийн асуудал ч хангалттай түвшинд байж чадахгүй байна./.

Үндсэн хуулийн 26.2 дахь хэсэгт иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжлах эрх, 16.17 дахь хэсэгт иргэдийн албан ёсны мэдээлэл хүртэх эрхийг заасан ч Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль болон УИХ-д мөрдөгдөж байгаа практик үйл ажиллагаа, заавраар эдгээр эрх нь ор нэрийн төдий болжээ.

Хуулийн төслийн тухай мэдээллийг иргэдэд хүргэдэг, мэдээлдэг тогтсон механизм, заавал хангахыг шаардсан хэм хэмжээ байхгүй, харин “үзэмжээр” шийддэг хандлага байна. Тухайлбал, дээрх хуулийн 6.1.5 дахь хэсэгт “хуулийн төсөл, түүнийг боловсруулах ажлын явцын талаар шаардлагатай гэж үзвэл олон нийтэд мэдээлнэ”, мөн 19 дүгээр зүйлд: “шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч нь хуулийн төслийг ард нийтээр /нийт ард түмнээр, нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжлийн хүрээнд, тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд/ хэлэлцүүлэх тухай саналаа УИХ-д оруулж болно, энэхүү саналыг УИХ-ын гишүүний гуравны хоёрын саналаар шийднэ” гэсэн байна. Энэ өндөр босго нь хуулийг нийтээр хэлэлцүүлэх боломжийг бараг бүхэлд нь хааж байна.

Хуулийн төслийн талаар саналаа илэрхийлэх арга замуудад:

- УИХ-ын гишүүд болон УИХ-д хандан захидал бичих
- УИХ-ын иргэдийг хүлээн авах байраар дамжуулах
- УИХ-ын үйл ажиллагааг сурталчлах төвүүдэд хандан саналаа өгөх

- УИХ-ын вэб хуудас руу орж саналаа өгөх
- УИХ-ын гишүүний биет төлөөлөгчөөр дамжуулж саналаа өгөх хэлбэрүүд байдаг талаар УИХ-ын танилцуулгад байна.

Гэтэл саналаа өгөх гээд байгаа,

- Хуулийн төсөл, түүний хэлэлцэгдэж буй явц
- Хэзээ, хэдийд, яаж хэлэлцэх талаар мэдээлэл, цаг хугацаа
- Байнгын хорооны хуралдааны болон чуулганы эхний болон эцсийн хэлэлцүүлгүүдийн хуваарь, хэзээ болох, хоорондын зай нь саналаа өгөх боломж
- Хуулийн төсөлд орсон өөрчлөлтүүдийн талаарх мэдээллүүд нь олдохгүй, хууль тогтоох үйл ажиллагаа нь хаалттай байгаа тул яаж саналаа өгөх вэ дээ?

Бусад орны туршлагаас:

Хуулийн төсөл болон явцын талаарх мэдээллийн ил тод байдал, хүртээмжийн асуудал

Америкчууд 7 хоног тутмын ажлын 5 өдөр хэвлэгдэн гардаг Федерал Режистр сониноор дамжуулан батлахаар төлөвлөж буй хууль дүрмийн төсөлтэй танилцдаг. Хуулинд заасны дагуу хүссэн хүн бүхэн уг асуудлын талаар саналаа чөлөөтэй илэрхийлж, бичгээр, и-мэйлээр болон өөрийн биеэр авчирч өгч болдог. Хэвлэснээс хойш 30-90 хоногийн хугацаанд саналаа өгөх боломжийг олгох ба хэрхэн саналаа өгөх талаар дэлгэрэнгүй заавар өгсөн байна. Санал авах хугацаа дууссаны дараа тухайн ард иргэдээс авсан саналууд, түүнийг шийдвэрт хэрхэн тусгасан талаар дээрх сониноор эргэж мэдээлдэг байна. Сонины дугаар бүрийг олж авах боломж нээлттэй бөгөөд сонины хуулбарыг нийтийн номын сан болон коллеж, түүнчлэн интернэтээс олж үзэж болдог байна.

Оролцооны эрхийн асуудал

Иргэд төр засагтаа сонгуулийн өдрөөр хязгаарлагдахгүйгээр байнга нөлөөлөх боломжийг хангах үүднээс холбооны хууль тогтоомжоор зохицуулдаг. Үүний нэг нь “Sunshine” акт буюу “нар гийх” акт юм. Энэ акт нь Америкийн бүх муж, улсуудад үйлчилдэг бөгөөд төр засгийн аливаа хурал, чуулганы тухай урьдчилан мэдэгдэж, олон нийтийг нээлттэйгээр мэдээлэл авах, өөрийн саналаа хэлэх, илэрхийлэх, уулзалтад биечлэн оролцох боломжийг хангадаг байна.

Хууль тогтоох үйл ажиллагааг ил тод болгох нь төрийн өөрийнх нь үүрэг болохоос иргэд, олон улсын байгууллага, иргэний нийгэмд хариуцуулахаа болих хэрэгтэй. Өнөөдрийг хүртэл хууль тогтоох үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах гэсэн санаачлагууд нь төрөөс биш харин олон улсын болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн зүгээс эхлэлтэй байлаа. Тухайлбал, УИХ-ын чуулганы хуралдааны тэмдэглэлийг 1996-2000 онд Азийн сангийн санхүүжилтээр нийтийн номын сангуудад тарааж байснаа санхүүжилт нь зогссоноор энэ үйл

ажиллагаа зогссон. Алдаг оног хуулийн төсөл, үйл ажиллагааныхаа зарим мэдээллийг тавьдаг УИХ-ын вэб сайт нь Соросын сангийн, Нээлттэй засаг вэб сайт нь АНУ-ын ОУХА-ийн, УИХ-ын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах төвүүд нь НҮБХХ-ийн санхүүжилтээр хийгдэж байна. Эдгээр санхүүжилт зогсохоор үйл ажиллагаа нь дагаад зогсох вий дээ. Төр дээрх үүргээ өөртөө авч, хариуцах эзэнтэй, хэрэгжих механизмтай, хөрөнгө төсөвтэй болгож хууль тогтоох үйл явцын нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллахыг иргэний нийгмийн бид шаардах цаг нэгэнт болжээ.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

С.Ганбаатар /“Үндэсний Соёмбо” хөдөлгөөн/:

Ерөнхий ярьж болно оо. Жаахан детальчлах сонирхол байна. Төрийн мэдээллийг ил тод байлгахын тулд иргэд долоо хоног бүр, сар бүр ийм асуултыг баг, сум, дүүрэг, аймгийн захиргаанаас асуух талаар зааварчилгаа гаргаж өгөх нь зөв болов уу. Тэгэхгүй бол бид яаж газардахаа мэдэхгүй байна. Жишээ нь, хороон даргаасаа энэ жил хэдэн шуудай нүүрс ирсэн бэ, хэн хэн гэдэг айлд олгосон бэ, энэ айлууд нь үнэхээр ядуу айл мөн үү, эсвэл, танай хамаатан уу гэдэг энгийн асуултыг асуух нь ил тод байдал юм.

Эцсийн эцэст төрийн ил тод байдал бол бидний нэрээр олсон төсвийг хянах шүү дээ. Тэгэхээр хотын дарга Батбаяр Ланд Круйзер машиндаа долоо хоногт хэдэн литр бензин хийж байна, үнэхээр Ланд Круйзер унах шаардлагатай юу гэж асуух детальчилсан зааврыг өгөх хэрэгтэй гэж бодож байна. Өөрөөр хэлбэл, Та эрхээ мэдэх үү гэсэн товхимлууд тараамаар байгаа юм. Жилийн өмнөөс манайхан хөөцөлдөөд л явж байгаа. Үүнийг анхаарч хамтран ажиллах юмсан. Хэрвээ дүгнэлт гэж байгаа бол түүндээ тусгах хэрэгтэй болов уу.

Том дарга нараасаа бид мэдээлэл авах гэхээр мэдээллээ хав дарж нуучихаад зовоогоод байх юм. Нөгөө талаас нь хандаж хэлэхэд та нар минь мэдээллийг ил тодоор биднээсээ авдаг байгаасай гэж бодох юм. Кейнсийн онолоор хэдэн элитүүд дээш гараад ард иргэдийг хаашаа явбал сайхан амьдрахыг заадаг тэр үе чинь өнгөрсөн. Дээр буй хүмүүс нь доор байгаа хүмүүсээ анхаарна гэдэг үеэ өнгөрөөж, харин доор буй хүмүүс тэднийг хэрхэн анхаарахыг дээдчүүлдээ хэлэх ажил бий болоод байна. Ялангуяа Тавантолгой, Оюутолгойн ордын асуудал дээр.

Энхбаяр ерөнхийлөгч Тавантолгойн ордыг Оросуудад өгөхөөр явчихлаа гэж хардах л ажил одоо бидэнд үлдсэн. Чадах юм нь хардах. Явсаар гүжирдэх болж хувирдаг.

Үндэсний болон дэлхийн хэмжээний бие даасан техникийн экспертүүдийг авчирч зөвлөмж гаргуулаач гэж зөндөө гуйлаа. Гэтэл улстөрчид нь мэргэжилтнүүдийнхээ өмнүүр орж шийдвэр гаргадаг жишиг тогтоочихсон. 68 хувь, 34 хувь нь яаж гарч ирсэн юм гэдгийг хэн ч тайлбарладаггүй. Улстөржөөд л хийчихсэн. Сумогийн 68-р аварга учраас л ингэж тогтсон болов уу гэж би ойлгоод байгаа. Тийм зөвлөмжөө духан дээрээ бариад явбал Орос, Хятадын янз бүрийн шахалтаас хамгаалах арга, аврах боломж шүү дээ. Манай Ерөнхийлөгч, Ерөнхий сайд Орос руу яваад л алга болчихдог. Тал талаасаа хэлэлцвэл буруугүй гэж бодож байна. Ийм форумыг байнга зохион байгуулж байгаасай.

Б.Батхүү /Нийгмийн хөгжил төвийн зөвлөх/:

Хууль их ерөнхий байна. Процедурын шинжтэй заалтуудыг нэмж өгөх хэрэгтэй байна. Жишээ нь, Авилгалын тухай хуулиар төсвийн байгууллага ил тод байдлыг хангана гэж заасан байгаа. Гэтэл яаж хангах юм, хэзээ хангах юм, хэн хангах юм гэдэг нь мэдэгдэхгүй. Харин иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил хоёрыг сайн заагаад өгчихсөн байгаа. Үйл ажиллагааны ёс зүйн дүрмийг гаргаж санхүүгийн тайлангаа тавьж бай гээд. Тэгэхээр авилгалын асуудлыг хариуцсан байгууллага нь иргэний нийгмийн байгууллагуудын ил тод байдлын болон санхүүгийн тайланг нь хянаад явчих вий.

Сүүлийн үед бид авилгал гэж ерөнхийд нь яриад байгаа. Төрд ажиллаж буй хүмүүсээ зөв ойлгуулж, хэн нь авилгал авч, хэн нь авахгүй байгааг нь ялгаж өгөхгүй бол байгаль орчин, газрын алба, эрүүл мэнд, боловсролын байгууллага чинь авилгал авдаг гэж яриад байхлаар төрд ажилладаг хүмүүс эмзэглээд байдаг болчихлоо шүү дээ.

Авилгалын тухай хуульд албан тушаалтан хэн нэгэнд, хувьдаа буюу ашиг сонирхолдоо давуу байдлыг олговол гэсэн заалт байгаа. Гэтэл иргэн шоколад аваачиж өгсөн нь авилгал мөн үү гэхээр хуулиараа үгүй болчихно. Тийм учраас энэ ойлголтуудаа зөв тайлбарлаж ярих хэрэгтэй юм.

Манай хуулиуд сүүлийн үед олон улсын байгууллагын санхүүжилт, тэдний эрмэлзлэлээр гардаг болоод байна. 2002 оноос хойших хуулийг та нар судлаад үзээрэй. Бүх хуулийн ард олон улсын байгууллагын ашиг сонирхол, төсөл явж байгаа. Үндэсний эрх ашгийн тухай ярьж байгаа бол үүнийгээ засах хэрэгтэй. Энэ бүхнийг засахгүй бол арван жилийн дараа ч үүнийгээ яриад сууж байна шүү.

Ч.Тамир /МУИС-ийн Социологийн тэнхимийн багш/:

Хуульд процедурын шинжтэй нарийн зохицуулалтуудыг зааж өгөх хэрэгтэй гэдэг нь харагдаж байгаа. Тэгэхгүйгээр ерөнхийлөөд орхичихоор нарийн асуудал нь орохгүй байгаа юм. Бид үндэслэлтэй гэж үзвэл, шаардлагатай гэж үзвэл, нийгмийн эрх ашиг хөндөгдсөн тохиолдолд гэх мэтчилэн найман үг олсон л доо. Ийм тохиолдолд иргэдээс санал авна, эсвэл, мэдээлнэ гэдэг ч юм уу. Гэсэн ч үнэн хэрэгтээ хэрэгждэггүй. Үүнийг хэрэгжүүлж буй байгууллага нь хэрэгжүүлэх сонирхол байдаггүй.

Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах тухай хуулийг өөрчлөх цаг нь болжээ. Энэ хуулийг хүмүүс бараг ярьдаггүй. Гэвч олон зүйлийг зохицуулж байдаг. Хүмүүс өргөдлөө аваачиж өгөхөд хугацаа энэ тэр гээд олон өөрчлөлтийг хийх хэрэгтэй байгаа юм.

Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль бол үлдсэн мэдээллийн эрх чөлөөний хууль болсон. Яагаад гэвэл өмнө нь Нууцын тухай гурван хуулиа баталсан. Ер нь зэрэгцүүлж явах нь зөв ч байж магадгүй. Гэхдээ Мэдээллийн эрх чөлөөний хуульд юугаа үлдээж, нууцын хуульдаа юугаа үлдээх вэ гэдэг нь зарчмын маш том асуудал болж тавигдах ёстой. Энэ ажилд иргэний нийгмийн байгууллагууд идэвхтэй

оролцох хэрэгтэй. Дэлхийн бусад оронд байдаг нууцлах шалгуур, хугацаа зэргийг харж байгаад дахин боловсруулах шаардлагатай юм.

Иргэд УИХ-д хүсэлтээ их тавьдаг ч энэ нь ихэвчлэн хувийн шинжтэй байдаг. Гэвч үүнийг ямар аргумент болгож тавьдаг вэ гэвэл иргэд мэдээлэл авахыг хүсдэггүй, эсвэл, иргэд хуулиа огт мэдэхгүй байна гэж хэлдэг. Төр ил тод болоод эхэлбэл хувийн хүсэлтээс нь илүү иргэдийн ажил хэрэгч санал тавигдах байх аа.

Манай гол гол хууль дээр олон улсын байгууллагууд санаачилгатай ажиллан санхүүжүүлж байгаа. Төрөөс санаачилга гаргадаггүй. Мөнгөгүй юм уу гэхээр үгүй юм шиг. Яагаад гэдгийг нь мэдэхгүй.

Д.Мижиддорж /31-р сургуулийн ахмад багш/:

Төрийн дээд болоод дунд шатны үйлчилгээний байгууллагуудын удирдах хүмүүсийг сонгон шалгаруулах, томилох үйл ажиллагаа үндсэндээ алдагдаад байна. Энэ талаар дээд, дунд шатанд нэг нэг жишээ хэлье.

Ерөнхий сайд Энхболд хотын дарга байхдаа газрын авилгалын сүлжээг бий болгосон, газрын луйварчин гэж нэрд гарсан хүн. Түүнийг би ямар ч нэр хүндгүй хүн гэж боддог. Намын дарга болон Ерөнхий сайд болсон үйл ажиллагаанууд дандаа ёс бусаар явсныг олон нийт ойлгож байгаа. Үүний цаана МАХН-ын нэр төр унаж, төр хямралд орсон гэж хэлж болно.

Арван жилийн 31-р дунд сургуулийн захирлыг сонгон шалгаруулах үйл ажиллагаа маш болхи явагдсан. Учир нь Энхболд сайд эрүүгийн хэрэг үйлдэж Ганц худагт гурван сар мөрдөгдөж явсан, 1-р сургуулийн нэг ангийн төгсөгч нөхрөө томилсон. Үүнээс юу болов оо. Тэр нөхөр 31-р сургуулийн биеийн тамирын талбай дээр газрын зөвшөөрөл олгож, сургуулийн мөнгийг нь баахан идэж, архидан согтуурч байгаад л яваад өгсөн. Үүний хор уршгаар манай сурууль Нийслэлийн хамгийн муу сургууль болсон. Тэгэхээр сургуулийн захирлын сонгон шалгаруулалтыг нарийн явуулж, хамт олны дунд мөрийн хөтөлбөрийг нь танилцуулж нэлээн нухацтай хандахгүй бол болохгүй байна.

Д.Ламжав /Иргэн/:

Бид Орос, Хятад хоёртой жишиж өөрсдийгөө ардчилалтай байна гэж ярьдгаа болимоор байна. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа бол ардчиллыг хэр зэрэг хөгжүүлж байгаагаас ихээхэн хамаарна. Тийм учраас бодлогоо ийм байдлаар тавих ёстой. Өнөөдөр нэг их шүүмжлэхийг би хүсэхгүй байна. “Зууны мэдээ” сонинд Лүндээжанцан даргыг Оросын “Единая партия” намын хурал дээр УИХ-ыг төлөөлж үг хэллээ гэж гарсан байна лээ. Ийм байж болохгүй ээ.

Авилгалыг гэмт хэрэг гэж Олон улсын конвенцид заасан байгаа. Тэгээд олон төрлийг нь заасан байна. Гэтэл манай хуулийн системд эрүүгийн хэргийг л гэмт хэрэгт тооцдог юм байна. Харин гэм хорын байдалтай уялдуулан захиргааны, эрүүгийн болон иргэний хэргүүдийг ойлгож конвенцид оруулсан байгаа юм. Тэгэхээр одоо өөрчлөх гэж байгаа хуулиуд дээрээ үүнийг анхаарах хэрэгтэй байна.

Хууль хэлэлцэх үеэр зөндөө санал хэлмээр санагддаг. Авилгалын тухай хууль хэлэлцэхэд арга ядаад бүх гишүүдийг арав арваар хаягийг нь оруулж атачмент хийж явуулсан. Яагаад гэвэл тэдэнд хандах өөр арга байхгүй. Ерөнхий лоозон бол байгаа. Их жагсаж цонхыг нь хагалбал сонсдог. Цонх хагалахгүй тайван байдлаар орж цаг хугацаатай байхаар нэг журам гаргах хэрэгтэй байна. УИХ-д тийм журам алга.

Хууль бүтээд гарч байна. Гэхдээ энэ хуулиуд нь иргэн рүүгээ чиглээгүй. Хуулийн дээд талд нь он, сар байгаа. Яасан он, сар юм мэдэхгүй. Тэгээд хууль дотроо түүхээ биччихдэг. Нэг заалтын дор нь энэ хууль төдийд өөрчлөгдсөн гэж. Энэ бол биш юм гэж эрүүл санаатай хүн ойлгохоор байгаа юм. УИХ-ын ТГ-ын ажилтнууд өөрчилчихөөд байгаа нь энэ гэж ойлгодог юм уу даа. Уг нь хуулийн дээд талд жижигхэн хүснэгт байх ёстой. Хэдийд баталсан, хэдийд ёсчилсон, хэдийд өөрчлөлт орсон, одоо хүчинтэй байгаа юу гэдгээ үүнд хийх хэрэгтэй байна. Ер нь УИХ-ын шийдвэрийн журмын тухай хуулийг өөрчилж энэ мэтийг хиймээр байгаа юм. Хуулийг судлах бол маш хэцүү. Одоо үед интернэтгүйгээр энэ үйлчилгээг хүргэхэд хүч хүрэхгүй дээ.

Сөөч буюу хайлт гэж ярьдаг. Интернэтийн хайлтын тусламжтайгаар маш чухал мэдээллийг дор нь олох бололцоотой шүү дээ. Гэтэл манай хууль бичиж байгаа хүмүүс нь бичиг үсгийн алдаа гаргачихдаг. Түүнээс болж хайлт хийх нь ач холбогдолгүй болдог. Дугаар, цэг тавьж араас нь залгуулаад бичихэд профиль авдаггүй. Тэгээд нэг хайлт хийхэд өөр үг гээд орхиод явчихна, гэх мэтээр энэ ажлаа хийгээч ээ. Би та нарт тусалмаар байна.

Д.Лүндээжанцан /УИХ-ын дэд дарга/:

Ламжав багш вэб сайтын талаар их тулж ярьж байна. УИХ-ын вэб сайтыг шинэчилж сайн болгох хэрэгтэй гэж. Үндсэн хуулийн 15 жилийн ой ч болох гэж байна. Та ойрын хугацаанд хүрээд ирмээр байна. Тэгээд нэг уулзаадахъя.

Намын хурал дээр үг хэлсэн юм биш шүү. 19 намын төлөөлөгч, 17 байнгын хорооны дарга, парламентын бүлгийнхэн оролцож “Парламентад суудалтай намууд парламент дотроо ямар үүрэг гүйцэтгэх ёстой юм бэ” гэсэн дугуй ширээний ярилцлага болж түүн дээр үг хэлсэн юм. Хэвлэл мэдээллийнхэн ер нь жаахан холиож бичиж байгаа шүү. Гуйвуулах маягаар. Тэдэнд мэдлэг дутаад байна аа. Байнгын хороо хоорондоо үзэлцсэн юман дээр өдөр жаахан сууж байгаад оройхон болохоор бүгд пархийгээд гараад явчихдаг. Хэвлэлийнхэн одоо баймаар байна гэхэд л алга болчихдог явдал бий шүү. Хэвлэл мэдээллийнхэн байвал үүнийг анхааруулмаар байна.

Б.Чимэд /ХЗДС-ийн Төр захиргааны тэнхимийн эрхлэгч, Гавьяат хуульч/:

Даргын ширээнээс яривал арай сүртэй байж магадгүй. Сайхан илтгэлүүд тавигдаж байна. Хамгийн гол нь өнгөрсөн борооны хойноос ямар цув нөмрөх чухал биш. Ил тод байдал гэдэг бол шийдвэрийн өмнө байх ёстой юм. Энэ манайд байхгүй. Тэгээд бүх юм өнгөрсөн хойно нь баахан идсэн уусан, урвасан шарвасан, тэнэглэсэн мангарласан гээд яваад өгдөг.

Ордны өмнө сайхан багана, хөшөө босчээ. Анх 7 тэрбум төгрөг гээд ярьж байсан. Дундуур нь нэмэгдээд байна гэлээ. 14 боллоо гэсэн. Одоо хэд болсныг нь би мэдэхгүй. Хэн барьж байгаа нь мэдэгддэггүй. Арвин гишүүний компани байгаа гэсэн. Тэгснээ үгүй ээ, тэр чинь өөр компани гэсэн. Тодорхой газар дээр барьж байгаа барилга нь хаанахын төсвөөр, хэн барьж байгаа нь хашаан дээрээ бичээстэй байх ёстой шүү дээ. Гэнэтхэн л барилга босоод ирдэг. Сүүлд нь бөөн хэрүүл болдог.

Би яагаад үүнийг ярьж байна гэвэл 2000 онд сонгогдсон парламент Үндсэн хуулийн нэмэлтийг гэв гэнэтхэн хийсэн. Уг нь хуулийн хоёр гурван хэлэлцүүлэг явагдах ёстой юм. Энэ нь хоорондоо хоёроос гурван долоо хоногийн хугацаатай байх ёстой юм. Гэтэл УИХ-ын гишүүдээр урьд шөнө нь гарын үсэг зуруулаад Үндсэн хуулийн хэлэлцүүлгийг үдээс өмнө хэлэлцэн нэгдүгээр хэлэлцүүлэг дуусгачихаад, өдөр хоолоо идэж орж ирчихээд хоёрдугаар хэлэлцүүлгийг хийчихэж байгаа юм. УИХ-ын гишүүн бодвол нэг, хоёрдугаар хоол иддэг байх л даа. Хоёр таваг шөлний хооронд хоёр сая хүн танилцаж мэдээд саналаа өгнө гэж байхгүй. Ийм л юм хийгээд байгаа юм.

Одоо ч гэсэн манай Лүндээ даргалаад Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлгийг өөрчилнө гэж яриад байгаа юм. Би айгаад унтаж чадахгүй байна л даа. Хэзээ л өөрчлөөд гараад ирдэг бол гээд. Тэрэн дотор юу байгаа нь мэдэгдэхгүй байна. Сураг сонсвол багийн хурлыг үгүй болгох санаа байх шиг. Ингэхэд Монголд ядуу, доод хүмүүс үгээ хэлэх газаргүй болох нь ээ. Бүх оронд коммун гэж өөрсдийнхөө эрх ашгийг шийддэг газрууд байгаа.

УИХ-ын удаа дараагийн дарга нар Үндсэн хуулийг өөрчлөхгүйгээр, уншихгүйгээр дарга хийгээд дуусч байгааг нь хараад би гайхдаг. Төмөр-Очир дарга Архангай аймагт явж байхад нэг өвгөн ярьж байна. Багийн даргыг сонгох нь буруу байна гэж. Гэтэл “Харин тийм ээ, Үндсэн хуульд ингэж заасан учраас яая гэхэв” гэж хэлж байгаа юм. Сая УИХ-ын дарга “Багийн даргыг сонгодгоо больё, томилдог болгоё” гэж байна. Үндсэн хуульд томилно гэж заасан байгаа юм. Хуулиа уншихгүй 8-10 жил парламентын гишүүн гээд яваад байдагт ямар учир байна.

Бүх юм дуулианаар явдаг. Сая хэн хэлэв. 7-8 үг олсон гэж. Ерөөсөө сайжруулна, мундаг болгоно л гэж ярьж байгаа болохоос, яах гэж байгаа нь мэдэгдэхгүй хууль их гарч байгаа. Хуульчид хууль боловсруулахаа байчихаж.

Манай Төсвийн хууль бол Монгол улсыг дампууруулж байгаа хууль. Түүн дотор техникийн хэрэгтэй заалтууд бий. Харин хууль зүйн ач холбогдолтой заалт бараг байхгүй. Үүнийг хэн мэдэж байгаа юм бэ. Манай УИХ-д шинжлэх ухааны доктор Лүндээгээс авахуулаад хуульчид байгаад байдаг. Тэнд хуульчид улсын менежер хийж байна уу, эсвэл тэнд суучихаад хувийн менежерээ хийгээд байна уу. Эд ямар хууль боловсруулж юуг шийдээд байгаа юм. Миний ганц нэг шавь нар бий л дээ. Багш болохоор хамаагүй хэлж байна. Нэр төрийг нь гутаах гэсэн юм байхгүй. Тийм учраас шийдвэр гарсан хойно нь хашгирах биш, гарахаас нь өмнө мэдэж байж, гараад дууссаны дараа анх ямар байсан, сүүлдээ ямар болов гэдэг дээр ил тод байх ёстой.

Наранжаргал, Бурмаа нарын илтгэл анх ямар гарсан, сүүлдээ яаж засагдсан тухай ярьж байна. Нууц гэж байна, очоод үзэхээр юу нууц болох нь мэдэгддэггүй нууц байдаг гэлээ. Нууц мэдэгдэхгүй байна гэдэг бол хортой л доо. Хүүхдүүд том хүний дор нь юу байгааг харах гэж шохоорхоод байдаг шүү дээ. Тэгээд том болж өөрийнхийгөө үзээд тайвширдаг юм шиг байгаа юм. Ингэж олон жил гацаах хэрэггүй. Хийх гэж байгаа юмыг нь ил хэлчихдэг, цуг усанд орчихдог байх хэрэгтэй гэж европынхон яриад байгаа шүү дээ.

Лүндээ сая нэг айхтар үг хэлээд орхилоо. Сүүлийн үед төрийн хүчийг сулруулах аятай юм яриад байна гэж. Энэ жагсаал цуглааныг хэлээд байна уу. Би саяхан “Өнөөгийн улс төрийг хуульчийн нүдээр харах нь” гэж ном бичсэн. УИХ, Засгийн газар, төрийн албыг аминдаа жаахан гүвж өгсөн юм. Тэрийг хэлээд байгаа юм уу. Далдуур ярьж байснаас ил хэлсэн нь дээр. Тэрийг чинь шударга ёс гэдэг юм. Тийм учраас ил тод байдал гэдгийг өнгөрсөн борооны хойноос биш, ирж буй бороо, бороо арилад юу болов гэдэг хоёрын үүднээс хуульчилж, хуралдаж хэлэлцэх хэрэгтэй.

Нэгэнт ам ангайсан дээр хэлэхэд Үндсэн хуулиа гэнэт өөрчилчихөв өө. Ер нь чимээгүй байж байгаад л хусаад хаяна шүү. Тэгээд л өнгөрнө. Тийм төсөл хийх гэж байгаа бол шууд ардчиллын эсрэг эргэлт хийх гэж байна гэж хэлнэ. Иргэдийн нийтийн хурал гэсэн Үндсэн хуулийн байгууллагыг үгүй болгоно гэдэг мөн ч том толгой. Архивт тусаагүй бол агуу их том толгой юм байна. Ийм юм хийж сууна гэдэг юу гэсэн үг вэ? Иргэд, ядуучууд хаана үгээ хэлдэг юм бэ гэвэл багийн хурал дээр хэлдэг юм. Элитүүд Их хурал дээр хэлдэг юм. Тэгэхээр элитүүд нь энгийн иргэдийнхээ амыг боох гэж суух хэрэггүй гэж хэлэхэд хатуудахгүй байх. Улс төрийн агсам тавьсанд уучлаарай.

Д.Алтай /МАСЭХ-ны тэргүүн/:

Төрийн ил тод байдлын асуудлыг иргэд, сонгогчдынхоо боловсролын түвшинтэй холбож ойлгох нь зүйтэй болов уу гэж бодож байна. Би өнгөрсөн парламентад сууж байхдаа парламентын ил тод байдал, ардчилсан парламентыг бэхжүүлэх чиглэлийн төсөл дээр идэвхтэй ажиллаж байсан.

Гадны орны туршлагаас үзвэл, жишээ нь, Австралийн парламентын гишүүнээс газрын асуудлын ил тод байдлыг яаж хангаж, яаж мэдээллээ олж авдаг талаар сонирхож байлаа. Австралид манай интернэт кафе шиг иргэдэд мэдээллээр үйлчилдэг тусгай төвүүд ажилладаг юм байна. Тэнд газрын тухай бүх мэдээлэл нь цахим сүлжээнд орчихсон байдаг: Тодорхой нэгэн газрын тухай мэдээлэл авахын тулд зохих төлбөр өгнө. Жишээ нь, Баянзүрх дүүргийн нэг хорооны нутаг дэвсгэр дээрх тухайн газрыг хэдэн оноос анх хэн эзэмшиж байсан, дараа нь хэнд худалдсан, хэнд түрээсэлсэн гэх зэргээр бүх мэдээллийг авах боломжтой.

Ийм болохын тулд цахим мэдээллийн төвүүдийг бий болгож, түүндээ бүх юмаа байршуулах нь мэдээж. Нөгөө талаас үүнийг зөвөөр ашиглах талаар иргэдийг гэгээрүүлэх ажлыг ТББ-ууд хиймээр байгаа юм. Учир нь иргэд хуулиа сайн мэдэхгүй, мэдээллээр дутагдсанаас болоод янз бүрийн сөрөг үр дагавар бий болж байна.

Олон байгууллага төслийн шугамаар ажил эхлүүлчихээд орхидог. Энэ нь монголчуудын сэтгэлгээ, ухамсартай холбоотой байх л даа. Гэтэл гадны хүмүүс маш няхуур хандаж, үр дүнг нь тооцож ажил эхлүүлдэг. Тэгэхээр энэ эхлэлээ цааш нь үргэлжлүүлж, нийгэмд нааштай үр дүн бий болгох талаар анхаармаар санагддаг.

Судлаач хүний хувьд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах гэдэгтэй санал нэг байдаг. 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш 15 жил болох гэж байна. Гадны орнуудын судалгаа болон модернацийн онолоор авч үзвэл шилжилтийн хугацаа нь 15-16 жил байдаг. Өнөөдөр бид яг ийм үедээ тулж ирсэн байгаа юм.

Бид өөрсдийгөө ч, гадныхан манайхыг ч магтдаг шүү дээ. Төв Азидаа улс төрийн болоод эдийн засгийн шинэчлэлийг хамтад нь хэрэгжүүлсэн үлгэр жишээтэй орон гэж. Гэтэл Үндсэн хууль болон бусад хуулийг дагаад иргэний нийгмийн хөгжил төлөвшил ямар түвшинд хүрч, цаашид ямар өөрчлөлт хийгдэх вэ гэдэг нь асуулт болоод байна. Үүний илрэл болж иргэний хөдөлгөөн, хуралдай гээд олон зүйл гарч ирж байгаа юм. Би хуулийн дагуу л үүнийг хийх ёстой гэж боддог.

Өнөөдөр манай улс олон намын төлөөлөлтэй парламенттай байгаа. Бид төлөөллийн ардчиллыг парламентаас хүсч хүлээдэг. Тийм болохоор улстөрийн намуудын ардчилал, улстөрийн намуудын удирдагчдын хүсэл зориг их чухал байгаа юм. Тэгж байж улстөрийн намууд зөв юман дээрээ зөвшилцөж 2008 он болтол шийдвэрээ гаргах хэрэгтэй байна.

Улстөрийн намууд Үндсэн хуульд оруулсан өмнөх нэмэлт, өөрчлөлтийн юу нь болж, юу нь болохгүй байгаа, одоо ямар чиглэлийн өөрчлөлтийг хийх вэ гэдгийг ил тодоор хоорондоо ярилцан зөвшилцөж олон нийтэд ил тод болгон саналаа авах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, өнөөдөр улс төрийн намуудын ардчилал, тэдний удирдагчдын хүсэл эрмэлзлээс бүх зүйл хамаарах болоод байна.

Энхтөр /“Тосон Заамар” хөдөлгөөн/:

Ардчилсан нийгэмд шилжээд бид даруй 16 жилийг өнгөрөөжээ. Үүний үр дүн гэвэл намуудын үзэл бодолд ард иргэдийг талцан хувааснаас өөр зүйл харагдахгүй байна. Бүр үүнийгээ улам бэхжүүлэх зорилгоор төрийн байгууллагын албан тушаалтнуудыг бүх шатанд намын харьяаллаар сонгож байгаа. Мөн орон нутгийн ИТХ-ын суудал бүгд намын суудал болж хувирсан. Энэ нь маш илэрхий харагдаж байгаа. Бүр эмгэнэлтэй төстэй байдалд очоод байна.

Хууль дүрэм гараад байна. Иргэн лүүгээ чиглэхгүй байгаа учраас иргэд өөрсдийн дүрэм журмаа бий болгож байна. Жишээ нь, нинжагийн бүлгийнхэн гээд өөрсдийн амьдралын хэв маягаа бий болгон, дүрэм журмаа зохиогоод явж байгаа. Цаашид бид яах юм бэ. Иргэд рүүгээ хандсан бодлого баримтлахгүйгээр өөрсдийн дүрэм журмаар нь амьдруулаад л байх уу. Монголын чадварлаг хүмүүс бүгдээрээ гадагшаа явж байна. Ийм нийгэмд амьдрахыг хэн ч хүсэхгүй шүү дээ. Энэ талаар төр засгаас бодлогын шинжтэй арга хэмжээ авмаар байна. Иргэний нийгмийн байгууллагууд ч үүнийг анхааралдаа авах хэрэгтэй.

Иргэний нийгмийн байгууллагууд үйл ажиллагаагаа орон нутагт эрчимжүүлэх шаардлагатай байна. Ийм шаардлага нь илэрхий байгаа. Тэгэхээр бүгдээрээ бодлого зорилгоо нэгтгэж орон нутгийн иргэд рүү хандан дуу хоолойгоо хүргэх хэрэгтэй байна.

Төсөл хэрэгжсэний дараа тухайн үйл ажиллагаа орхигддог гэлээ. Энэ бол бодитой асуудал л даа. Иргэний нийгмийн байгууллагууд санхүүгийн бэрхшээлтэй байдаг. Гэвч төр засгийн орхичихсон иргэдийг, тэдэнд дутагдаж буй зүйлийг иргэний нийгмийн байгууллагууд нөхөж байгаа. Тийм учраас 250 сая төгрөгийг хувааж авах биш, иргэн лүүгээ чиглэсэн бодлогод хөрөнгө оруулалт хийвэл яасан юм бэ. Төр бол хувийн компани биш. Уг нь Монголын 2.5 сая хүнийг сайхан амьдруулахад их хэцүү биш шүү дээ. Зөв бодлого, зөв хандлага байвал цөөн ард түмэн эвтэйхэн амьдарч болно гэж бодож байна.

Ц.Монгол /Хаан банкны хуулийн газрын дарга/:

Наранжаргал, Бурмаа нарын илтгэлийг бүрэн дэмжиж байна. Лүндээжанцан даргын тавьсан илтгэлтэй холбогдуулж хоёр зүйл хэлье. Илтгэлийн дүгнэлтэнд иргэд хувийн асуудлаар өргөдөл их бичдэг болсон, түүний тоо нь их олширч байгаа гэлээ. Түүний дүгнэснээр иргэд хууль эрх зүйн мэдлэггүй учраас бичиж байгаа гэнэ. Гэтэл эсрэгээр буюу орон нутгийн төлөөллийн байгууллага нь ажиллахгүй байгаа учраас иргэд УИХ-д хандаж байгаа юм. Бас нууц биш болсон зүйл нь Солонгост гарах иргэдийг УИХ-ын туслахууд бүртгэж байгаатай холбоотой.

250 сая төгрөгийг Төсвийн хууль болон Үндсэн хууль зөрчин хуваарилахад 16 жил УИХ-д суусан хуульчдын нэг нь ч эсрэг санал өгөөгүйд би их харамсаж байна. Та нар ард түмнээсээ их хөндийрчээ. Харьж очоод телевиз үздэггүй гэж байна. Харин хурал хийхээр үг хэлчихээд гараад явчих юм. Лүндээжанцан даргыг энд сууж байгаад баярлаж байна.

Гадаадынхан Монголыг ардчилалтай байна гэж дүгнэдэг тухай томчууд ярих болсон. Үүнээс би их ичдэг. Ингэж ярьж болохгүй ээ. Монголд бодит ардчилал алга. Хэврэг ардчилал ноёрхож байгаа. Хүнд суртал даамжирсан, захиргаад алт, төвлөрөл дээд цэгтээ тулсан. Энэ нь сүйрэлд хүргэдэг. Тийм учраас энэ асуудал дээр эрүүл ухаанаар хандаж дүгнэлт хийх болов уу гэж найдаж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд 100 хувиар хөрөнгө оруулна гэсэн заалт бий. Гэтэл одоо Монголоор нэг гадны 100 хувийн компани дүүрээд байгаа. Энэ бол үндэсний тусгаар тогтнолд аюултай заалт юм.

Ашигт малтмалын тухай хууль бол Үндсэн хуулийг зөрчиж гарсан хууль. Гэтэл манай хуульчид юу ч хэлэхгүй байна. Ашигт малтмалын хуулиар Монголын газар нутгийг худалдаад дуусч байгаа. Тэгээд төрөө дээдэл гэх юм. Төр гэдэг бол хүмүүс, өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд юм. Тийм учраас төрөөр далайлгаж ард түмнийг хуурч, ядуу зүдүү амьдрахад хүргэж байгаадаа дүгнэлт хиймээр байна.

Чимэд багшийн хэлсэн үг маш үнэн. Үндсэн хуульд сумын дарга, багийн даргыг томилно гэж заасан байгаа. Харин томилох гэснийг өөрчилж, доороосоо

сонгох ёстой юм. Ардчилал зөрчигдсөн байгаа. Гэтэл одоо бүр лавшруулж эсрэгээр нь хийх гэж байна. Үүнийг анхаарахгүй бол Монголын ардчилал төгсгөл болно.

Нарантуяа /Ховд аймаг/:

Төрийн ил тод байдал нь боловсон хүчинтэй холбоотой гэж бодож байна. Орон нутагт, ялангуяа сум, багт мэдээллийг иргэдэд хүргэж байгаа боловсон хүчний үйл ажиллагаа ялгавартай байдаг. Хууль эрх зүй болон бодлогын чанартай зүйлээ өөрийн ойлгосон хүрээнд мэдээлж байгаа. Гэхдээ олон нийтэд хэрэгтэй мэдээллийг төрийн ажилтнууд өөрсдөө эхлэн ашиглаж байна. Уг нь төрийн мэдээллийг иргэдэд хүргэж, тэдний ахуй амьдралыг сайжруулах ёстой атал төсөл хөтөлбөр, боловсон хүчинтэй холбоотой мэдээллийг тухайн төрийн ажилтнууд өөрсдөө аваад ах дүүгээ ажилтай болгож, авгай хүүхэддээ төсөл хөтөлбөрийг олгож байна. Энэ нь улмаар төрийн байгууллагын нэр хүндийг унагааж байгаа юм.

Төрийн албаны тухай болон намуудын тухай хуульд тодорхой өөрчлөлт оруулахгүй бол боловсон хүчнүүд намдаа үйлчилж байна. Бүр даргадаа л үйлчилж ажиллаж байна.

Хөдөө орон нутагт Багийн засаг дарга нар төрийн мэдээллийг хамгийн ихээр гуйвуулж, төрийн албаны нэр хүндийг унагаж байгаа. Багт төрийн мэдээллийг аман хэлбэрээр л хүргэж байна. 2-4 цагийн хугацаагаар цахилгаан авч буй иргэд өөр хаанаас мэдээлэл авах юм бэ. Тийм учраас багийн иргэдэд төрийн мэдээллийг хүргэх механизмыг бий болгомоор байна. Өмнө нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ННФ-аас хэд хэдэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байсан. Тэгээд бүх шатны сонгууль болохоор хэрэгжсэн байсан төсөл нь зогсчихдог. Эсвэл буруу замаар орж бизнесийн үйл ажиллагаа болчихдог талтай.

Форумд оролцогчид хамтран ярилцаж, төр болон иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг бодитой хиймээр байна. Ховд аймагт иргэний нийгмийн байгууллага нь төртэйгээ түншилж байгаа гэж ярьж байгаа боловч энэ талаар тодорхой алхам хийгээгүй гэж хэлж болно.

“УЛСЫН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ” САЛБАР ХУРАЛДААН

Хоёрдахь хэсэг буюу “Улсын төсвийн ил тод байдал” салбар хуралдааныг Татвар төлөгчдийн холбооны дарга Ж.Уртнасан даргалан явуулав. Энэ сэдвийн хүрээнд Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Батжаргал “Улсын төсвийн ил тод байдал”, ННФ-ын менежер Н.Дорждарь “Нээлттэй төсөв-Хариуцлагатай төр”, МУИС-ийн Нийгмийн Судалгааны Хүрээлэнгийн захирал Ж.Мөнхбат “Төрийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал” илтгэлүүдийг тавьж, дараа нь хэлэлцүүлэг өрнөлөө.

ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

САНГИЙН ЯАМНЫ ТӨСВИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б. БАТЖАРГАЛ

Нээлттэй Нийгэм Форумаас зохион байгуулж буй “Төрийн ил тод байдал: нийгмийн баялаг хуваарилалт” сэдэвт форумын “Улсын төсвийн ил тод байдал” дэд хуралдаанд үндсэн илтгэл тавьж энэ чиглэлээр хийгдсэн, хийж байгаа болон хийхээр төлөвлөж байгаа ажлаа та бүхэнд танилцуулан хэлэлцүүлж санал солилцох боломж олгосонд СЯ-ны зүгээс Та бүхэнд талархалаа илэрхийлье.

Энэхүү илтгэлийг:

1. Төсвийн ил тод байдал
2. ЗГ-ын тусгай сангуудын ил тод байдал
3. Худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн 3 чиглэлээр бэлтгэлээ.

1. Төсвийн ил тод байдлын талаар

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрт мэдээлэл, харилцаа холбооны технологийг нийгмийн бүх салбарт нэвтрүүлэх талаар олон чухал зорилт хөтөлбөр дэвшүүлсэн. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, холбооны технологийг нэвтрүүлэх, мэдээллийн үйлчилгээгээр дамжуулж иргэдэд нийгмийн харилцаанд идэвхтэй,

эрх тэгш оролцох боломж олгох, иргэд мэдээллийг чөлөөтэй олж авах тогтолцоог бүрдүүлэх зэрэг мэдээлэлжсэн нийгмийг байгуулах асуудал улсын төсвийн ажиллагаанд нэн хамааралтай болно. Яагаад вэ?

ДНБ-ий 3 триллион төгрөгийн 43-тай тэнцэх бараг 1.5 триллион төгрөгийн зардлын хуваарилалт, гүйцэтгэлийн үр дүн төсвөөр явагдаж байна. Гадаадаас жил тутам 70-80 тэрбум төгрөгтэй тэнцэх зээл авч ашиглаж байна. Засгийн газрын өр зээлийн удирдлагыг төсвөөр хэрэгжүүлж байна. Улсын сангуудын менежмент мөн төсөвт шууд хамааралтай. Засгийн газрын 22 сангийн менежмент төсвөөр дамжиж хэрэгжиж байна. Төсвийн Хөрөнгө оруулалт нэмэгдсээр байна. Жил бүр ДНБ-ий 30 гаруй хувьтай тэнцэх татварыг бизнес эрхлэгч, иргэдээс хурааж зарцуулж байна. Үүнтэй уялдуулж “ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ” вэб хуудсыг бий болгох ажлыг Нээлттэй Нийгэм Форумын санхүүгийн дэмжлэгтэйгээр хийж 2006 оны 11-р сараас СЯ-ны Төсвийн бодлого, зохицуулалтын газар ажиллуулж эхлээд байна. Ингэснээр:

1. Иргэдээс төр, засаг руу улсын төсвийн талаар хандах мэдээллийн шинэ урсгалыг бий болгох
2. Улсын төсвийн үйл ажиллагааны ил тод, найдвартай, шуурхай байдлыг хангах, авилгал, хүнд суртлыг арилгах, төр засгийн шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэд, олон нийтэд зориулагдсан мэдээллийн илүү нээлттэй, чөлөөтэй орчинг бүрдүүлнэ гэж үзэж байгаа.

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэн бүр татвар төлөгч байдаг утгаараа иргэд төсвийг боловсруулах, хэлэлцэх, батлах, хянах аль ч түвшинд оролцох эрхээ хэрэгжүүлэхэд энэхүү вэб хуудас онцгой үр дүнтэй ажил болсон гэж үзэж байна. Та бүхэн <http://www.iltod.gov.mn> хаягаар орж үзнэ үү.

Вэб хуудас нь байнгын ажиллагаатай бөгөөд ерөнхий бүтэц нь:

- нүүр хуудас
- танилцуулга
- хууль эрх зүй
- төсөв
- мэдээлэл, судалгаа
- хэлэлцүүлэг
- холбоосууд гэсэн жишиг бүтэцтэй.

Эдгээрээс ТӨСӨВ хэсгээс Таны татварт төлсөн мөнгийг

- хэн, хаана, юунд, хэдий хэмжээний хөрөнгийг хэрхэн зарцуулж байгаа талаарх мэдээллийг Нэгдсэн төсөв, Төсвийн хуваарь хэсгээс,
- хэн, хаана, юунд, хэдий хэмжээний хөрөнгийг зарцуулаад юу хийж бүтээв гэдэг талаарх мэдээллийг ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ хэсгээс

- ЗГ-ын тусгай сангуудын талаарх мэдээллийг авах боломжтой.

Хэрэглэгчийн хэсэгт мэдээллийг энгийн иргэдэд ойлгомжтой, хялбар байхаар зохион байгуулж, батлагдсан төсвийн мэдээллийг хамгийн доод түвшинд хүртэл “мод” бүтцээр задалж харах боломжтойгоор хийсэн байгаа.

Энэхүү вэб хуудас нь Монгол Улсын 2007 оны төсвийг хэлэлцэж буй үед ажиллаж эхэлснээр “МУ-ын 2007 оны төсвийн төсөл”, “МУ-ын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл” үндсэн баримт материалуудыг бүрэн эхээр нь байрлуулж, төсвийн талаарх мэдээллийг олон нийт нээлттэй авах боломжийг бүрдүүлсний зэрэгцээ төсөв хэлэлцэх үед цаашид төсөвт учирч болох дарамт, түүнээс сэрэмжлэх талаар зөвлөхүүд, мэргэжилтний боловсруулсан танилцуулга, саналуудыг мөн нээлттэй байрлуулсан. Ингэснээр улсын төсвийн ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог хангахад зохих алхам болж байна. Тухайлбал, “Монголын эдийн засаг дахь голланд өвчний шинж тэмдэг”, “Нийгмийн даатгалын тогтолцоо ба Тэтгэврийн сангийн тухай”, “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс бий болсон татварын орлогоор сан байгуулах, зарцуулах чиглэлийн тухай”, “Аж үйлдвэржүүлэлтэд Хөгжлийн банкны үүрэг” зэрэг танилцуулгыг дараа оны төсөв хэлэлцэж байгаа цаг үед олон нийтэд мэдээлэл болгохоос гадна энэ чиглэлээр олон нийтийн санал, бодлыг сонсож, хэлэлцүүлэх зорилгоор вэб хуудсанд байрлуулсан.

2. ЗГ-ын тусгай сангуудын ил тод байдлын талаар

Сангийн менежментийн тогтолцоо бол төсвийн тогтолцооны шинэ хандлага мөн. ЗГ цаашид санхүү төсвийн удирдлагын хувьд корпорацийн зарчмаар ажиллах чиглэлтэй болж байна. ТБУСТ хуулийн үзэл санаа ийм байгаа.

Монгол Улсын Засгийн газрын шугамаар гадаадын донор орнууд болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслийн шугамаар орж ирсэн зээл, тусламжийн хөрөнгө болон төсвийн хөрөнгөөр бий болсон сангуудын үйл ажиллагааг хяналттай, нэгдсэн зохицуулалттай болгохын тулд “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийг боловсруулж, 2006 оны 6-р сард УИХ-аар батлуулан хэрэгжүүлж байна. Энэхүү хуулиар:

1. Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийн орлогыг Засгийн газрын тусгай сан гэж тодорхойлсон.
2. Тусгай сангийн орлого, зарлагын тайлан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болж байгаа.
3. Тусгай санг хуулиар байгуулах болсон.

Ийнхүү ЗГ-ын сангийн төрөл, ангилал, эх үүсвэр бүрдэлт, зарцуулалт, тайлагналт, түүнд тавих хяналт, хариуцлагыг хуульчилсан. Энэхүү хуулиас өмнө Нэгдсэн төсвийн тухай хуульд 2 сан /ЗГ-ын нөөц хөрөнгө, Болзошгүй зардлын эрсдэлийн сан/-г байгуулж болох тухай заасан байдаг ба бусад сангуудыг тухай бүр ЗГ-ын тогтоолоор байгуулдаг, удирдлага, зохион байгуулалт, хяналт,

хариуцлагын нэгдсэн тогтолцоогүй байсан бол энэхүү хуулиар нийт 22 төрлийн тусгай сан байхаар хуульчлагдсан ба тэдгээрийг эх үүсвэрийн бүрдэлтээс хамаарч 4 ангилсан байдлаар харуулбал:

1. Тусгай хуулиар зохицуулах санд дараах тусгай сан хамаарна:
 - 1.1. Нийгмийн даатгалын сан;
 - 1.2. Нийгмийн халамжийн сан;
 - 1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;
 - 1.4. Улсын авто замын сан;
2. Эх үүсвэрийг нь 100 хувь төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх санд дараах тусгай сан хамаарна:
 - 2.1. Засгийн газрын нөөц сан;
 - 2.2. Монгол Улсыг хөгжүүлэх сан;
 - 2.3. Эрсдэлийн сан;
3. Эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх санд дараах тусгай сан хамаарна:
 - 3.1. Аялал жуулчлалын сан;
 - 3.2. Байгаль хамгаалах сан;
 - 3.3. Дархлаажуулалтын сан;
 - 3.4. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;
 - 3.5. Соёл, урлагийг хөгжүүлэх сан;
 - 3.6. Сургалтын төрийн сан;
 - 3.7. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан;
 - 3.8. Хүүхдийн төлөө сан;
 - 3.9. Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан;
 - 3.10. Шинжлэх ухаан технологийн сан;
 - 3.11. Эрүүл мэндийг дэмжих сан;
4. Эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг буцалтгүй тусламж, хандиваар бүрдүүлэх санд дараах тусгай сан хамаарна:
 - 4.1. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан;
 - 4.2. Мал хамгаалах сан;
 - 4.3. Тариаланг дэмжих сан;
 - 4.4. Олон улсын гэрээний дагуу байгуулагдсан сан;

4-д заасан тусгай сан үйл ажиллагаагаа өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар явуулна.

Дээрх сангуудын дотроос шинээр байгуулагдсан, сүүлийн үед олны анхаарлын төвд байгаа сан бол Монгол Улсыг хөгжүүлэх сан билээ.

Монгол Улсыг хөгжүүлэх сан нь Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн дагуу улсын төсөвт орох орлогоос бүрдэнэ.

Сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

1. давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн төсвийн орлогын дутагдлыг нөхөх;
2. улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, жижиг, дунд бизнес /аж ахуйн үйл ажиллагаа/-ийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт;
3. хүүхэд, гэр бүлийг дэмжих арга хэмжээ тус бүрт гуравны нэгээр хуваарилна.

Сангуудын тайлан харьяа төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд нэгтгэгдэх болсноор Сангууд ЗГ-ын санхүүгийн нэгдсэн тайланд тусгагдахаар болсон. Энэ тухай ТБУСТ хуульд нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 1-р сарын 27-ны 32 тоот тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж гаргах аргачлал”-д заасан. Эдгээр сангуудын санхүүжилт, зарцуулалт, үйл ажиллагааны чиглэл, үр дүнг олон нийтэд ил тод нээлттэй болгохын тулд энэ талаарх мэдээллийг “Төсвийн ил тод байдал” вэб хуудсанд байрлуулсан.

Тусгай сангийн гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих талаар:

1. Тусгай сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.
2. Тусгай сангийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор өдөр тутмын хэвлэлд нийтэлж нийтэд мэдээлнэ.
3. Засгийн газрын нөөц сан, Эрсдэлийн сан, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн зарцуулалтын тайланг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 37.2-т заасан тайланд тусгаж Засгийн газар болон Улсын Их Хуралд тайлагнана.
4. Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг хэлэлцэж болно.

Төсвийн болон Засгийн газрын тусгай сангийн эх үүсвэр бүрдэлт, хөрөнгө зарцуулалт, үйл ажиллагааны үр дүн зэргийг олон нийтэд улам бүр ойр, ил тод, ойлгомжтой байлгах, ингэснээр олон нийтийн санаа бодлыг авч тусгах, хэрэгжүүлэх чиглэлээр бидэнд цаашид хийх зүйл нэлээд байна. Тухайлбал:

- үр дүнд суурилсан бодит төсөвлөлтийг боловсронгуй болгох
- нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулж Төсвийн ерөнхийлөн захирагчдын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсронгуй болгох

- тусгай сангийн мэдээллийг бүрэн, илүү тодорхой байдлаар вэб хуудсанд байрлуулах нэгдсэн удирдамж гарган хэрэгжүүлэх

Энэ бүхнийг сайжруулан хэвшил болгоход шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг олох талаар бид ажиллаж байна. Та бүхнийг дэмжин ажиллахыг мөн уриалж байна.

3. Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Монгол Улсын Их Хурлаас 2000 онд анх баталж 2005 онд шинэчлэн найруулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хуулиар зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчим болон олон улсын стандартад нийцсэн засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоонд шилжих нөхцөл бүрдэж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад үр ашиг, хэмнэлт, ил тод байдал, шударга өрсөлдөөнийг хангасан эрх зүйн орчин бий болсон билээ.

Улсын хэмжээнд жилд 600 гаруй тэрбум төгрөгийн худалдан авалтыг төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд хэрэгжүүлдэг бөгөөд үүний 30 орчим хувь нь төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 500 гаруй төслүүдэд ногдож байна. Төсвийн хөрөнгөөр санхүүжигдэж буй томоохон төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахад нээлттэй тендер шалгаруулалт явуулах нь засгийн газрын үйл ажиллагааг илүү ил тод, хариуцлагатай болгох нэг чухал процесс болохыг түүнд оролцогч талууд, олон нийт ойлгож суралцсаар байна.

Шинэчлэн найруулсан хуулийн талаар товч мэдээлэл:

1. Өмнөх хуулиар худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгөөс хамааран захиалагчид туслах, гүйцэтгэгч сонгох ажиллагаанд хяналт тавих зорилгоор байгуулагддаг шат шатны тендерийн хороо ажилладаг байсныг өөрчилж, тухайн төсвийг захиран зарцуулж буй байгууллага холбогдох хууль журмын дагуу бие даан худалдан авалтаа зохион байгуулж, үр дагаврыг бүрэн хариуцдаг байхаар зохицуулсан юм. Ингэснээр аливаа төслийн хэрэгжилтэнд төвлөрлийг сааруулж, хэрэгжүүлэгч байгууллагуудын уян хатан, шуурхай ажиллах боломжийг нэмэгдүүлсэн юм.
2. Сангийн яам нь яам дундын тендерийн хороогоор дамжуулж худалдан авах ажиллагаанд оролцох замаар явцын хяналт тавьж байсныг өөрчилж, зөвхөн засгийн газрын тогтоосон томоохон төслийг гэрээ байгуулахын өмнөх шатанд хянаж, ажлын 5 хоногт зөвшөөрөл олгож байх үүрэгтэй болж өөрчлөгдсөн. Энэ нь эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх цөөн тооны өндөр өртөгтэй төслүүд бөгөөд тухайлбал төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төслүүдийн 5 орчим хувь болж байна.
3. Аливаа худалдан авах ажиллагаа хуулийн хүрээнд шударга, зөв явагдаж буй эсэхийг хянах механизм нь олон нийт, тендерт оролцогч хувийн хэвшлийнхний гомдол, хүсэлтээр дамжин хэрэгждэг.

Тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг шүүхийн өмнөх шатанд эхлээд захиалагч байгууллагад, дараа нь гэрээ байгуулагдаагүй бол Сангийн яаманд гаргаж болох бөгөөд хуульд заасны дагуу 14 хоногт багтаан гомдлыг хянан шийдвэрлэж байгаа нь Засгийн газрын үйл ажиллагаанд ил тод байдлыг хангасан нэг чухал механизм юм.

4. Сангийн яамнаас хянан зөвшөөрөл олгосон томоохон тендер шалгаруулалттай холбоотой зөрчил гарсан гэж тендерт оролцогч үзсэн тохиолдолд гомдлыг бие даасан хөндлөнгийн 3 шинжээчдээс бүрдсэн Шинжээчдийн багаар дүгнэлт гаргуулж шийдвэрлүүлэхээр хуульчилсан нь Төсвийн зарцуулалтын ил тод, шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бас нэгэн шинэ механизм юм.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны ил тод байдал, түүнд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлэх зорилготой шинэ өөрчлөлтүүдийн нэг нь тендерийн зар болон үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны тусгай вэб хуудсанд зарладаг журамд шилжлээ. WWW.E-PROCUREMENT.MN хаягтай цахим сүлжээг Сангийн яам эрхлэн ажиллуулж байна. Энэхүү вэб хуудаснаас засгийн газрын байгууллагуудын хэрэгжүүлж буй төслийн тендер шалгаруулалтын талаарх мэдээллийг олон нийт нэг эх сурвалжаас, шуурхай, үнэ төлбөргүй авах боломжтой.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль 2006 оны 2-р сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан хуулийг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах зорилгоор Дэлхийн Банкны техник туслалцааны төслийн хүрээнд бүх шатны төсөвт байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтыг өнгөрсөн 10 сарын хугацаанд орон даяар зохион байгуулж 3000 гаруй төрийн албан хаагчдыг хамрууллаа.

Шинэчилсэн хуулиар тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүдийн олонх нь худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх шаардлага тавигдаж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан дээрх сургалтын хүрээнд холбогдох ажилтнуудад худалдан авах ажиллагааны анхан шатны мэдлэг эзэмшүүлж 2000 гаруй хүнд анх удаа худалдан авах ажиллагааны мэргэжлийн сертификат олгоод байна.

Цаашид Засгийн газрын байгууллагуудын худалдан авах ажиллагааг удирдан зохион байгуулах чадавхи, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, өөрөөр хэлбэл бусад орны нэгэн адилаар худалдан авах ажиллагааны үндэсний мэргэшсэн боловсон хүчин бий болгох тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөрийг засгийн газар ирэх оноос хэрэгжүүлж эхлэхээр ажиллаж байна.

Төсвийн ил тод байдал нь сайн засаглалын нэг гол хэлбэр болно. Иймд төсвийн ил тод байдлыг хангахад дараах шинэчлэл хийхээр зорьж байгаа юм. Үүнд:

- Төсвийн тайлагналын тогтолцоог сайжруулах, үүнд бэрхшээх хэрэггүй юм. Тухайлбал ТБУСТ хуулийн дагуу сар, улирал, жилийн ба дунд хугацааны үр дүнгийн тайлагналыг хэвшүүлэх.

- Улсын санхүү, төсвийн удирдлагын хариуцлагын тогтолцооны тухай хууль эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай. Үүнд ялангуяа улс төрийн нам, хүчин, шийдвэр гаргагч, гүйцэтгэх засаглалын өнөөгийн шийдлүүд, амлалт нь улсын төсөв санхүүгийн урт хугацааны тогтвортой байдалд хэрхэн сайн ба зохисгүй нөлөөлөх тал байгаад хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг бусад орны туршлагыг харгалзан үзэх
- ТДХ-ны хүрээ, жилийн төсвийн төсөлд хөндлөнгийн мэргэжлийн шинжээ хийлгэж олон нийтийн оролцоог сайжруулан дэмжлэг авах
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шинэ төлөвлөлтийн систем бүрдүүлэх, нийгмийн болон эдийн засгийн зардал-үр ашгийн үнэлгээг томоохон төсөл бүрд хийдэг болгох, түүнийг олон нийтэд мэдээлэх тогтолцоо бүрдүүлэх
- Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцын гүйцэтгэлийн үнэлгээг “хэдийг зарсанаар бус”, “бодит үр дүн” (outcome based evaluation)-ээр үнэлэх, тайлагнах тогтолцоо бүрдүүлэх
- Хөгжлийн санхүүгийн байгууллагын тогтолцоо байж болох. Ашгийн төлөө хувийн хэвшлийн байгууллага бус зохистой бодлогод суурилсан хөгжлийн санхүүжилт, судалгааны тогтолцоо байх ёстой.

НЭЭЛТТЭЙ ТӨСӨВ – ХАРИУЦЛАГАТАЙ ТӨР

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН МЕНЕЖЕР Н. ДОРЖДАРЬ

Энэ хуралдаанд оролцогч Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. “Аливаа нянг хамгийн сайн устгадаг зүйл бол нарны гэрэл” гэсэн яриа байдаг. Үнэхээр төрд нян үржиж, өвчин болон нийгэмд тархахаас сэргийлэхийн тулд “нарны гэрэл” буюу ил тод байдал ямар их үүрэгтэй болохыг хэн хүн ойлгож байгаа биз ээ.

1. Төсөв, төсвийн үйл явц нээлттэй, ил тод байх ямар ач холбогдолтой вэ?

Үг яриа бус төрийн жинхэнэ бодлогыг илэрхийлэгч толь бол улсын төсөв билээ. Нөөц, хөрөнгийг төрийн тодорхой үйлчилгээнд хэрхэн зарцуулахыг зааж өгдөг тул тухайн засгийн газрын зорилго, баримталж буй байр суурийг харуулдаг. Тиймээс энэхүү баримт бичиг нь олон нийтэд нээлттэй, ил тод байх нь чухал. Эс бөгөөс тухайн засгийн газрын үйл ажиллагаа олон нийтэд хүрэхгүй, чухал шийдвэрүүдийн ач холбогдлыг иргэд ойлгохгүй тул төрд итгэх итгэл буурч, цаашид төр засгийн бодлого амьдралд хэрэгжихэд зайлшгүй шаардагдах улс төрийн дэмжлэгийг авч чадахгүйд хүрнэ. Үнэхээр, төсвийн хөрөнгөөр сумын сургуулийн засварыг хийх үү, эсвэл сумын даргад үнэтэй машин авч өгөх үү гэсэн асуултыг иргэд асуух нь зүй ёсны хэрэг. Сумын даргаа унаажуулснаар төрийн олон үйлчилгээг үр ашигтайгаар хүргэх боломж байгааг төр засаг тайлбарлах л ёстой.

Харин төр засгийн шийдвэрийг ойлгохгүй бол иргэд төр засагтаа итгэх итгэл алдарна. Үүний гол шалтгаан нь ил тод бус байдал байдаг. Төсвийн ил тод байдлыг хангаснаар иргэд төр засагтай хариуцлага тооцох боломжтой болохоос гадна авилгал, төсвийн үр ашиггүй зарцуулалт зэрэг сөрөг үзэгдэл үүсэх нөхцлийг хязгаарлах юм. Мөн эдийн засгийн утгаараа ч хэн хүнд ижил тэнцүү мэдээллийг хангаснаар өрсөлдөөнийг хөхүүлэн дэмжиж, хязгаарлагдмал нөөцийг илүү үр ашигтай зарцуулах нөхцлийг бүрдүүлэх нь тодорхой юм. Энэ бүхэн ардчилалд харш төдийгүй улс орны хөгжил дэвшилд ноцтой саад тотгор учруулах билээ.

Зах зээлийн эдийн засагт шилжин орсон цагаас Монгол улсын төсөв хүнд бэрх үеийг туулж ирсэн. Нэг үе төсвийн хөрөнгийг бүрдүүлэгч аж ахуйн нэгжүүд дампуурч, орлогын эх үүсвэргүй болсон. Төсвийн хөрөнгийг зориулалтын бус хэлбэрээр захиран зарцуулах явдал их гарч байсан нь төсвийн харилцааг зохицуулагч хууль тогтоомжийг бүхэлд нь өөрчлөхөд хүргэж байсан. Орлогын бааз суурь ихээхэн хязгаарлагдмал байдлаас төсвийг хүссэн хэмжээнд бүрдүүлж

чадахгүйд хүрч байсан. Харин өнөөдөр төсөвт хуримтлуулж буй хөрөнгө мөнгөний хэмжээ үлэмж өссөн тул тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх боломж ч нэмэгдсэн. Тиймээс ч төсөв зохиоход бодлогын түвшинд нарийн тооцоо, дүн шинжилгээ хийж, асуудлыг олон талаас нь хэлэлцэж байх нь чухал гэдэгтэй хэн бүхэн санал нийлэх биз. Мөн төсвийг хэрэгжүүлэх, үр дүнг нь хянахад ч сонирхолын бүлэглэлүүдийн оролцоог хангаж байх нь төсвийн зарцуулалтын үр нөлөөг нэмэгдүүлнэ.

Төсвийг илүү нээлттэй, ил тод болгож, иргэд төсвийг боловсруулах, хянах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боломжоор хангагдсан байх шаардлага энэ бүхнээс урган гарч байна.

Тиймээс төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах нь иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхээс гадна дараах ач холбогдолтой. Үүнд:

- Мэдээлэл, дүн шинжилгээнд тулгуурласан мэтгэлцээн, хэлэлцүүлгийг хийх боломжтой болно;
- Төр засагт мөнгө хэнээс орж ирж, хэнд зарцуулагдаж байгааг ойлгох боломжийг хангана;
- Иргэд төрийн албан тушаалтнуудын гаргасан шийдвэрийг хянаж, хариуцлага тооцох боломжтой болно;
- Тодорхой шийдвэрүүдийг гаргаж байгаа шалтгааныг иргэд илүү ойлгох боломжийг бүрдүүлнэ;
- Хууль тогтоогчдод тодорхой төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн ач холбогдлыг таниулж өгнө;
- Төсвийн тодорхой саналын давуу, сул талуудыг иргэд ойлгох боломжийг олгоно.

Монгол улсад төсвийн ил тод байдал өнөөдөр ямар түвшинд байгаа талаар иргэний нийгмийн байр сууринаас хийсэн олон улсын судалгааны дүнг ашиглан та бүгдэд танилцуулахыг хүсч байна.

2. Нээлттэй Төсвийн Индекс-2006

Улс орны төсвийн баримт бичиг иргэддээ хэр нээлттэй байдаг талаар 59 улс орныг хамарсан судалгааг АНУ-д төвтэй “Олон улсын төсвийн төсөл” байгууллага (цаашид ОУТТ гэх) зохион байгуулж, Монгол улсын хувьд Нээлттэй Нийгэм Форум гүйцэтгэсэн ба энэхүү баримт бичигт гарсан үр дүнг танилцуулж байна. Судалгааны дүнд Нээлттэй Төсвийн Индекс-ийг боловсруулсан. Төсвийн ил тод байдлыг үнэлсэн уг индексийг харахад төсвийн талаар зарим нэгэн мэдээлэл иргэдэд хүрдэг ч ихэнх улс орон, түүний дотор Монгол улс сайн засаглалыг хангахад зайлшгүй шаардлагатай, суурь мэдээллийг иргэддээ хүргэдэггүй байна.

Олон улсын төсвийн байгууллагын Гүйцэтгэх захирал Уоррен Крафчикийн хэлснээр, “Судалгаанд хамрагдсан 59 улс орноос 53 нь иргэдийг мэдээллээр хангалттай хэмжээнд хангаж чадахгүй байгаа ба 10 улс орон, түүний дотор Монгол улсад засгийн газрын данс бүртгэл үнэн хэрэгтээ хаалттай байна. Тухайн улсын

Нээлттэй Төсвийн Индекс-д эзлэх байр нь тухайн засгийн газрын хариуцлага хүлээх, ил тод байдлыг хангахад хэрхэн анхаарч байгаагийн хэмжүүр юм.” Төсвийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхийн тулд иж бүрэн, бодит мэдээллээр иргэд, хууль тогтоогчид, иргэний нийгмийг уг судалгаа хангаж байна.

Судалгааны дүнд үндэслэн төсвийг илүү нээлттэй, ил тод болгоход чиглэсэн шинэтгэлийг төрийн байгууллагууд хийх талаар авч үзнэ гэдэгт найдаж байна. Мөн шаардлагатай шинэтгэлийг хийхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг явуулахад судалгааны мэдээлэл иргэний нийгмийн байгууллагуудад тустай байна гэж найдаж байна.

2.1. Судалгааны аргачлал

Ил тод, нээлттэй байдал гэж юуг хэлэх вэ? Нээлттэй, ил тод байдлыг хэмжиж, улмаар аливаа ахиц дэвшил гарч байгаа эсэхийг харьцуулан хянах боломжтой юу? гэсэн асуулт тавигдана. Эдгээр асуултад хариу өгөхөд энэхүү ил тод төсвийн судалгаа нь чухал ач холбогдолтой юм. Уг судалгааг анх туршилтын журмаар 36 орныг хамруулан 2004 онд явуулсан бол 2005-06 онд судалгаанд нийт 59 улс орон хамарсан байна. Ийнхүү улс орныг хооронд нь харьцуулахын хамт тухайн улсын төсвийн ил тод байдлын хувьд цаг хугацаа өнгөрөхөд ахиц дэвшил гарсан эсэхийг хянах боломжтой юм.

Судалгаа нь гурван үндсэн хэсэгтэй. Эхний хэсэгт төсвийн холбогдолтой баримт бичгийн хүртээмжид үнэлгээ өгсөн. Хоёрдугаар хэсэгт гүйцэтгэх засаглалаас хууль тогтоогч байгууллагад өргөн барьдаг төсвийн төслийн талаар дүн шинжилгээ хийсэн. Эцэст нь, төсвийн үйл явц хэр нээлттэйг судалгааны гуравдугаар хэсэгт авч үзсэн байгаа.

Судалгаа нь 122 үндсэн асуулттай ба асуултуудыг боловсруулахдаа ОУВС-ийн Тэргүүн туршлагын код, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын “Төсвийн ил тод байдлын шилдэг туршлагууд” зэрэг баримт бичгийг үндэслэсэн болно.

Судалгааны асуултыг Нээлттэй Нийгэм Форумын судлаач хариулсан болно. Ингэхдээ хэд хэдэн зарчмыг баримталж байсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Үүнд:

- Судалгааны асуултуудад хууль тогтоомжид заасан байдлаар бус, бодит амьдралд байдал ямар байгааг харгалзан хариулсан.
- Засгийн газрын төсвийн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд үнэлсэн ба төв, орон нутгийн хоорондын харилцааны, мөн орон нутгийн түвшин дэх байдлыг тодорхойлох асуудлыг авч үзээгүй.
- Зөвхөн олон нийтэд ил болгосон мэдээлэлд үндэслэн судалгааг хийсэн болно.
- Төсвийн үйл явцад бүрэн бэлтгэгдсэн хамгийн сүүлийн баримт бичигт дүн шинжилгээ хийсэн болно. Жишээлбэл, судалгааг хийхэд 2005 оны

төсвийг батлах үйл явцыг түлхүү судалсан ба 2006 оны төсвийн төслийг үнэлэх боломжгүй байв.

Судалгааны дүнг мөн шүүмжлэгч нэг хүнээр хянуулсан болно. Уг шүүмжлэгчийг ОУТТ дангаар сонгож, хэн болохыг судлаачдад мэдэгдээгүй болно.

Өмнө нь туршилтын зорилгоор 2004 онд хийгдсэн судалгааны дүнгээр Монгол улсын төсөв ерөнхийдөө хаалттай гэсэн дүгнэлтэд хүрсэн. Уг судалгаа нь мөн гурван хэсэгтэй хийгдсэн бөгөөд гүйцэтгэх засаглалын бэлтгэдэг төсвийн баримт бичиг, тайлан, хяналтын тайлангуудад хийсэн үнэлгээнд Монгол улс ганц ч оноо аваагүй бөгөөд зөвхөн хууль тогтоогч байгууллагын оролцоо, олон нийтийн хэлэлцүүлгийн асуудлаар дунджаар авч болох 100 онооноос 19 оноо буюу хангалтгүй дүн авч байсан байна. Тиймээс төсвийн мэдээллийн хүртээмж, олон нийтийн оролцоо зэрэг асуудлаар ихээхэн ажил хийх шаардлагатай байсан нь тодорхой бөгөөд дор танилцуулсан 2006 оны судалгааны дүнгээс тодорхой ахиц дэвшил гарсан эсэхийг харах боломжтой.

2.2. Судалгааны үр дүн

Засгийн газар иргэдийнхээ өмнө хариуцлага хүлээхэд төсвийн үе шат бүрт үнэн зөв, иж бүрэн мэдээллийг шуурхай хүргэсэн байх шаардлагатай. Нээлттэй төсвийн судалгааны гол үр дүн нь 2006 оны Нээлттэй Төсвийн Индекс юм. Судалгаанд хамрагдсан 59 улс орны төсвийн ил тод байдлыг үнэлсэн уг индексээс харахад 90 хувь нь шаардлагатай түвшинд ил тод байдлыг хангаж чадахгүй байна.

Судалгааны гол дүнг тоймловол, хамарсан 59 улс орноос:

- Зөвхөн зургаа нь (Франц, Шинэ Зеланд, Словени, Өмнөд Африк, Их Британи, АНУ) төрийн хариуцлагатай байдлыг хангах төсвийн иж бүрэн, дэлгэрэнгүй мэдээллийг хангаж байна.
- Талаас илүү хувь нь (32 улс) гаргадаг долоон төсвийн гол баримт бичгийг бүгдийг нь олон нийтэд ил болгодоггүй байна. Эдгээр улс орны засгийн газар нь уг мэдээллийг дотоод хэрэгцээ, мөн олон улсын хандивлагч нарт зориулж боловсруулдаг ч иргэддээ хүргэдэггүй байна.
- 6 улс оронд (Ангол, Буркина Фасо, Чад, Египт, Монгол ба Вьетнам) төсвийг хууль тогтоогч байгууллагаар баталал нууц байлгадаг ба ингэснээр төсвийн хэлэлцүүлэгт иргэд олон нийт оролцох боломжийг үнэндээ хааж байдаг байна.
- Тал орчим нь (25 улс) төсвийн талаар олон нийтийн нээлттэй сонсголыг зохион байгуулаагүй байна.
- 16 улс оронд тухайн улсын аудитын байгууллагын даргыг хууль тогтоогч байгууллага, эсвэл шүүх засаглалтай зөвшилцөхгүйгээр гүйцэтгэх засаглал ажлаас нь халах эрхтэй байна. Ингэснээр аудитын байгууллагын засгийн газраас хамаарахгүй байх институцийн үндсэн зохицуулалт байхгүй байна.

Төсвийн холбогдолтой бүх мэдээллээ иргэдэд зориулж нийтэлснээр ихэнх улс орон уг индексийн оноогоо ихээхэн нэмэгдүүлэх бололцоотой болдог. Монгол улс төсвийн мэдээллийг цаг тухайд нь иргэддээ хүргэдэггүй учир ихээхэн доогуур үнэлгээ авч, “иргэдээ мэдээллээр огт хангадаггүй буюу бага хангадаг” 10 улс орны эгнээнд явж байна. Өөрөөр хэлбэл, Монгол улсын Засгийн газраас ирэх жилийн төсвийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд 10-р сарын 1-ний дотор өргөн барьдаг ч уг мэдээллийг бүрэн эхээр нь олон нийтэд хүргэдэггүй байна. Улмаар иргэд төсвийн хэлэлцүүлэгт мэдээлэлтэйгээр оролцох боломж үндсэндээ байхгүй гэж дүгнэж болох байна. Уг индексийг хүснэгт 1-ээс үзнэ үү

Хүснэгт 1. Нээлттэй Төсвийн Индекс-2006¹

Иргэдээ иж бүрэн мэдээллээр хангадаг	Франц, Шинэ Зеланд, Словени, Өмнөд Африк, Их Британи, АНУ
Иргэдээ боломжийн хэмжээний мэдээллээр хангадаг	Ботсвана, Бразил, Чех, Норвеги, Перу, Польш, Румын, Өмнөд Солонгос, Швед
Иргэдээ зарим мэдээллээр хангадаг	Болгар, Колумб, Коста-Рик, Хорвати, Гана, Гватемал, Энэтхэг, Индонези, Иордан, Казахстан, Кени, Малави, Мексик, Намиб, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Филиппин, ОХУ, Шри Ланка, Танзани, Турк
Иргэдээ бага хэмжээний мэдээллээр хангадаг	Албани, Алжир, Аргентин, Азербайжан, Бангладеш, Камерун, Эквадор, Эл Сальвадор, Гүрж, Гондурас, Непал, Уганд, Замби
Иргэдээ хангалтгүй хэмжээний мэдээллээр хангадаг, эсвэл огт хангадаггүй	Монгол , Ангол, Болив, Буркина Фасо, Чад, Египт, Марокко, Никарагуа, Нигери, Вьетнам

Индексээс харахад хөгжингүй улс орнуудын төсвийн үйл явц илүү нээлттэй байдаг байна. Гэхдээ зарим хөгжиж буй улс орон ч төсвийн үйл явцдаа ил тод байдлыг хангаж чадсан байна. Словени, Өмнөд Африк зэрэг улс орон ийм амжилтад ихээхэн богино хугацаанд хүрсэнийг тэмдэглэх хэрэгтэй.

Төсвийн ямар баримт бичиг Монгол улсад олон нийтэд ил тод бус байна вэ?

¹ Тухайн улс орныг дээрх ангилалд хамруулахдаа Нээлттэй Төсвийн Индексийн судалгааны иргэддээ нээлттэй байлгах ёстой төсвийн 7 гол баримт бичгийг үнэлсэн 91 асуултад өгсөн хариултын онооны дунджийг тооцох аргыг ашигласан. 81-100 хувь авсан улс орон эхний буюу “Иргэдээ иж бүрэн мэдээллээр хангадаг” ангилалд, 61-80 хувь авсан улс орон “Иргэдээ боломжийн хэмжээний мэдээллээр хангадаг” ангилалд, 41-60 хувь авсан улс орон “Зарим мэдээллээр хангадаг” ангилалд, 21-40 хувь авсан улс орон “Бага хэмжээний мэдээллээр хангадаг” ангилалд, харин 0-20 хувийн оноо авсан улс орон “Хангалтгүй хэмжээний мэдээллээр хангадаг, эсвэл мэдээллээр огт хангадаггүй” ангилалд багтаж байгаа.

Нээлттэй Төсвийн Индекс-ийг тооцоход ашигласан судалгааны материалтай бүрэн эхээр нь www.openbudgetindex.org болон Нээлттэй Нийгэм Форум-ын www.forum.mn вэб хуудаснаас танилцаж болно.

Дээрх Нээлттэй төсвийн индекст Монгол улс ямар учир шалтгаанаар доогуур байранд орж байгааг нэг бүрчлэн авч үзье. Гэхдээ төсвийн гол баримт тус бүрээр Монгол улс ямар оноо авсныг авч үзэхийн өмнө чухам хэдэн оны баримт бичгүүдийг энэ судалгаанд ашигласан болохыг Хүснэгт 2-г харуулав.

Хүснэгт 2. Судалгаанд ашигласан төсвийн баримт бичгийн хамрах төсвийн жил, олон нийтэд ил тод тайлагнасан байдал

Баримт бичиг	Хамрах он	Олон нийтэд ил байсан эсэх	Нээлттэй төсвийн индекст авсан оноо
Төсвийн хүрээний мэдэгдэл	2006	Тийм	89 %
Засгийн газрын төсвийн төсөл	2006	Үгүй	0 %
Төсвийн тухай хууль	2005	Тийм	--
Жилийн явцын тайлан	2005	Тийм	93 %
Хагас жилийн тойм	2005	Үгүй	0 %
Жилийн эцсийн тайлан	2004	Тийм	10 %
Аудитын тайлан	2004	Тийм	83 %
ЕРӨНХИЙ ОНОО			18%

Төсвийн хүрээний мэдэгдэл-ийн хувьд 2005 оны УИХ-ын хаврын чуулганаар батлагдсан 2006 оны төсвийн хүрээний мэдэгдэлд дүн шинжилгээ хийсэн болно. Юуны өмнө уг баримт бичгийг Сангийн яаманд хүсэлт гаргасны дагуу судлаач авах боломжтой байсныг тэмдэглэх хэрэгтэй. Энэ үзүүлэлтээр Монгол улс харьцангуй өндөр буюу 89 оноо авч жагсаалтын эхний 15-д орж байгаа нь Их Британи зэрэг өндөр хөгжилтэй улс оронтой ижил оноотой байна. Өмнө нь буюу 2004 онд хийсэн судалгаагаар төсвийн хүрээний мэдэгдэл үндсэндээ нийтэд ил бус байсан тул тэг оноо авч байсан. Үүнээс харахад Засгийн газраас төсвийн төсөл зэрэг бусад баримт бичгийг батлагдахаас нь өмнө олон нийт хэлэлцэх боломж олгохуйц цаг хугацаанд нийтэд ил тод болговол манай улсын ихэнх оноо харьцангуй өндөр байх нь тодорхой байна. Энэ нь бас манай төсвийн баримт бичгийн боловсруулалт олон улсын стандартыг тодорхой хэмжээнд хангаж боловсруулагддаг болохыг ч мөн харуулж байна.

Төсвийн үйл явцад Засгийн газраас бэлтгэдэг хамгийн чухал баримт бичиг нь түүний ирэх жилийн **төсвийн төсөл** билээ. Уг баримт бичгийн хувьд 2005 оны намар УИХ-д өргөн барьсан 2006 оны улсын төсвийн төслийг судалгаанд хамруулсан болно. Харамсалтай нь төсвийн төслийн баримт бичгийг тухайн жил Засгийн газрын аль нэг яам, агентлагийн вэб хуудаснаас авах боломжгүй, мөн судлаач холбогдох байгууллагын асуудал хариуцсан албан тушаалтнуудад хүсэлт гаргасан ч татгалзсан хариу авч байв. Ийм хүсэлтэд албан тушаалтнууд төслийг хууль тогтоох байгууллагад өргөн барьсан тул УИХ-аас авахыг зөвлөж байв. Харамсалтай нь УИХ-ын Тамгын газрынхан уг баримт бичгийг зохиогчоос нь

буюу Сангийн яамнаас олж авахыг мөн л зөвлөж байв. УИХ-ын гишүүд, бусад цөөн байгууллагын дарга нарын тоогоор хэвлэгддэг уг баримт бичгийг УИХ-ын гишүүдээс хувиран авахад хүрч байв. Олон улсын тогтсон жишгээр уг баримт бичгийг бэлтгэн боловсруулсан байгууллага нь нийтэд хүргэдэг үүргийг хүлээдэг байна. Тиймээс ч уг баримт бичгийг олон нийтэд ил тод бус гэж дүгнэхэд хүрсэн бөгөөд уг баримт бичиг ил тод байсан бол Монгол улсын Нээлттэй Төсвийн Индекс-т авах оноо ихээхэн нэмэгдэх байлаа. Харин **батлагдсан төсөв**-ийн хувьд 2005 оны төсвийг судалгаанд авч үзсэн ба нэгэнт хууль болж гардаг тул уг баримттай олон нийт танилцах бүрэн боломжтой байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийг иргэд хянах боломжтой байх нь төсвийн үр ашгийг дээшлүүлэх, авилгал, зориулалтын бус зарцуулалт зэрэг алдаа завхрал гарахыг цаг тухай бүрт нь таслан зогсоох нөхцлийг хангахад төсвийн тайлангууд чухал үүрэгтэй билээ. **Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан**-гийн хувьд 2005 оны Үндэсний Статистикийн Газрын нэгтгэн гаргадаг эмхтгэлд гарсан мэдээллийг судалгаанд ашигласан юм. Уг тайлангийн тоо, мэдээлэл нэгтгэсэн хэлбэртэй байдаг байна. Энэ тайланд өгсөн үнэлгээгээр Монгол улс 12-р байранд орсон нь сайн үзүүлэлт байна. Харин **хагас жилийн тойм**-ын хувьд төсвийн төслийн нэгэн адил олон нийтэд уг баримт бичиг ил тод бус байв. Хэдийгээр уг баримт бичгийг Засгийн газраас бэлтгэж, УИХ-аар хэлэлцдэг ч 2005 оны хувьд судлаач уг мэдээллийг авах боломжгүй байв. Олон улсын жишгээр хагас жилийн тойм тайлангийн хувьд сар тутмын тайлангаас ихээхэн дэлгэрэнгүй мэдээлэлтэй, дүн шинжилгээ хийсэн баримт байдаг байна.

Эцэст нь, **жилийн эцсийн тайлан** тухайн жилийн төсвийн хэрэгжилтийн үр дүнг харуулдаг чухал баримт бичиг билээ. Энэ судалгааны хувьд 2004 оны жилийн эцсийн тайланг авч ашиглалаа. Харамсалтай нь жилийн эцсийн тайланг иж бүрэн байдлаар иргэд авах боломж хаалттай, зөвхөн хэвлэл мэдээлэл, статистикийн эмхтгэлд гарсан цөөн тоо баримттай танилцах боломжтой байв. Тиймээс Монгол улс 59 орноос 45-р байрт орсон байна. Харин жилийн эцсийн тайланг хуулийн дагуу төрийн аудитын байгууллага нягтлан шалгаж, дүгнэлтээ гаргадаг ба уг тайланг олон нийтэд хүргэх нь төрийн үйл ажиллагааг иргэдэд үнэн зөв, бодитой хэлбэрээр тайлагнах явдлыг хангах хамгийн чухал баримт бичгийн нэг билээ. 2004 оны жилийн эцсийн төсвийн тайланд хийсэн **аудитын тайлан**-г Үндэсний аудитын газар өөрсдийн вэб хуудаснаа бүрэн эхээр нь байршуулсан нь дэвшилтэт алхам болж, Монгол улс уг судалгаанд эхний байранд орсон 16 улсын эгнээнд багтсан байна. Гэхдээ уг тайланг бэлтгэхэд хүртэл аудиторуд гүйцэтгэх засаглалаас бүрэн мэдээлэл авч чадаагүй гэж дүгнэсэн байсан нь анхаарал татаж байна.

3. Дүгнэлт

Ил тод байдал нь сайн засаглалыг бүрдүүлэхэд нэн чухал үүрэгтэйг олон судлаачид тогтоосон байдаг. Тэр тусмаа төр засгийн ил тод байдлыг бэхжүүлэх нь ардчилал бэхжих, хариуцлагатай төр тогтох, иргэд улс орны хөгжлийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож хувь нэмрээ оруулах нөхцлийг хангана. Түүнчлэн авилгал цэцэглэхээс сэргийлэх чухал хэрэгсэл бол иргэдийн өмнө төсвийн “ном”-ыг дэлгэх явдал юм.

Судалгааны үр дүнг гурван тусдаа хэмжүүрээр авч үзэн дүгнэхийг хүсч байна. **Юуны өмнө** ил тод байдлыг “институци”-ийн тогтолцооны хувьд авч үзэж болох юм. Энэ өнцгөөс авч үзвэл гол асуудал бол төсвийн төлөвлөлт, хэрэгжилт иргэдийн эрх ашгийн төлөө байх нөхцлийг хангасан байх үүднээс төр засгийн үйл ажиллагаанд үр нөлөө бүхий мониторинг хийх боломжтой байх явдал юм. Үүний тулд засгийн газар төсвийн болон бодлогын зорилтуудыг тодорхойлон дэвшүүлж, түүнийгээ төсвийн баримт бичгээр дамжуулж олон нийтэд таниулж, төсвийн гүйцэтгэлийг болон тайлан баримт бичгүүдийг ил тод тайлагнах шаардлагатай. Монгол улсын “институцийн ил тод байдал”-д Нээлттэй төсвийн индексийн баримт мэдээллийг ашиглан үнэлэлт дүгнэлт өгье. Үүнд:

- Төсвийн баримт бичиг Монгол улсад хаалттай байна. Цаашид ялангуяа төсвийн төслийг УИХ-д өргөн барих үед буюу жил бүрийн 10-р сарын 1-ний дотор олон нийтэд хүргэж байх нь нэн чухал. Ингэснээр иргэд төр засгийн зорилго, явуулж буй бодлогын чиглэлтэй танилцах боломжтой болж, төсөв эцэслэн батлагдахаас өмнө өөрсдийн ашиг сонирхлыг илэрхийлж, төсвийн эрүүл мэтгэлцээнийг өрнүүлэх боломжтой болно. Мэдээлэлтэй иргэний нийгэм өөрсдийн өнцгөөс төсөв зохиох үйл явцад оролцох нь төсвийн чанарыг нэмэгдүүлэх нь гарцаагүй.
- Ихээхэн нарийвчилсан мэдээллийг төсвийн баримт бичигт тусгах шаардлагатай байна. Иргэд тухайн орон нутгийн сургууль, эмнэлгийн төсвийн зарлагын задаргааг мэдэх сонирхолтой байдаг тул аймгийн бүх сургуулийн нэгдсэн төсвийг мэдэх нь хангалтгүй юм. Ийм мэдээллийг хангаснаар төсвийн зарцуулалтыг хянах явцад иргэд оролцох боломжтой тул эргээд төрийн хяналт тавих үүрэгтэй холбоотой ачааг хөнгөрүүлэх юм.
- Төсвийн баримт бичгийг иргэдэд хүргэхэд төрөл бүрийн суваг, хэрэгслийг ашиглах нь зүйтэй. Үүнд ялангуяа интернэтийг ашиглан төсвийн баримт бичгийг иргэддээ хүргэх нь зардал хямд байхаас гадна сонирхсон бүх талуудад мэдээллийг зэрэг хүргэх боломжтойгоороо давуу талтай. Хэн нэгэн албан тушаалтны тухайн өдрийн үзэмжээс хамааран зарим иргэд мэдээлэл авах боломжгүй байх нь шударга ёсонд нийцэхгүй. Гэхдээ Монгол улсад интернэтийн гарц ялангуяа хөдөө орон нутгийн иргэдэд тэр бүр байдаггүйг тооцон, бусад хэлбэрээр ч төсвийн мэдээллийг иргэдэд хүргэх тал дээр Засгийн газар анхааран ажиллах шаардлагатай.
- Монгол улс олон улсын жишгээр төсвийн баримт бичгийг бэлтгэдэг байна. Нэгэнт дотоод хэрэгцээнд, эсвэл хандивлагчдад зориулан бэлтгэдэг мэдээллийг олон нийтэд ил тод байдлаар хүргэхэд уг баримт бичгийг бэлтгэх чадавхи дутсан, эсвэл хөрөнгө мөнгө хүрэлцээгүй гэж шалтаглах нь учир дутагдалтай юм.
- Төсвийн баримт бичгүүд мэргэжлийн нэр томъёо, ухагдахууныг ихээр агуулдаг тул зарим улс оронд “Иргэдийн төсөв” хэмээх иргэд ойлгоход дөхөм, мэдээллийг хялбарчлан тайлбарласан гарын авлагыг бэлтгэн гаргадаг сайн туршлагыг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

- Интернэтэд төсвийн баримт бичгийг байрлуулахдаа судлаач, иргэд ашиглах боломжтой хэлбэрийг сонгох нь чухал. Өөрөөр хэлбэл, төсвийн тоо, хүснэгтүүдийг иргэд *Excel* зэрэг түгээмэл хэлбэрээр авч, өөрсдийн харьцуулалт, дүн шинжилгээ, тооцоог хийх боломжтой байх нь чухал билээ.

Хоёрдугаарт, төсвийг зохиох, хэрэгжүүлэхэд ашиглаж байгаа үзүүлэлтүүдийн бүртгэл тооцоог хийж байгаа аргачлалыг ил тод байлгах явдал иргэдийн хувьд чухал байна. Ялангуяа төсвөөс гадуур хийгддэг засгийн газрын санхүүгийн үйл ажиллагааны талаар төсвийн баримт бичгээс мэдээлэл авахад хүндрэлтэй байна. Энд төрөл бүрийн тусгай сангууд, тэр дотроо нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал зэрэг томоохон сангуудын мэдээллийг ил тод болгох шаардлагатай байна. Мөн төрийн өмчит компани, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын санхүүгийн гүйцэтгэлийг төсөвт тусгадаг байх нь чухал юм. Түүнчлэн засгийн газрын санхүүгийн тайлан тэнцлийг нарийвчлан гаргаж, жил бүр гарсан өөрчлөлтийн хамт иргэдэд тайлагнах шаардлагатай байна. Энэ бүх нөхцөл хангагдаагүй байхад төсвийн ерөнхий үзүүлэлтүүд, эдийн засагт нөлөөлж байгаа байдлыг үнэлэх, хянах үндсэндээ боломжгүй юм.

Гуравдугаарт, төсвийг зохиоход ашиглаж буй аливаа тооцооны үзүүлэлт, таамаглалыг ил тод байлгах шаардлагатай байна. Зэсийн үнийг хэт доогуур төлөвлөх нь чухал төслүүдэд мөнгө дутахад хүргэж болзошгүй. Хэт өөдрөг тооцоо, төсөөлөл нь төсвийг хэтрүүлэн зарах шалтаг болох магадлалтай. Мөн засгийн газрын өр төлбөр, авах зээл, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр, төсвийн урт, дунд, богино хугацааны тэнцлийн тооцоо зэргийг ямар урьдач нөхцлийг ашиглан тооцсоноо ил тод байлгах нь чухал байна.

Сүүлийн үед төсвийн үйл явцад иргэдийг оролцуулах, иргэдэд мэдээллийг ил тод байдлаар хүргэх тал дээр Сангийн яам, УИХ, Үндэсний Аудитын Газар зэрэг төр засгийн байгууллагууд ахиц дэвшил гаргаж байгааг эцэст нь тэмдэглэхийг хүсч байна. Тухайлбал, 2007 оны төсвийг хэлэлцэж байхад анх удаагаа Засгийн газар төсвийн төслөө вэб хуудаснаа байрлуулаа. Цаг хугацааны хувьд УИХ-д төслийг өргөн барьснаас нэлээд хугацаа өнгөрсөн байсан ч энэ нь нааштай алхам боллоо гэж дүгнэж байна. Мөн аудитын тайлан, Байнгын хороодын хурлын материал зэрэгтэй танилцах боломжтой болж байгааг талархан хүлээн авч байна. Цаашид ч энэ тал дээр анхааран ажиллана гэдэгт найдаж байна.

Эцэст нь Нобелийн шагналт эдийн засагч Амартя Сен-ий хэлсэн үгийг бага зэрэг өөрчлөн энд дурдахыг хүсч байна. “Хоол олдохгүй болоод улс орон өлсгөлөнд автдаггүй юм. Харин мэдээлэл олдохгүй аваас өлсгөлөн нүүрлэдэг” гэж тэрбээр ядуу зүдүү, өлсгөлөнд автсан олон улс орныг харьцуулж судалж үзсэний үндсэн дээр хэлснийг бид санахад илүүдэхгүй байх.

Анхаарал тавьсан та бүгдэд талархалаа илэрхийлье.

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

МУИС-ИЙН НИЙГМИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ, ДОКТОР (PH.D) О. МӨНХБАТ

Үндсэн ойлголтууд: ил тод байдал, төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоо, худалдан авах ажиллагааны мэдээллийн хүртээмж, нээлттэй байдал, иргэдийн оролцоо, иргэний нийгмийн байгууллагууд

Оршлын оронд:

2005 онд Монгол улсын нийт төсвийн орлогыг 708.2 тэрбум төгрөгөөр, төсвөөс зарцуулах зарлагын доод хэмжээг 775.1 тэрбум төгрөгөөр тооцон баталснаас төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд /цаашид худалдан авах ажиллагаа гэнэ/ нийт төсвийн 27.6 хувь буюу 222.8 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Харин 2006 онд Монголын улсын дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.9 триллион төгрөг хүрнэ хэмээн мэргэжилтнүүд тооцож байгаа бөгөөд үүнээс 640 тэрбум төгрөгийг зөвхөн төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Монголчууд бид олсон гурван бор төгрөгнийхөө бараг л нэгийг нь эргээд зарцуулж байгаа төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа бол үнэхээр төрийн үйлчилгээний маш чухал бүрэлдэхүүн хэсэг гэдгийг хэлэх юун. Төрийн худалдан авах ажиллагаа нь хамрах хүрээ өргөн, хэлэлцэх асуудал арвинтай зүйл учраас би өөрийн илтгэлдээ зөвхөн эл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, олон түмний оролцооны төлөв шинжэд гол анхаарлаа хандуулж байгаа гэдгийг сонордуулья.

Чухамдаа төрийн үйлчилгээний энэ онцгой салбарыг авилгал, хээл хахууль зэрэг гаж, сөрөг хүчин зүйлсээс хамгаалах арга замуудын нэг бол шударга, ил тод, нээлттэй, хариуцлага тооцох механизмтай, олон нийтийн оролцоог дэмжин тэтгэсэн тогтолцоо, түүний бодит орчинг бүрдүүлэх явдал гэдэгтэй маргах хүн гарахгүй буй за.

Ингээд та бүхэнд толилуулж байгаа энэхүү илтгэлдээ худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг 1) мэдээллийн хүртээмж, нээлттэй байдал, 2) олон нийтийн оролцооны боломж, бололцоо гэсэн шалгууруудаар хэмжиж,

шинжиллээ. Ингэхдээ уг тогтолцооны эрх зүйн орчин нь ил тод, нээлттэй байдлыг хөгжүүлэхэд хэрхэн нөлөөлж байгааг голлон авч үзэх болно.

Худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмж, нээлттэй байдал:

Эл асуудлыг ярихын өмнө төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны бүтцийн хэв шинжийг товч авч үзье.

Худалдан авах ажиллагаа нь үндсэндээ 1. Төвлөрсөн, 2. Холимог, 3. Төвлөрсөн бус гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй байдаг аж.

Төвлөрсөн тогтолцооны үед төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг улсын хэмжээнд нэгэн байгууллага хариуцан эрхэлж, захиалгын дагуу нэгдмэл байдлаар ханган нийлүүлэлтийг хийдэг байна. Энэхүү тогтолцооны сонгодог жишээ бол 1990 оноос өмнө Монгол улсад үйлчилж байсан төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоо юм.

Холимог тогтолцоо гэдэг нь хэдий улсын хэмжээнд нэгдсэн байдлаар худалдан авах ажиллагаа хийдэг төвлөрсөн байгууллага үгүй ч гэсэн тодорхой салбарын хүрээнд тухайлбал, боловсролын, эрүүл мэндийн гэх мэт тодорхой нэг байгууллага төвлөрсөн худалдан авах ажиллагааг хэрэгжүүлдэг тохиолдлыг хэлнэ.

Харин төвлөрсөн бус тогтолцооны үед төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шат шатны менежерүүд хэрэгцээт бараа, үйлчилгээ, ажлыг төрийн хөрөнгөөр худалдан авах үйл ажиллагааг бие даан хариуцан эрхэлдэг агаад эдүгээ Монгол улсад чухам эл тогтолцоо үйлчилж байгаа юм.

Эл тогтолцоо нь төвлөрлийг сааруулж, бараа, ажил, үйлчилгээг хэрэглэгчид нь ойртуулдагараа ил тод, нээлттэй байдал, хэрэглэгчдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх боломжийг олгодог. Гэвч боломж олгоно гэдэг маань заавал тийм байдаг гэсэн үг биш нь харамсалтай бөгөөд өнөөгийн гажуудсан тогтолцооны дүнд захиалагч нь тодорхой эрх мэдэлтэн, албан тушаалтнууд, харин чухам хэрэглэгч нь хяналт тавих, оролцох эрхгүй, мэдээлэлгүй жирийн ажилтан албан хаагч, иргэд болон хувирчээ.

Энэхүү тогтолцооны эрх зүйн орчин хэрхэн бүрдэж ирсэн, худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдал, олон нийтийн оролцоог дэмжих үзэл санаатай хэрхэн холбогдож байгаа тухай товч өгүүлье.

2005 оны 12-р сард Монгол Улсын Их хурал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” хуулийг шинэчлэн батлав.¹ Энэ хууль бол 2000 онд батлагдсан хуулийн шинэчлэн боловсруулсан хувилбар байлаа. Чухамдаа Монгол улс төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохицуулах бие даасан эрх зүйн актгүй явсаар 2000 онтой золгожээ.

¹ Монгол улсын хууль

2000 оноос өмнө худалдан авах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль², Монгол улсын Засгийн газрын тухай хууль³, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль⁴, Төсвийн тухай хууль⁵, Иргэний хууль⁶, Үнэт цаасны тухай хууль⁷ хэмээсэн хуулиуд хийгээд “Тендерийн журам” Засгийн газрын тогтоол, “Менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын нийтлэг журам”, (ТӨХ -ны тогтоол) гэсэн тогтоол журам бүрдүүлж ирэв.

Эдгээр хуулиуд *нэгдүгээрт*, төрийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хуульчлан баталгаажуулсан, *хоёрдугаарт*, тэдгээрийг хэрхэн зарцуулахыг тодорхойлон зохицуулахад чиглэгдсэн байна. Түүнээс гадна эдгээр эрхзүйн актуудад худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг дэмжих үзэл санаа тусгагдаагүйг дурдах хэрэгтэй.

Харин 2000 онд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай”⁸ хууль батлагдсанаар засгийн газрын худалдан авах тогтолцооны эрхзүйн орчин бүрэлдэхэд нэгэн алхам болов. Гэсэн хэдий ч энэ хууль ил тод, нээлттэй байдлыг дэмжин хөгжүүлэх үзэл санаагаар тун ч дорой байсан бөгөөд харин 2005 онд шинэчлэгдэн батлагдсан хувилбар нь олон нийтийн байгууллагын оролцоог тусгаснаараа дэвшилттэй болжээ. Гэхдээ мөн л хязгаарласан, заавал салбарын шинжтэй олон нийтийн байгууллагын оролцоо байж болно гэсэн хоёрдмол санаатай тул өөрсдийн санхүүжүүлдэг Ахмадын хорооноосоо ганц нэг хүн оруулаад л ам хаах боломжийг агуулж байна. Түүнчлэн дээрх хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий “ босго үнэ батлах тухай”, “шинжээчдийн багийн ажиллах тухай” зэрэг хэд хэдэн журмууд нь худалдан авах ажиллагааг түмэн олонд ил тод байх нөхцлийг хангах тухайд мөн л санаа тавиагүй аж.

Ер нь худалдан авах ажиллагааны өнөөгийн эрх зүйн орчин нь тендерийг зохион байгуулах техник горим журамд гол анхаарлаа хандуулснаас биш олон нийтэд ил тод, нээлттэй болгох талаар төдийлэн санаа тавиагүй нь илэрхий харагддаг.

Өнөөдөр худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийн хүртээмжит байдлыг голлон тендерийн урилга буюу зартай холбон ойлгох, тайлбарлах эрмэлзлэл шийдвэр гаргах түвшинд түгээмэл ажиглагддаг. Ийм ядмаг ойлголт нь ганц хоёр сонины хавсралт нүүрэнд хүний нүдэнд үл өртөх жижиг зурвас зар гаргаснаар ил тод байдлыг хангасан гэж нүүр тахлах боломжийг эрх мэдэлтнүүдэд өгдөг нь ойлгомжтой. Гэтэл чухамдаа мэдээллийн хүртээмж гэдэг бол тус худалдан авах ажиллагааг төлөвлөхөөс авахуулаад хянан үнэлэх гэх мэт бүхий л үе шатыг хамрах ёстой өргөн цогц зүйл болж байж сая үүргээ гүйцэтгэх боломжтой болдог.

² Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. УБ:1993 7.1 –р зүйлүүд

³ Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль УБ:1993, 20.5,4 –р зүйлүүд

⁴ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль УБ:1996, 46-53 –р зүйлүүд

⁵ Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль УБ:2000, 24-р зүйл

⁶ Иргэний хууль УБ:2003, 22-р зүйл

⁷ Үнэт цаасны тухай хууль 11-р зүйл

⁸ Худалдан авах ажиллагааны эмхтгэл №1 МУ –ын Санхүү Эдийн Засгийн Яам. УБ:2001

Тендерийн урилгын тухайд гэхэд хуульд заасны дагуу манайд голлон сонин, FM радио зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлагддаг бөгөөд энэ нь өргөн олонд хүртээмж муутайн зэрэгцээ ашиглахад яршиг төвөг ихтэй хэлбэр аж.

Сүүлийн нэг жилд “Зууны мэдээ”, “Өдрийн сонин” болон “Өнөөдөр” зэрэг өдөр тутмын сонинуудад сард дунджаар 30 орчим янз бүрийн тендерийн зар нийтлэгдэж байсан агаад тэдгээрийн ихэнх нь нэг зарыг хэд хэдэн сонинд зэрэг тавьж, давтан хэвлүүлсэн аж.

*ННФ.Чанарын судалгаа. 2005 оны 10-11-р сар Контент анализ**

Энэ баримтыг жилийн турш улсын хэмжээнд нийт 100.000 гаруй худалдан авах ажиллагаа хийгддэг гэсэн тоотой харьцуулах юм бол тун ч өрөвдмөөр бага дүр зураг гарч байгаа биз.

Харин худалдан авах ажиллагааны урилга, зар мэдээг нэгтгэн хэвлэсэн үнэгүй тараагддаг товхимол гэх мэт зүйлийг аль ч төрийн байгууллага, яам тамгын газар хэвлэн түгээдэггүй бөгөөд 2005 оны төгсгөлөөр шинэчлэгдсэн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” Монгол улсын хуульд /цаашид гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль гэнэ/ энэ талаар ямар ч заалт байхгүй байна.

Үүний сацуу бас ил тод байдлын хувьд гэрэл гэгээтэй зүйлс байгааг дурдахгүй өнгөрч болохгүй. Тухайлбал, 2005 оны хуулийн зөвхөн томоохон хэмжээний тендерийн тухай мэдээллийг цахим сүлжээгээр нийтэд хүртээл болгохтой холбоотой өөх ч биш булчирхай ч биш заалтыг “Цахим сүлжээнд тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам” тун аятайхан залруулж чаджээ. “Цахим сүлжээнд тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам” нь ил тод байдлыг дэмжихэд тун нааштай хандлагыг агуулсан ганц бичиг баримт гэхэд хилсдэхгүй. Гэвч (харамсалтай нь дахиад л гэвч) цахим сүлжээг Сангийн яам хариуцахаар заасан нь дахиад л төвлөрлийг үүсгэж, төрийн байгууллагуудын өчнөөн төчнөөн хөрөнгө зарж байгуулсан веб хуудсыг “хүндэт самбар” аятай байдаг өнөөгийн гажуудлыг өөгшүүлэхэд хүрсэн байна.

УИХ-ын Тамгын газраас аваад Засгийн газрын яам тамга, тэдгээрийн харьяа агентлаг, газруудын 33 веб хуудсыг шүүрдэж үзэхэд 90 гаруй хувьд нь төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой ганц ч зарыг олж үзсэнгүй. Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яам, Цагдаагийн ерөнхий газар гэсэн худалдан авах ажиллагааны томоохон субъектуудын веб хуудсанд тендерийн сураг ч алга. Эдгээр веб хуудсуудыг иргэдэд мэдээлэл өгөхөөс илүүтэй дарга, албан тушаалтнууд өөрсдийгөө сурталчилсан, зураг хөргөө залдаг “хүндэт самбар” болгосон нь эмгэнэлтэй. Түүнчлэн худалдан авах ажиллагааны захиалагчид болох төрийн яамд, газар, агентлагуудад тендерийн асуудалтай холбоотой мэдээллийг өгөх үүрэгтэй тодорхой албан тушаалтнуудын нэр ус, албан тушаал тодорхойгүй учир мэдээлэл хүссэн хүн ихэнхдээ харуулын дэргэдээс хөөгдөн гарахад хүрдэг байна.

* Тодотгол: Энд болон цаашид иш татаж байгаа тоо баримтууд бол 2005-2006 онд ННФ-ын Бодлогын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн “Төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог боловсронгуй болгох нь” судалгааны дүн болно.

Тендерийн бичиг баримтыг хэвлэж, олшруулах, түгээх, тендер шалгаруулалтыг зохион байгуулахад зарцуулсан өртөгт үндэслэн үнэлж, тендерт оролцохыг сонирхогчдод уг үнээр саадгүй олгоно гэсэн 2005 оны 12-р сард батлагдсан “Гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн” заалт ил тод, нээлттэй байдлыг хясан бооход хүргэж байгаа нэг хүчин зүйл болоод байна. Ийнхүү тендерийн материалын үнэ хэдэн арван мянгаас сая сая төгрөг хүртэл үнэлэгдсэнээр тэдгээрийг худалдаж авах байгууллага иргэдийн тоо цөөрч, ил тод, нээлттэй байдалд ноцтой хохирол учруулж байгаа юм.

Тендерийн материалыг нийтийн өмнө нээнэ гэсэн хуулийн заалт нь таатай сонсогдож байвч нийт гэдгийн дор хэнийг хэлж байгааг тодотгож өгөөгүйгээс мөн л хоёрдмол утгыг үүсгэн будлиантуулах үүд хаалгыг нээж өгч байна.

Түүнчлэн худалдан авах ажиллагааны захиалагчид дэргэдээ мэдээлийн төвийг ажиллуулдаг нь ор нэрийн төдий зүйл бөгөөд тэндээс худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл, явагдаад өнгөрсөн тендерийн материалыг олж үзэх боломжгүй нь судалгаанаас харагдаж байлаа. Шалгарсан тендерийн материалыг тодорхой хугацааны туршид олон нийтэд нээлттэй байлгах нь ил тод байдлын нэгэн үзүүлэлт боловч өнөөгийн эрх зүйн орчинд үүнийг зохицуулсан заалт журам бас л үгүйлэгдэж байгаа нь харамсалтай.

Олон нийтийн оролцооны боломж, бололцоо:

Төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлын нэгэн чухал үзүүлэлт бол иргэд олон нийтийн оролцооны боломж бололцоо, бодит байдал мөн билээ.

Гэвч өнөөгийн нөхцөл байдал нь иргэдийн ийм оролцоог дэмжих тал дээр тун чиг хязгаарлагдмал бөгөөд үнэлгээний хороодын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нь бүү хэл хөндлөнгийн ажиглагчийн байр сууринаас хандах боломжоор хомс байгаа юм.

Тендерийн үйл явцад олон нийтийн оролцоо байдаг эсэх тухайд нийт респондентын 8.2 хувь нь ийм оролцоо байдаг гэсэн бол, заримдаа л байдаг гэж 12.8 хувь, огт байдаггүй хэмээн хариулсан хүмүүс хамгийн олон буюу 32.8 хувийг эзэлж байна.

ННФ. Тоон шинжилгээ. Анкетын судалгаа. 2005 он

Худалдан авах ажиллагааны өнөөгийн эрх зүйн орчин нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд дорвитой нөлөө үзүүлэх чадваргүй байгаа юм. Ялангуяа иргэд мэдээлэл авахдаа эрхээ эдлэх биш бэрхийг туулах “хүнд аянд” гарахад хүрдэг тул улмаар залхаж, буянаараа бол хэмээн зөнд нь хаяхад хүрдэг. Харин иргэдийн эрхийг ийнхүү завхруулж байгаа албан тушаалтнууд иргэдийн идэвхгүй, сул доройг нь гайхан шагшиж, бид ч тун нээлттэй ил тод байдаг боловч энэ иргэд л өөрсдөө ирэхгүй, оролцохгүй, болохгүй байна гэж “гомдоллох” нь нийтлэг.

Чухамдаа төрийн байгууллагууд, албан тушаалтнууд төрийн аливаа үйлчилгээний ил тод байдлыг хангах, иргэдэд сурталчлах, тэднийг идэвхжүүлэхэд

хүч нөөц бололцоогоо дайчлах ёстой авч, бодит байдал дээр усанд живж байгаа хүн аврагдах эсэх нь өөрөөс нь хамаардаг юмаа хө гэсэн байдалтай сууж байна. Үнэндээ аман дээрээ дэмжиж байвч ачир дээрээ иргэдийн оролцоо, ил тод, нээлттэй байдлыг хөгжүүлэх асуудал бол төрийн үүрэг биш харин олон улсын байгууллага, ТББ -уудын үүрэг мэт хүлээж авдаг болсон нь монгол төрийн бас нэгэн ёс бус төрх мөн аж.

Төрийн хөрөнгөөр бараа үйлчилгээ, ажил худалдан авах ажиллагааны олон арван функцийг ганцыг нь боловч иргэдийн оролцооны гол эх суваг иргэний нийгмийн байгууллагад даатгаж өгөөгүй нь энэ чиглэлийн орон зайг хаалттай байлгах бас нэгэн нөхцлийг бүрдүүлж байна.

Монголд үйл ажиллагааг явуулж байгаа 5000 гаруй ТББ -уудын дотор төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны чиглэлээр дагнан ажиллаж байгаа байгууллага ердөө л ганцхан байгаа нь үүний нэг илрэл билээ.

Төрийн худалдан авах ажиллагааг зохицуулах хуулийг УИХ-аар хэлэлцэхэд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын дунд ямарваа нэгэн хэлэлцүүлгийг зохиож явуулаагүй нь чухамдаа овоо босгохгүй бол шаазгай суудаггүй л байхгүй юу гэсэн эрх баригчдын эрмэлзлэлтэй холбоотой гэвэл дэмий хардсан зүйл болохгүй биз ээ.

Үнэн хэрэгтээ авилгал гэдэг нь баригдах биегүй, сонсогдох дуу хоолойгүй хийсвэр зүйл биш агаад чухамдаа засгийн газрын худалдан авах ажиллагаа, татвар, гааль зэрэг төрийн үйлчилгээний гол төрлүүдээр “амилж” хүчирхэгжин тархаж байдаг зүйл юм. Гэтэл ийм асуудлыг ярихдаа иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцох боломжийг хангахгүй байгаа явдал бол ил тод, нээлттэй байдлыг боомилох гэсэнтэй агаар нэг билээ.

Товч дүгнэх нь:

Төсөв мөнгөний багагүй хувь зарцуулагддаг худалдан авах ажиллагааны ил тод байдлыг мэдээллийн хүртээмж, нээлттэй байдал хийгээд иргэдийн оролцоо гэсэн шалгуур үзүүлэлтүүдээр товч авч үзлээ.

Эдгээрийг товчоолон дүгнэх аваас дараах дүр зураг харагдана. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны эрх зүйн орчин нь мэдээллийн ил тод байдал, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх эрмэлзлэл бүхий иргэний нийгмийн үзэл санааг удирдлага болгоогүй, зөвхөн тендерийг явуулах техник горим журмыг хуульчилсан зохицуулалтын шинжтэй тул ил тод, нээлттэй байдал хөгжин дэвжихэд үр өгөөжтэй байж чадахгүй байна.
- Худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмжит байдлыг дан ганц тендерийн урилга тараах хүрээнд ойлгох нь төлөвлөх, шалгаруулах, хянах, үнэлэх зэрэг эл ажиллагааны дийлэнх гол үе шатуудыг олны хараа хяналтаас ангид байлгах нөхцлийг бүрдүүлж байгаа юм.
- Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг тараах хэлбэрүүд нь оновчтой бус, хариуцсан албан тушаалтан тодорхойгүй, зориулалтын

хэвлэмэл эх сурвалж байдаггүй, вэб хуудасны ашиглалт муу зэрэг нь мэдээллийн хүртээмжтэй байдлыг хязгаарлаж байна.

- Худалдан авах ажиллагаанд иргэдийн оролцох оролцоо нь эрх зүйн баталгаа, нэгэн мөр заасан зохицуулалт байхгүй зэргээс үүдсэн объектив шалтгаан хийгээд иргэдийн өөрсдийн идэвх зүтгэл гэх мэт субъектив хүчин зүйлсээс үүдэн маш доогуур түвшинд байна.
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх тухайд төр, түүний албан тушаалтнууд хойрго ханддаг нь худалдан авах ажиллагааны орон зайд иргэд олон нийтийн төлөөлөл болох иргэний нийгэм, ТББ-уудыг тоглох боломжийг хязгаарлаж байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр

1. Жереми Поуп (2005). Авилгын эсрэг сурвалж бичиг. Англи хэлнээс орчуулсан. УБ: Тоо ном принт хэвлэлийн ХХК
2. Хүний аюулгүй байдлыг хангах төсөл (2003). Үндэсний Шударга Ёсны Тогтолцоо: түүний үзүүлэлтүүд. Англи хэлнээс орч. УБ: Тоо ном принт хэвлэлийн ХХК
3. О.Мөнхбат (2006) Төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог боловсронгуй болгох нь. Бодлогын судалгааны тайлан. УБ:
4. О.Мөнхбат (2005 оны 11-р сарын 24). Албан тушаалтнуудын халаасыг зузаалдаг тендер хэмээх луйвар. Зууны мэдээ өдөр тутмын сонин, № 281.
5. О.Мөнхбат (2005 оны 11-р сарын 02). Төрийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах мэргэжилтэн бэлтгэе. Зууны мэдээ өдөр тутмын сонин, № 262

Англи хэлээр

6. Bhargava, V., Bolongaita. E. (2004) Challenging Corruption in Asia. Case Studies and a framework For Action. Washington, DC: The World Bank Press
7. The World Bank (2003). Mongolia Country Procurement Assessment Report. Ulaanbaatar:
8. Shah, A (Ed) (2005). Procurement Policies and Rules. European Bank for Reconstruction and Development : Public expenditure analyses. London: Alan G. Havesi (2005). Strengthening State Procurement Practices. New York

Монгол улсын хууль, тогтоол

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль.

2. Монгол улсын Засгийн газрын тухай хууль.
3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль.
4. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль.
5. Иргэний хууль
6. Үнэт цаасны тухай хууль
7. Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль
8. Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хууль
10. Монгол улсын Засгийн газрын 2000 оны 101-р тогтоол
11. Худалдан авах ажиллагааны эмхэтгэл №1 МУ –ын Санхүү Эдийн Засгийн Яам. УБ, 2001

Web pages

1. Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions (www.oecd.org),
2. Transparency international (www.transparency.org),
3. Multilateral Development Banks` Working Group on Anticorruption, Governance and Capacity Building (www.worldbank.org/publicsector).
4. United Nations Development Programme (www.undp.org/governance/account.htm)
5. Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions(www.oecd.org),
6. www.wto.org www.apecsec.org.sg
7. The World Bank, Washington, DC. Convention Against Corruption UN.International Anti-Corruption Conference. www.11iacc.org
8. Global Forum Series. www.globalforum3.org
9. Overview of the Agreement on Government Procurement. WTO. www.wto.org

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

С.Бямбаа /НДЭХ-ий Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийн зохицуулагч/:

Манай байгууллага сүүлийн долоон жил орон нутгийн төсвийн асуудлаар судалгаа хийж байгаа. Саяхан орон нутгийн төсөвт бодлогын мониторинг хийх төслийн ажлыг хэрэгжүүлсэн. Төсвийн цаана улс төрийн зарчим, улс төрийн бодлого байдаг, хүмүүсийн амьдрал байдаг нь харагдаж байсан. Өөрөөр хэлбэл, төсвийн бодлого нь хүнийг хөгжүүлэхэд чиглэж байна уу, эсвэл, хүчгүйдүүлэхэд чиглэж байна уу гэдэг талаас дүгнэлт хийхийг хүсч байна.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуульд орон нутаг нь хавчуурга маягаар орсон байгаа. Ийм учраас орон нутаг хуулийн гадна гарчихжээ. Хуулийн гадна гарсан учраас орон нутгийн иргэд ямар ч идэвхгүй, асрамж халамжийн сэтгэхүйтэй роботууд болж хувирсан байна. Нөгөө талаас хуулиар хийх, хийхгүй юмны зааг байхгүй болж, найр наадам зохион байгуулах, эрх баригчдыг хүлээн авах, элдэв тэмдэглэлт ойг гаргаж ярих, түүнчлэн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгө өгөх, бие биенээ шагнах ажлыг хийж байна. Харин хууль сурталчлах болон төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх тухай асуудал байхгүй. Яагаад гэвэл төсвийн бодлогоор байхгүй болгочихсон. Энэ хуулийг хэн ч ойлгодоггүй.

Төсөв дээр нэг хүнд ногдох норм, стандарт гэж байдаггүй учраас бүтээгдэхүүн тооцох боломж байдаггүй. Үр дүнг эрхэмлэсэн төсвийн шинэ бодлого хэрэгжүүлж байгаа гэдэг боловч гол хяналт буюу мэргэжлийн хяналт, төрийн аудитын байгууллага нь дансны хэмээх хуучны арга барилаар хянадаг учраас төсөв бодитой явагдаж байгаа, үгүйг мэдэх аргагүй.

Төсвийн бодлого бол улс төрийн бодлого гэж би хэлсэн. Уг нь аймаг, сумын ИТХ бол иргэдийн эрх ашгийг хамгаалах ёстой байгууллага. Гэтэл орон нутгийн сонгуулийн хуулийн дагуу ИТХ-ыг намаас сонгодог болохоор намуудын эрх ашгийг хамгаалдаг байгууллага болчихсон. Нөгөөтэйгүүр засаг захиргааны ажилтнуудыг сонгон оруулснаас болж засаг захиргааныхаа эрх ашгийг хамгаалдаг байгууллага болсон. Тийм учраас орон нутгийн эрх ашгийг хамгаалах мөнгө үр ашиггүй байна.

С.Ганбаатар /“Үндэсний Соёмбо” хөдөлгөөн/:

Хөдөө орон нутгийн иргэний нийгмийн төлөөлөл ирсэн учраас үгээ хэлэх нь чухал гэж үзээд байн байн гараад байгаа шүү. Үүнийг ойлгоорой.

Деталь дотор чинь чөтгөр явж байгаа гэж ярьдаг. Их ерөнхий байна. Батжаргал даргадаа төрөө нэг магтаад хэлчихье. Тал талаас нь баахан муулцгаасан байгаа. Иргэд биднийгээ маш ухаалаг болгож байгаа төрдөө баярлалаа. Намайг хүүхэд байхад аав, ээж маань ухаантай болгох гэж байна гээд оньсого таалгадаг байсан. Төрийн үйл ажиллагаа, төсөв нь оньсого шиг байгаа учраас биднийг маш мэргэн харддаг, таадаг болгосонд баярлаж байна.

Ингээд хоёр оньсого тааснаа хэлье. НӨТ-ын буцаан олголтын сан гэж гарах болов уу гэж сая харж байлаа. Та үсрүүлчихэв үү, би үсрээд харчихав уу, олж харсангүй ээ. 2005 онд НӨТ-ын буцаан олголтоор 47 тэрбум төгрөг буцаж олгогдсон. Тэр нь худалдаж авсан жинхэнэ хүмүүстээ очих байтал Ерөнхий сайдын багцад ороод алга болчихдог. Эндээс л тэрбумтангууд гарч байгаа болов уу. 2005 оны 8-р сарын 15-нд УИХ-аас “НӨТ-аас зарим бараа, бүтээгдэхүүнийг чөлөөлсүгэй” гэсэн Нямдорж даргын гарын үсэгтэй хууль гарсан байгаа. Энэ хуулийг хэнд ч хэлээгүй хав дарчихсан. Тэгээд хуулийг хэсэгчлэн хэрэгжүүлж байгаа. Барилгын компаниудыг материал, техник авахлаар нь татвараас хөнгөлдөг. Гэтэл байр авсан хүмүүст татварыг нь өгдөггүй. Тодруулбал, 11 сая долларыг 3500 өрхөд өгөх ёстой байтал тас нуучихсан. Одоо ухаад гаргаад ирсэн байгаа. Бөөн авилгалыг ухаж гаргах болсон. Энэ бүхнийг маш сайн тооцоолж иргэд маань ч хариуцлагатай байгаасай.

Төрөөс баахан тэрбумтан төрөөд л байдаг. Үүнийг иргэд бид хянах ёстой ч гэлээ цалинг нь авч коридорт нь сууж буй хяналтын функц байгаа шүү дээ. Улсын Ерөнхий аудитын газар байдаг гэж би ойлгож байгаа. Эсвэл байхаа больсон юм болов уу. Улсын ерөнхий аудитор нь аливаа нам, улс төрийн үзэл бодлоос ангид байна гэж хуульд заасан байгаа. Гэтэл дарга нь МАХН-ын бага хурлын нэлээн том гишүүн, ирэх сонгуульд гарах нь тодорхой шахуу хүн яваа. Ийм арчаагүй байдлаа өөрчлөөсэй гэж хүсч байна. Биднийг маш их ухаажуулж байгаа төрдөө баярлалаа.

Алтанцэцэг /Дархан-Уул аймаг/:

Би аймгийн ИТХ-д төлөөлөгчөөр суудаг. Төсвийн хэлэлцүүлэг нь орон нутгийн хэмжээнд маш хангалтгүй явагддаг. Яагаад гэвэл оруулж ирж байгаа материал нь барагцаалсан байдаг. Ямар тоо баримтыг яаж оруулж ирсэн нь ил тод биш учраас иргэдийн төлөөлөгчид нь мэдлэггүйгээр тоог баталж явуулдаг.

Тендерийн шалгаруулалт бас учир дутагдалтай. Нэг жишээн дээр ярья. 560 сая төгрөгийн тендер шалгаруулалт хууль бусаар явагдаж нэг компани аваад одоо хүлээн авалтын шатандаа орчихсон байгаа. Зөвхөн нүүрсний пункерийг 26 сая төгрөгөөр хийсэн гэсэн. Гэтэл 5-хан сая төгрөгийн хөрөнгө оруулалт орсон байгаа юм. Энэ мэтээр тендерийн хөрөнгө оруулалт будлиантай явагддаг. Мэдэж байгаа нь л энэ болохоос олон тендер ингэж явагдаж байгаа.

Ил тод байдал гэж ярьж байна. Гэтэл хөдөө орон нутаг буюу дунд шатандаа завхрал их гардаг. “Үдийн цай” хөтөлбөрөөр Дархан-Уул аймагт тендер зарласан. 8-р сарын 26-нд дүгнэхэд бэлэн болсон. Гэтэл сургуулийн захирал болон эрх мэдэлтэнгүүд нь сурагчдад сургуулийнхаа гуанзанд 300 төгрөгийн хоол өгнө гэж

байгаа юм. Тэгэхээр энэ нь ямар илчлэгтэй хоол байх вэ, ямар стандартыг хангах юм бэ. Ийнхүү ил тод байдал алдагдаж, иргэдийн эрх ашиг хөндөгдөж байна.

ИТХ ил тод биш байна, иргэддээ үйлчлэхгүй байна гэдэг бол үнэн шүү дээ. Мэдээлэл иргэдэд хүрч чаддаггүй. Тэдэнтэй уулзахаар ямар ч мэдээлэл байдаггүй. Мэдээллийн хуудсыг зохих хэмжээгээр бид гаргадаг. Гэтэл төрөөс гарч буй мэдээлэл нь хэнд ч хэрэггүй ганц нэг тоо тавьчихсан, ТББ-ын ажлыг өөрсдөө хийсэн гээд биччихсэн тайлан байдаг. Иргэд төрийн байгууллагын хийсэн ажил уу ТББ-ын хийсэн ажил уу гэдгийг ялгадаггүй.

Б.Батжаргал /СЯ-ны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга/:

“Төсвийн ил тод байдал” вэб сайт нээж мэдээллийг ард түмэнд хүргэж байгаа энэ ажлыг ямар нэг судалгааны байгууллагад зориулж хийгээгүй юм. Үнэнийг хэлэхэд өөрсдийн ажлын чанарыг бодож хийж байгаа. Өнөөдөр Сангийн яам, Мэргэжлийн хяналт, Төрийн аудитын газар гурав нийлээд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 5200 төсөвт байгууллагын 125 мянган ажиллагсадтай холбоотой санхүүгийн үйл ажиллагааг шуурхай хянах чадвар, боломж байхгүй. Үүнийг хэрхэн шийдэх вэ гэдэг талаар бид бодож үзсэн юм. Хамгийн боломжит арга нь төсөвтэй холбоотой бүх мэдээллийг зэрэгцүүлэн харах боломжтойгоор олон нийтэд хүртээмжтэй болгох байсан.

Та бүхэнд нэгэн жишээ хэлье. Өвөрхангай аймгийн зэргэлдээ хоёр суманд хэмжээний хувьдижил хоёр цэцэрлэг байлаа. Тэр хоёр цэцэрлэгийн зардал хэрхэн явж байгааг дурын хэн нэгэн интернэтээс харьцуулж харах боломжтой болно. Бас тухайн цэцэрлэгийн ажилчид хяналт тавих боломжтой. Өөрөөр хэлбэл, энд мэргэжлийн хяналт, аудит хэрэггүй. Энэ үүднээс бидний ажлыг сайжруулах зорилгоор хийж байгаа юм. Бид хэн нэгэн хүнд таалагдах гэж вэб сайтыг хийгээгүй ээ.

Та үнэний хувьтай зүйл хэллээ. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хууль нь санхүүжилтийн зарчмыг өөрчилсөн, орон нутгийн эрх мэдлийг нэлээн багасгасан. Үүнтэй санал нэг байна. Гэхдээ цаанаа бодлогын томоохон үр дүнг авчирсан хууль болсон юм. Орон нутгийн эрх мэдэл, ялангуяа ИТХ, Засаг даргын эрх хэмжээ буурч байна гэдгийг Сангийн яам ажигласан. Олон ч санал ирсэн. Энэ үүднээс Засгийн газраас УИХ-д оруулж ирсэн төсвийн төсөл дээр цогц арга хэмжээ авахаар оруулсан байгаа. Вэб сайт дээр байгаа учраас та бүхэн олж харж болно. Сонирхуулбал, хууль сурталчлах зардал, Засаг даргын нөөцийн сан, ЗДТГ-ын урсгал засварт зориулж тодорхой хэмжээний хөрөнгийг тусгаж өгсөн. Өмнөх жилүүдэд төсвийн хатуу бодлого явуулж байсныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Харин энэ жилээс орон нутагт чиглэсэн ийм арга хэмжээг авсан.

Та андуурч хэлэв үү, эсвэл, үнэхээр хэлэв үү. Таны ярианд хуулиас гадуур үлдсэн гэж дурдагдлаа. Миний зүгээс үзвэл орон нутаг хуулиас гадуур үлдэх боломж байхгүй ээ. Харин эрх хэмжээний хязгаарлагдмал байдалд орсон юм бий. Ийм арга хэмжээ авснаар орон нутгийн төсөв дээр зөвхөн захиргааны хэдэн байгууллага л үлдсэн шүү дээ. Бусад нь буюу нийгмийн халамж, цагдаа зэрэг нь

ерөнхийлөн захирагчтайгаа харьцаж байгаа юм.

Бүтээгдэхүүн тооцох арга байхгүй гэлээ. Хэрэгжүүлэх механизм нь үнэхээр түвэгтэй учраас ийм хүндрэл үүсч байгаа юм. Харин дүрэм журмыг нь батлаад өгсөн байгаа.

НӨТ-ын асуудал дээр бид олон нийтэд мэдээлэл хүргэхээр бэлтгэж байсан юм. Үүнийг та бүхэнд танилцуулъя. Засгийн газар, УИХ-аас зах зээл дээрх барилгын үнийг бууруулах зорилгоор барилгын компаниудыг НӨТ-аас чөлөөлсөн. Өөрөөр хэлбэл, тухайн барилгын компаниуд орон сууцаа НӨТ-гүй зарах ёстой гэсэн үг. Гэтэл татвартай зарсан гэж асуудал үүсч байгаа юм. Энэ асуудлаар иргэний нийгмийн байгууллагууд Сангийн яаманд шууд хандсан нь харамсалтай. Процедура мэдэхгүй байж болно. Харин Сангийн яам ямар үйл ажиллагаа явуулдаг вэ гэвэл ҮТЕГ-аас баримтаар нотлогдож шалгагдсан тэр хөрөнгийг нь Төрийн сангаас гаргах шилжүүлэг хийх л үүргийг гүйцэтгэнэ. Журмаа сайн барьсан бол иргэний нийгмийн байгууллагууд ҮТЕГ-т хандах ёстой. Гэхдээ эхлээд тохиолдол бүрт тухайн байгууллагыг НӨТ-тай зарсан эсэхийг нотлох хэрэгтэй. Бид энэ талаар судалгаа хийж үзсэн л дээ. Тухайлбал, А гэдэг компани Ч гэдэг хүнд байр зарахдаа м²-ыг нь 500 доллар шүү гэж гэрээн дээр тусгасан болохоос биш, үүнээс НӨТ нь төд байлаа гэж ... /хөтлөгч үгийг нь таслав./

Маралмаа /МЭХ/:

ТББ-ууд үүсч хөгжөөд өнөөдрийн түвшиндээ хүрч, төр засагтаа нөлөөлөн бодлого боловсруулах хэмжээнд хүрсэн явдалд их баяртай байна. Нийгмийн баялгийн хуваарилалтыг авч үзвэл хувьчлал нэрийн дор хууль бус аргаар эд баялгийн дийлэнхийг нэг хэсэг нь авсан байгаа. Газар доорх ашигт малтмал бол ард түмний өмч шүү дээ. Энэ өмчийг лиценз маягаар хэдхэн тооны хүмүүс мөн адил өмчилж авсан. Тэгэхээр үлдэж байгаа нийгмийн баялгийг ард түмэн яаж хүртэх вэ гэдэг нь эмзэг асуудал болж байгаа юм.

Нийгмийн баялгийг эзэмшиж буй баян хүмүүс бүх шатны төрийн байгууллагын албан тушаалыг эзэлж, маш их хүнд сурталыг бий болгон суудлаасаа ховхороход маш хэцүү хүмүүс болж хувирсан байгаа. Тийм учраас 2008 оны сонгуульд ТББ-уудад ажиллаж байгаа, эдгээр асуудлыг ойлгож мэдэрсэн боловсон хүчнүүдийг гаргаж дэвшүүлэх ажлыг зохион байгуулах ёстой гэж бодож байна.

Өнөөдрийн форумд УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга ирж нүүрээ харуулчихаад гараад явчихлаа. Гэтэл төрийн байгууллагад ажиллаж буй хүмүүсийн хүнд суртал, авилгал гээд болж бүтэхгүй байгаа өчнөөн асуудлыг нь ярьж байхад яагаад тэвчээртэй сонсоод гарч болдоггүй юм бэ. Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгч нь хүртэл гараад явчихлаа. Тэгэхээр ТББ-ууд энэ амь бөхтэй хүнд суртал бүхий дарга нарыг тал талаас нь шахаж, энэ байдлыг нь ойлгуулахын тулд ирэх сонгуульд идэвхтэй оролцох ёстой байх аа.

Ч.Тамир /МУИС-ийн Социологийн тэнхимийн багш/:

Мэдээж ил тод байдалд төрийн байгууллагаас иргэдэд мэдээлэл өгөх асуудал орно. Үүнээс гадна төрийн харагдахгүй далд байгаа зүйл, бидэнд харагдахыг хүсдэггүй зүйлүүд яригдах ёстой болов уу. Тийм учраас төсвийг боловсруулах үйл явцад ТББ-ууд болон хэвлэлийнхэн экспертиз хийж иргэдийн санаачилгыг авч анхааралтай ажилламаар юм шиг санагддаг. Сонин хэвлэлээс харж байхад хэвлэл мэдээллийн байгууллага болон ТББ-уудад энэ талын чадавхи нь дутагдаад байгаа юм шиг санагддаг.

Иргэд төсвийг уншаад саналаа хэлж түүнийгээ шууд тусгуулах нь хязгаарлагдмал болов уу. Иргэний нийгмийн байгууллагууд болон бусад байгууллагууд үүнд тусалдаг байгаасай гэж хүсч байна. Саяын 250 сая төгрөг ил тод яригдсан учраас олон нийтийн анхаарлыг үүнд нэлээн хандууллаа.

Үндсэн хуульд иргэд төлөөллийн байгууллагаараа дамжуулж болон шууд оролцох тухай заасан байгаа. Гэвч шууд оролцоог нэг их ярьдаггүй. Энэ талаар ярих хэрэгтэй байгаа юм. Тухайлбал, ард нийтийн санал асуулга гэх мэтээр.

Сүүлийн үед Дэлхийн Банкнаас зээл тусламжаас хамааралтай хөгжиж буй орнуудад нийгмийн аудитын тухай ярьж байгаа. Иргэд хэрэглэгч учраас тухайн зүйлд өөрсдөө дүн тавьж, өөрсдөө аудит хийнэ гэсэн үг. Тэгэхгүйгээр төрийн нэг байгууллагад даатгаад орхивол далд муу зүйл нь харагдахгүй ээ.

Ж.Халзанбанди /Монголын татвар төлөгчдийн холбооны захирал/:

Төсөв бүрдүүлэхэд Монголын бүх хүний хувь нэмэр орж байгаа. Гэсэн ч төсвийн зарцуулалтад огт хяналт тавьдаггүй. Их бүдэг байгаа. Татвар төлөгч байгууллага бүр төсвийн зарцуулалтад тодорхой системтэйгээр хяналт тавимаар байна.

Нөгөө талаас нь харвал төсөв баталж байгаа, зарцуулж байгаа нь судалгаа шинжилгээ, тооцоо муутайгаар, өөрийн тойрогтоо ахиухан юм авчихъя гэсэн байдлаар явж байна.

Төсөв нь тэтгэврийн шинжтэй болсон. Хүүхэд төрөөд 10 мянган төгрөгийн тэтгэвэр авдаг, жаахан том болохоороо халамж хүртдэг, шинээр гэр бүл болоод 500 мянга, хүүхэд төрүүлээд 100 мянган төгрөг авна гэх мэтчилэн. Тэгэж явсаар жинхэнэ тэтгэврээ авна. Тэгэхээр тодорхой ажил хөдөлмөр хийж улс орондоо хэрэгтэй зүйлийг бүтээхгүй байсаар дуусах нь. Татвар төлөгч хувь хүн, байгууллага бүр үүнийг анхаарах хэрэгтэй. Өнөөдөр татвар төлөхгүй иргэн гэж байхгүй шүү дээ.

Одончимэг /ЛЭОС-ийн гүйцэтгэх захирал/:

Парламентын гишүүн нь Засгийн газартаа орж ажилладаг олон улсын жишиг байдаг юм билээ. Гэхдээ нийт парламентын гишүүний 5 орчим хувийг эзэлдэг юм байна. Дунджаар Засгийн газарт орж ажиллах парламентын гишүүдийн тоо нь манай улсад одоогоор 20 гаруй хувь болчихоод байгаа. Тэгэхлээр төсөв боловсруулан оруулж буй сайд нар, УИХ-ын гишүүд өөрсдийн салбарын, эсвэл

хувийн явцуу эрх ашгаар хандаж байна уу гэж бодогддог. Энэ байдлыг өөрчлөх санал дэвшүүлж байна.

Х.Оюунцэцэг /Хуульч эмэгтэйчүүдийн холбооны гүйцэтгэх захирал/:

Хуулийн өмнө төр, иргэн тэгш эрхтэй гэсэн үндсэн зарчим байдаг. Нийгмийн даатгалын санд одоогийн тэтгэвэр авагч нарт зориулсан тэтгэврийн мөнгийг төсвөөс оруулах ёстой байдаг. Энэ мөнгийг оруулсан уу, хэдий хэмжээгээр оруулсан бэ? Оруулаагүй тохиолдолд ямар хариуцлага тооцох вэ?

Ажахуйн нэгж, байгууллага, хувь хүнд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй тохиолдолд 0.3 хувийн алдангийг тооцдог. Миний мэдэж байгаагаар өнөөдөр Сангийн яаманд нэг ч төгрөг ороогүй. Гэтэл ямар нэгэн алдангийн тухай ойлголт Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд байдаг. Ийм шударга бус зохицуулалт манайд байна. Энэ талаар та өөрийн байр сууриа илэрхийлэхгүй юү?

Ж.Уртнасан /“Төсвийн ил тод байдал” хуралдааныг даргалагч/:

Ийм танин мэдэхүйн шинжтэй асуултаа бичгээр өгчихөж болох байх. Бидэнд цаг маш бага байна. Тэргэнцэртэй иргэдийн “Төмөр” сангийн төлөөлөгч үг хэлье гэж саналаа ирүүлсэн байна.

Төмөрбаатар /“Төмөр” сан/:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөрсдийнхөө талаар мониторинг хийх боломж олгосон ННФ-д талархалаа илэрхийлье. Би 20 гаруй жилийн өмнө Ленинград хотод оюутан байхдаа машины урдуур гүйсэн хүүхдийг аврах гээд өөрөө аваарт орсон. Арван жил хэвтэрт байсны эцэст суумгай нөхцөлд амьдрах болсон хүн л дээ. Тэгээд аваарт орсныхоо дараа хамгийн хэцүү нөхцөлд амьдарч байна, надаас илүү хүнд нөхцөлд амьдарч байгаа хүн Монголд байдаг ч юм уу үгүй ч юм уу гэж бодож байсан л даа. Сургуулиа ч төгсч чадаагүй болохоор группын хэдэн төгрөгөөрөө чадан ядан амьдарч байлаа. Тэгээд хүн өөрийнхөө төлөө тэмцэхгүй бол төр засаг маань ч олигтой тусалж чадахгүй юм байна гээд таван тэргэнцэртэй хүн нийлж энэ холбоогоо байгуулсан юм. Анх бүгдээрээ нэг сарынхаа группын мөнгийг нийлүүлээд тамга тэмдэг, данс энэ тэр гээд олигтой өсч дэвшиж чадаагүй.

Өнгөрсөн жил ННФ-аас зарласан мониторингийн төсөлд хамрагдаж өөрсдийн гол зорчих хэрэгсэл болох тэргэнцэрийг төр засгаас хэрхэн олгодог талаар мониторинг хийсэн. Мониторинг хийх явцад их сонин зүйлүүд ажиглагдаж байсан. Төр засгийн байгууллагуудад хандаж дарга нартай нь уулзах гэхээр орж гарахаас эхлээд их хэцүү. Манай дарга нар ихэнхдээ тухайн байшингийнхаа хамгийн дээд талд нь суух юм.

Ямартаа ч мониторинг амжилттай болсон. Бид зөвхөн Нийслэлийн хэмжээнд мониторингоо хийсэн. Гэтэл Хэнтий аймагт та бүхэнд олдохгүй байгаа тэргэнцэрийн 10 жилийн нөөц байна, тэр бүү хэл, сайн малчин нь тэргэнцэрээр аргал түүдэг, та нар ирж үзээч гэсэн хүсэлт тэндээс тавьсан. Мониторинг хийх

хэсэг маань зөвхөн хотод болохоор тийшээ хүрч чадаагүй. Өнөөдөр нийслэлд тэргэнцэр олж авч чадахгүй байгаа хүн олон бий.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүсэлтийн дагуу дараагийн шатныхаа мониторингийн төслөө бичээд өгсөн байгаа. Боломжтой бол үүнийг минь дэмжээрэй гэж хүсэх байна. Улсын хэмжээгээр тэргэнцэртэй иргэдэд зориулсан автобус унаа байдаггүй. Тэдэнд таксинаас бусад нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчих эрхтэй гэсэн үнэмлэх олгодог. Гэвч эрхтэй атлаа түүнийгээ ашиглах боломж байдаггүй. Жишээ нь, автобусанд суух гэхээр лифт энэ тэр нь байхгүй учраас орох боломж байхгүй.

Улсын хэмжээгээр 10000 гаруй тэргэнцэртэй иргэн байдаг гэсэн албан бус тоо бий. Тэд цас оронгуут тарвага шиг ичээндээ орчихдог. Хавар цас хайлж дулаарсаны дараа гадагшаа гарахаас өөр аргагүй байдаг.

Яг энэ чиглэлээр мониторингийн төсөл өгчихсөн байгаа. Тэргэнцэртэй иргэдэд зориулсан гар удирдлага, тусгай тоноглолтой автомашиныг гаднаас оруулж ирэхэд ямар журмаар оруулах талаар. Социализмын үед ийм автомашиныг төр засгаас хариуцан оруулж ирээд 50 хувийг нь хөнгөлж олгодог байсан юм билээ. Одоо энэ нь байхгүй болсон. Би энэ тал дээр туршлагажих гээд сарын өмнө нэг машин захиалж Японоос оруулж ирээд 2000 гаруй долларын өрөнд орчихсон.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай тоноглолыг онцгой албан татвараас чөлөөлнө гэсэн хуулийн заалттай. Үүний дагуу тооцоолчихсон чинь хуульд тусгай тоноглол гэж заасан болохоос автомашин гэж заагаагүй гэж тайлбарлаж байгаа юм. Уг нь тусгай тоноглолтой, гар удирдлагатай, массаж энэ тэр хийдэг машин л даа. Нэгэнт автомашин гэж заагаагүй учраас гээд 1000 долларын өрөнд орчихож байгаа юм. Гэтэл тэр машин нь 1000 гаруй долларын үнэтэй байдаг юм байна. Тэгээд 2000 гаруй долларын өрөнд орчихсон. За яахав, амьд хүн аргатай гэдэг. Яаж ийж байгаад төлчих л байх. Гэтэл надаас бусад захиалсан хүмүүс маань яг ийм байдалд хүрээд байгаа учраас энэ чиглэлээр мониторинг хийх сонирхолтой байна. Хэрвээ миний төсөл шаардлага хангаж байгаа бол дэмжиж өгөхийг хүсч байна

Б.Чимэд /ХЗДС-ийн Төр захиргааны тэнхимийн эрхлэгч, Гавьяат хуульч/:

Мэргэжлийн үүднээс хэдэн үг хэлмээр байна. Манай төсвийн ил тод байдал гэдэг чинь шуудхан хэлэхэд байхгүй л байгаа. Сангийн яамнаас өгсөн лимитээр аймаг, аймгаас суманд хуваарилж очоод түүгээр нь гэрээгээ байгуулна. Ард түмэн төсвийн орлого, зарлагын тухай хэлэлцээд орлогоо ингэж нэмэгдүүлье, бидэнд ийм бололцоо байна, зарлагаа ингэж хэмнэе, бидэнд бололцоо байна гэсэн юм байхгүй.

Тендер гэхээр заавал Улаанбаатараас компаниуд аваачиж засвар хийлгэдэг. Ард талдаа бас дэгээтэй. Гэтэл сумын иргэд ярьж байна. Бид өөрсдөө энд хэдэн хүн цуглуулаад, хуучин хэллэгээр бол хагасыг нь субботникдаад, сургууль, тамгын газрынхаа байшинг засч яагаад болдоггүй юм гэж. Эндээс юу хэлэх гээд байгаа юм бэ гэвэл Төсвийн байгууллагын хууль нь Үндсэн хуультай маш их зөрсөн.

2000 онд Төсвийн байгууллагын тухай хуулийг манай санхүүгийн байгууллага өөрсдийн санааны зоргоор, ёс бусаар үйлдсэн. Жам ёсоор тусгаж байж хууль болдог болохоос биш, ямар нэгэн хүний арга мэхийг томъёолсноор хууль болдоггүй юм.

Монгол улсын төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсвөөс бүрдэх ёстой. Орон нутгийн төсөв бол орон нутгийн байгууллагаас иргэдэд үзүүлдэг үйлчилгээ, орон нутгийн засаг захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлдэг орлого, зарлагын данс, зардлын төсвийг хэлдэг. Гэтэл орон нутгийн байгууллагын цуглуулдаг мөнгийг орон нутгийн төсөв гэх юм. Өөрийг нь өөрөөр нь боомилсон. Манай ямар ч сум зарлагаа бүрэн нөхөж чадахгүй. Ямар ч аймаг, за яахав, 3-4 аймаг байгаа. Орлого зарлага нь тэнцэж чаддаггүй. Энэ мөнгө хаанаас гардаг юм бэ гэхээр орлого хэрэгтэй. Нутаг дэвсгэрийн нэгжээс орлого багатай нутаг дэвсгэрийн нэгжид нэг хүн, нэг ажилтанд ногдох зардлын хэмжээгээр нь тэгшитгэн хуваарилж, нийгмийн баялгийг хуваарилах замаар хэлэлцүүлэг явуулах ёстой болохоос ч бага оруулбал бага ид, чи их идвэл би тэрийг чинь булааж авна гэдэг маягаар төсөв хийдэггүй.

Тодорхойлолтоосоо эхлээд Төсвийн тухай хууль чинь улс төрийн бодлогын хувьд алдаатай. Энд аймгийн дарга нар сууж байх шиг байна. Үүнийгээ хэлж ярихад яадаг юм бэ. Албан тушаалаа бодоод дуугарахгүй байж болох юм. Ялангуяа Сангийн яамтай шөргөөцөлдвөл төсвөө хасуулна гэдгийг чинь сайн мэдэж байна. Би бол төсөв гуйдаггүй, горьддоггүй хүний нэг. Сум төсөв байхгүй, аймаг төсөв байхгүй. Сумын төсөв гэж юу байдаг юм гэвэл сумын Тамгын газрын есөн түшмэл, хурлын хоёр дарга, сумын засаг дарга, орлогч дарга гээд 13 хүн, дээрээс нь 4-5 багийн даргын цалин, аар саар бичиг үсгийн зардал гэсэн юмыг л сумын төсөв гэж нэрлээд хуурч байх юм. Тэгээд сургууль, цэцэрлэг, багийн эмчийн зардлын төсвийг хүртэл яамдын сайд нар авсан. Сайдын багц гэдэг үгийг олсон байна. Манай улсад төсвийн нэгдсэн бодлого алга. Төсвийн нэгдсэн бодлогыг Ерөнхий сайд хариуцах ёстой. Гэтэл Ерөнхий сайдын багц, Шадар сайдын багц, БСШУ-ны сайдын багц, ЭМ-ийн сайдын багц гэх юм. Багц гэж буруу бичсэн, зөв бичгийн алдаа юм шиг байгаа юм. Богц гэвэл таарна. Энэ чинь тоглоом биш шүү.

Зургаан мужтай Шинэ Зеландын төсвийг бизнесийн аргаар зохицуулах гэсэн туршилтыг манайд авчраад туршсан. Экспертүүд болохгүй гэж УИХ-д бичиг ирүүлснийг би тарааж байсан хүн. Тэгээд гишүүдийг үлчихээд байсан чинь Австрали хуулсан гээд УИХ-ын 20 гишүүн яваад ирсэн. Тэд номхорчихоод ирсэн. Худлаа байж магадгүй юм. Хүн бүрт 2000 доллар өгсөн гэж сонссон. Хамгийн чухал болзол нь Азийн банк 12-р сард л үүнийг хийхгүй бол долларын зээл өгөхгүй гэж Энхсайханы үед бойкотолсон. Ингээд бид чинь өөрийгөө мэдэхээ больсон. Хүний амаар өгүүлбэр зохиодог ийм улсууд болжээ. Сангийн яамны түшмэдүүдийг хараад өрөвдөж байна.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуульд сайн юм байгаа. Яагаад гэвэл үр дүнгээр нь санхүүжүүлнэ гэдэг бол лоозонгоор нь санхүүжүүлснээс хамаагүй илүү гэдгийг судлаач хүний хувьд эрхбиш ойлгож байна. Гэтэл үр дүн юу вэ. Өнөөдөр сумын Тамгын газрын дарга, аймгийн Тамгын газрын дарга болон ажилтнуудын үр дүнгийн гэрээ, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ нь дандаа лоозонгууд байгаа. Нэг ч хэмжүүртэй ажил байхгүй. Яагаад ийм байдаг юм, яаж боловсруулах ёстой юм гээд Сангийн яамны зааврыг эрээд туугаад байсан чинь

олддоггүй, аймагт байдаггүй, суманд байхгүй, ХЗДХЯ-д байдаггүй. Сангийн яамнаас эрээд хэд дахиж хүн явуулаад эцэстээ хүн нь амраад явчихаж гэсэн. Ийм юм болж байгаа юм. Гурван жил.

Сая би Хэнтий аймгийн төсөвтэй газар дээр нь танилцсан. Малын удмын сангийн тухай хууль ёсоор 25 өвчнийг улсын төсвөөр санхүүжүүлэн урьдчилсан сэргийлэх буюу анагаах ёстой байгаа. Түүний дагуу малдаа тааруулаад 70 хэдэн сая төгрөгийг төлөвлөж явуулахад 42 сая болгон хасчихсан байна. Иймэрхүү маягаар төсвийн гүнд нь орж ярихгүй бол зүгээр олон нийтийн оролцоо гэж яриад юу хийх юм бэ. Хэдэн төгрөгийг хаана зарах гэж байгаа юм, хэнд өгөх гэж байгаа юм, юу хийх гээд байгаа юм, эмнэлэг, сургуулиа яах гэж байгаа юм бэ.

Уржнан Могод суманд судалгаа хийгээд үзэхэд сургуулийн засварыг тендер шалгаруулж төвөөс хүмүүс хийсэн байна лээ. Ноднин Булган аймгийн Төрийн удирдлагын хэлстийн даргатай уулзах гээд хоёр өдөр чаддаггүй. Хаачсан бэ гэхээр Могод суманд сургуулийн засвар хүлээж авахаар Боловсролын яамны хүн дагаад явсан гэж байна. Тэр засварыг яагаад сумын сургуулийн захирал, сумын дарга, иргэдийн хурлын төлөөлөгчид, тэр 3000 хүн хийж чаддаггүй юм бэ.

Би номдоо бичсэн. Намайг хөөрхий гэж магадгүй. Завхан аймгийн Идэр сум эндээс 1000 км зайтай. 10 ортой больницын барилга барих тендерийн шалгаруулалтыг зарлаж байна. ЗГ-ын 8-р байр, 106-р өрөө гэсэн зар яваад байна. 10 ортой амбаарыг яагаад Завхан аймгийн 100 мянган хүн барьж чаддаггүй юм бэ. Ийм байдалд орчихоод байгаа. Энэ шинэ хууль нь Монголыг санхүүгийн хувьд дампууруулж байгаа хууль гэж хэлээд байгаа юм. Үүнийхээ төлөө цөлөгдсөн ч бэлэн байна. Залуучууд аа, үүнийгээ янзлах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол хүний үгэнд хууртсан хуучин сармагчин байсан. Одоо шинэ сармагчин битгий төрүүлээч ээ. Монгол толгойгоор Монголынхоо амьдралыг судалж байж хийгээч.

Юунд зарж байна вэ. Ихэвчлэн ёс бусын юманд зарж байгаа шүү. Би хоморгонд орохоос айгаад тэр наадамд нь явдаггүй юм. Хэнтийд Чингисийн их том наадам боллоо, энэ жил. Зөвхөн түүнд Улаанбаатар хотын дүүрэг бүрээс 20 сая төгрөг төсөвлөсөн байна. Бензин тосонд зарж байна. Аймаг бүрээс 50-60 саяыг зарж байна.

Монголын хэмжээгээр хэчнээн овоо тахиж байгаа юм, мэдэхгүй. Овоо тахилгын мөнгө хаанаас гарч байна гэж ТББ-ын хийсэн судалгаанаас үзэхээр сургуулийн хүүхдийн хоолны зардлаас гарч байгаа шүү. Тэр бол нотлогдсон үнэн. Хүүхэд чинь мэддэггүй юм байна л даа. 70 грамм боорцог өгөхийн оронд 40 грамм боорцог өгөөд төсвийнхөө 50 хувийг хэмнэж байна. Энэ чинь их нарийн. Ийм юмыг төсвийн хяналт гэдэг болохоос биш 250 сая төгрөг дээр хэрэлдээд байгааг хэлж байгаа юм биш гэж хэлэх гэсэн юм. Жаахан хатуудсан байж магадгүй. Гэхдээ энэ бүхний цаана баримт бий. Энэ бүгдийн цаана амьдрал бий. Энэ бүгдийн цаана Монголын төрийн өөрийнх нь туршлага байгаа шүү.

Гаднаас нэг юм авахаар тендер гээд яриад байна. Энэ чинь уралдаант шалгаруулалт гээд 1963 онд байсан зүйл. Тендер гэхээр шинэ юм болчихдог гэнэ. Өрсөлдөөнт шалгаруулалт гэж байгаа юм. Өрсөлдүүлээд байгаа юм ч алга л даа. Өрсөлдүүлсэн нэрээр өөрийнхөө хүнийг тавихыг тендер гэж байгаа юм.

Г.Цогтсайхан /Азийн санаачилга институтийн захирал/:

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хууль нь Азийн Хөгжлийн Банкнаас манайд импортолсон хууль юм. Дэлхийд ганцхан улс үүнийг санаачилж гадагшаа импортолж эхэлсэн нь Шинэ Зеланд. Ерээд оны дундуур, тэр үед Шинэ Зеландын Сангийн сайд байсан хүн санаачилснаас хойш 10 орчим жил туршаад үр дүнгүй нь батлагдсан. Үүнийг импортолж авсан цөөн хэдэн орны нэг нь Монгол улс байгаа юм.

Сая бидний импортолж авсан хуулиудын нэг байсан Ашигт малтмалын тухай хуулийг буцаасан. Одоо Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийг эргэж үзээд солих цаг нь болсон байж магадгүй. Тухайн үед дэмжиж байсан АХБ энэ зарчим төдийлөн зөв арга зам биш гэдгийг хүлээн зөвшөөрч түүнээс буцаж байгаа. Тэгэхээр манай Сангийн яам болон УИХ-ын гишүүд энд байгаа бол түүнийг анхаарч, сонгодог маяг руу нь оруулахад буруудахгүй байх гэсэн саналыг хэлэх гэсэн юм.

Б.Батжаргал /СЯ-ны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга/:

Чимэд гуай манай төсвийн тулгуур хуулиудын зарчмын асуудлуудыг хөндлөө. Түүхэн хроникоос нь авч үзвэл та бүхэн хоёр зүйлийг харьцуулж харна уу. Өмнө нь тендер дээр зар, урилга гэж байдаггүй байлаа. Өөрөөр хэлбэл, тухайн төсвийн байгууллагын дарга нь авилгал авна уу, машин авна уу гэдгээ өөрөө шийдэх тийм зарчим үйлчилж байсан.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хууль дангаараа гарч ирээд манай санхүүгийн тогтолцоог сайжруулчихсан, бас муудуулчихсан юм биш ээ. Үүний зэрэгцээ Сангийн яамнаас Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоог хэрэгжүүлсэн байгаа. Бидний хамгийн ололттой хийсэн ажил бол төсвийн бүтцийг үндэс сууриар нь өөрчилсөн.

Ганцхан жишээ хэлье. Та бүхэн хэрвээ санаж байгаа бол 1999 оны үед цалингаа тавьж чаддаггүй байлаа. Учир нь юу вэ гэвэл дансанд хэдэн төгрөг хуваарийн дагуу орж ирэхэд түүнийг зарцуулах онцгой эрхийг төсвийн байгууллагын дарга, нягтлан хоёр л мэддэг байсан. Өөрөөр хэлбэл, 5200 төсөвт байгууллагыг хоёроор үржүүлбэл 10400 хүн л тэр бүх шийдвэрийг гаргадаг байсан юм. Төрийн дансны нэгдсэн тогтолцоонд шилжээд 14 хоногийн дараа гэхэд Монгол улсын нэгдсэн дансны үлдэгдэл 80-100 тэрбум төгрөгийн хооронд эргэлддэг болсон. Өнөөдрийн байдлаар бол 180 тэрбум. Энэ бол маш том үзүүлэлт. Өөрөөр хэлбэл, өмнө нь хэчнээн тэрбум төгрөг орж ирснийг хуваарийн дагуу бүх төсөвт байгууллагад хуваарилаад өгчихдөг байсан. Тэд өөрсдөө яаж зарцуулах, хэдэн банканд данстай байхаа мэддэг байсан бол өнөөдөр Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоог Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуультай хослон хэрэглэснээр бид зарчмын өөрчлөлтөд хүрсэн юм.

Гэхдээ Чимэд гуайн хэлснээс нэг зүйлийг нь хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Орон нутгийн их засвартай холбоотой асуудал байгаа. Ховд аймгийн аль нэг сумын 10 сая төгрөгийн их засварыг журмын дагуу тендер зарлахад Улаанбаатараас шалгарсан компани тийшээ очиж хийдэг, тэгээд чанар нь муу

болдог гэдэг асуудал 2-3 жил дараалан яригдаж байгаа. Ялангуяа сургууль, эмнэлгийн байгууллагад энэ асуудал гардаг. Үүнийг шийдэхийн тулд төсөвт их засварын зардлыг бөөнд нь тавьж өгөөд төсвийн ерөнхийлөн захирагчаас буюу Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдаас аймаг, орон нутгийн Засаг даргатай гэрээ байгуулдаг. Гэрээ байгуулахдаа мөнгөн дүнг тэр чигээр нь багц руу шилжүүлээд өгчихье гэсэн байдлаар зохицуулж яваа. Үнэхээр Төсвийн байгууллагын удирдлага, санхуужилтийн хуультай холбоотой ямарваа нэгэн хүндрэлтэй асуудал байвал Сангийн яаманд хандаж болно. Энэ хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэг гэж байгуулагдсан байгаа. Тэдэнд энэ хуулийг сайжруулах талаар саналаа хэлбэл бид баяртай байх болно.

Гаргаж ирсэн зүйлээ нураахад их амархан. Чухам юу нь болохгүй байна гэдэг дээр ярилцаж хэлэлцээд, дараа нь гарах арга замаа хайж байж өнөөгийн тогтолцоогоо нураах уу, үгүй юү гэдгээ ярих нь зүйтэй байх.

Ж.Уртнасан /“Төсвийн ил тод байдал” хуралдааныг даргалагч/:

Өнөөдөр хоёр цаг хурал даргалсаны хувьд ганц нэг үг хэлье гэж бодож байна. Саяхан болтол төсөв гэдэг далдын хар малгайтай хүн шиг байлаа. Төрийн нууцад хамаардаг гээд хэн ч үзэж харж чаддаггүй. Яаж төлөвлөж, яаж хэрэгжиж байгаа, бас яаж тайлагнах нь нууц байсан юм.

Харин одооноос энэ мөс хайлж, Монгол оронд ардчилал хөгжин, бид энэ талаар мэдээлэл авдаг, үгээ хэлдэг, хянадаг болж байгаа нь сайшаалтай хэрэг л дээ. Энэ нь өнөөдрийн тавьсан илтгэл, хүмүүсийн хэлснээс тодорхой харагдаж байна.

Гангар шаазанг ямар ч тэнэг хага шидэж болдог ч түүнийг хийдэг нууцыг одоо болтол хэн ч мэдэхгүй хэвээр байгаа. Түүнтэй адил ардчилал, шилжилтийн үе дууслаа гээд ярих биш, олон жилийн тогтолцоо, өөрийн орны уламжлал, түүхэн зан заншилд тулгуурлаж өөрийн төсвөө өөрийн хэм хэмжээгээр төсөвлөдөг, хариуцдаг байвал сайн сан.

Улаанбаатар хотод болж байгаа юм манай хөдөө орон нутаг, аймаг, сум дээр очихоор их будлиантай. Ганцхан жишээ хэлье. Урьд Төв аймгийн Эрдэнэ сум, Баяндэлгэр, Архус сум тус тус 150 хүүхдийн сургуультай, 100 ортой эмнэлэгтэй байсан. Одоо үүнийг хэн ч тоохгүй. Яагаад гэвэл Улаанбаатар хот, Багануур гээд хоёр талд нь том хот бий болчихсон учраас эдгээр сумын төсөв нь, нийтийн аж ахуй, тээвэр, эмнэлэг, сургуулийн асуудал нь шийдэгдчихсэн. Үүнийг тэгшитгэн хуваах зарчмаар хуваавал бид ямар үр дүнд хүрэх вэ дээ. Хаа хаанаа бодууштай. Ялангуяа орон нутгийн удирдлагууд энд оролцож буй учраас үүнийг хэлж байгаа юм. Энэ хэдэн төгрөгөө юунд зарах вэ гэдгийг оновчтой төлөвлөж, авилгал хээл хахууль, эдийн засгийн бүлэглэлээс сэрэмжтэй байхыг ард түмэнд анхааруулж байгаа хэрэг.

ГАЗАР ОЛГОЛТЫН ИЛ ТОД БАЙДАЛ САЛБАР ХУРАЛДААН

Гуравдахь хэсэг буюу “Газар олголтын ил тод байдал” салбар хуралдааныг “Очирбат” сангийн тэргүүн П.Очирбат даргалан явуулав. Энэ сэдвийн хүрээнд Нийслэлийн Газрын албаны дарга Б.Төмөрхуяг “Газар олголтын ил тод байдал”, Хуульч эмэгтэйчүүдийн холбооны гүйцэтгэх захирал Х.Оюунцэцэг “Газар олголтын ил тод байдалтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт”, “Үндэсний Соёмбо” хөдөлгөөний төлөөлөгч О.Эрдэнэ-Өлзий “Газар олголтын асуудлыг иргэд хянах боломж” илтгэлүүдийг тавьж, дараа нь хэлэлцүүлэг өрнөлөө.

ГАЗАР ОЛГОЛТЫН ИЛ ТОД БАЙДАЛ

НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН АЛБАНЫ ДАРГА Б. ТӨМӨРХУЯГ

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе!

“Нээлттэй Нийгэм Форум”-аас төр, захиргааны болон мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэд, олон нийтийн төлөөллийг оролцуулан нийгмийн өмнө тулгамдсан чухал чухал сэдвүүдээр хэлэлцүүлэг, ярилцлага, семинар, мэтгэлцээн байнга зохион байгуулж, асуудлыг шийдвэрлэх арга замын талаар санал зөвлөмж гаргаж байдагт нийслэлийн удирдлага талархалтай хандаж байдаг билээ.

Монгол улс ардчилсан нийгмийн тогтолцоо, чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэн өнгөрсөн 16 жилийн хугацаанд газрын харилцааны шинэтгэлийн бодлого тодорхой болж, газрын харилцааны эрх зүйн орчин бүрэлдэн тогтов. Газрын харилцааны багц хуулиуд шинээр болон шинэчлэн найруулсан хэлбэрээр батлагдаж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх баталгаажиж, “газар өмчлөх” гэсэн цоо шинэ ойлголт гарч ирэв. Өнгөрсөн хугацаанд газрын асуудал нийгмийн суурь харилцааны нэг болон төлөвшиж, газрын үнэ цэнэ улам бүр нэмэгдэж, улс орны эдийн засагт чухал нөлөөтэй хүчин зүйл болов.

Газар эзэмшиж, ашиглан, түүнийг эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар ашиг шимийг нь хүртэх гэсэн иргэдийн сонирхол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, энэ нь нийслэл хотод бүр ч илүү байна.

Монгол Улсын газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг Улаанбаатарын бүсэд 2005 оны байдлаар улсын нийт хүн амын 37.7 хувь нь оршин сууж байна. Бүсийн хүн амын 94.1 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн хэсэг нь хаяа хот, тосгодод амьдарч байна. Улаанбаатарын бүсийн 470444.0 га газрын дөнгөж 6 хувийг хот тосгон, суурины ангиллын газар эзэлж байгаа юм.

Хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирэгсдийн тоо байнга нэмэгдэж, хотын газрын нөөц жил ирэх тусам багасч байгаатай холбоотойгоор газрын эрэлт хэрэгцээ ийнхүү өсч байна. Дэд бүтэц сайтай, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийгмийн бусад үйлчилгээнд ойр газарт амьдрахыг хэн ч болов хүсэх нь зүйн хэрэг. Хот хаяагаа тэлэхийн хэрээр хотын төвд, ашигтай газарт байрлалтай үл хөдлөх эд хөрөнгийн үнэ улам бүр нэмэгдэж байна. Юм юмандаа ойрхон, дуу чимээ багатай, цэвэр эрүүл агаартай орчинд орон сууцны барилга барьж худалдах, хүн ам шигүү суурьшсан олны хөлийн газарт дэлгүүр, гуанз, баар цэнгээний газар ажиллуулах нь өнөөдөр хамгийн ашигтай бизнес болж, иргэд, бизнесийнхэн энэ зүгт хошуурах болсныг буруутгах аргагүй юм.

Эрэлт, нийлүүлэлтийн хууль газрын харилцаанд ч үйлчилж, газрын төлөө хэн хүнгүй тэмцэж байгаа нь өнөөдөр нууц биш болжээ. Ашигтай учраас, цаашид ашиг үр шим нь улам бүр нэмэгдэх магадлалтай тул иргэд багахан ч болов газар олж авахын төлөө чадах бүхнээ хийх болов.

Ийм нөхцөлд Нийслэлийн төр, захиргааны байгууллагаас явуулж байгаа бодлого тодорхой, үйл ажиллагаа нь ил тод байх учиртай гэж хотын удирдлага үздэг юм.

Улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зорилтын үүднээс нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөр, Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө зэрэг тулгуур баримт бичгүүдийг боловсруулж, Засгийн газраар батлуулан хэрэгжүүлж байна. Дээрх баримт бичгүүдийг үндэслэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан ажиллаж байна. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтыг тусган түүний дагуу газар олголтын асуудлыг шийдвэрлэж байгаа билээ.

“Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”, “Нийслэлийн 2006 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын болон Нийслэлийн Газрын албаны вэб сайтад тус тус байршуулан иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж байна. “Нийслэлийн 2006 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г 2006 оны 2 дугаар сард вэб сайтад тавьсан бөгөөд өнгөрсөн хугацаанд 120-иод хүн тус сайтад зочилж, дээрх төлөвлөгөөтэй танилцсан байна.

Үүнээс гадна газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэдэд сурталчлах, тайлбарлан танилцуулах ажлыг байнга зохион байгуулж байна. Энэ оны 5-р сард газрын харилцааны мэргэжил сурталчлах өдөрлөгийг ГХГЗЗГ, Нийслэлийн Газрын албанаас зохион байгуулж, “Монголын хүүхдийн ордон”-д үзэсгэлэн

гаргаж, “тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г иргэд, олон нийтэд сурталчилсан байна. Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулсан яамдын нээлттэй мэдээллийн өдөрлөгийн хүрээнд БХБЯ, түүний харьяа байгууллагууд Сүхбаатарын талбайд 2 өдрийн турш сурталчилгааны ажил зохион байгуулсан бөгөөд энэ ажлын хүрээнд Нийслэл, дүүргийн Газрын алба өөрийн үйл ажиллагааг сурталчилж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэдэд танилцуулах, тайлбарлах ажлыг хийсэн байна.

Нийслэлийн удирдлага, Газрын албаныхан хэвлэл, мэдээллийн байгууллагатай байнга хамтран ажиллаж байгаа бөгөөд Нийслэлийн Газрын албанаас төвийн хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөгчийг оролцуулан уулзалт ярилцлагыг сүүлийн жилүүдэд 2 удаа зохион байгуулав. Энэ үеэр байгууллагын үйл ажиллагаа, цаашдын бодлого зорилтыг танилцуулж, газар олголт, газрын зөрчил маргааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгч, сэтгүүлч сурвалжлагчдын сонирхсон асуултад хариулж, харилцан санал бодлоо солилцов. Нийслэлийн Газрын албанд хэвлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ажилтны орон тоо бий болгож, хэвлэл, мэдээллийн байгууллагад мэдээ мэдээлэл өгөх, хэвлэлийн нийтлэлийн мөрөөр ажил зохион байгуулах талаар илүү анхаарлаа хандуулан ажиллаж байгаа билээ.

Нийслэл, дүүргийн Газрын албаны дарга, мэргэжилтнүүд телевизийн шууд нэвтрүүлэгт оролцож, хэвлэлд ярицлага өгөхдөө газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилт, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газар олголтын асуудлаар илэн далангуй ярьж, иргэдэд тодорхой мэдээлэл өгч байгаа юм.

“Газрын тухай” шинэчлэн найруулсан хууль 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж байгаа бөгөөд энэ хуулийн өмнөх хуулиас ялгагдах зарчмын онцлог нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад аж ахуйн зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг зөвхөн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах зарчмаар олгож байхаар хуульчилсан явдал юм. Харин иргэний гэр бүлийн хамтын хэрэгцээний болон төсвийн байгууллагын газрыг өргөдөл хүсэлтээр олгож байгаа юм.

2003 оноос хойш газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг 14 удаа зарласан байна. Дуудлага худалдаанд давхардсан тоогоор 412 иргэн, аж ахуйн нэгж оролцож, 109 байршлын 84.5 га газрыг 44 иргэн, аж ахуйн нэгж үйлдвэрлэл, үйлчилгээ, орон сууц, амралт, аялал жуулчлал, фермерийн аж ахуйн зориулалтаар эзэмшиж, ашиглах эрх авсан байна.

Дуудлага худалдаа явагдсан огноо	Зарлагдсан байршлын тоо	Газрын хэмжээ м2	Оролцсон иргэн, аж ахуйн нэгжийн тоо	Ялагчийн тоо
2003.12.22	11	10,580	179	8
2004.3.26	2	10,080	5	1
2004.4.14	5	21,260	5	2
2004.6.8	7	54,900	7	2
2004.6.11	3	25,500	Санал ирээгүй	
2005.9.26	22	52,160	101	17
2005.10.14	8	65,400	9	2
2006.2.27	4	4,800	15	4
2006.6.8	9	106,100	23	3
2006.7.5	6	91,300	Санал ирээгүй	
2006.10.13	8	152,200	Санал ирээгүй	
2006.11.30	5	6,100	54	5
2006.12.6	9	179,200		
2006.12.8	5	5,000		
	109	844,980	412	44

Дээрх хугацаанд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 6 удаа зарлаж 194.8 га газрыг контор, үйлчилгээний барилга барих зориулалтаар олгов.

Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан журамд: ”дуудлага худалдааны зар мэдээг дуудлага худалдаа явуулахаар товлосон өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө, төсөл шалгаруулалтаар газар эзэмшүүлэх зар мэдээг уг ажиллагааг явуулахаас товлосон өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ” гэж заасан байгаа.

Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зар мэдээг олон нийтэд ил тод, шуурхай хүргэхэд юу юунаас илүү анхаарч байна. Газрын дуудлага худалдааны зар мэдээг төвийн өдөр тутмын сонин, телевизүүдээр тогтмол явуулж ирлээ. Жишээ болгож, энэ оны 11-р сарын 30-ны өдөр явуулсан газрын дуудлага худалдааны зар мэдээг хэрхэн түгээсэн, хичнээн хүн мэдээлэл авсан талаар танилцуулъя гэж бодож байна. Дээрх зарлалыг “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Ардын эрх”, “Зууны мэдээ”, “Өглөөний сонин”, “Улаанбаатар таймс” сонинд 6-16 удаа нийтлүүлж, МҮОНТ, UBS, 25-р суваг, ТВ-9,

ТВ-5 телевизээр дүрстэй 10 удаа, дүрсгүйгээр 26 удаа, УБ радио, FM 101.7-аар 6-15 удаа зарлаж мэдээлсэн байна. Дээрх зарыг хэвлэлээс хэдэн хүн олж мэдсэн байж болохыг ойролцоогоор тооцож үзье.

Сонины нэр	2006 оны 4-р улирлын захиалгын тоо	Худалдаагаар зардаг тоо ширхэг	Дуудлага худалдааны зарыг хэдэн дугаарт нийтлүүлсэн	Зарлалыг хамгийн багаар бодоход хэдэн хүн олж үзсэн байх магадлалтай
“Өнөөдөр”	10000	7000	14	108000
“Өдрийн сонин”	13000	700	16	24200
“Ардын эрх”	3000	200	14	5800
“Зууны мэдээ”	7000	800	6	11800
“Өглөөний сонин”	34000	300	10	37000
“Улаанбаатар таймс”	3000	200	16	6200
Дүн	70000	9200		193000

Радио, телевизээр явуулсан зарыг хэдэн хүн үзэж сонссоныг тооцох боломжгүй ч гэсэн газар авах сонирхолтой, дуудлага худалдаанд оролцохыг хүссэн хүн бүхэн мэдээлэл авах бололцоотой байсан гэж үзэж байна.

Түүнээс гадна дуудлага худалдаагаар олгох газрын байршлын схем, баригдах барилга байгууламжийн эскиз, техникийн нөхцөл, шугам сүлжээний зураг зэргийг Нийслэлийн Газрын албанд дэлгэн тавьж, сонирхсон хэнд ч гэсэн үзүүлж тайлбарлаж, хувилан өгч байна.

Газрын дуудлага худалдааг нээлттэй явуулж байгаа бөгөөд сонирхсон хэн ч гэсэн оролцох, ирж ажиглах бололцоотой байгаа. Засгийн газраас баталсан журамд зааснаар газрын дуудлага худалдаанд оролцогч, ажиглагчдаас хураамж авах ёстой бөгөөд борлуулсан тасалбараар тооцож үзэхэд өнгөрсөн 14 удаагийн дуудлага худалдааг 300-аад хүн ирж сонирхсон байна. 2003 оноос хойш зохион байгуулсан газрын дуудлага худалдаанд хэвлэл, мэдээллийнхнийг байнга урьж, явцыг сурвалжлуулан, дүнг мэдээлж байгаа билээ.

Иргэдийн амины орон сууц, хашааны газар болон төрийн байгууллагуудын хэрэгцээний газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаас гадуур, тэдний санал хүсэлтийг судлан, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу олгож байгаа тухай дээр ярьсан. 2003 оноос хойш хорооны Засаг дарга, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор, сургууль, эмнэлэг, ҮХЯ-ны харьяа агентлагуудын нэгдсэн байр, УМХГ-ын лаборатори, ҮТЕГ-ын контор, СХД-

ийн Эрүүл мэндийн нэгдэл, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын нэгдсэн байр, Цагдаагийн академийн сургалтын полигоны газрыг олгож шийдвэр гаргасан байна.

Түүнчлэн Хужирбулан, Бэлх, Өлзийт, Тахилт, Баруунтуруун, 361-ийн гарам зэрэг газруудад шинэ суурьшлын бүс үүсгэн, иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар олгож, эзэмшүүлж, өмчлүүлсэн байна.

Эцэст нь нэг зүйлийг зориуд тэмдэглэхийг хүсч байна. Газрын тухай шинэчлэн найруулсан хууль хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2003 оноос өмнө олгосон газруудад барилга байгууламж барих ажил одоо ид явагдаж, нэлээд хэсэг нь барилгаа бариад ашиглалтад оруулж байна. Үүнийг иргэд, олон нийт буруу ойлгож, хэсэг бүлэг хүмүүс хуйвалдан дуудлага худалдаа, төсөл шалгаруулалтад оруулахгүйгээр газар олгосон юм шиг ярьж бичих юм.

Нийслэлийн хэмжээнд газар олголтын байдал төр, иргэний хараа хяналтын дор, хуулийн дагуу хэрэгжиж байгаа. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөг жил бүр хэлэлцэн баталж, түүний хэрэгжилтийн байдалд тогтмол хяналт тавин ажиллаж байна. НИТХ-ын дэргэд Газрын асуудал эрхэлсэн хороо байгуулж, газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, газрын зөрчил маргааны асуудалд анхаарлаа хандуулан идэвхтэй ажиллаж байгаа билээ. Нөгөө талаар, сүүлийн үед иргэний хөдөлгөөн, СӨХ, оршин суугчдын зүгээс Нийслэлийн хэмжээнд газар олголтын байдалд хяналт тавьж, НИТХ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулан тодорхой газруудад шалгалт хийх зэргээр ажиллаж байна.

Иймд нийслэл Улаанбаатар хотод газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх ажил хуулийн хүрээнд, төр, олон нийтийн хяналтын дор, ил тод, нээлттэй явагдаж байгаа гэж хэлэх бүрэн үндэстэй юм.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ГАЗАР ОЛГОЛТЫН ИЛ ТОД БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

МОНГОЛЫН ХУУЛЬЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБООНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х. ОЮУНЦЭЦЭГ

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” хэмээн газрын эрх зүйн үндсийг тодорхойлсон бөгөөд зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийг эрх зүйн хувьд баталгаажуулах шинэтгэлийн хүрээнд Улсын Их Хурал /УИХ/ 2002 оны 6-р сарын 7-нд “Газрын тухай”, 2002 оны 6-р сарын 28-нд “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хууль батлан гаргаж мөрдүүлсэн билээ. Эдгээр хуулийн дагуу гагцхүү төрийн өмчлөлд байсан газрыг иргэд хувьдаа өмчлөн авч, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж, орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх, улмаар ядуурлыг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар олгох гэдэг ойлголт нь:

- Эзэмшүүлэх
- Ашиглуулах
- Өмчлүүлэх /зөвхөн Монгол улсын иргэнд хамаарах бөгөөд гэр бүлийн хэрэгцээ болон газар тариалангийн зориулалтаар өмчлүүлнэ/ хэлбэрээр илэрнэ.

Газрын тухай хуулийн 3.1.3.-т "газар эзэмших" гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг; 3.1.4.-т "газар ашиглах" гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг; Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 3.1.2.-т "иргэнд газар өмчлүүлэх" гэж Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэнд өмчлүүлж болохоор заасан газраас энэ хуульд заасан хэмжээ, болзол, шаардлага, журам, нөхцлөөр иргэний өмчлөлд шилжүүлэхийг тус тус ойлгоно гэж заажээ.

Газрыг эзэмших, ашиглах, өмчлөх ойлголтуудаас хамааран газар олголтын үе шатууд, зориулалт, олж авч байгаа субъектуудын эрх зүйн зохицуулалт өөр өөр байна.

Газрын тухай хуулийн 30.1-т зааснаар “Газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 15-60 жил хүртэл хугацаатайгаар эзэмшүүлж болно.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг нэг удаад сунгах хугацаа 40 жилээс илүүгүй байна”

Газрыг олгох төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд:

- Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны засаг дарга, ИТХ, баг, хорооны ИНХ
- Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
- Аймаг, нийслэлийн газрын алба, сумын газрын даамал

2002 оны Иргэний хуульд барилга, байгууламж барих эрх болон уг эрх нь иргэний эрх зүйн объект болохыг хуульчлан тодорхойлсон нь уг эрхийн хүчинтэй байх хуульд заасан 60 жил (цаашид 99 жил хүртэл хугацаагаар сунгаж болох)-ийн хугацаанд эзэмшиж ашиглах, түрээслүүлэх, барьцаалуулах зэргээр иргэний гүйлгээнд чөлөөтэй оролцуулах боломж бүрдүүлсэн. Энэ нь гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, газрын талаарх эрхээ хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой зохицуулалт болсон юм.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар олгох харилцааг дараах хууль, тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

1. Иргэний хууль, 2002 он
2. Газрын тухай хууль, 2002 он
3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 2002 он
4. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2002 он
5. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, 1999 он
6. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай, 2003 он
7. Барилгын тухай, 1998 он
8. Хот байгуулалтын тухай, 1998 он
9. Засгийн газрын 2003.02.07-ны өдрийн “Хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний талаар” тогтоол №28
10. Засгийн газрын 2003 оны “Аргачлал, үнэлгээ батлах тухай” тогтоол №103
11. Засгийн газрын 2003 оны “Журам батлах тухай” тогтоол №213 “Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны үйлчилгээний хөлс, түүний орлогыг захиран зарцуулах журам”
12. Засгийн газрын 2004 оны “Журам батлах тухай” тогтоол № 48 “Эд хөрөнгийн улсын бүртгэгчийн ажиллах журам”
13. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дүрэм

14. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2003 оны “Журам батлах тухай” тушаал №165 “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”
15. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2003 оны “Аргачлал батлах тухай” тушаал №218 “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”
16. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2003 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тушаал № 157 гэх мэт.

Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо 2006 онд Монголын Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад барилга, байгууламж барих зорилгоор газар олгох төрийн үйлчилгээнд мониторинг хийх нь” төслийг хэрэгжүүлсэн юм. Уг мониторингийн үр дүнг дараах байдлаар дүгнэж болно.

- Газрын асуудал эрхэлсэн төр захиргааны байгууллага, иргэдийн хооронд газар өмчлөх, өмчлөх эрхээ сэргээлгэх, бусдад шилжүүлэх, эзэмшүүлэн ашиглуулах үйл ажиллагаанд дээрх хуулиудын заалт зөрчигдсөн тохиолдол олон гарсан. Нөгөө талаар иргэдэд үйлчилгээг ойртуулж, санаачилгыг нь өрнүүлэх механизм байхгүйгээс иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх хугацааг 2008 оны 5-р сарын 1-эн хүртэл сунгасан байна.
- Газар эзэмших эрх олгох үйл ажиллагаа эрхэлдэг төрийн байгууллагуудын хүнд суртал, шат дараалал, “гар харах”, авилгалд өртөх зэрэг сөрөг үзэгдлүүд нь иргэдийн эрх ашгийг зөрчиж, төрийн үйлчилгээний чанар, үр өгөөжийг бууруулж байна. Тухайлбал, газар эзэмших хугацаа нь хуулиар 15-60 жил байна гэсэн атал газар эзэмших эрх болон гэрээг бодит байдал дээр 2-5 жилээр байгуулж иргэдийг чирэгдүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, 2 жил тутам гэрээг сунгахыг шаардаж авилгалын зах зээлийг бий болгож байна. Газар эзэмших эрх сунгах ажиллагаанд ч мөн ийм байдал ажиглагдаж байв. Тухайлбал, эрх бүхий засаг дарга өөрийн үзэмжээр хугацааг сунгаж байгаа тул нэг удаад 10-аас доошгүй, 40-өөс дээшгүй жил шууд сунгахаар хуульчлах хэрэгтэй байна.
- 2005 оны байдлаар, 1146 иргэн НГА-д хандаж өргөдөл, гомдол, санал ирүүлсний 284 нь УИХ-ын гишүүд, Засгийн газрын хэрэг эрхлэх газар /ЗГХЭГ/, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид /НИТХТ/, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улаанбаатар хотын Ерөнхий менежер, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраар уламжлагдан иржээ. Дээд шатанд гаргасан гомдлыг доод шатны байгууллагын даргад буцаан хүргүүлдэг журам үйлчилдэг учир өмнө нь гаргасан шийдвэрээ хамгаалаад л дуусдаг аж. Иймд маргаан шийдвэрлэх журмыг шинэчлэх шаардлагатай нь тодорхой байна.
- Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх буюу /ҮХХБУА, газрын албыг нэгтгэх замаар/ нэгдсэн бүртгэлийн байгууллага хийх учиртай. Газрын тухай хуулийн 31.3-т “Хүсэлт гаргасан газар нь бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай

ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна” гэсэн заалт зөрчигдөж, нийслэл, дүүргийн засаг даргын газар олголт хэсэгчлэн болон бүхэлдээ давхарддаг байна. Хууль тогтоомжид зааснаар дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ бүхий газар буюу ирээдүйд холбогдохоор төлөвлөгдсөн газрыг аймаг, нийслэлийн үлдсэн газруудад дүүрэг, сумын засаг дарга нар газар олгодог. Хэдийгээр хуулиар энэхүү засаг дарга нарын эрх мэдлийг зааглаж өгсөн боловч Нийслэлийн засаг дарга /НЗД/ нь Дүүргийн засаг дарга /ДЗД/-ын бүрэн эрхэд халдах тохиолдол давамгайлж байна. Газар олголтын нэгдсэн мэдээллийн сан байхгүйгээс сум, дүүргийн засаг дарга нар газар давхардуулан олгосон тухай маргаан түгээмэл гарчээ. Уг асуудлыг НЗД-ын захирамжийг хүчингүй болгох байдлаар шүүх шийдвэрлэж байна. Түүнчлэн дүүргийн газрын албанаас авсан газар эзэмших эрхээ улсын эрхийн бүртгэлд бүртгүүлэх тухай хуулийн заалт байдаг ч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд бүртгүүлдэггүй учир нэг газрын эзэмших эрхийн гэрчилгээг алга болсон нэрийдлээр хэд хэдэн удаа авч улмаар түүнийгээ хэд хэдэн банк, Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/, Хадгаламж зээлийн хоршоо /ХЗХ/-д барьцаалах тохиолдол байнга гарч байна. Иймд хуульд заасан улсын бүртгэлийг бүх түвшинд хийх нь зүйтэй юм.

- Бидний хийсэн тооцоогоор газрын зөвшөөрөл авч, барилга барихад давхардсан тоогоор 60 гаруй албан тушаалтны гарын үсэг шаардлагатай байдаг. Комиссын шийдвэр гаргах, дүгнэлт өгөх, гарын үсэг зурж эцэслэн батлах хугацааг нарийвчлан тогтоогоогүйгээс хүнд суртал гаргах, “гар хүндрүүлэх” шаардлага гардаг гэж ярилцлагад оролцсон зарим иргэд гомдоллож байлаа. Эдгээр 60 хүний гарын үсэг, зөвшөөрлийг авахад дунджаар 2.5 жил зарцуулах бөгөөд харин уг газар дээр 10 сарын хугацаанд барилга барих бололцоотой байдаг аж. Барилга барих зөвшөөрөл авах нь барих хугацаанаас 3 дахин урт байна. Ийнхүү хүнд суртал ихтэй төрийн үйлчилгээнээс залхсан, нөгөө талаар танил тал харж, шан харамж өгч, асуудлыг түрэмгийлэн шийдвэрлэдэг байдал газар авсан тул зөвшөөрөлгүй баригдсан барилга байгууламжийн амнист /өршөөл/-ийн асуудлыг хэлэлцэх хэрэгтэй мэт санагдаж байна. Өөрөөр хэлбэл өнөөгийн хэмжээнд иргэд, байгууллагын зүгээс хөрөнгө оруулалт хийж баригдсан, холбоо, дулаан болон бусад шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн хувьд зөрчилгүй баригдсан барилгад газрын төлбөрөө хийх болзолтойгоор хялбаршуулсан журмаар газрын зөвшөөрөл, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ /ҮХЭХБГ/-г олгож болох юм. Ингэснээр эдгээр этгээдүүд ч өөрийн хөрөнгийг баталгаажуулах, түүнийгээ зээлийн барьцаанд тавих зэргээр алдагдсан боломжийг нөхөж болно.
- Орон сууцны нэгдүгээр давхрыг бизнесийн зорилгоор өргөтгөх, нэмэлт барилга байгууламж барих тохиолдолд Нийслэлийн ерөнхий менежер тушаал гарган, зөвшөөрөл олгодог. Гэтэл газар олголт хийгдсэн гэж үздэггүй учир газрын төлбөр авах эрх зүйн үндэслэл байхгүй гэж үзэж газрын төлбөр ногдуулдаггүй. Түүнээс гадна эдгээр нэмэлт барилгын техникийн шаардлага, барилгын аюулгүй байдалд нөлөө үзүүлж болох эсэхэд төрийн хяналт муу хийгддэг ба улсын комисс хүлээж авахыг

хуулиар шаарддаггүй. Барилгын тухай хуулинд нэмэлт барилгын талаарх зохицуулалт байдаггүй ба гаднах заслын өнгө үзэмж, дизайн, шаардлагын талаар нэгдмэл бодлого байхгүй, хотын үзэмж, архитектур төлөвлөлтийн бодлого хэрэгжихгүй байна. Түүнчлэн гараж, автомашины ил зогсоол, худалдаа үйлчилгээний цэгүүдийн газар эзэмшлийн асуудал хуульчлагдаагүй байдаг. Дээрх зориулалтаар дуудлага худалдаа явуулах, төсөл сонгон шалгаруулах зарчмаар эрх бүхий этгээдэд сум, дүүргийн засаг даргын шийдвэр, гэрээний үндсэн дээр түр ашиглуулж болно. Хугацаа нь 2 жил хүртэл байж болох ба нөхөн олговоргүйгээр олгож болох юм гэж үзэж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд:

1. Газрын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа зөрчил дутагдлыг хянан шийдвэрлэдэг хурдан шуурхай, төрийн болон газар, хот байгуулалт, хуулийн чиглэлийн мэргэжлийн мөн хуулийн /шүүхээс бусад, өмгөөллийн болон их дээд сургуулийн эрдэмтэн, шинжээч зэрэг/ байгууллагын /ТББ, мэргэжлийн холбоо/ оролцоо бүхий, байнгын ажиллагаатай, хурдан шуурхай, мэргэжлийн өндөр түвшинд шийдвэр гаргах чадвартай маргаан шийдвэрлэх тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Өнөөгийн байдлаар дүүргийн засаг дарга, газрын албаны хэлтэс, газрын дарга нараас бүрдсэн байнгын бус ажиллагаатай маргаан таслах комисс нь эрх зүйн статус, үйл ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтгүй байгаа учраас комиссоос гарсан шийдвэр эрх зүйн хувьд хүчин төгөлдөр болж чадахгүй байна.
2. Хүнд суртал, зөрчил дутагдлыг арилгах хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор гарч байна.
3. Иргэнд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг ил тод шийддэг болгох.
4. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон кадастрын зураг нь олон нийтэд нээлттэй, ил тод биш учраас сонголт хийх боломжгүй зэрэг нөхцөл байдлууд бий болсноос иргэн хүн хуулийн дагуу газар өмчлөх, эзэмших эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадахгүй байх зэрэг асуудлууд гарч байна. Учир нь илт хууль зөрчиж бариагүй хашаа байшин, “зуслангийн” харшуудыг албадан буулгах, нүүлгэхэд төрөөс олгох нөхөн олговрын эх үүсвэрийг хаанаас олох нь ойлгомжгүй байгаа тул уг асуудлыг эцэслэн шийдвэрлэх.
5. Газар өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээг авах үйл ажиллагаа нь барилга байшин зэрэг үл хөдлөх хөрөнгийн бүртгэлээс тусдаа явагдаж байна. Энэ утгаараа иргэн, байгууллага газар эзэмших эрх мөн барилга байшингаа өмчлөх эрхээ баталгаажуулахын төлөө Газрын алба болон Үл хөдлөх Эд хөрөнгө болон түүнтэй холбогдох эрхийн улсын бүртгэлийн албанд давхардсан процессыг туулж, Үл хөдлөх эд хөрөнгийн татвар болон газрын татвар, төлбөрийг мөн давхардуулан төлж байна.

6. “Газардээрхобъектөмчлөгчийнхболно” гэсэн заалтөнөөгхүртэлүйлчилж байна. Түүнчлэн дундын орон сууцны байрны доорх газар нь нийтийн буюу нийслэл, аймгийн /сум/ хөрөнгө байгаа өнөөгийн зохицуулалт хотын Засаг даргын үзэгний үзүүрээр олон хүний амьдрал ахуйг шийдэх өргөн эрх мэдлийг олгож байгаагаас жишээлбэл цэцэрлэгийн талбайд байшин барих эрх олгож байна.
7. Өнөөгийн хэмжээнд иргэд, байгууллагын зүгээс хөрөнгө оруулалт хийж баригдсан, холбооны, дулааны болон бусад шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн хувьд зөрчилгүй баригдсан барилгад газрын төлбөрөө хийх болзолтойгоор хялбаршуулсан журмаар газрын зөвшөөрөл болон ҮХЭХБ-ийн гэрчилгээг олгож болох юм. Ингэснээр эдгээр этгээдүүд ч өөрийн хөрөнгийг баталгаажуулах, түүнийгээ зээлийн барьцаанд тавьж, цаашид хөдлөх зэргээр алдагдсан боломжийг нөхөж болох юм.
8. Газар олгосон тухай Засаг даргын захирамж гарсан боловч газрын алба нь гэрээ байгуулж, газар эзэмших тухай гэрчилгээг олгохгүй хүнд суртал гаргадаг тул гэрчилгээ олгох хугацааг хуульчлах хэрэгтэй байна. Газрын тухай хуульд газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгах хугацаа 40 жил хүртэл буюу доод хугацаа байхгүйгээр заасныг өөрчилж газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгах доод хугацаа 10 жил байх нь зүйтэй юм.
9. Газрын тухай хуульд зааснаар Сууц өмчлөгчдийн холбоонд орчны газрыг нь ашиглуулахад орчны газрын ерөнхий төлөвлөгөөг батлах шаардлагатай бөгөөд үүнийг орон нутгийн Газрын алба болон хот байгуулалтын алба хоёр хамтран батлахаар зохицуулсан байна. Дээр дурдсан 2 этгээд, эрх бүхий этгээдүүдийн шийдвэрийг зөвхөн хэрэгжүүлэх үүрэг бүхий байх тул СӨХ-д орчны газрыг нь ашиглуулах ерөнхий төлөвлөгөөг орон нутгийн ИТХ баталдаг байх нь Газрын тухай хуулийн ерөнхий зарчимд нийцэхээр байна.
10. Түүнчлэн Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх үүргийнхээ дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлж, ашиглуулахдаа юуны өмнө дээр дурдсан мэдээллийн системээс тухайн газрын талаарх лавлагаа /зөвшөөрөл/-г авсны үндсэн дээр шийдвэрээ гаргадаг байхаар, түүнчлэн Засаг дарга эргээд мэдээллийн системд шийдвэрээ хүргүүлэх бөгөөд түүнийг үндэслэн мэдээллийн системд заавал өөрчлөлт оруулдаг байх, энэ журмыг зөрчиж гаргасан Засаг даргын захирамж хүчингүй байхаар хуульчлах нь зүйтэй.

Газар олгохтой холбоотой ил тод байдлын эрх зүйн орчны талаар та бүхнийг үнэтэй санал гаргана гэдэгт итгэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ГАЗАР ОЛГОЛТЫН АСУУДЛЫГ ИРГЭД ХЯНАХ БОЛОМЖ

“ҮНДЭСНИЙ СОЁМБО” ХӨДӨЛГӨӨНИЙ ТӨЛӨӨЛӨГЧ О. ЭРДЭНЭ-ӨЛЗИЙ

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе!

Иргэдийн бухимдлыг бий болгосон, олон жилээр үргэлжилж байгаа газрын маргаантай асуудлыг шийдвэрлэх гарцыг бий болгоход тодорхой үр дүнгээ өгөх энэ арга хэмжээг зохион байгуулж байгаа Нээлттэй Нийгэм Форумын хамт олонд гүн талархалаа илэрхийлье!

1. Ил тод гэж ярихын өмнө, яагаад бид цаг зав, хөрөнгө мөнгөө үрэн энэ тухай ярилцах болов, газрын маргаан гэж юу вэ? Энэ үнэхээр нийгмийн бухимдал төрөх асуудал мөн үү гэдгийг харахыг оролдоё.

- Ээжээ би гадаа гарч тоглоё л доо...гэх тоглоомын талбайгаа нэхсэн хүүхдийн тоо олширсоор эцэг эхчүүд, иргэдийн бухимдал нэмэгдсээр...
- Аливхүүминьгадаагарчтолгойгоосэргээхюмсан...гэхгавъяаныамралтандаа суугаа ахмадууд маань тухлах газаргүй болсондоо бухимдсаар...
- Манайх нар үзэхээ болилоо доо яана аа..., хөөе наад орцны хаалга онгойлгооч..., хүүхдийн тоглоом устгаад байна... яах вэ...гэсэн төрийн цагдаагаас туслалцаа авч чадахаа больсон иргэдийн бухимдал газар авсаар...
- Би хуулийн дагуу захирамжтай та нар яах юм..., чаддаг юм бол шүүхээр яваад газраа аваарай гэсэн газрын наймаачдын сүлжээ болсон барилгын компанийн эздийн дээрэнгүй байдал ихэссээр
- Та нарын маргаан үндэслэлгүй байна...иргэн бүрт тэгш үйлчлэх шүүх засаглал маань мөнгөтний өмнө хүчгүй болж хууль дүрмээ гууль болгосоор
- Би энэ шанаган дотроос чинь гарахгүй...газар шороогоо хамгаалж, амь насаа ч хайрлахгүй ахмад буурлууд, иргэдийн тэмцэл хурцадсаар
- Өнөөдөр ийм ийм газрын маргаан гарлаа...гэж радио, телевиз, хэвлэл мэдээллээр байнгын хөтөлбөр болсон ч иргэд эрхээ хамгаалж чадахгүй хэвээрээ үлдсээр
- Хэн энэ шийдвэрийг гаргав... гэх мэт иргэдийн бухимдлыг дагуулсан, иргэд хоорондын тэмцлийг бий болгосон, хариуцлагагүй шийдвэрийн золиос болсон үйлдлийг Монголчууд “газрын маргаан” гээд хэвшиж, энэ ч шийдэгдэхгүй дээ гэсэн хулчгар байдалд иргэд маань дасч эхлээд байна.

2. Энэ маргааныг хэн бий болгов? Нийгэм юу хийж байна?

Нийгмийн бухимдал болж, иргэд хоорондын тэмцэл болсон газрын маргааныг үүсгэгч баримт бичиг болох ЗАХИРАМЖ хэний гаргасан шийдвэр вэ? Яагаад иргэд ийм олон жил ялагдал хүлээсэн мөртлөө тэмцээд байдаг юм бэ? гэх мэт асуултуудын хариу болгож иргэд эрх ашгаа хамгаалах, төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод болгохын төлөө тууштай тэмцэж байна. Иргэдийн энэ тэмцэлд иргэний нийгмийн байгууллагуудын дэмжлэг туйлаас чухал байгаа болон төрийн байгууллагуудын энэхүү хууль бус үйлдлүүдийг таслан зогсоохын төлөө “Үндэсний Соёмбо” Хөдөлгөөн газрын маргаантай асуудлаар иргэдийн шударга тэмцлийг дэмжин ажиллаж байна.

Та бүхэнд “Үндэсний Соёмбо” Хөдөлгөөний Нийтлэг үндэслэлээс товч танилцуулж байна.

- Монгол Улсад улс төрчдийн коррупци, авилгал, хээл хахууль, шударга бус явдалд нийгэм бүхэлдээ автагдан, засаглалын гүн хямралд орсныг хүлээн зөвшөөрч,
- Төрийн үйл ажиллагааг элдэв дүрэм журам, тушаал заавраар халхавчлан нууцлах замаар бүх шатны засаглал иргэдийн хяналтаас гарсан нь хямралын үндсэн шалтгаан болсныг тогтоож,
- Иргэний нийгмийн үндэс болсон иргэний хяналттай засаглалыг тогтоох нь хямралаас гарах бодит гарц болохыг тодорхойлж,
- Засаглалын хямрал ужгирч, ядуурал улам урхагшиж, шударга бус байдал нь ард иргэдийн бухимдлыг дээд цэгт хүргэж, төрд итгэл алдахаар үл барам ардчиллын үзэл баримтлал, үнэт зүйлсээс ухрах аюул нүүрлээд байгаа нийгмийн бодит шаардлагад үндэслэн,
- Иргэний хөдөлгөөн, ТББ-ууд засаглалын хямралыг илрүүлж, төр нийгэм дэх гажуудалтай хүчтэй тэмцэл өрнүүлж байгаа боловч тэдний хамтын үйл ажиллагаа тархай бутархай байгааг харгалзан,

Монгол Улсад ардчилсан, нээлттэй, иргэний засаглал буюу тунгалаг засаглалыг тогтоохыг эрхэм зорилго болгон тэмцэхээр иргэний нийгмийн байгууллага, хөдөлгөөнүүд нэгдэн “Үндэсний Соёмбо” Хөдөлгөөнийг байгуулан ажиллаж байна.

“Үндэсний Соёмбо” Хөдөлгөөн тэмцлийн хэлбэрийг нэн тэргүүнд тавилгүй, явал МУ-ын хууль, тогтоомжийн хүрээнд энэ асуудлыг шийдвэрлэж болох гарцыг иргэддээ таниулах, хамтран ажиллах зарчмыг баримтлан ажиллаж байна.

Үүнд:

1. Одоогийн байдлаар “Үндэсний Соёмбо” Хөдөлгөөнд газрын маргаантай 42 асуудлаар иргэд эрх ашгаа хамгаалуулахаар хандаад байна. Бид уг асуудлыг шийдвэрлэхийн тулд газрын маргаантай асуудал болгоныг хариуцан сонгогдсон төлөөлөлтэй “Газрын маргаантай асуудал хариуцсан иргэний зөвлөл” байгуулан ажиллаж байна.

2. НИТХ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулж маргаантай бүх газраар явж нөхцөл байдалтай танилцав. Хамтарсан ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, НЗД-д газрын маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлэх хугацаа заасан үүрэг даалгавар өгч хариуцлага тооцох тогтоол, шийдвэр гаргах шаардлагыг НИТХ-ын чуулганд хүргүүлэв.
3. НЗД-тай иргэдийн санал, хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх талаар уулзаж газар олголтод оршин суугчдын санал авдаг байх, СӨХ-той гэрээ байгуулах ажлыг яаравчлах, гэр хорооллыг барилгажуулах газар олголтын асуудлуудыг түлхүү анхаарах, Монгол Улсын хууль, УИХ, Засгийн газар, НИТХ-ын тогтоол шийдвэрүүдийг эрчимтэй хэрэгжүүлж газрын маргаантай асуудлуудыг эцэслэн шийдвэрлэхийг санал болгов.
4. Газрын тухай МУ-ын хууль, тогтоол, бусад эрх зүйн баримтад судалгааны баг ажиллуулж байна.
5. Гарц санал болгож байна, хариуцлагыг сануулж байна.
6. Хүүхдийн тоглоомын талбайн газар олголтон дээр хяналт тавих, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 12 хүүхдийн байгууллага нэгдсэн Хүүхдийн эрх хамгаалах эвсэл байгуулав.
7. ННХ-н шугамаар МХЭХХ төв, ХЭХ, ЭҮСТ зэрэг байгууллагууд төсөл хэрэгжүүлэн үнэн зөв дүгнэлтүүдийг гаргажээ.

3. Яагаад шийдэгдэх боломжгүй байна? Нийгмийн баялгийг иргэд тэгш хүртэж чадаж байна гэж үү?

Монгол Улсад хууль, гууль болжээ гэдгийн зөвхөн нэг жишээ нь газрын маргаантай асуудал юм. Яагаад энэ их зөрчлийг нийгэмд авчирч байна вэ?

а. Газар бол маш үнэ цэнтэй нийгмийн баялаг. Гэвч улс төрөөр хамгаалуулсан, хуулийг гууль болгодог тодорхой албан тушаалтны шийдвэр нь газрыг авилгал, хээл хахуулийн гол сүлжээний нэг болгожээ. Газрын үнэ цэнийн тухай нэг жишээ дурдъя, дөнгөж сая хүүхдийн тоглоомын нэг газар 96 сая төгрөгөөр дуудагдаж байна. Энэ бол зөвхөн газар дор гарааж барих нөхцөлөөр авч байгаа газар, өнгөрсөн хугацаанд мөнгө төлөлгүй энэ их үнэ цэнэтэй баялгийг ЗАХИРАМЖААР хэдхэн барилгын компанид өгсөн, одоо өгч байна гээд бод доо... Яагаад энэ их үнэ цэнтэй баялгийг хуваарилахад иргэд тэгш эрхтэй оролцож чадахгүй байна вэ гэдэг нь асуудлын гол бус болж харин газрын наймааны бүлэглэл хэдий хэмжээний эдийн засгийн хохирлыг улс оронд авчрав, энэ сүлжээг хэрхэн таслан зогсоох вэ гэдэг нь нийгэм, иргэдийн анхаарал татсан асуудал болоод байна.

“Ардчилал” сонин дээр гарсан шиг 50 тэрбум ам.долларын наймаа биш юмаа гэхэд олон тэрбум ам.долларын наймаа гэдэг нь нийгэмд тодорхой болоод байна.

б. Шүүх засаглалд хандсан нэг ч иргэн газрын маргаантай асуудлаар ялалт байгуулж чадаагүй, өмгөөлөгчдөд хэдэн төгрөгөө өгөөд шүүхийн өмнө гэм буруутан болоод өнгөрч байна.

в. Нийслэлийн Засаг дарга, Дүүргийн Засаг дарга нар бүтээн байгуулалт гэдгээр энэ асуудлыг далдалж байна. Гэвч энэ бүтээн байгуулалт нийгмийн шинжтэй болон иргэдийн эрүүл мэнд, үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн, амьдрах тав тухыг алдагдуулсан, мөнгөөр үнэлж баршгүй хохирол авчирч байгаад иргэний байгууллага, иргэд тун бага ойлголттой байна. Улаанбаатар хотод сая шахам иргэд оршин сууж байгаагийн 410.4 мянга нь 0-14 насны хүүхэд байна.

Өсвөр насны хүүхэд хөдөлгөөний хомсдолд орсноор бие бялдар, эрүүл мэндийн хохирлоос гадна сэтгэхүйн ноцтой хохиролд ордгийг НЭМБ-ууд судалгаагаар гаргадаг, бичдэг боловч амьдрал дээр хэн үүнийг нийгэмд ойлгуулах, төрийн байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэх, иргэдийн өмнө хариуцлага хүлээх ёстой юм бэ, Засаг дарга нар шүү дээ... Үүнийг ажилдаа мөрдлөгөө болгоогүй бол Засаг дарга нар иргэдийнхээ эсрэг гэмт үйлдэл хийж байна гэсэн үг биз дээ... Хариуцлага хаана байна... байхгүй, жишээ нь: 100 залуучуудаас зөвхөн 30 нь цэрэгт тэнцэж байгаа нь энэ бүгдийн нэг баталгаа, нотолгоо биш гэж үү дээ. Дээр нь хотын утааг нэмэхээр юу болох вэ? Энэ гэмт үйлдэл биш гэж үү...

г. Газрын асуудал хариуцсан байгууллага босоо удирдлагатай, зөвхөн ЗД-ын мэдэлд байдаг учраас ЗД-ын хамгийн найдвартай, итгэлтэй хүмүүс тэр албыг хашиж, нийгэмд өгөх ёстой мэдээллийг нуун дарагдуулж, ил тод ажиллахаас ихээхэн болгоомжилж байна.

д. Улс төрөөр хамгаалуулсан ЗД нарт хэн ч халдаж чадахгүй, ИТХ нь тэдний өмнө хүүхэлдэй мэт болсон нь энэ олон жил газрын маргаантай асуудал шийдэгдэх боломжгүй байсан шалтгаан юм. Тэдэнд хэн ч хариуцлага тооцож чадахгүй өнөөдрийг хүрлээ. Жишээ нь: “УИХ-ын дарга нь, шийдвэр гаргасан цаад нөхдүүд чинь хэрэгжүүлэхгүй юм” гээд л УИХ-ын чуулган дээр яриад сууж байх жишээтэй.

- МУ-ын Үндсэн хууль...
- МУ-ын Газрын тухай хууль
- МУ-ын Эрүүгийн хуулийн 263/1,2/, 264/1,2/ дугаар зүйлүүд
- Авилгалын эсрэг хууль
- УИХ-ын тогтоол, дугаар 43
- НИТХ-ын тогтоол 6/34
- НИТХ-ын тогтоол 227 гэх мэт олон хууль дүрмүүдийг Засаг дарга нар гууль болгож өнөөдрийг хүрч байна.

е. Сүүлийн үед ажиллах арга нь нарийсч иргэний байгууллагуудтай хамтарч ажиллаж байгаа нэр зүүж, тавьсан шаардлагыг нь биелүүлэхийн төлөө бус, цаг хожих, тэдний үйл ажиллагааг саармагжуулахыг зорих болжээ.

За ингээд нийгэм өөрөө энэ тухай ярьж, шүүмжлээд олон жил болж байгаа асуудлыг та бүхэнд дахин давтсан учир нь, “Үндэсний Соёмбо” Хөдөлгөөн НИТХ-тай хамтран ажиллах явцдаа явган яриа бодит үнэн юм байна гэдгийг баталсанд байгаа болно.

4. Одоо яах вэ? Ингээд л хоосон гомдоллоод байх уу, энэ бүгдийг таслан

зогсоох уу, бидэнд тийм боломж байна уу гэдгийг л ярилцах гэж өнөөдрийн арга хэмжээ маань болж байгаа. Иймд Үндсэн хуулиар олгогдсон үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэх, МУ-ын хууль тогтоол болон бусад эрх зүйн шийдвэрийг хэрэгжүүлэхийг төрийн алба хашигч нарт шаардъя, нийгэм хариуцлагаа тооцож чаддагийг иргэний байгууллагуудын хамтын ажиллагаагаар харуулья. “Үндэсний Соёмбо” Хөдөлгөөн газрын маргааныг эцэслэн шийдвэрлэхэд доорх гарцыг үр дүнгээ өгнө гэж найдан та бүхэндээ хандаж байна.

Гарц: Иргэний байгууллагууд НЗДТГ-ын үйл ажиллагаанд ил тод байдлыг бий болгох “Иргэний зөвлөл” байгуулан ажиллах. Энэ бол ямар нэг бүтцийн тухай биш, Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх механизм юм.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

1. Нийслэл, дүүргийн үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах. Иргэний хяналтыг төлөвшүүлэх
2. Төрийн байгууллагын үйл ажиллагааг шуурхай, хүнд сурталгүй болгох
3. Төрийн албан хаагчдад хариуцлагын тогтолцоог бий болгох
4. Нийгмийн Эрүүл мэндийн бодлого хөгжлийн бодлоготой салшгүй байх тогтолцоог бий болгох

Энэ ажлыг зохион байгуулах, санхүүжүүлэх төсөл боловсруулан ажиллах саналыг “Үндэсний Соёмбо” Хөдөлгөөн тавьж байгаа бөгөөд Нээлттэй Нийгэм Форум болон бусад байгууллага, хамт олон, иргэд дэмжин, хамтран ажиллана гэж найдаж байна.

Хүрэлцэн ирсэн хүмүүст хүндэтгэлээ илэрхийлэхийн ялдамд газрын маргаантай асуудлыг таслан зогсооход хамтран ажиллахыг уриалж байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Д.Мижиддорж /31-р сургуулийн ахмад багш/:

Газрын маргаантай асуудал нь хүүхдүүдэд их хохирол учруулж байгаа. Яагаад гэвэл ЕБС-иудын биеийн тамирын талбай, орон сууцны хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын талбайг булааж аваад дуусч байна. Гэтэл Үндсэн хуульдаа хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулна гэж заасан. Өнөөдөр хүүхдийнхээ эсрэг ийм үйл ажиллагаа явуулж байгаа төр засаг яаж иргэний ардчилсан нийгмийг байгуулах юм бэ.

Газрын асуудлаар Ерөнхий сайд Энхболдыг гурван удаа шүүхэд өгсөн. Гурвууланг нь түдгэлзүүлсэн. Харин 31-р сургуулийн газартай холбоотой асуудлаар сонинд нийтлэл бичсэн сэтгүүлчийг шүүхэд өгч, энэ хэрэг нь Энхболдын талд шийдвэрлэгдсэн. “Зууны мэдээ” сонин дээр Энхболдод тусгай хууль гаргая гэж бичсэн байна лээ. Тэгвэл Ерөнхий сайд Энхболдоос бусад нь хуульд захирагдана гэсэн хуулийг гаргах гээд байна уу. Арай үгүй байх аа. Үнэхээр Ерөнхий сайдад хууль үйлчлэхээ байжээ.

Сайн хүний нэрийг гурав худалдана гэдэг. УИХ-ын гишүүн Мөнх-Оргил 31-р сургуулийн биеийн тамирын талбай дээр Сүхбаатар дүүргийн спорт цогцолборыг барина гээд мөрийн хөтөлбөртөө оруулсан гэж байгаа. Гэтэл тэр спорт цогцолбор нь байгуулагдсан юм байхгүй, харин одоо 12 давхар хоёр барилга, нэг хувийн сургууль, нэг зочид буудал баригдчихсан байж байна.

Дөрөвдүгээр сургуулийн захирал Сэнгээг их шударга хүн гэж ярьдаг. Гэтэл тэр, манай сургуулийн биеийн тамирын талбай дээр барилга барьж болно гэсэн зөвшөөрлийг өгсөн байгаа юм. Түүний хэлсний дагуу барилга барьсан, гэхдээ энэ сургуулийн байрыг түрээсэлж байсан Даваахүү захиралтай хувийн сургууль барьсан байгаа юм. Өнөөдөр сургуулийн багш нар шүүхэд шилжээд явж байна. Манай сургуулийн багш нар ч бас ёс зүйгүй гэсэн нэр аваад явж байна.

Хүчинд автаж эзлэгдсэн, биеийн тамирын талбайгаа алдсаны хохирлыг барагдуулах талаар тодорхой шийдвэр энэ хэлэлцүүлгээс гарах болов уу. Үнэхээр хууль зөрчсөн нь тогтоогдсон бол тухайн хүн хэн ч байлаа гэсэн хариуцлага хүлээдэг механизмыг тогтоомоор байна.

Өчигдөр телевизээр олон улсад нэг мэдээ цацлаа. Монгол Улс авилгалаар 99-р байрт орсон, гэхдээ Нийслэлийн газрын алба Монголд толгойлж байна гэж. Энэ бодитой юу, эсвэл худлаа юу? Энэ талаар танайх судалгаа хийсэн үү?

Монгол Улсад Нийслэлийн газрын алба авилгалаар толгойллоо гэж дэлхий дахинд цацаж байгаад би их харамсаж байна. Миний хувьд Нийслэлийн

газрын алба арай ч тийм биш байх гэж боддог юм. Энэ талаар хуульчид болон мэргэжилтнүүд юу гэж бодож байна вэ?

Х.Оюунцэцэг /Хуульч эмэгтэйчүүдийн холбооны гүйцэтгэх захирал/:

Бид авилгалын асуудлаар судалгаа хийгээгүй. Манай судалгааны явцад газар олголттой холбоотой ямар асуудал байна вэ, асуудлыг шийдэх ямар боломж байна вэ гэсэн асуултыг иргэдэд тавихад “гарыг нь хүндрүүлэхэд асуудал хурдан шийдэгддэг” гэж 68 хувь нь хариулсан. Энэ бол Хан-Уул, Сүхбаатар дүүрэгт өргөдлөө өгөөд хариуг нь хүлээж байгаа хүмүүсийн хариулт.

Татвар, гааль гээд төрийн байгууллагаас ажилчиддаа зориулж байшин барьж өгдөг. Тэр нь барилгын компаниудын үнээс доогуур байдаг. Яагаад гэвэл барилгын компаниуд уг газраа авахдаа хахууль өгч, түүнийхээ өртгийг барилгын үнийн өртгөнд суулгаж байгаа учраас иргэдэд зарахдаа үнэтэй байдаг. Хэдий хэмжээний авилгал өгдөг гэдэг нь төрийн байгууллагын байшингийн нэг квадрат метрийг хэдээр үнэлж байгаатай холбоотой байдаг. Төрийн байгууллага нэг метр квадратыг нь 300 мянгаар авч байхад бид 460 мянгаар авч, квадрат метрээс олсон 160 мянгын 50 хувь нь ашиг, үлдсэн 50 хувь нь авилгалын өртөг болж байгаа. Би үүнийг батлахгүй. Ер нь ийм тооцоог барилгын компаниуд ярьдаг шүү дээ.

Чулуунбаатар /Татвар төлөгчдийн үйлдвэрчний холбооны ерөнхийлөгч/:

Газар олголт дээр авилгал байдаг уу, үгүй юү гэж маргаад яахав. Энэ бол маргахын ч шаардлагагүй. Үнэхээр байгаа зүйл юм. Баримтаар нь хэлж өгч болно. Шаардлагатай бол нэрийг нь хэлж ч болно.

Нэг жишээ хэлье. Хүүхдийн нэг байгууллагаас сургалтын төв барих гэж газар хөөцөлдсөн байгаа юм. Тэгээд хотын газрыг зохицуулдаг нэг инженерийг уриад цайлж дайлсан чинь овоо болмоор болсон байна. Тэгтэл бас л болж өгдөггүй ээ. Дараа нь хоёрдахь удаагаа нөгөө хүнийг цайлсан байгаа юм. Гэтэл “сая төгрөг өгчих, тэгж байж шийддэг шүү дээ” гэж хэлжээ. Тоглоом ч юм шиг, үнэн ч юм шиг байдалтайгаар ингэж хэлсэн байгаа юм. Тэгэхээр нь юу гэж тийм зүйл байхав гэж бодоод хүүхдийн байгууллага ядуу учраас түүнийг нь өгөөгүй гаргасан байна. Бүтэхгүй яваад байхаар нь жаал байж байгаад яваад очсон чинь “наад газар чинь дороо шугамтай” гэж хэлээд өөр газар өгчээ. Тэгэхээр нь “би аль хэдийнээс хөөцөлдсөн зүйл шүү дээ” гэхэд нь “тоглосон юм, наад доор чинь шугам байгаа, шугам дээр барилга барьж болохгүй” гэж хэлжээ. Тийм л юм байлгүй гээд орхисон байгаа юм. Гэтэл тэр газарт нь нэг хүн барилга барьсан. Тэр хүн Монгол Улсын томоохон сургуулийн эрдмийн зэрэг, цол олгох асуудлыг мэддэг хүн. Газрыг олгосон хүн тун удалгүй эрдмийн цол хамгаалсан байна. Энэ мэтээр олон амьд жишээ дурдаж болно.

Газрын төлөө хүмүүс их явж байна гэдэг. Анх газрын байцаагчтай уулзахаас эхлээд энэ асуудал их чухал гэдэг нь нүүр царайнаас нь илт харагддаг. Нэг их чухал хэрэгцээгүй мөртлөө зөв ч бай, буруу ч бай газартай болъё гэсэн үзэл иргэдийн тархи толгойд шингэчихээд байгаа учраас газрын бухимдлыг нэмэгдүүлээд байгаа юм.

Газар олголтын хуульд анхаарлаа хандуулж, үүнийг сайжруулмаар байна. Яагаад гэвэл газар олгож болдоггүй стандарт, журам огт байхгүй. Хотын ерөнхий төлөвлөгөө гэж нэг юм байдаг гэдэг. Үүнийг жирийн иргэн байтугай би ч мэдэхгүй. Би ном сонин бишгүй л эргүүлдэг хүн.

Засаг даргатай заргалдах асуудал хуульд байхгүй шүү дээ. Хүнд давхардуулж олгосон тохиолдолд хоёр хүн хоорондоо нэг заргалдана. Тэгээгүй бол юу гэж заргалдах юм бэ. Засаг дарга гэрийн чинь дээд талд газар өгчихгүй л бол хаа өгөх нь дурын хэрэг юм. Байрнаас төдий хэмжээний зайд тийм газрыг олгож болохгүй гэсэн юм байхгүй. Энэ талаар бодолцвол яасан юм бэ. Дээр нь монголчуудын хэнэггүй, хуулиа мэддэггүй, өөрөө газрын маргаанд оролцоогүй бол бусдын асуудал хамаагүй, нийгмийнхээ төлөө нэгдэж боддоггүй, хажуудахь Доржийн цонхыг нь халхалсан бол манайх төдөн метр зайтай юм чинь хамаагүй гэж сэтгэдэг. Маргааш танай цонхыг хаана шүү гэдгийг монголчууд ойлгодоггүй. Энэ байдлаас болж газрын маргаан ихээхэн хүндрэлтэй тулгардаг юм.

Монгол Улс иргэнийхээ эрх ашгийг тууштай хамгаалах хэрэгтэй. Газар олгоход тухайн газар дээр нь хүн барилга босгоно оо доо. Гэтэл баталгаа огт байхгүй шүү дээ. Таван жилийн хугацаатайгаар гэрээ байгуулж, дөрвөн давхар байшин барьтал таван жилийн дараа газрыг нь авна гэвэл яах юм бэ.

Иргэдийг ихээхэн хохироож байгаа. Нэгэн жишээ хэлье. 32-ын тойрог дээр Батбаяр дарга очоод “Чамд хоёр сая төгрөг өгнө, наад хашаагаа аваад зайл” гээд байсан. Дараа нь “10 саяыг ав, тэгээд зайл” гээд байсан. Болохгүй шүү дээ. Батбаяр даргын өмсч яваа костюмыг би өмсмөөр байна, 30 төгрөгөөр өгчих гэвэл тэр зөндөө юм ярина даа. Би 450 доллараар авсан юм гээд. Ингэж болохгүй ээ. Хөөцөлдөж хөөцөлдөж газар авлаа, таван жилийн дараа боль гэвэл яах юм бэ.

Газар олголтын хуульд 15 жилээр гэрээ хийнэ гэж заасан байгаа. Гэтэл яагаад таван жилээр хийж Монголын хуулийг зөрчөөд байгаа юм бэ. Эсвэл хуулиа өөрчлөөч ээ.

Хотын төвд эзэмшил газартай иргэнд өмчлөх газрыг нь яагаад өгөхгүй байгаа юм бэ. Иргэн өргөдлөө гаргаж 0.7 га-гаас илүүг нь эзэмшиж болохгүй юм уу. Албан тушаалтнууд нь хотын төвд өгөхгүй, наад асуудлыг чинь шийдэх болоогүй гэх юм.

Б.Төмөрхуяг /Нийслэлийн Газрын албаны дарга/:

Ер нь газрын асуудал дээр авилгалтай холбож нэлээн юм ярьдаг. Энэ чиглэлээр сүүлийн жилүүдэд нэлээн эрчимтэй ажлыг дотооддоо зохион байгуулж байгаа. Олон хүчин зүйлээс хамаардаг юм байна лээ. Саяын яригдаж буй хүмүүс нь манай байгууллагын хүн мөн үү, биш үү гэдгийг би сайн мэдэхгүй.

Нийслэлийн Засаг даргын захирамж гарч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас газрын албатай гэрээ байгуулж гэрчилгээ авснаас хойш газрын алба тэнд оролцохгүй шүү дээ. Түүнээс хойш журмаа баталж дулаан, техникийн нөхцөл гэж явсаар хоёр жилийн дараа л дөнгөж сая дууслаа гээд орж ирдэг. Энэ хооронд нэлээн цаг хугацаа барж зовдог шиг байгаа юм. Цаашдаа үүнийг нэг мөр

болгон цэгцлэх шаардлага байна. Буруу юм болохоор Газрын албан дээр бууж ярьдаг. Ерөөсөө газраас л боллоо гэж. Би үүнийг зөвшөөрөхгүй гэж өөрөөсөө түлхэж байгаа юм биш л дээ. Энэ асуудлыг олон удаа ярьдаг учраас ийм байр суурьтай байдаг юм.

Өнгөрсөн жил хоёр гурван газраас авилгалын судалгаа хийсэн. Тэгээд түүнийг дотор нь задалсан шүү дээ. Яагаад Газрын алба гээд гарч ирэв гэж. Гэтэл шал өөр судалгаа гарсан. Энэ талаар Батсүх дарга жаахан тодруулж тайлбарлах байх аа.

Хуулиар 15-60 жил, сунгаж буй тохиолдолд 40 жил гэсэн хоёр л заалт байгаа. Энэ асуудлыг 15 жилээр заалт хийж оруулахаар ганц Газрын алба биш, баталгаажуулах түвшинд нь мэргэжлийн байгууллагууд хүлээн зөвшөөрдөггүй. Одоо наад газарт чинь таван жилийн дараа зам тавина, зургаан жилийн дараа цахилгааны шугам татна гээд маш олон субьектийн дарамт орж ирдэг. Тийм учраас хот байгуулалтын асуудал олон юмнаас хамаарч байдаг юм. Үүнээс шалтгаалж Нийслэлд иргэний аж ахуйн зориулалттай газрыг өмчлүүлэх ажлыг эхлүүлж чадахгүй байгаа. Тэгэхээр хотын ерөнхий төлөвлөгөөг хуульчилж өгөөч ээ. Хуульчлагдахгүй болохоор цаашаа явахгүй байгаа юм. Түүнээс биш энэ асуудлыг шийдэж болно. Үнэхээр барилга объект нь баригдсан, ерөнхий төлөвлөгөөний шаардлага хангасан газруудад 15, 20 жил, бүр 60 жил хүртэл баталгаажилт хийж байгаа.

Бид одоо газар зохион байгуулалтын энэ жилийн төлөвлөгөөг боловсруулж байна. Тэгэхээр хотын төвд газар өмчилж авах байршил нь тогтоогдсон тухай саналаа өгвөл төлөвлөгөөндөө тусгаж, Иргэдийн хурлаар баталж хуулийн дагуу энэ ажил явагдах юм.

Чулуунбаатар /Татвар төлөгчдийн үйлдвэрчний холбооны ерөнхийлөгч/:

83 м² газар илүү гарсан байгаа юм. Гэтэл үүнийг өмчилж авахын тулд м² газрын тариф нь 12 мянга гаруй төгрөг гээд нийтдээ сая шахам төгрөгийг нэхэж байна гэсэн. Наана чинь жимсний мод тарьсан нэлээн талбай байгаа юм гэсэн чинь: Тэр чинь ямар хамаатай юм бэ, 1000 м²-аас цааш ярьдаг яриа гэж байна. 702 м² талбайг хоёр жилийн хугацаагаар эзэмшүүлж татвараа төлчихсөн байгаа. Гэтэл ийм хүнийг жил гаруй явуулаад байх юм.

Б.Төмөрхуяг /Нийслэлийн Газрын албаны дарга/:

Хуулиар бол тухайн өрхийн өмчилж авч байгаа газрын хэмжээ 0.7-гоос илүү бол тэр илүү газрынх нь 25 хүртэлх хувийг Засгийн газраас тогтоосон үнээр худалдана гэж заасан байгаа. Хуулийн дагуу л ингэж яригдаж байгаа хэрэг. Худалдаж авахгүй бол та эзэмшиж болно шүү дээ. Заавал худалдаж авах шаардлагагүй. Гэр хороололд ийм зүйл зөндөө тохиолдож байгаа. Тэгэхээр бид энэ хоёрын хооронд зурвас газар үлдээгээд Дамбынх ч биш, Доржийнх ч биш байдлаар тэнд нь зохицуулалт хийж өгч л байгаа.

Баяраа /Багануур/:

Саяхан “Газрын харилцаа ба иргэд” гэсэн төслийг хэрэгжүүлсэн. Үүнээс хэдэн дүгнэлт хэлье гэж бодож байна. Юуны өмнө төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангахын төлөө ажиллаж буй ННФ-ынханд баярлалаа гэж хэлэхийг хүсч байна. Хот байгуулалт, газар төлөвлөлтийн асуудлыг салгаж ойлгох ямар ч боломж байхгүй. Багануурт газар төлөвлөлт болон хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө гэж байхгүй. Ийм байдал нь төрийн захиргааны албан тушаалтнуудыг дураар авирлах боломжийг нээж өгдөг. Хаа дуртай газраа барилгаа барих, түүнээс авилгал хүртэх үндэслэл нь болж байгаа юм. Тийм учраас хот төлөвлөлт, хот байгуулалтын бодлогыг олон улсын стандартад нийцүүлэн зохион байгуулах шаардлага байна. Үүнд эрх бүхий хүмүүс анхаараач ээ.

Газрын албан дээр хүнд суртал маш их байдаг. Нэг нөхөр өргөдөл бичээд очихоор түүнийг нь авдаг хүн байхгүй. Өөр ажилд хөөгөөд явуулчихсан байдаг. Бас газрынхаа хуулийг мэддэггүй. Үүнээс болж баахан чирэгдэл үүсдэг. Тэгэхээр орон нутгийн газрын албаны ажил үүргийн хуваарийг нарийн гаргаж, ажилтнуудын мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх хэрэгтэй байна.

Өнгөцхөн харвал хүүхдийн тоглоомын талбай, хөгшдийн нарлах газарт нь байшин барилга барьж байгаа нь харагддаг. Гэтэл тэнд гал түймэр гарвал яаж очих вэ. Явах газар байхгүй. Түүнчлэн барилга байгууламж барих талбай, стандарт, дизайны хувьд ч анхаарах зүйл байна.

Т.Төрбат /Орон сууц эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг/:

Энэ асуудалд цогцоор хандахгүй бол болохгүй. Жишээ нь, БЗД-ийн 7-р хорооны 38 Б орон сууцны хажуудах айл нь цонхоо худалдчихсан. Үүнийг нь би мэддэггүй байсан юм. Тэгсэн чинь тэр хүн хажуугийн хүндээ “аз болоход сая төгрөг байдаг юм байна, цонхоо битүүлж ганц сая төгрөг оллоо” гэж ярьж байна. Энэ нь юуг харуулж байна гэвэл манай иргэдийн эрх зүйн боловсрол дутмаг, хяналт тавих механизм буюу хяналт тавихын тулд харьцуулдаг стандартын баримт бичиг нь дутагдаад байгаа юм. Иргэдэд энэ талаар зөвлөгөө өгдөг байгаач ээ.

Олон жил барилга баригдаж ирсэн учраас хуучин стандарт нь их сайн гарчихсан юм шиг байгаа юм. Орчин үед барьж буй барилгуудад стандарт хэрэгжихгүй байгаа учраас гал тогооны өрөөгүй баригдаж байна. Түүнтэй холбоотойгоор янз бүрийн зүйл гарч ирсэн. Нийслэлийн барилгын стандарт гэж тусдаа баймаар юм шиг.

Томоохон орнуудад тодорхой нэг компанид жижиг дүүргээр нь эрх олгож шалгаруулалт явуулдаг гэдэг. Тэгвэл газрын харилцаанд ордог олон субъектийн хооронд авилгал авдаг завсрын бөөс хуурс нь алга болно. Тухайн газрыг, жишээлбэл, Яармагийн дэнжийг нэг томоохон компанид бүрэн хариуцуулж чадвал тэндээ өөрийнхөө халаалт дулаан зэрэг бүх асуудлаа шийдээд явчихна.

ХИС-ийн газар бараг дуусч байгаа гэдгийг та бүхэн мэдэх байх. Тийм учраас нийслэлийн боловсролын байгууллагуудад хүүхдийн гэсэн утгаар нь салбарын эрх ашгийг хамгаалах ямар нэгэн бодлого хэрэгжүүлдэг үү?

Алтанцэцэг /Дархан-Уул аймаг/:

Газрын кадастрын албанаас ИТХ-д тухайн жил иргэдэд өмчлүүлэх газрын материалыг оруулж ирж батлуулдаг. Гэтэл үнэтэй цэнтэй буюу ашигтай газрынхаа зураг, төсвийг оруулж ирдэггүй.

2006 онд манай газрын албаныхан ИТХ-д материал оруулж ирлээ. Гэхдээ үнэ цэнтэй газрынхаа зураг төслийг оруулж ирэхгүйгээр ерөнхий кадастрын зургаа оруулж ирээд л батлуулчихдаг. Саяхан Иргэдийн хурлын тайланг хэлэлцэх гээд иргэдийн төлөөлөгчид өөрийн баг дээр очиж тайлангаа тавих боллоо. Гэтэл манай баг дээр очсон чинь гэр хорооллын дунд ШТС барьчихсан байгаа юм. Ямар ч зөвшөөрөл байхгүйгээр. 2006 оны газрын төлөвлөгөөнд ороогүй байсан. Газрын албанд очоод асуухаар мэдэхгүй гэсэн хариултыг өгдөг. Ил тод байдал гэдэг нь хөдөө орон нутагт байхгүй байна. Яг дунд шатандаа замхарч байгаа юм.

Газрын хуульд 15 жилээс доошгүй хугацаагаар гэрээ хийнэ гэсэн байгаа. Гэтэл Дархан-Уул аймагт хоёр жилээр гэрээгээ хийчихдэг. Хоёр жил өнгөрөөд гэрээ сунгуулах болохоор баахан бичиг баримт бүрдүүлэх болдог. Тэгэхээр хуулиас давсан Засаг даргын захирамж гэж байдаг юм уу.

Ямар нэг хууль гарлаа гэхэд тухайн хуулийг давсан Засаг даргын захирамж гардаг. Тэгээд 800 хүний суудалтай Залуучууд театрт тайлангаа тавиад ил тод байдлыг эрхэмлэж байна гэж ярьдаг. Гэтэл тэнд хэдэн хэлтэс, агентлагийн дарга нар нь ирээд суучихдаг. ЗДТГ-аас төлөвлөгөө, төсөл зэрэг ерөнхий зүйлээ багтаасан нэг эмхтгэл гаргадаг боловч мөнгө төгрөг болон иргэдтэй холбоотой гомдол шийдвэрлэсэн тогтоол, захирамжийг бичдэггүй.

Б.Төмөрхуяг /Нийслэлийн Газрын албаны дарга/:

ХИС-ийн тухай асуудал хөндөгдлөө. Улаанбаатар хотод үнэхээр олон сургууль байгаа. Энэ их, дээд сургуулиудыг хэрхэн цааш нь зохицуулах вэ. Нэг тийш нь гаргавал түүнийг хангах техник энэ тэр гээд олон асуудал үүсч болох юм. Өнөөдөр Улаанбаатар хотод хувийн сургуулиуд маш их ачаалал өгч байгаа. Өнгөрсөн жилийн тоогоор 125 мянган оюутан байна. Тэдний 20000-30000 оюутан нь улсын сургуулийнх. Энэ оюутнууд нэг нэг хүн дагуулаад хотод амьдрах гээд хашаа бариад суучихсан бужигнаад байдаг. Төгсөөд ажлын байр байдаг юм уу. Ийм бэрхшээлүүд байдаг юм аа. Улаанбаатар хотыг төвлөрүүлэхэд боловсролын байгууллага их хүчин зүйл болж байгаа. Цаашид яах вэ гэдгийг зохих түвшиндээ ярьж байж энэ асуудлыг шийдье гэж бодож байна.

Иргэн:

Бодит жишээ ярья. 2001 оноос хойш, бараг долоон жил газрын маргааны асуудлаар хөөцөлдөөд явж байгаа. Зарим хүмүүс нэг жилийг их хугацаа гэж үзэж байна л даа. Ингэж долоон жил явсан нь хэний буруу вэ гэж дүгнэхээр газрын албаны ажилтнуудын буруу байгаа юм. Энэ хугацаанд 16 сая төгрөгөөр хэмжигдэх хохирол гарчихаад байна. Жишээ нь, гаргасан зураг, талбай шилжүүлсэн гээд өчнөөн юм бий.

Би энэ хохирлыг барагдуулахын тулд хэн дээр очих вэ гэж Төмөрхуяг даргаас асууж байна. Хэрвээ шүүхийн байгууллагаар шийдүүл гэвэл шууд тэнд хандъя, газрын албан дээрээ буруу, зөвийг нь гаргаж шийдээд өгье гэвэл танай байгууллага дээр очье. Би өөрийгөө 16 сая төгрөгөөр хохирох ёсгүй гэж үздэг.

Газрын албаныхан дээшээ мэргэжлийн хяналтын байгууллагатай холбогдож дааж давшгүй хэрэм бий болгосон байдаг. Албан тушаалдаа үлдэхийн тулд. Хэн дээр нь ч очсон цаагуураа ярилцаад тохирчихсон юм шиг байдаг.

Б.Төмөрхуяг /Нийслэлийн Газрын албаны дарга/:

Анх ямар маргаан болсныг би мэдэж байгаа. Таван жил болсон гэж санаж байна. Материалтай нь танилцаагүй учраас шууд хариулт өгөх боломжгүй. Надтай очоод уулзаарай.

Ш.Батсүх /Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга/:

Бид асуудлаа зөв ойлгохын тулд зарим зүйлийг тодруулж, асуултад хариулья гэж бодож байна. Хуульд нэг удаа 15-60 жил хүртэл хугацаагаар газраа эзэмшиж, 40 жилээр нэг удаа сунгана гэж заасан байгаа. Өөрөөр хэлбэл, тухайн газраа дахин 40 жилээр сунгаж болно гэсэн үг. 2003 оны 1-р сараас хойш гарч байгаа захирамж нь 15-60 жилийн хооронд хэлбэлзэж байгаа. Гэхдээ манай газрын албаны зарим нөхөд, зарим Засаг дарга хуулиа ойлгодоггүй ч юм уу, дураараа авирладаг ч юм уу 15-аас доош жилээр захирамж гаргасан ганц нэг тохиолдол байдаг юм. Хуулийн дагуу үүнийг цуцал гээд бид бичгээр ханддаг. Цуцлахгүй бол дээд шатны Засаг даргад нь ханддаг.

Бид сая захирамжийн тухай ярьсангүй. Гэрээний тухай л ярьж байна. Захирамж гарсны дараа иргэн газрын албатай гэрээ байгуулна. Тэр гэрээгээ богино хугацаагаар байгуулж байгаа. Гэвч богино хугацаагаар газар эзэмшүүлэх нь гэж айх хэрэггүй юм. Газрын алба голдуу 2-5 жилээр гэрээ байгуулж байгаа. Яагаад гэвэл газрын төлбөрийг тухай бүрт нь хөөцөлдөн авч, хяналт тавин ажиллах үүднээс ингэж ажиллаж байгаа юм. Энэ нь захирамж гаргаж, гэрчилгээ олгосон хугацаатай огт хамаагүй гэдгийг ойлгоосой гэж хүсэх байна.

Нийслэлд гэр бүлийн хэрэгцээнд зориулж иргэнд 0.07 га газрыг нэг удаа үнэгүй өмчилнө гэсэн тодорхой заалт хуульд бий. Улаанбаатар хотод 0.03, 0.05 га, сүүлд 0.07 га газрыг эзэмшүүлж байсан юм. Гэтэл 0.07 га-гаас илүү газар эзэмшсэн иргэдийг яах вэ гэж Засгийн газар дээр нэлээн ярьсан. Тэгээд 0.07-оос хэтэрч буй газар нь нийт газрын 25 хувиас хэтрэхгүй бол тухайн иргэнд нь худалдаж өмчлүүлэхээр хуульд заасан байгаа. Хүсэхгүй бол эзэмшээд явж болно. Эсвэл би өөр газар өмчилж авъя, энэ газраа буцааж өгье гэж шийдэж болно. Ихэнхдээ хүмүүс тэгдэггүй, үнээр нь худалдаж авъя гэдэг. Худалдаж авсан тохиолдол нэлээн бий. Энэ нь газрын байгууллагаас иргэдэд шахалт үзүүлж байгаа юм биш ээ. Иргэд сайн дурын үндсэн дээр илүү гарсан газраа үнээр нь худалдан авъя гээд өмчилж байгаа юм шүү. Үүнийг сайн ойлгоорой.

Зургаан сар хийсэн судалгааны үр дүнд Нийслэлийн газрын алба Монголын нэг номерын авилгалтай байгууллагаар шалгарсан тухай хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр өчигдөр танилцуулсан байгаа. Би энэ салбарыг удирдаж байгаагийн хувьд ажилтнуудаа өмөөрөх зүйл дээр нь өмөөрч, хууль зөрчсөн тохиолдолд шударгаар хариуцлага тооцно.

Судлаач хүний хувьд Монголд газартай холбоотой асуудлаар авилгал нэгдүгээрт байна гэвэл үнэнд арай ойр байх болов уу гэж бодож байна. Яг Нийслэлийн газрын алба гэдэг нь юу л бол. Яагаад гэвэл түрүүчийн хэлээд байгаа, нэрийг нь хэлж ядаад байгаа хүмүүс нь газрын албаных байна уу, эсвэл, дэд бүтцийн инженер байна уу гэсэн асуудал бий.

Оюунцэцэг багшийн ярианд гарч байна лээ. Ер нь газар олголтоос байшин бариад хүлээж авах хүртэл 60 гаруй хүн гарын үсэг зурдаг тогтолцоо байгаа гэж. Тэдний дотор газрын албаны хоёр л хүн гарын үсэг зурж байгаа. Ихэнх нь хэн байна гэвэл дэд бүтцийн инженерүүд, барилга хүлээж авах, барилгыг эхлүүлэх зөвшөөрөл олгодог мэргэжлийн хяналтын комиссынхон гээд хориод хүн бий. Үүнийг ялгаж ойлгомоор байгаа юм. Бид асуудлаа тодорхой ойлгож, бие биеэ хүндэлж байвал дутагдлаа засч чадна. Тэгэхгүйгээр нийтлэг ярих нь огт нэмэргүй юм.

Хууль зөрчсөн гээд байдаг. Би их гайхдаг. Яагаад хуулийн байгууллагад хандаж шийдүүлж болдоггүй юм бэ. Засаг даргын захирамж болон захиргааны байгууллагын шийдвэр нь хууль зөрчсөн байгаа бол Захиргааны хэргийн шүүхэд өгч шийдүүлэх хэрэгтэй. Захиргааны хэргийн шүүхээс манайхыг экспертизээр дүгнэлт гаргаж өгөөч гэсэн хүсэлт их ирж байгаа. Бид дүгнэлт гаргаж өгч байгаа. Харин эрүүгийн юм уу, иргэний асуудал байгаа бол зохих шүүхийн байгууллагаараа шийдэгдэх ёстой шүү дээ. Бид асуудлаа харилцан зөв ойлголцож ярих нь зүйтэй болов уу.

Чулуунбаатар /Татвар төлөгчдийн үйлдвэрчний холбооны ерөнхийлөгч/:

Батсүх дарга аа, таны ярьж байгаа зүйл чинь маш сайхан юм. Тантай санал нэг байна. Гэвч энэ чинь хэрэгжээгүй л байна. Гэрээгээ 5 жилээр байгуулсан ч захирамжаа 15 жилээр гаргаж гэрчилгээ өгч байгаа гэлээ. Тэр чинь худлаа. Бүх гэрчилгээ чинь 5 жилээр явж байгаа шүү.

Нэгэнтээ гэрээ нь 5 жилээр байгуулагдлаа гэхэд ямар ч баталгаагүй шүү дээ. 5 жилийн дараа одоогийн газрын албанд ажиллаж байгаа хүмүүс нь тэндээ байх ч юм уу, үгүй ч юм уу. Шүүх дээр очихоор таны байгуулсан 5 жилийн гэрээ дууссан учраас одоо эрх зүйн чадамжгүй болсон гэж хэлнэ. Тэгэхээр 15 жилээр гэрчилгээ өгөх асуудлыг хэрхэн шийдэх юм бэ.

Төмөрхуяг дарга бусад инженерийн байгууллага нь зөвшөөрдөггүй гэж ярьж байна. Тэд Монгол Улсын хуулийг зөвшөөрөхгүй байх эрхгүй шүү дээ. Та хуулийн дагуу 15 жилээр гэрээгээ хийх ёстой. Цаад газрууд нь хуулиа дагах ёстой гэсэн зарчим үйлчлэх ёстой юм.

Газрыг чинь өгч байгаа гэж ярилаа. Энэ бас худлаа. Эзэмшиж буй газрынхаа 0.07 хувиас илүү гарсныг нь худалдаж авъя гэхэд “Өгөхгүй ээ, олон үг ярилгүй наадахаа эзэмшээд байвал бай, хэл ам гаргавал буцааж хурааж авна шүү” гэдэг. Тэгэхээр таны ярьж байгаа зүйл чинь огт үндэслэлгүй байна. Таны ярьдаг шиг байвал бидэнд ярих ч юм алга.

Эрдэнэбилэг /“Үндэсний Соёмбо” хөдөлгөөн/:

Манайд эрх зүйт төр оршиж байгаа юм шиг харагдах боловч үнэн хэрэгтээ хөл толгойгоо олохоо больсон, эрх зүйт бус төр ажиллаж байна. Тухайлбал, 1992 оны Үндсэн хуульд хоёрхон этгээд дур мэдэж өөрчлөлт оруулсан. Үүнээс болж төрийн эрх баригчид нь, УИХ-ын гишүүд нь мөнгө төгрөгтэйгээ хутгалдсан. Гүйцэтгэх засаглал нь УИХ, шүүх, цагдаатайгаа холилдсон. Өөрөөр хэлбэл, гүйцэтгэх засаглал нь УИХ-ынхаа дээр гараад суучихсан байгаа. УИХ нь ажил хийх гэж оролддог, гэвч мөнгө төгрөгөө 250 саяар нь хуваарилж аваад сууж байгаа. 250 сая гэж тоо гаргаж ирсэн нь их өрийн 250 сая долларыг бүдгэрүүлж, иргэдийн анхаарлыг 250 сая төгрөг рүү хандуулах гэсэн оролдлого юм.

Прокурор, шүүхийн байгууллага гэж яриад байх юм. Бид чинь эрхтэн дархтануудад үйлчилдэггүй хуультай улс шүү дээ. Өөртөө тохиолдсон нэгэн жишээг хэлье. Монголын ард түмэн, түүний дотор Улаанбаатарын иргэдийн эд эс, организмыг цаг мөч бүрт хөнөөж байдаг цахилгаан соронзон долгионы асуудлаар би таван жил хөөцөлдсөн. Улсын прокурор Алтанхуягт Үндсэн хуулиас авхуулаад таван хуулийн заалтыг зөрчөөд байна гэж хэлэхэд таны ярьж буй хуулийн чинь цаана Засгийн газрын захирамж гэж бий шүү дээ гэж байгаа юм. Тэгээд 2001 оны 1-р сарын 16-ны өдөр Дээд шүүхийн хяналтын шатанд хүрч байж миний талд шийдэгдсэн. Харилцаа холбооны зохицуулах хорооны хуулийн зөвлөх Ганболд, би тусгай зөвшөөрөл дээр газрын байршлыг бичиж өгсөний төлөө хариуцлага хүлээхгүй гэж шүүх дээр хэлж байгаа юм. Хот төлөвлөлтийн бодлогын хэлтэс нь бид захирамж гаргаагүй гэж ярьж байгаа юм. Уг хэргийг Захиргааны хэргийн шүүгч Цогт, Дуламсүрэн нар давж заалдах шатнаас буцаж очиход нь хэрэгсэхгүй болгож байсан. Харилцаа холбооны хууль, Орон сууцны хууль, Дундын өмчлөлийн орон сууцны хууль, Радио долгионы хууль, Үндсэн хуулийн 16-р зүйлийн 2, 3-р заалт зөрчигдчихөөд байхад хэрэгсэхгүй болгоод сууж байгаа хүмүүстэй юу ярих вэ дээ.

Ард иргэд нь хуулийг биелүүлдэг. Харин эрхтэн дархтанууд нь хуулиа биелүүлдэггүй. Ийм учраас өнөөдөр хуульд, төрд итгэж явна гэдэг бол өнгөрсөн хорвоо юм байналээ. Хатуухан хэлбэл Хятадын дагуур улс гэх юм уу. Энэ ард түмний татвараас бий болсон төсвийн мөнгөнөөс цалин авч байгаа хүмүүсийн амнаас ийм үг гарахгүй ээ. Тэр даргын хүн, энэ сайдын хүн учраас тэдний эсрэг үг хэлж болохгүй, хэлбэл ажил, амьдралгүй болно гэж бодож байгаа. Өөрсдийн цалингаа 30 хувиар нэмсэн. Гэтэл доод түвшний ажилчдын цалинг нь нэмдэггүй.

Үндсэн хуулийн 6-р зүйлд: “Монгол орны газар нутаг, түүний хэвлий, ой, ус, ургамал, түүний хэвлийн баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна” гэсэн заалт байгаа. Гэтэл өнөөдөр яаж байна. Бид хэний газрыг хэнээс худалдаж авах гээд байгаа юм бэ. Хэдэн эрхтэн дархтаны мэдлийнх юм уу, эсвэл,

манжийн ноёдынх юм уу, 1911 оны Богд хаант Монгол Улсын газар юм уу, 1921-1940 оны үеийн хэлмэгдлийн Засгийн газрын үеийн газар юм уу. Үндсэн хуулийн ийм заалт байтал ард иргэд бид нэгдэж тэмцэхгүй, шуудайнд хийсэн үхрийн эвэр шиг яваад байж болно гэж үү.

Монголын ард түмэнд 1911-1921 оны үеийн татвар төлөөс ноогдчихоод байна. 17 төрлийн татварыг давхардуулж авч байгаа. Зөвхөн бензинээс онцгой татвар, гаалийн татвар, ашиг орлогын албан татвар, НӨТ-ын татвар гээд таван татвар авч байна. Бас дээр нь улсаас өөрийн ашгийг нэмэхээр зургаан татвар болчихдог. Монголын ард түмэн цалингаараа энэ татварыг чинь яаж даах юм бэ. Тэгээд өөрийнхөө газрыг төрийн албан хаагчдын цалин, гэдэсний түгжээ хийх мөнгө төлж авах юм уу. Ёстой горьдов оо.

Баянгол дүүргийн Засаг дарга Цогтбаатар:

Соёмбо хөдөлгөөний гишүүдийн хамт газар дээр нь очиж хараад хүүхдийн тоглоомын талбай дээр барьсан хашаа, жорлон, гэр гурвыг нь буулгаж өгнө гэж хэлээд явсан. Би бараг сар утасдлаа. Гэсэн ч хоёр гэрийг нь буулгаж хашааг нь жижиг болгож барьсан. Энэ газар нь Нийслэлийн захирагч Энхболдын захирамжтай юм билээ. Ирэх жилийн 3-р сарын 1-эн хүртэл би хөдөлгөж чадахгүй гэж бидэнд хэлсэн. Олон түмний нүдэн дээр зайлуулж өгнө гэж амлачихаад дараа нь ингэж хэлдэг.

Өнөөдөр бид цаг заваа барж ингэж суухаар уншиж мэдэж байх нь арай дээр юм. Соёлтой ертөнцөд нанотехнологийн тухай ярьж байна. Манайх макро дээрээ дэнжигнэн тогтож байгаа. Газрын технологи, үйлдвэрлэлийн технологи, биотехнологи нь бүгд нано дээр явж байгаа шүү. Бид энд цаг зав, эрчим хүч бараад яахав дээ. УИХ-ын гишүүд нь хоёр хууль зөрчиж 250 саяыг хуваарилаад авчихаж байх юм. Аргагүйн эрхэнд хүчинд автагдаад яаманд хуваарилна гэсэн. Энэ мөнгөөр ядуу амьдарч байгаа хөдөөгийн иргэддээ зам, барилга барьж өгч болно шүү дээ.

Газрын асуудал хуульгүй яваад байна аа. Газрын байгууллагад ажиллаж буй хүмүүс чинь ажлаа хийж, үүргээ биелүүлж чадахгүй байна. Газар чинь маргаантай бол татвараа битгий өг гэж уриалмаар байна. Иргэний хөдөлгөөнийхөн хамтарч тэмцье.

Ц.Ишдорж /“Гэгээ” СӨХ-ны захирал/:

Батсүх дарга аа, танайх газар дээр нь шалгаж мэдэгдэл өгсөн. Тэр чинь буруу байна аа. Байхгүй газар дээр зурж хуурамч зураг үйлдсэн байна. Тийм учраас Батсүх дарга, Төмөрхуяг дарга та хоёр бидэнтэй хамт яваад тэр газрыг үзчихвэл цааш нь гомдол гаргах юм байхгүй ээ. Газар дээр нь очоод харчихмаар байгаа юм. Үүнийг харвал тэнд барилга барих байтугай яах гэж ийм захирамж гаргасан юм бол гэх байх. Та хоёр зөвшөөрөх үү. Байхгүй юмыг хийчихээд хотын дарга, Төмөрхуяг дарга зугтаагаад байна. Өнөөдөр ганц удаа уулзаж юм асууя гэхээр дуугарахгүй суугаад байх юм.

Ардын эмнэлгийн хүрээлэнгийн 20 метр газрын цэцэрлэгийг сүйтгээд байна. Та нар зөвшөөрөхгүй бол би зургийг нь харуулъя. Ийм зураг байсныг 20 метр зайтай гэж танайхаас анх олгожээ. Танай байрыг чинь өөр газарт аваачиж зурж байгаад зөвшөөрөл авчихжээ. Манайхан ийм юм хийдэг нь буруу.

Хуурамч бичиг баримт байна, хариуцлага тооцох арга хэмжээ аваач гэхээр Нийслэлийн Засаг дарга ерөөсөө тоохгүй байгаа. Сүүлийн үед хотын Засаг дарга жингийн цуваа явж л байна, жингэрийн ноход хуцаж л байна биз гэж суудаг болсон. Жингэрийн нохой гэж хэнийг хэлж байгаа юм бэ. Монголын эмэгтэйчүүдийг жингэр, эрэгтэйчүүдийг нохой гэж хэлээд байгаа юм уу, эсвэл, ИТХ-ын даргаа жингэр гээд, гишүүдийг нь нохой гэж байгаа юм уу. Өөртөө хэрэгтэйг нь авдаг, бусдад хэрэгтэйг нь хаядаг гэж сая сонин дээр гарсан шүү дээ. Хотын дарга ийм үг хэлээд сууж байхад бид хэнд хандах вэ дээ. Тэгэхээр ил тод байдлын тухай биш, далд нууц байдлын тухай хурал хиймээр байгаа юм.

Энхболд сайд өөрөө газар дээр нь очиж үзээд энэ хэдэн модыг устгаж болохгүй гээд Төмөрхуяг даргаар захирамжийг нь авчируулаад өнгөрсөн 11-р сард хүчингүй болгосон. Дараа нь 2006 оны 3-р сард 85-р захирамжийн нэрийг бичээд газрын гэрчилгээг олгосон байдаг юм. 85-р захирамж бол газрыг сунгасан захирамж. Ийм л хууль бус юм хийдэг хүмүүс шүү дээ. Тэгэхээр ард түмэн дургүйцэхгүй яах юм бэ.

Хэдэн цэцэрлэгийг дуусгасан. Ганц үлдсэн ногоон байгууламжийг нь та нар авраач ээ. Галын болон эрүүл мэндийн нормыг нь бариач ээ. Төмөрхуяг дарга сүүлийн үед өвчтэй гээд хүнтэй уулзахаа болилоо. Гэтэл ард түмэн чинь танаас доргүй ядарсан хүмүүс байгаа шүү дээ. Та үүнийг анхаараарай. Газар дээр нь очиж үзээрэй. Тэгэхгүй бол бид тэмцлийн хурц хэлбэрийг сонгоно шүү.

Б.Төмөрхуяг /Нийслэлийн Газрын албаны дарга/:

Би төрийн байгууллагын ажил хариуцаж байгаа хүний зүгээс хэлье. Ямар нэгэн улс төрийн өнгө аястай зүйл ярихгүй байя. “Боорчи тур” компанид тухайн газар олгогдсон байсан. Үүний дараа тухайн байрын СӨХ-ны дарга, гишүүдтэйгээ барилгыг бариулахгүй гэсэн эсэргүүцлээ илэрхийлсэн. Энэ маргааны үүднээс Нийслэлийн Засаг дарга захирамжийг нь цуцалсан. Гэтэл захирамжийг цуцалсны дараа “Боорчи тур” компани шүүхэд маргаан үүсгэсэн байгаа юм. Гурван удаагийн шүүхийн шийдвэр “Боорчи тур” компанийн талд гарсан. Ийм л юм болсон. Би энэ асуудлыг анхнаас нь мэднэ ээ. Газар дээр нь очиж байсан. Одоо дахин очих шаардлага байхгүй ээ. Хуулийн хүрээнд асуудал нь шийдэгдсэн байгаа.

Нарантуяа /Ховд аймаг/:

Газрын асуудал зөвхөн Улаанбаатарт гардаг юм биш. Хөдөө орон нутаг, тэр дундаа аймгийн төвд ч гэсэн энэ асуудал өдөр бүр шахам яригдаж байгаа. Хэлэлцүүлгээс гарах зөвлөмж нь Улаанбаатар хотын хэмжээнд гарна гэнэ. Зөвлөмжөө зөвхөн Улаанбаатарт биш, Монгол улсын хэмжээнд гаргаж өгвөл зүгээр болов уу.

Малчид, тариаланчдад газрын асуудалтай холбоотой мэдээлэл хүрэхгүй байгаа учраас хүмүүс газраа яаж авах тухайгаа мэддэггүй. Ийм учраас ил тод байдал байхгүй гэсэн үг.

Газрын агентлагийн харъяа аймаг, орон нутгийн мэргэжилтнүүд иргэддээ биш, даргадаа үйлчилж байгаа учраас авилгал авсан ч, аваагүй ч танай байгууллагын нэр хүнд унаад байгаа юм биш үү. Нэг жишээ хэлье. Иргэний нийгмийн байгууллагаас өрх гэрийн орлого бий болгох чиглэлээр хүмүүсийг зохион байгуулж, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлсэн. Тэгэхдээ Ховдод ашиглагдахгүй байгаа 10 га газрыг аваад ажилласан чинь тэр газар нь ашигтай болж хувираад баахан мөнгө нэхдэг юм байна. Ашиглахгүй хаяхаараа газар нь хог хаягдал болж байдаг юм билээ. Үүнийг Газрын алба цаашдын хөгжилтэйгээ уялдуулан авч үзэх байх аа.

Туул /МӨХ/:

Би газрын маргаантай асуудлын шүүх хуралд өмгөөлөгчөөр оролцож явдаг. Энэ бүхнээс ажиглахад төрийн албан хаагчид хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудаа мэддэггүй юм байна лээ. Жишээ нь, Газрын хуульд газар шилжүүлэх гээд, бүр яаж шилжүүлэх тухай хуулийн заалт байгаа. Гэтэл манай газрын албаны мэргэжилтнүүд эрхгүй этгээд шилжүүлчихсэн байхад түүнийг нь хүлээж аваад шийдвэрээ гаргачихдаг. Илт ийм алдааг шүүхээр биш, өөрсдөөр нь шийдвэрлүүлж болдоггүй юм уу гэсэн асуудлыг гаргаж тавьдаг юм. Тэгэхээр шүүхэд өгчих, тэгвэл бидэнд амар гэж хэлдэг. Үүнийг баталж ярих олон баримт бий.

Санал зөвлөмжинд оруулах юм юу байна гэвэл нэгд, өнөөдрийн үйлчилж байгаа Газрын тухай хууль болон холбогдох хуулиудыг боловсоронгуй болгох заалтыг хиймээр байна. Тэр хүн 60-аад гарын үсэг зурж авсан газраа яагаад шилжүүлчихдэг юм, нөгөө талаар хохирсон тал нь энэ захирамж буруу байна гэж шүүхдэж байдаг. Гэтэл өөр захирамж гарсан байдаг. Ингээд цаг хугацаа алдаад яваад байдаг. Тэгэхээр шилжүүлэх заалтыг бүр хүчингүй болгуулах саналтай байна.

Газар өнөөдөр хамгийн үнэ цэнтэй объект учраас иргэдэд хэрэгтэй санал зөвлөмж гаргая гэвэл иргэд өөрсдийнхөө өмчлөлд байгаа 0.07 га газрыг бүртгүүлдэг газар байдаггүй учраас эдийн засгийн эргэлтэд орж чадахгүй байна гэж би боддог юм. ҮХХ-ийг ҮХХ-ийн газарт бүртгүүлээд банкуудад барьцаанд тавьдаг. Банкууд үүнийг эдийн засгийн эргэлтэд сайн оруулж чаддаггүй. Ийм тусгай газар хэрэгтэй байгаа юм. Өнөөдөр банкууд орон сууцнаас илүү газрыг нь барьцаанд авч зээл олгохыг хүсч байгаа. Орон сууц нурчихна, газарт элэгдэл байхгүй.

Х.Оюунцэцэг /Хуульч эмэгтэйчүүдийн холбооны гүйцэтгэх захирал/:

Хүнд суртлыг багасгахад хамгийн гол нь энэ их орон тоо, бүтэц бүрэлдэхүүнийг нь өөрчлөх хэрэгтэй. Тэгэхээр бүтэц, зохион байгуулалтаа дахин харж үзэж давхардсан үйл ажиллагааг нь багасгаач ээ.

Ил тод байдал гэж яриад л байдаг. Бүх юм далд явагдаад л байдаг. Хөгжилтэй орнуудад төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа вэб сайтыг ихээхэн ашигладаг юм билээ. Манайхан ашигладаг байж магадгүй. Газрын асуудал ихээхэн яригдаж байгаа өнөө үед иргэдээ энэ талын мэдээллээр хангамаар байна. Энэ мэдээллийг өгч байх газартай болох хэрэгтэй юм.

Б.Төмөрхуяг /Нийслэлийн Газрын албаны дарга/:

Байранд амьдардаг айлууд газраа хэзээ өмчлөх вэ гэсэн асуулт бичгээр ирлээ. Энэ асуудлыг удахгүй Иргэдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Нийслэлийн газрын алба бүх дүүрэгтээ мэдээллийн сүлжээтэй болсон байгаа. Өөрийн вэб сайт бий. Ямар нэгэн шүүхийн маргаан үүсвэл түүнтэй холбоотой баримт бичиг бүрдүүлэх хүн манай архиваас авдаг журамтай.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ САЛБАР ХУРАЛДААН

Дөрөвдэх хэсэг буюу “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал” салбар хуралдааныг Азийн санаачилга институтийн захирал Г.Цогтсайхан даргалан явуулав. Энэ сэдвийн хүрээнд Үйлдвэр худалдааны дэд сайд Я.Содбаатар “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал”, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн ахлагч Д.Батбаяр “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга ба Монгол Улс”, Олборлох салбарын ил тод байдлын төлөө ТББ-уудын эвслийн зохицуулагч Ц.Ганболд “Төлсөн авснаа ил тодоор нийтлэх цаг боллоо”, “Айвенхоу Майнз” компанийн дэд ерөнхийлөгч Содхүү “Олборлох байдлын ил тод байдлын санаачилгын талаарх компанийн хандлага” илтгэлүүдийг тавьж, дараа нь хэлэлцүүлэг өрнөлөө.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА- МОНГОЛ УЛС

**ЕРӨНХИЙ САЙДЫН АХЛАХ ЗӨВЛӨХ , ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ, ХЯНАН ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА, АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ Д. БАТБАЯР**

Газрын тос, байгалийн хий, уул уурхайгаас олсон мөнгө нь зөрчил, авилгал, ядуурал хоосролтой холбоотой байдаг нь олон улсын түвшинд нилээд дэлгэрсэн үзэгдэл мөн гэж үздэг юм билээ. Дэлхий нийтээрээ “нөөц баялгийн хяслан” гэж нэрлэдэг ийм байдал нь компаниудаас Засгийн газарт төлж байгаа орлогын эргэн тойронд ил тод хариуцлагатай байдал үгүйлэгдэж байгаагаас гол төлөв гардаг үүдэлтэй.

Тийм учраас олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын зорилго нь тэрхүү үгүйлэгдэж байгаа ил тод, хариуцлагатай байдлыг бий болгох явдал мөн.

Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд баримтлах зарчмуудыг олон улсын баримт бичгүүдэд дараах байдлаар тодорхойлжээ.

Зарчим

1. *Зохистой удирдах*: Байгалийн нөөц баялгийг ухаалгаар үр өгөөжтэй ашиглах нь эдийн засгийн тогтвортой өсөлтийн нэг чухал хөшүүрэг мөн бөгөөд хэрэв үүнийг зохистой удирдахгүй бол нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсгэж болно гэдэг итгэл үнэмшил байдаг.
2. *Ард иргэдийнхээ тусын тулд ашиглах*: Аливаа улс орон байгалийн нөөц баялгаа ард иргэдийнхээ тусын тулд ашиглах асуудал нь үндэсний хөгжлийнхөө ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх гэсэн тусгаар улсын Засгийн газрын анхаарлын төвд байдаг асуудлын нэг мөн..
3. *Зах зээлийн үнээс хамааралтай байх*: Нөөц баялгийг олборлосны ашиг тус нь олон жилийн турш хуримтлагдах орлогоор илэрхийлэгдэх бөгөөд энэ нь зах зээлийн үнээс ихээхэн хамааралтай байхыг хүлээн зөвшөөрсөн байна.
4. *Засгийн газрын орлого, зарцуулалтын талаар ард иргэд тодорхой ойлголттой байх, зардал, орлогын урсгалыг зохицуулах*: Төрийн зардал, орлогын урсгалыг зохицуулах талаар Засгийн газрын бүх ард түмнийхээ өмнө хүлээсэн хариуцлагын зарчмууд, үйл явцад итгэж байна. Засгийн газрын орлого, зарцуулалтын талаар ард иргэд ямар нэгэн ойлголттой байх нь цаашдын тогтвортой хөгжлийн зохистой бодит хувилбаруудын сонголтын талаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах, мэдээлэл өгөхөд ач тустай гэж ойлгож байна. Зардал, орлогын урсгалыг зөв оновчтой зохицуулснаар ард түмний итгэлийг олно, дэмжлэг авна.
5. *Ач холбогдолтой байх*: Олборлох салбарт ажиллаж буй Засгийн газар ба компаниудын ил тод байдлын ач холбогдол болон төрийн санхүүгийн удирдлага, хариуцлагатай байдлыг сайжруулах шаардлагыг онцлон тэмдэглэх учиртай.
6. *Хүндэтгэн үзэх*: Илүү их ил тод байдлыг бий болгох явдал нь байгуулсан гэрээ хэлэлцээр, үйлчилж буй хууль тогтоомжуудыг хүндэтгэн үзэх байдлаар хийгдэх ёстой гэж ойлгоно.
7. *Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах*: Гадаад, дотоодын шууд хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах нь санхүүгийн ил тод байдлыг хянахад тус дэм үзүүлнэ хүргэнэ гэж үзэж байна.
8. *Дээд зэргийн стандартуудыг дэмжин нэвтрүүлэх*: Олон нийтийн амьдрал, бизнес, Засгийн газрын үйл ажиллагаанд ил тод байдал, хариуцлагын дээд зэргийн стандартуудыг нэвтрүүлэхийн төлөө байна.
9. *Энгийн хялбар арга барил хэрэглэх*: Төлбөр болон орлогыг ил тод болгохын тулд өргөн хүрээтэй уялдаа холбоо бүхий, хэрэгжихүйц бөгөөд хэрэгжүүлэх, ашиглахад энгийн хялбар арга барил хэрэглэх шаардлагатай.
10. *Бүх компаниудыг хамруулах*: Бид, аливаа улс орон дахь төлбөр тооцоог ил тод болгоход тухайн оронд үйл ажиллагаа явуулж байгаа олборлох үйлдвэрлэлийн бүх компаниудыг хамруулах ёстой.

11. *Аливаа байгууллага, аж ахуйн нэгж бүр хувь нэмрээ оруулах:* Бүх оролцогчид, түүний дотор Засгийн газар, түүний агентлагууд, олборлох салбарын компаниуд, үйлчилгээний компаниуд, олон талт байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, төрийн бус байгууллагууд аливаа шийдэл гаргахад тус тусын чухал хувь нэмэр оруулах ёстой.

ОУИТБС-ын хэрэгжилт нь доорх шалгууруудад нийцсэн байх ёстой

1. *Хэвлэн нийтлэх:* Газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас Засгийн газарт төлж байгаа бүх материаллаг төлбөр (“төлбөрүүд”), газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас Засгийн газрын хүлээн авсан бүх материаллаг орлогын (“орлогууд”) талаар өргөн олон нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой, цогц байдлаар тогтмол хэвлэн нийтэлж байх.
2. *Аудит:* Хэрэв хөндлөнгийн хяналт байхгүй бол дээрх төлбөр болон орлогуудыг итгэмжлэгдсэн, хараат бус аудитаар олон улсын аудитын стандарт хэрэглэн шалгуулдаг байх.
3. *Нэгтгэлт:* Төлбөр болон орлогыг итгэмжлэгдсэн, хараат бус Захирагчаар олон улсын аудитын стандарт хэрэглэн нэгтгэн дүгнүүлж, хэрэв ямар нэг зөрүүтэй байдал илэрсэн бол энэ талаарх тухайн Захирагчийн дүгнэлтийг хэвлэн нийтэлдэг байх.
4. *Хамрах хүрээ:* Энэ арга нь бүх компаниуд, түүний дотор төрийн өмчит үйлдвэрийн газруудад хамаатай байх.
5. *Иргэний нийгэм:* Дээрх үйл явцыг зохион байгуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд иргэний нийгмийн төлөөлөл идэвхтэй оролцож, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмрээ оруулах.
6. *Үйл ажиллагааны төлөвлөгөө:* Санаачилгыг хэрэгжүүлж буй хүлээн авагч Засгийн газар, шаардлагатай тохиолдолд олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламжтайгаар, дээрх бүх үйл явцад зориулан санхүүгийн хувьд тогтвортой үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах бөгөөд энэхүү ажлын төлөвлөгөөнд хэмжиж болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа, гарч болзошгүй хүндрэл бэрхшээлийн үнэлгээ зэргийг багтаасан байх.

Үйл явцын өрнөл Нэг. ОУИТБС СУДЛАХ, СУРТАЛЧЛАХ, ЭЛСЭН ОРОХ ҮЙЛ ЯВЦ:

1. Анх Дэлхийн Банкны Монголыг хариуцсан захирал 2005 оны 5-р сард сард олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад манай улсыг нэгдэж болох тухай саналыг Монгол Улсын Засгийн газарт тавьсан.
2. Монгол Улсын Ерөнхий сайд 2005 оны 6-р сард Дэлхийн Банканд энэ санаачилгад яаж нэгдэн орох чиглэлээр туслалцаа үзүүлэх тухай хүсэлт илгээсэн.

3. Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны дарга, Эдийн засгийн Байнгын хорооны дарга нарын бүрэлдэхүүнтэй Улсын Их Хурал, Засгийн газрын эрх мэдэл бүхий хэсэг хүнийг Киргиз Улсад явуулж, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлж байгаа туршлага судлуулсан.
4. Мөн оны 10-р сард Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Эдийн засгийн Байнгын хорооны хамтарсан хурлаар Олборлох салбарын ил тод байдлын санаачилгад Монгол Улс нэгдэх тухай асуудлыг хэлэлцэн дэмжиж, энэ санаачилгад нэгдэх чиглэлийг Засгийн газарт өгсөн.
5. Үүний дараа Ерөнхий сайд 2005 оны 10 дугаар сард хоёр дахь захидлаа Дэлхийн Банканд явуулж дэмжлэг хүссэн.
6. Уг санаачилгыг танилцуулах анхны семинарыг 2005 оны 10-р сард зохион байгуулсан.
7. Ерөнхий сайдын ажлын албанаас хариуцан 2005 онд хэд хэдэн удаа ярилцлага явуулсны гадна 12-р сарын эхээр “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга” сэдэвт Олон улсын бага хурлыг Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн Банк, Их Британи, Умард Ирландын Вант Улсын Олон улсын хөгжлийн агентлаг хамтран зохион байгуулж, НҮБ, АХБ, ОУВС, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Америк, Канад, Франц, Герман, Япон, ОХУ зэрэг орны Элчин сайд, дипломат байгууллагын төлөөлөгчид, мөн манай улсын төр засгийн байгууллага, яам, агентлаг, уул уурхайн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон.
8. Нээлттэй Нийгэм Форум, “Олборлох салбарын ил тод байдлын санаачилга” Сурвалж бичиг номыг монгол хэлнээ орчуулан нийтэлж сурталчилсан.
9. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсын Засгийн газар дэмжих тухай тогтоолыг 2006 оны 1-р сарын 4-нд гаргасан. Энэ асуудлыг хариуцсан Ерөнхий сайд толгойлсон Үндэсний зөвлөл, Үндэсний зөвлөлд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг Ерөнхий сайдын ахлах зөвлөхөөр ахлуулж байгуулсан. Засгийн газар шинээр байгуулагдсаны дараа яамдын бүтэц өөрчлөгдсөн тул ажлын хэсэгт 2006 оны 3 дугаар сард өөрчлөлт оруулсан. /Ажлын төлөвлөгөө, ажиллах журмын төсөлд Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан/
10. Энэ асуудал нь улс төрийн шийдвэр, шинэ бодлого гэдэг утгаар асуудлыг Ерөнхий сайд, түүний ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт төвлөрүүлж бодлогоо гаргах нь зөв гэж бүрэлдэхүүнийг тогтсон.
11. Ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулж Дэлхийн Банкны дотоодын зөвлөхөөс зөвлөгөө авч 2006 оны 4-р сардажлын хэсгийн хурлаар хэлэлцэн дэмжиж, Үндэсний зөвлөлийн хурлаар мөн оны 5-р сард зөвшөөрүүлсэн. Түүний дагуу ажиллаж байгаа /Дэлхийн Банкны зөвлөхүүд ажлын

төлөвлөгөөг хэмжиж болохуйц зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, зардал зэргийг нэмж тусгах зөвлөгөө өгсний дагуу шинэчлэн боловсруулж Дэлхийн Банкны зөвлөхүүдэд хүргүүлж зөвлөгөө авсан/.

Хоёр. Бэлтгэл ажлын хүрээнд

Эрх зүйн орчинг бий болгох чиглэлээр

- Ашигт малтмалын тухай хуулийн “48.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 1-дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” гэж заасан нь эрх зүйн үндэслэл болж байна.
- Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байгаа “Эрдэс баялгийн салбарыг 2015 он хүртэл хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ын төсөлд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах бодлого тусгалаа олсон.
- Мөн зарим төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах тухай хэд хэдэн журмыг Засгийн газраас баталж, зарим асуудлыг Улсын Их хуралд өргөн мэдүүлээд байна.
- Үйлдвэр, худалдааны яам хууль хэрэгжүүлэх 20 орчим асуудлыг боловсруулж байгаа.

Үйл ажиллагааны чиглэлээр

Үндэсний зөвлөл

- Үндэсний зөвлөл 1 удаа хуралдсан, ажиллах журмаа баталсан, ажлын төлөвлөгөөг дэмжсэн;
- Үндэсний зөвлөлийн гишүүдийг мэдээллээр хангаж байна, ажлын явцаа танилцуулж чиглэл авсан;
- Үндэсний зөвлөлийн дарга нийтэд хандаж хэлсэн үгэндээ 3 удаа олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын талаар ярьсан байгаа

Ажлын хэсэг

Ажлын хэсэг 2 удаа хуралдсан: Хэлэлцсэн асуудал:

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын үндсэн асуудал, манай улсын зорилго;
- Ажлын төлөвлөгөөний төсөл;
- Уул уурхайн үйлдвэр, аж ахуйн нэгжийг тус санаачилгад хамруулан тайлагнуулах шалгуур үзүүлэлт тогтоох, аж ахуйн нэгжийг сонгох;
- Ажлын хэсгийн ажиллах журмын төсөл гэх мэт.

Ажлын хэсгээс хийсэн судалгаа

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад хамруулах аж ахуйн нэгжийн судалгаа;
- Аж ахуйн нэгжийн улсад төлсөн албан татвар, төлбөрийн судалгааг 2005 оныхоор ҮТЕГ, 2004 оны аж ахуйн нэгжийн тайланг АМГТХЭГ нэгтгэж 2 хувилбараар гаргаж багцаа тойм мэдлэгтэй болсон;
- Үүний зэрэгцээ орон нутагт юунд хандив төлбөр өгч байгаа талаарх тандан судалгааг ярилцлагын аргаар хийж байгаа;
- Ажлын нэгжийн улс болон орон нутагт төлөх албан татвар, төлбөр, хураамж, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс зэргийн эрх зүйн үндсийг судалсан;
- Санаачилгад оролцох төрийн байгууллагуудын судалгаа, түүний одоогийн чиг үүргийн судалгаа /14 байгууллага/;
- Төрийн бус байгууллагуудын талаарх мэдээллүүд цуглуулсан

Аж ахуйн нэгжийг сонгох зарчим:

1. Ашигт малтмалын тухай хуулийн дагуу манай оронд үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн олборлох үйлдвэрлэлийн компани /гадаадын хөрөнгө оруулалттай, хамтарсан, дотоодын хувийн, хувьцаат болон төрийн өмчит/ хамрагдах;
2. Аж ахуйн нэгж нь сайн дурын үндсэн дээр тайлагнахыг зөвшөөрсөн байх, аж ахуйн нэгж аудитаа сонгох, тайлан гаргах талаар гэрээ байгуулахыг зөвшөөрсөн байх;
3. Эхний ээлжинд санаачилгад оролцох аж ахуйн нэгжийн тайланд тусгагдах санхүүгийн урсгалын дүн нь аудитын зардлаас их байх /50 саяас дээш, 25 саяас дээш/ гэсэн 2 хувилбар;
4. Туршилтын, эсхүл аль нэгэн төрлийн ашигт малтмалын төрлийг сонгон эхний ээлжинд хамруулж, улмаар үе шаттайгаар компаниудыг санаачилгад оролцуулах;
5. Аж ахуйн нэгжийг сонгохдоо ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн санал, түүний дотор Засгийн газар, яам, агентлаг, аудитын байгууллага, аж ахуйн нэгж, түүнийг төлөөлөх төрийн бус байгууллага, иргэний нийгмийн төлөөллийн саналыг харгалзах.

Зохион байгуулсан уулзалтууд

- Олборлох үйлдвэрлэл эрхэлдэг санаачилгад хамрагдах урьдчилсан судалгаанд хамрагдсан аж ахуйн зарим томоохон нэгжийн удирдлагатай уулзалтууд хийсэн, цаашид ч хийнэ /Ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, Уул уурхайн ассоциаци хамтран санаачилгад хамрагдах

урьдчилсан нэр бүхий зарим аж ахуйн нэгжийн удирдлагатай байгууллага дээр нь очиж ярилцсан, дүнгээ ажлын хэсгийн хуралд танилцуулсан, олон санал гарсан, санаачилгатай холбоогүй асуудлууд ч гарсан. Зарим удирдлага нь ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох санал ч тавьсан /

- Нээлттэй Нийгэм Форумд хэрэгцээтэй үедээ хүсэлтээ тавьж харилцан хамтран ажиллаж байгаа, төрийн бус байгууллагын эвслийн удирдлагатай уулзаж ярилцсан
- Олон улсын хуралд 2 удаа оролцсон.
- Дэлхийн банкны зөвлөхүүдтэй хэд хэдэн удаа уулзалт хийж, зөвлөгөө авч байгаагийн дээр Дэлхийн банканд явуулсан 5 асуудлын талаар манай улсад суугаа суурин төлөөлөгчтэй уулзахдаа ярилцсан. Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газарт орон тооны хагас ачаалалтай зөвлөх авч хамтран ажиллаж байна.

Боловсруулалтын шатанд байгаа асуудлууд

- Дэлхийн Банкны итгэлийн сангаас буцалтгүй тусламж авах төсөл боловсруулж хүргүүлсэн, хариуны дагуу дахин боловсруулж явуулсан;
- Тайлан гаргах маягт 2 хувилбараар боловсруулсан, бас нэг хувилбар гаргах ажлын хэсгийн гишүүд томилогдсон, Төрийн бус байгууллагын эвсэл 1 хувилбар боловсруулна /Ажлын хэсгээс боловсруулсан Тайлангийн маягтын загвар, түүнийг гаргах зааврын төслийн хамт Дэлхийн Банканд явуулсан, мөн ажлын хэсгийн зарим гишүүдээс зөвлөгөө авч байгаа/;
- Ажлын албаны дүрэм төсөл /Дэлхийн Банканд өгсөн/;
- Засгийн газрын зүгээс санаачилгад оролцох байгууллагууд, тэдгээрийн чиг үүрэг;
- Төлөвлөгөөг ихээхэн шинэчилсэн, зорилтоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тайлан гаргахад бэлтгэх, чадавхижуулах, баталгаажуулалт зэрэг бүхий л асуудлыг төвлөвлөгөөнд нэг мөр тусгасан, хугацаа өөрчлөгдсөн, зардал тооцсон;

Гарч буй шүүмжлэл

- Алгуурлаж байна гэж байгаа, шаардлага ч ирж байгаа /Үндэсний зөвлөл, ажлын хэсгээс барьж байгаа чиг бол эрх зүйн орчинг сайн бүрдүүлэх, бэлтгэлээ сайн хийх, аль болох судалгаа сайтай, асуудлаа боловсруулахад анхаарч байгаа/
- Энэ нь мэдээлэл, мэдлэггүйгээс болж алдаа гаргахгүй байх, шинэ зүйлийг сайн судалж байж асуудалд хандаж байх гэсэн чиглэл баримталж байгаатай холбоотой

- Ил тод байдал гэдгийг сайн ойлгоогүйгээс ОУИТБС-ын хүрээнээс хальж байгаль орчны асуудал их яригддаг, асуудлаа онож ярих, санал хэлэх нь ажилд чухал байгаа
- Нийгэмд хандсан мэдээлэл бага байна гэж байгаа, тэр ч үнэн, сайн төлөвлөж хэрэгжүүлбэл хэрэгжинэ. Цаашид үүнд анхаарна.
- Ажлын албатай болох /Гишүүд бүгд давхар ажилтай тул ажлын цагаар зав гарахгүй зовлон байгаа/.

Ойрын үед хийх ажил

- 2006 оны 12 дугаар сард багтаан Үндэсний зөвлөл, ажлын хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулж, 2007 оны 2-р сард шинэ бүрэлдэхүүнээр хуралдуулна.
- Үндэсний зөвлөлийн хувьд шийдвэр гаргах байгууллага тул Засгийн газар давамгайлсан бүрэлдэхүүнтэй байна. /Дэлхийн Банк ч ийм чиглэл өгсөн/
- Ажлын хэсгийн хувьд санаачилгад 3 талын оролцоог тэгш хангах, тэдний саналыг боловсруулж байгаа асуудалд тусгах, гарах шийдвэрт анхаарах, оролцогчдын бие биедээ тавих хяналтыг бий болгох зэрэг олон талаас харж үзэх чадавхитай тэгш бүрэлдэхүүнтэй байна.
- Ажлын хэсгийн хурлыг хийж одоо бэлэн болоод байгаа асуудлуудаа хэлэлцүүлнэ.
- Бэлтгэл ажил 2-р сараас эрчимжихээр төлөвлөгөөнд тусгагдсан байгаа
- Тайлан гаргах, түүний маягт, үзүүлэлт зэргээр 3 талын ярилцлагууд зохион байгуулна. Семинар ч зохион байгуулна.
- Санаачилга сайн дурын үндсэн дээр хэрэгжих учир оролцогч талуудын оролцоог сайн хангаж, харилцан зөвшилцөж асуудлаа ярьж явна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх онцлог

1. Санаачилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа оролцогч 3 талын зөвшилцлийн үндсэн дээр хэрэгжинэ. /Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ажиллах журам зэрэгт тусгалаа олсон, цаашид үйл ажиллагааны гол зарчим байх болно./
2. Бусад оронд энэ санаачилга газрын тос, байгалийн хийн салбарт голлон хэрэгжиж байгаа бол манай оронд эрдэс баялгийн үйлдвэрлэлд голлон хэрэгжинэ. Энэ нь манай орны онцлогоос урган гарч байгаа.
3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга бусад оронд Төв засгийн газрын төвшинд тайлагнах байдлаар хэрэгжиж байгаа бол манайд улсын төвшинд ч, орон нутгийн төвшинд ч нэгэн зэрэг хэрэгжинэ. /Санаачилгыг хэрэгжүүлж тайлан гаргасан орнууд Төв засгийн газрын төвшинд хэрэгжүүлсэн, 2006 онд олон улсын зөвлөх бүлгээс гаргасан

тайланд тэдгээр оронд орон нутгийн төвшинд хэрэгжүүлэх зөвлөмж гаргасан байгаа. Эндээс дүгнэлт хийж ажлын хэсэг Тайлангийн маягт, түүнийг гаргах зааврыг өөрийн орны энэ онцлогийг харгалзан төв, орон нутгийн төвшинд нэгэн зэрэг гаргах хэмжээнд боловсруулаад байна. Аж ахуйн нэгжүүд, Засгийн газар ирэх оны 1 дүгээр улирлаас Тайлан гаргаж нийтэд мэдээлнэ гэж төлөвлөж байна./

ТӨЛСӨН АВСНАА ИЛ ТОДООР НИЙТЛЭХ ЦАГ БОЛЛОО

ОЛБОРЛОХ САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТӨЛӨӨ ТББ-УУДЫН
ЭВСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ Ц. ГАНБОЛД

Энд чуулж байгаа эрхэмсэг хатагтай, ноёд та бүхний өдрийн амгаланг айлтгая.

Юуны өмнө өнөөг хүртэл төдийлөн хөндөгдөж байгаагүй боловч Монголын нийгэмд ус агаар шиг хэрэгтэй болоод байгаа төрийн ил тод байдлын тулгамдсан асуудлуудыг өргөн хүрээнд авч үзэж оновчтой шийдэл, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох бололцоо олгосон Нээлттэй Нийгэм Форумд эвсэлд нэгдсэн ТББ-уудынхаа өмнөөс талархал илэрхийлье.

1. Олон улсын муу туршлага

Олборлох салбарын ил тод байдлын асуудлаар мэргэшсэн Лондонд төвтэй *Global Witness* (Даян дэлхийн гэрч) ТББ-аас Казахстаны Ерөнхийлөгч Н.Назарбаевын тэнгисийн эргээр усны хувцастай нүцгэн гүйж байгаа гэрэл зургийг сэтгүүлд нийтлүүлээд тэрхүү зургийн дор Ерөнхийлөгч та хөрөнгө орлогоо яг энэ нүцгэн байгаа шигээ ил тод нийтэлнэ үү гэсэн тайлбар дагуулжээ. Энэхүү содон гэрэл зургийг татсан англи сэтгүүлчийг хожим Казахстаны нутаг дэвсгэрт оруулахыг хориглосон юм гэнэ.

Казахстанд сүүлийн жилүүдэд нефть болон байгалийн хийн асар их нөөц илэрснийг та бид мэднэ. Ялангуяа 6 тэрбум баррель орчим нөөцтэй Тенгизийн орд газар нөөцөөрөө дэлхийд 5 дугаарт ордог байна. Энэ том орд газрыг ашиглахад оролцох эрхийг Америкийн *Chevron* болон *Mobil* компаниуд 1993, 1996 онд олж авчээ. Олборлолтын эрх олж авахын тулд Мобилийн нефтийн брокер Уильямс, Зөвлөлтийн үед Америк, Зөвлөлтийн худалдаа, эдийн засгийн зөвлөлийг толгойлж байгаад 1991 онд Назарбаевын тусгай зөвлөх болсон америкийн иргэн Гиффен нарыг Казахстаны өндөр албан тушаалтнуудад ойртох зуучлагчаар ашигласан ба Гиффений байгуулсан Нью-Йоркт төвтэй хувийн *Mercator* банкаар дамжуулан ашигтай гэрээ байгуулж чадсаны шагналд 1995-2000 онд 67 сая доллар шилжүүлсэн байна. Энэ хугацаанд Гиффен Швейцарийн 4-өөс цөөнгүй банканд өөрөө нууцаар хяналт тавьж ирсэн 50-60 тооны эргэлзээтэй дансуудад Казахстаны нефть хийн эрх олж авсны төлөө гэх нэрийн дор нефтийн компаниудаас гаргуулсан 70 сая орчим долларыг бас төвлөрүүлж чадсан байна. Ийнхүү төвлөрүүлсэн мөнгөнөөсөө 78 сая орчим долларыг Казахстаны ерөнхийлөгч Назарбаев, тус улсын тухайн үеийн нефтийн сайд Бальгимбаев нарт хууль бусаар төлснийг энэ дуулиант хэргийг авч

хэлэлцсэн Америкийн Дээд шүүхийн дүгнэлтэд дурджээ. Америкийн шүүх ийм дүгнэлт гаргахдаа Швейцарийн хуульчдын туслалцааг авсан байдаг. Энэ хэрэг явдлын улмаас ноён Гиффен 88 жил шоронд хоригдох, 80 гаруй сая долларын торгууль төлөх ял сонсчээ. Мэдээж ноён Назарбаев Америкийн шүүхийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй. Нэлээд хожуу Казахстаны Ерөнхийлөгч болон түүний гэр бүл, тэдгээрийн эдийн засгийн сонирхол, хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллийг нийтлэх нь улсын нууц задруулсан хэмжээнд цээрлэл хүлээхээр хуульчлагдсанаар энэ хэрэг явдлыг тойрон Казахстанд өрнөж эхэлсэн шуугиан намжжээ.

Байгалийн баялаг ихтэй, төрийн тогтолцоо нь ардчилсан бус орнуудад ийм дур зоргын үйлдэл олонтаа давтагдсаар иржээ. Зарим жишээ хэлье.

Мөн *Global Witness*-ийн нотолж байгаагаар Анголд 1996 оноос эхлэн жил бүр 1 тэрбумаас илүү долларын нефтийн орлого албан ёсны статистик тооцоонд оролгүй алга болсоор байжээ. Энэхүү зувчуулсан орлого нь тус орны жилийн орлогын дөрөвний нэгтэй тэнцэж байжээ. Гэтэл Анголд шинэ төрсөн хүүхдүүдийн дөрөвний нэг нь 5 нас ч хүрэлгүй нас бардаг байх юм. Швейцарт явуулсан мөрдөн шалгалтын дүнд иргэний дайны үймээн самууныг ашиглан ерөнхийлөгч Дош Сантос нефтийн орлогоос сая сая доллар хувьдаа халаасалсан нь тогтоогдсон байна.

Конго-Браззавильд улсын нефтийн компани *Elf* (одоогийн нэр нь Total) эрх баригчидтайгаа сүжрэн улсын нефтийн ирээдүйн орлогоор барьцаалан өндөр хүүтэй зээл гаднаас авахад нь тусалж байжээ. Олон улсын валютын сангийн тооцоолсноор үндэсний нефтийн компани *Societe Nationale des Petroles du Congo* нефть олборлолтоос олон сая долларын ашиг олсон хэдий ч улсынхаа санд юу ч төлөөгүй ажээ.

Энэ мэт олон муу жишээ юуг нотлон харуулна вэ. Зөвхөн нефть төдийгүй олборлох салбарыг бүхэлд нь орлогын хувьд ч, зарцуулалтын хувьд ч хянах шаардлагатайг тодотгож байгаа юм.

2. Тэгвэл Монголд...

Дахиад л жишээ татъя. Улсын Их Хурлын гишүүн агсан, “Миний Монголын газар шороо” хөдөлгөөнийг үүсгэн санаачлагч О.Энхсайхан Оюутолгой, Тавантолгой, Бороо гоулд зэрэг хэд хэдэн ордтой холбоотой мэдээлэл авахаар Үйлдвэр худалдааны яам, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар зэрэг төрийн байгууллагуудад удаа дараа хандаад ч хүссэн мэдээллийг нь гаргаж өгөөгүй тухай надад ярьж байсан юм. Талийгаач ялангуяа Бороо гоулдтай Засгийн газар байгуулсан Тогтвортой байдлын гэрээний нөхцлүүд, уг компанийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой баримтуудыг уйгагүй сураглан хөөцөлдөж байлаа. Түүнд татварын албаны нэгэн шударга байцаагч тус хүргэснээр Бороо гоулд компани хуулийн дагуу 5 жилийн турш орлогын албан татвараас чөлөөлөгдөж байгаа төдийгүй нэгэнт төлөгдсөн нэмүү өртгийн албан татварыг буцаан суутгах замаар Бороо гоулд улсаас авлагатай болчихсон баримтыг олон нийтэд дэлгэж билээ.

Яагаад татварын байцаагч бараг нууцаар энэ мэдээллийг өгөв. Төсвөөс санхүүждэг Үндэсний татварын ерөнхий газар энэ энгийн гэмээр мэдээллийг хууль тогтоогчид гаргаж өгч болохгүй байсан гэж үү?

2002 онд батлагдсан Татвар ноогдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4-т: “...татвар төлөгчийн зөвхөн бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн хуулиар хориглоогүй мэдээ баримтуудыг нийтэд танилцуулж болно” гэж заажээ. Хуулийн энэ заалтаар бол Бороо гоулдын татвартай холбогдох мэдээллийг зөвхөн энэ компанийн бичгээр өгсөн зөвшөөрлөөр татварын байгууллага ил зарлаж болох нь.

Өнөөг хүртэл аж ахуйн нэгж, байгууллагууд, түүний дотор уул уурхайн компаниудын улс, орон нутгийн төсөвт төлсөн татвар, хураамжийн дүн мэдээ бүрэн хаалттай байгаа нь чухамхүү хуулийн дээрх зохицуулалтаас шалтгаалж байгаа ажээ.

Өөр нэг жишээ. Өнгөрөгч өвөл Нээлттэй Нийгэм Форумын санаачилгаар уг форумын вэб сайтад Оюутолгойн ордын талаар Засгийн газар, Айвенхоу Майнз компанийн хооронд ажлын баримт бичгийн түвшинд хэлэлцэж байсан Тогтвортой байдлын гэрээний төслийг байршуулахад зарим яамны түшмэд, Айвенхоу Майнз компанийн зүгээс илт таагүй хандаж байлаа. Хэрвээ энэ төслийг дээрх вэб сайтад байршуулаагүйсэн бол Монголын нийгэмд Оюутолгойн ордын талаар даацтай яриа хөөрөө өрнөхгүй, УИХ Ашигт малтмалын тухай хуулиа өөрчлөхгүй, Оюутолгойн тогтвортой байдлын гэрээ Хөрөнгө оруулалтын гэрээний түвшинд очтолоо өндөр авахгүй байсан байж мэдэх юм. Энэ бол уул уурхайн томоохон гэрээний төслийг ил болгох анхны амжилттай оролдлого байсан юм.

Харамсалтай нь энэхүү тохиолдлоос хойш дээрх гэрээний төсөл, хувилбарууд албан тушаалтнуудын чанд хяналтад оржээ. Монголчууд бидэнд нэг сүрхий дутагдал байдаг. Нэг хэсэг шуугидаг, тэгээд мартдаг, залхдаг. Одоо л бид Оюутолгойн гэрээний эргэн тойронд юу болж байгааг жинхэнэ утгаар хянах цаг боллоо. Гэтэл бидэнд ямарваа нэг мэдээлэл алга, тэр ч байтугай хэлэлцээ хийж байгаа Засгийн газрын ажлын хэсгийн бүрэлдэхүүний нэрс ч таамаг төдий байна.

Гуравдахь жишээ. 1997 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх хавар анхны Ерөнхийлөгч П.Очирбат гуай нэгэн сайхан дээлээ Монголын газрын хөрснөөс ундарсан нефтийн дээжээр мялааж сонгуулийн PR хийж билээ. Ерөнхийлөгчөөсөө эхлэн хэн хүнгүй баярласан тэр торгон эгшнээс даруй есөн он улирав. Гэвч манайх газрын тосоор баяжсангүй. Тос байхгүй юм уу гэтэл байгаа бололтой. Дорнодын Тамсагт Америкийн Соко компани хэдэн жил хайгуул хийж, олборлолт явуулж байгаад гэнэт гараад явчихлаа. Орыг нь Хятадын том компани Дачинь эзлэв. Хятадууд тооцоотой улс. Юу ч үгүй газар орж ирэхгүй. Ямар боловч Тамсагаас Хятад руу автотээврээр тос тасралтгүй зөөсөөр байгаа нь бодит үнэн юм. Тамсагт хайгуулын тусгай зөвшөөрөл олгохдоо манай Засгийн газар Соко компанитай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Хоногт олборлох тосны баррель хэмжээ нэмэгдэх тусам Монголын талд оногдох ашиг нь ахих нөхцөлтэй. Яг одоо манайд энэхүү гэрээний биелэлт юу болов гэдгийг яг таг хэлэх албан тушаалтан бий юү? Манай сонин хэвлэлээр л лав энэ тухай ямар ч мэдээлэл алга.

Дээрх гурван жишээ манай олборлох салбарын ил тод байдлыг бус, харин хаалттай байдлыг илүү тодотгож өгөх болов уу гэж бодож байна.

3. Цаашид юу хийвэл зохилтой вэ?

Олборлох салбарын ил тод байдлын төлөө ТББ-уудын эвслийн үзэж байгаагаар юуны өмнө Монголын Засгийн газар энэ оны эхэнд нэгдэн орсон Олборлох салбарын ил тод байдлын санаачилгыг ам хэлээр төдийгүй ажил хэрэг дээр түргэн шуурхай хэрэгжүүлэх ёстой болно. Хэдийгээр манай улс энэ чухал санаачилгад харьцангуй хожуу нэгдэн орсон ч Монголын хууль тогтоомж Төв Азийн санаачилгад манайхаас өмнө нэгдсэн зарим орноос илүү хурдан урагшлах бололцоо олгож магадгүй юм. УИХ-аар баталсан Ашигт малтмалын тухай шинэ хуульд (48 дугаар зүйлийн 10 дахь заалт) “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” гэж заасан. Энэ нь саяхан Норвегийн нийслэл Осло хотноо чуулсан Олборлох салбарын ил тод байдлын санаачилгын дээд хэмжээний уулзалтад оролцогчдод хандаж Америкийн тэрбумтан Ж.Сорос видео дэлгэцээр хэлсэн үгэндээ санаачилгыг хэрэгжүүлэхэд ахиц олж байгаа хоёрхон орныг дурдахдаа Монголыг нэрлэхэд хүргэсэн болов уу.

Гэхдээ одоогоор энэ заалт зөвхөн цаасан дээр байгааг та бид бүгд мэдэж байгаа. Ирэх оны эхний улиралд компаниудын тайлан хуульд заасны дагуу нийтлэгдэж эхлэхийн тулд наад зах нь тайлангийн маягт нэн даруй бэлэн болох ёстой. Эгнээндээ улсад бүртгэлтэй 16 ТББ-ыг нэгтгэсэн манай эвсэл иргэний нийгмийн сонирхол, байр сууринаас боловсруулсан маягтын хувилбараа санаачилгыг хэрэгжүүлэх Үндэсний зөвлөл, ажлын хэсэгт санал болгох гэж байгаагаар энэ дашрамд дуулгая.

Ирэх оны эхний улиралд зөвхөн уул уурхайн компаниудын төдийгүй Засгийн газар (Үндэсний татварын ерөнхий газар), аймаг, орон нутгийн татварын хэлтсийн уул уурхайн компаниудаас улс, орон нутгийн төсөвт төлсөн татвар хураамжийн тайлан нэгэн зэрэг нийтлэгдэх нөхцлийг бүрдүүлэх нь санаачилгыг хэрэгжүүлэх чухал түлхэц болно. Тэрчлэн хараат бус аудитыг зөв сонгох нь амжилтын тулгуур болох учиртай.

Манай эвсэл зөвхөн санхүүгийн тайлангийн хүрээнд олборлох салбарын ил тод байдал хангагдана гэж үзэхгүй байна. Санхүүгийн мэдээлэл ил болох нь эхний алхам боловч цааш ахин олборлох салбараас төсөвт орж байгаа асар их мөнгөн урсгалын зарцуулалтыг ил болгох учиртай.

Үүнтэй зэрэгцүүлэн ашигт малтмалын орд газруудтай холбоотой уул уурхайн гэрээ хэлэлцээрүүдийг ил болгох, ийм гэрээ хэлэлцээр байгуулах явцад эрх ашиг нь хөндөгдөх орон нутгийн иргэдийн төлөөллийг заавал оролцуулдаг шинэ жишигт шилжихийг санал болгож байна.

Орд газруудын тусгай зөвшөөрөлтэй холбогдох мэдээлэл Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын вэб сайтад боломжийн нээлттэй байгааг тэмдэглэхийн сацуу одоо хэр хамгийн хаалттай байгаа хуулийн хэллэгээр бол

лиценз шилжүүлэх, үнэн хэрэгтээ лицензийн арилжааны тухай мэдээллийг ил болгож, үүнээс олсон ашгаасаа ямар хэмжээний татвар төсөвт төлснөө нийтлүүлж байхыг уул уурхайн компаниуд, аж ахуйн нэгж, хувь хүмүүст уриалж байна.

Олборлох салбарын ил тод байдлаас улс, нийгэм, иргэд, хувь хүн бүгд хожно. Тэгэхдээ мэдээллээ нүцгэлүүлж байгаа уул уурхайн компаниуд эцсийн дүндээ хамгийн их хожих юм. Иргэдийн итгэл нэмэгдэж бизнесийн таатай орчин бүрдэнэ. Хэн нэг том даргын гар хүндрүүлэх ч юм уу, орон нутгийн аль нэг хурган түшмэлийн машин унаа, эхнэр хүүхдийн аар саар хэрэгцээ, сумын наадмын бай шагналд өртэй юм шиг гар сунгахаа болино.

Өгсөн ч хандив тусламжаа ил тод нийтлүүлж хэвшицгээе.

Төлсөн нь төлснөө, авсан нь авснаа олон нийтэд дэлгэх цаг болжээ.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Ж.Занаа /Иргэдийн Альяанс төв/:

Төрийн ил тод байдлын тухай ярьж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-д айлчилж байгаа. Гэтэл ийм ийм асуудлын тухай ярилцахаар ОХУ-д айлчилж байна гэдгээ яагаад хэлээгүй юм бэ? Таван толгойн ордын асуудлаар ярилцах гэж явсан тухай сониноор бичээд байна. Үнэхээр Таван толгойн ордыг Орост худалдахаар явсан уу?

Б.Болдбаатар /“Миний Монголын газар шороо” хөдөлгөөний гүйцэтгэх захирал/:

Тамсагбулагаас өдөр шөнөгүй нефть зөөгөөд байна. Энэ ямар учиртай юм бэ?

Таван толгойн ордын асуудал байна. “Энержи ресурс” компанийн хайгуулын лиценз дуусаагүй байхад яагаад ашиглалтын лиценз олгодог юм бэ?

Одоогийн Засгийн газар байгуулагдсанаас хойш 812 лицензийг олгосон байна. Энэ ямар учиртай юм бэ?

С.Оюун /УИХ-ын гишүүн/:

Олборлох салбарын ил тод байдлын санаачилга маш хэрэгтэй. Засгийн газар энэ санаачилгыг дэмжээд жил гаруй боллоо. Монгол Улсын иргэн олборлох салбарт хичнээн төгрөг орж байгааг хэзээ мэдэх вэ? Өөрөөр хэлбэл, энэ санаачилгын эхний тайлан хэзээ гарах вэ?

Я.Содбаатар /Үйлдвэр худалдааны дэд сайд/:

Ерөнхийлөгчийн айлчлалын талаар Тамгын газраас нь хариулах байх. Таван толгойн ордыг Орост зарна гэсэн асуудал байхгүй.

Ашигт малтмалын хуулийн дагуу стратегийн ач холбогдолтой ордуудыг эцсийн байдлаар нь оруулсан байгаа. Таван толгойн орд стратегийн ач холбогдолтой гэдэг нь хуулиар олгогдоогүй байгаа.

Тамсагбулагт “Соко” компани нефть олборлож байсан. Одоо Хятадын “Дайчэн” компани худалдаж авч нефть олборлож байгаа. Энэ компани бүтээгдэхүүн хуваах гэрээнийхээ дагуу ажиллаж байгаа.

ҮХЯ-наас Ашигт малтмалын хууль гарахтай холбогдуулж лиценз олголтыг шалгасан. Тэгээд нэг салбарын сайдын тушаалаар өгсөн нь буруу гэж үзсэн байгаа. Зарим иргэний хөдөлгөөний зүгээс Кадастрын албан дээр лиценз олголтын түвшинд янз бүрийн зүйл гарч байна гэсний дагуу УМХГ-аас шалгалт явагдаж байгаа. Шалгалтын дүн ойрын үед гарах байх аа. Яамны шалгалтын дүн бол гарсан.

Д.Батбаяр /Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн ахлагч/:

Дараа оны нэгдүгээр улиралд багтаж хуулиа гаргасан байх ёстой. Нэгдүгээр улирлын тайлан баланс гарсны дагуу нийтэд мэдээлнэ.

Б.Болдбаатар /“Миний Монголын газар шороо” хөдөлгөөний гүйцэтгэх захирал/:

Засгийн газар “Дайчэн Ойл” компанитай бүтээгдэхүүн хуваах гэрээг хийхдээ Хятад 75 хувь, Монгол 25 хувиар тохиролцсон гэсэн. Үүнээс гарч байгаа нэг баррель нефтийн үнэ 63 мянган ам доллар гэж ярьж байна. Үүнээс цааш ямар ч мэдээлэл байхгүй. Энэ талаар мэдье гэхээр ЗГ, ҮХЯ-наасаа асуу гэж байгаа юм. Одоо яг энэ хувиар явж байгаа юу. Хэчнээн хэмжээний олборлолт явуулаад байна вэ? Үүнээс Монгол Улсын төсөвт хэчнээн хэмжээний хөрөнгийг оруулаад байна?

Я.Содбаатар /Үйлдвэр худалдааны дэд сайд/:

“Соко” компани 100 мянган баррель нефть олборлож байсан. Одоо Хятадын компани зардлаа нэмэх төлөвлөгөө гаргаад ажиллаж байгаа. Энэ жил 212 мянган баррель нефть олборлоно.

Монгол Улсын бүтээгдэхүүн хуваах гэрээний хувийг нь би мэдэхгүй байна. Дөчин хэдэн хувь л байх ёстой. Жил жилээр нэмэгдээд явдаг. Та очоод энэ мэдээллийг авч болно. Тамсагбулагаас хүнд нефть гарч байгаа. Яг үйлдвэрлэлийн зориулалттай нефть гарч чадахгүй байгаа.

Энхтөр /“Тосон Заамар” хөдөлгөөн/:

ҮХЯ-ны сайд АМГТХЭГ-т гудамжны хөдөлгөөнүүдэд лицензийн тухай мэдээлэл битгий өг гээд хаасан байсан. Энэ ямар учиртай юм бэ? Лицензийн цаана Монголын ард түмний өмч байгаа шүү дээ.

Я.Содбаатар /Үйлдвэр худалдааны дэд сайд/:

Мэдээллийг хаа гэж хэлээгүй ээ. Харин ч өрөө гаргаж өг гээд өгчихсөн байгаа. Хавраас хойш манай хөдөлгөөнийхөн тэнд сууж л байж байгаа шүү дээ. Хэн тэгж хэлсэн юм бол би мэдэхгүй байна. Манай яаманд тийм бодлого байхгүй.

Ж.Занаа /Иргэдийн Альяанс төв/:

Хууль эрх зүйн орчноос эхэлье. Би нэлээн хууль судалсан. Эвгүй пактууд байдаг юм байна. 1998 оны хуульд үнэт металлыг орлогын албан татвараас чөлөөлөөгүй байсан. Татварын хууль бус хөнгөлөлтөөр “Бороо гоулд” компани 100 хувь чөлөөлөгдсөн. Гаалийн албан татвар зэрэг олон татвараас чөлөөлсөн, одоо ч хүртэл татвараа төлөөгүй байгаа гэсэн.

Нэг юм асуухаар манай дарга нар яаман дээр ирээд үзээрэй гэх юм. Уучлаарай, 2.5 сая хүн ҮХЯ руу гүйж чадахгүй ээ. Вэб ашигладаг хүн манайд 5 хувь л байгаа болов уу. Мэдээллээр ард түмнийг хангахын тулд МҮОНРТ дээр шинэ суваг нээж болно. Олон нийтийн радио, телевизэд өгөх мөнгөө битгий харамлаач. Мөнгө байхгүй гээд суугаад л байдаг. Өөрсдөө болохоор 250 саяар нь аваад л байдаг. Мэдээллийн хэрэгслээр дамжуулж иргэддээ үйлчилмээр байна.

Ашигт малтмалын тухай хууль гарсан байгаа. Гэтэл УИХ-ын гишүүд баталсных нь дараа өөрчлөлт хийсэн. Стратегийн шинж чанартай орд гэдэг хэллэгийг төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн орд гэж зассан байгаа. Энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цацсан. Мөн Үндсэн хуулийн цэцэд энэ асуудлыг өгсөн байгаа.

Бид гадаадын хөрөнгө оруулалттай болон стратегийн ач холбогдолтой ордуудын хөрөнгө оруулалтын гэрээг бие даасан экспертийн дүгнэлтэд үндэслэж хийгээч гэсэн саналыг тавьж байгаа. Гэвч ийм оролдлого хийгдэхгүй байна.

Чагнаадорж /“Ариун суварга” хөдөлгөөн/:

Ил тод байдал гэхээр вэб сайт яриад байх юм. Зарим аймагт интернэт байхгүй шүү дээ. Гэтэл үүнийг л ил тод болгочихлоо гэх юм. Алт олборлож байгаа, бараг гэрээ барих буурьгүй хүмүүс ямар ч мэдээлэл алга байна. Засаг дарга, ИТХ-ын дарга, байгаль хамгаалагч гэсэн харьцаагаар л мэдээлэл хүрч байгаа. Цаашдаа ил тод байдал нь сайжрах болов уу.

“Эрс шинэчлэл” хөдөлгөөнийхөн Баянхонгор аймгийн Цагаанцахиртын уурхайн газар дээр нь очиж танилцаад ард иргэд болон байгаль орчинд хохиролтой гэж тогтоочихоод байхад төрийн цагдаагаас авхуулаад ҮХЯ-наас ямар ч арга хэмжээ авахгүй байсаар нэг малчны 60 мал үхчихээд байгаа.

Би юмыг муу ойлгодог, социализмын үеийн хүн байгаа юм. Орчин үеийн сэхээтнүүдийг яаж гүйцэхэв. Тамсагбулагт нефть олборлож байна гээд Очирбат гуай сайхан дээлээ мялаагаад үнэгүй нефтийн тухай ярьж байсан. Би ч дотроо их баярлаж байлаа. Дараа нь Канадын том компани нь захын наймаачин шиг Хятадад дамжуулж худалдсан гэж ярьж байна.

“Бороо гоулд” компанийн муу муухайг бүгд мэднэ. Би нэг удаа тэнд очлоо. Танайх нөхөн сэргээлтээс оруулах ёстой төгрөгийн хэдэн хувийг нь орон нутагт оруулсан бэ гэсэн чинь ерөнхийлөгч нь үүнийгээ мэдэхгүй байгаа юм. Тухайн сайдтай ярьж тохиролцоод хийсэн гэсэн. Гэтэл миний хажуунаас Шаравдорж гуай босоод ямар сайд гэж асуусан чинь бөөрөнхийлсөөр байгаад өнгөрөөсөн. Одоо дахиад 25 тонн алтны нөөц илэрсэн гэж ярьж байсан. Тэр нь яаж явахыг

бүү мэд. “Айвенхоу Майнз” компанийн захирал нь ярьж байна. Тэд ингэж яриад явах хэрэгтэй шүү дээ. Үнэхээр “Бороо гоулд”-ыг бид дийлэхгүй байна.

Өвөрхангай аймгийн “Гацуурт” компани Монгол улс даяар нөхөн сэргээлтийг сайн хийж байна гэж магтаад байсан. Тэдний нөхөн сэргээлт гэж юу байхав дээ. Өрөө шиг газарт мод тарьж үрлүүлчихсэн байсан шүү дээ. Тэднийх Орхон Гурван тээл гэдэг газрын эхэн дээр алтаа олборлоод байгаа. Тэнд Улаан цутгалан байхгүй болж байна. Энэ гол, нуураа хамгаалах талаар бодмоор юм.

Энхтөр /“Тосон Заамар” хөдөлгөөн/:

Олборлох салбарын уурхайнууд ямар ард түмнийг тэжээж байна вэ. Бодитой хэдэн жишээ дурдъя. Засгийн газар нинжагийн дайралтаас болоод Заамарын ар талыг онцгой объект гэж хамгаалалтад авсан. Тэгээд тор татчихаад иргэний үнэмлэхгүй хүн түүгээр гарах боломжгүй болчихсон. Малчин байнга үнэмлэхээ авч явж чадахгүй. Тийм учраас иргэдийнхээ гар дээр нь тамгалаад өгчихвөл яасан юм бэ.

Нинжа нарыг том машинд ачаад Туулын гүүрний цаана буулгаад хаячихсан. Тэд иргэд шүү дээ.

Би үүнээс юу хэлэх гээд байна гэвэл тодорхой тогтоол шийдвэр нь хэрэгжих үедээ маш хурдан, сайн хэрэгжээд байдаг. Гэтэл зарим талаараа учир дутагдалтай байгаа. Тэгэхээр хөрөнгө оруулалттай компаниуд нөхөн сэргээлтээ төдий хугацаанд хий гэдгийг төрөөс хатуу шаардаж баймаар.

Олборлох салбарыг ил тод байлгая гэвэл орон нутагтай холбоотой мэдээллийн сүлжээг бий болгох хэрэгтэй байгаа юм. Уул уурхайн салбарт авилгалын хамгийн том хэлбэр явж байгаа. Мэргэжлийн хяналтын байгууллага, төрийн шат шатны албан хаагчид, иргэдийн хурал гээд. Авилгал нь тодорхой ханштай, бүр орлого нь төрөлжихсэн байгаа. Иргэд очоод компанитай хэрүүл хийхээр тэр хэрүүлийн дундаас нь мөнгө олдог. Ялангуяа Мэргэжлийн хяналтын байгууллагад дутагдал их байгаа. Тиймээс олборлох салбарын ил тод байдлыг нээлттэй байлгая гэвэл төр анхааралдаа авах хэрэгтэй байна.

Ариунаа /Баянхонгор аймаг/:

Цагаанцахиртад 5 тонн циант натри яригддаг байсан чинь одоо амонитын тухай яригдаж байгаа. Хэрэгцээгээ хангах гэж хүний эрхийг зөрчдөгөө зогсоох хэрэгтэй. Цагаанцахиртын уурхайг зогсоогоод өгөөч. Үүнийг шийдэхэд нутгийн байгууллагын эрх нь хүрэхгүй байна.

С.Ганбаатар /“Үндэсний Соёмбо” хөдөлгөөн/:

Өдөр бүр харсаар байгаад их дотно болчих юм. Энхболд сайдад хэлж өгөөч гэж хүсч байна. Оюутолгой, Таван толгой гэсэн маш том ордуудын тухай ярьж байна. Энэ бол зөвхөн өнөөдрийн юм биш. Тийм учраас “Бороо гоулд” шиг алтаа тавиад туучихгүйн төлөө дэлхийн хэмжээний, мэргэжлийн бие даасан техникийн

экспертүүдийг оруулж дүгнэлт гаргуулах хэрэгтэй. Өнгөрсөн оны тавдугаар сард та бүхнийг оролцуулж байгаад шийдвэрлэсэн шүү дээ. Гурван сарын дотор буюу 9-р сарын 1-эн гэхэд шийдвэр гаргахад тусалж болохуйц дүгнэлтийг гаргана гэсэн чинь хаашаа алга болчихов оо. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үл тоож өөрсдийгөө дэлхийн цөм гэж ойлгож байгаа явдлаа таслан зогсоогооч. Улстөрчдийг бид нар бүхнийг мэднэ гэж бурханчлан гаргаагүй ээ. Үнэн зөв сэтгэлтэй байгаарай гэж гаргаж байгаа юм.

Кадастрын албаны лиценз өгдөг нөхдүүд идээд болохоо болилоо гээд иргэний нийгмийн байгууллагаас нэлээн хүчилсний үр дүнд сумын ИТХ шийдвэр гаргахад нь оролцоно гэдгийг та бүхний тусламжтайгаар хуульд оруулсан байгаа. Гэтэл сумын засаг дарга нар шиг баяжиж байгаа хүн ойрын үед алга аа. Тэгэхээр сумын иргэд маань энэ асуудал дээр хяналтаа сайн тавьдаг байгаасай гэж хүсч байна.

Цагаанцахиртад цианитийн 5 тонн хор байна гэдгийг жилийн өмнө Содоо сайд бид хоёр ярьж байсан. Одоо 70 ямаа үхсэн гэнэ. Хүн үхэхийг нь хүлээгээд байгаа юм уу? Тодорхой арга хэмжээ аваач ээ. Та нартайгаа хамтран ажиллаж эв дүйгээ олно гэж бид харсаар байна. Зэвсэг барихгүйн тулд жагсаал цуглаан хийдэг аргыг хүн төрөлхтөн нээж олсон гэж би ойлгодог.

Отгонцэцэг /“Онон Улз гол” хөдөлгөөн/:

Орон нутагт ил тод байдал алга байна. Төрийн болон татварын асуудлаар мэдээлэл авах гээд очиход өгдөггүй.

Сонинуудад лиценз худалдах зар явах юм. Утасны дугаарын дагуу залгаж үзлээ. Сэлэнгийн Ерөөд алтны орд газар худалдана гэж байна. Гэтэл тэр газрын доорх баялгийг аж ахуйн нэгж банканд барьцаалаад зээл авсан юм байна. Банкны ажилтан энэ тухай хэлсэн. Энэ бол жижигхэн орд газар байгаа юм.

Хайгуулын лицензийн шинэчилсэн бүртгэлийг ямар журмаар явуулах вэ?

О.Цэрэннадмид /Зориг сан/:

ОБИТБС-ыг хэрэгжүүлэхэд зориулж энэ оны төсөвт мөнгө суусан уу?

Батболд /Сэлэнгэ аймгийн Ерөө сумын салбар зөвлөл/:

Иргэдээ муур хулгана болгож тоглодгоо болимоор байна. Учир нь нинжа нар аймгаас аймаг руу паасалдаг болчихлоо. Нинжагийн хуулийг гаргахад дэмжих нь зүйтэй юм.

Цианитыг хянах ажилтан манай суманд байдаггүй. Үүний үр дагавар нь арваад жилийн дараа гарна.

Б.Болдбаатар /“Миний Монголын газар шороо” хөдөлгөөний гүйцэтгэх захирал/:

“Цайрт минерал” компанийн Ганбат гэдэг хүн 49 хувийг нь эзэмшдэг гэсэн. Хятадын 200 сая юанийн хөрөнгө оруулалттай, Засгийн газраас бас баталгаа гаргаж өгсөн байна. Энэ бол Монгол Улсад асар баялагтай орд. Хажуудахь компани нь бас ямар ч хараа хяналтгүй гараад явдаг юм байна лээ. Тийм учраас ҮХЯ олон нийттэй хамтарч ажилламаар байна.

ҮХЯ-наас манай хөдөлгөөнд хандаж албан бичиг ирүүлсэн. Танайх стратегийн ач холбогдолтой ордуудад санал оруулсан байна лээ. Түүндээ 23 ордыг оруулчихжээ. Гэхдээ Нарийн сухайтын нүүрсний орд, Төмөртэй ороогүй байгаа мөртлөө Хустай, Төмөртөлгой зэрэг жижиг ордуудыг оруулах боломжтой гэсэн байна. Том ордыг яагаад оруулаагүй юм бэ?

Бадраа:

Тавантолгойн орд газарт орон нутаг дэмжээгүй байхад лиценз олгосон байна.

Хувиараа алт олборлогчид Өмнөговийн бүх суманд бий. Нэгдсэн бодлого баримтлахгүй бол уул толгод, ус голууд бүгд цианид, мөнгөн ус болж дуусах нь ээ. Өмнөговьчууд амьдрахад хэцүү болох нь байна шүү.

Бямбажав /Судлаач/:

Юуг ил тод болгох вэ гэдгийг хамгийн түрүүнд ярих хэрэгтэй юм. Яг ийм ийм асуудлыг ил тод болгоно гэж. Ил тод биш байгаа учраас хөдөлгөөнүүд бий болж байгаа. Тэгээд хардаж байна. Ард түмний хүртэх ёстой юмыг л ил тод болгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, ил тод болгох үзүүлэлтүүдээ тогтоох хэрэгтэй. Төсөвт орж байгаа зүйлс нууц байгаа. Төсвийн орлогыг өнөөдөр ч мэдэхгүй байна.

Ашигт малтмалын хуулиар Тогтвортой байдлын гэрээ ил тод байна гэж заасан. Энэ нь буруу юм. Хамгийн түрүүнд хөрөнгө оруулалтын гэрээгээ байгуулдаг, хамгийн сүүлд нь 5 жил, 10 жил тогвортой байна гэдгээ тохирдог.

Гомбосүрэн /ШУТИС-ийн Уул уурхайн сургуулийн тэнхимийн эрхлэгч/:

Би уул уурхайн инженер хүн. Салбарын бодлогын асуудлаар нэлээн хэдэн жил ажиллаж байгаа. Цианид, мөнгөн усны тухай их ярьж байна. Энэ нь их хүнд байдалд орж байх шиг.

Хөрөнгө оруулалтын гэрээ гэж ярьж байна. “Айвенхоу майнз”-тай хурдан байгуулбал зүгээр. Гэхдээ яарч хуудуутай юм хийж болохгүй. Эхлээд ТЭЗҮ хийх хэрэгтэй. Нөгөө талаас хөдөлмөрийн зах зээлийн квотыг хэрэгжүүлэх талаар хөрөнгө оруулалтын гэрээнд тусгах хэрэгтэй.

50 хувь, 34 хувь гэж яриад байгаа. Би Ашигт малтмалын тухай хуулийг бүхэлд нь шүүмжлэхгүй. Гэхдээ зарим нэг зүйлийг тодруулахгүй бол болохгүй. Улсын

төсвөөр хайгуул хийсэн ордыг 50 хүртэл хувь хөнгөлнө гэж заасан байгаа. Хөнгөлнө гэдэг нь юу гэсэн үг вэ? Сайд очоод 5 хувиар байгуулчихсан байхад хэн ч мэдэхгүй шүү дээ. Зөндөө олон хуульчид байгаа. Гэтэл тэд мэдэхгүйдээ биш, цаана нь өөр ямар нэгэн учир байна. Энэ бүхнийг сайн тооцоолж хийгээсэй гэж бодож байна.

Иргэний хөдөлгөөнийхөн ярьж байна. Гаднаас эксперт авчирч хийлгэ гэж. Үүнээс өмнө “Айвенхоу майнз”-ыг яаж ашиглах тухай ТЭЗҮ хийлгэх хэрэгтэй. ТЭЗҮ нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндэслэл юм.

Баярсайхан /“Хил хязгааргүй алхам” ТББ/:

Олборлох салбарын ил тод байдлын санаачилгыг дэмжиж, Ерөнхий сайд нэгдэнэ гэдгээр зарласан. Тэгээд Үндэсний зөвлөл байгуулсан. Жилийн хугацаанд нэг удаа хуралдсан юм байна. Үүнд гурван талын оролцоо чухал. Ийм учраас саналыг дэмжиж, эвсэл байгуулагдсан юм байна. Арван зургаан ТББ нэгдсэн юм байна. Үүнийг нэмэгдүүлж олон болгох хэрэгтэй. Иргэний нийгмийн байгууллагууд үүнд хүчээ нэгтгэх ёстой гэж бодож байна. Үндэсний зөвлөл болон ажлын хэсэгт иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийн гуравны нэгийг оруулах хэрэгтэй. Гэтэл уул уурхайн ассиоциацийг оруулчихдаг. Энэ байгууллага бол үйлдвэрлэгч компаниудын эрх ашгийг хамгаалах байгууллага шүү дээ. Тэгэхээр иргэний төлөөлөл болж чадах уу, үгүй юү. Эвсэл далайцтай хүчтэй шаардаж ажиллахгүй бол төр засаг болон үйлдвэрлэгч байгууллагууд үүнийг хэрэгжүүлэхэд төдийлөн чармайхгүй дээ.

Цэрэндаваа /“Жамп” компани/:

Төрийн ил тод байдал гэдгийг зөв ухамсарлаж ярих хэрэгтэй. “Айвенхоу Майнз”-ын тухай яриад байх юм. Төрөөгүй хүүхдэд төмөр өлгий гэгчээр. Нөөц нь батлагдсан юм уу. Хэн ч батлаагүй шүү дээ. Тогтоогдоогүй юмны төлөө юу яриад байгаа юм бэ. Төрөө дандаа шүүмжлээд байх юм. Хамтарч ажиллаач ээ.

Засгийн газарт шүүмжлэлтэй хандах зүйл байгаа. Хөдөө орон нутгийн Засаг дарга, сумын ИТХ, тэнд ажиллаж байгаа байцаагч нар төрийн бодлогыг хэрэгжүүлж чадахгүй байгаа. Хамтарч суугаад ярилцъя, ингэж тохирч ийм зарчим дээр ажиллая гэхийн оронд эмнэлгийн дээврийг засах, цагаан сараар хөгшиддөө хэдэн боов өгч шагнуулахын төлөө л явдаг. Суманд үнэхээр хөрөнгө байхгүй.

Нөөцийн татвар гэж яриад байна. 2000 оноос өмнө 5 хувийг нь суманд өгдөг байсан. Манайх Увс аймгийн Зүүнхангай суманд олборлолт явуулдаг. Банкаар дамжуулаад шилжүүлдэг л байсан юм. 2000 оны сонгуулиас хойш устгаад хаячихсан. Сумын Засаг дарга нь гараа хүлүүлчихсэн. Яагаад гэвэл ямар ч мөнгө байхгүй. Тэгэхээр олборлолт хийж байгаа компанийн аманд орохгүй яадаг юм бэ.

Ярьж байгаа хүмүүс үнэхээр үнэн юм ярьж байна. Зөв саналууд гарч ирж байна. Олборлолт хийж буй компани нүүрээ буруулж явахгүй ээ. Алт олборлоод найман жил боллоо. Ажиллаад болоод л байдаг юм. Хоорондоо зохицох, тохиролцох асуудал бол бий.

1997 оны хуульд тусгасан шүү дээ. Харин хэрэгжүүлэх шатанд толгойг нь тасдаад хаячихсан. Хэрэгжүүлж байгаа мэргэжлийн хяналтын ажилтнууд ямар ч мэдлэг чадваргүй, боловсролгүй хүмүүс байдаг. Үүнд Засгийн газар анхаарах хэрэгтэй. Бодлогыг унагаагаад байгаа хүмүүс чинь дунд шатандаа байгаа шүү.

“Онон Балж гол” хөдөлгөөний хүн үг хэллээ. Бид хамтарч ажиллахад бэлэн. Битгий шүүмжлэлийн байр сууринаас хандаач ээ. Ойртож, уулзаж ярилцаач ээ. Хамтарч ажиллана гэхээр манай энэ хүнийг ажилд ав гэж шахдаг. Тэгээд ажилд авахаар архи уудаг, хулгай хийдэг, мэргэжилгүй хүмүүс байдаг. Одоо ч гэсэн нэг бульдозерыг маань шатаачихсан сууж байгаа. Ийм асуудал их гардаг. Тэгэхээр сумын удирдлагыг зөв гольдролд нь оруулж ажиллуулах хэрэгтэй юм. Та нар хяналтаа тавьж ажиллаач ээ. Бид хамтран ажиллахад бэлэн.

Ц.Монгол /Хаан банкны хуулийн газрын дарга/:

Нийгмийн баялгийн хуваарилалт шударга зарчмаар явагдахгүй байна. Монголын Үндэсний аюулгүй байдалтай холбоотой учраас шүүмжилж яриад байгаа юм. Тодорхой эрүүл саруул нам, хөдөлгөөн нэгдэж асуудалд хандахгүй бол дийлэхгүй ээ.

Гадныхнаас айх юм байхгүй. Ямар ч юм гарсан ч шударга зарчмаараа явчихна. Манай хүмүүс хувийн байдлаа ашиглаж аюулгүй байдалд хохирол учруулж байгаа. Дотроо төрөө цэвэрлэж авахгүй бол гадаадынхан руу дайраад шийдэж чадахгүй. Энэ тал дээр аль аль талаасаа ухаантай хандаж ажиллах нь чухал.

ҮХ-ны сайд гадаадын хөрөнгө оруулалтын хуулийн 100 хувь гэдгийг эргэн харж үзмээр юм. Гадаадын хөрөнгө 49 хүртэл хувь гэлээ ч болохгүй байгаа шүү дээ.

Я.Содбаатар /Үйлдвэр худалдааны дэд сайд/:

Олон нийтийн болон иргэний нийгмийн хөдөлгөөнүүдийн хяналт сайжирч байгаа. Төрийн ажил хийж яваа бид нарт ч тустай.

Цагаанцахиртын уурхай дээр хавраас эхлээд ажиллаж байна. Ажлын хэсэг гурван удаа явуулсан. Хуулийн дагуу ажиллаж болно гэсэн УМХГ-ын дүгнэлт гарсан. Гэтэл дахиад мэдээлэл ирсэн. Одоогоор үйл ажиллагааг зогсоосон байгаа. Эхлээд цианитын хүчлээр, дараа нь амонитын хүчлээр дүгнэлт гарсан. 64 ямаа үхсэн асуудал бий. Занданшатар гишүүн газар дээр нь ажиллаж байгаа.

Хөрөнгө оруулалтын гэрээг хуульд нэлээн тодорхой зааж өгсөн байгаа. Хэдэн талаас нь сайн харж үзэж байгуулна. Монгол Улсад ашигтай, бас бизнес хийж байгаа хүмүүстээ ч ашигтай байдлаар зохицуулах нь мэдээж.

Стратегийн ач холбогдолтой ордууд гэдгийг УИХ-аас шийдээгүй байгаа.

Үндэсний болон олон улсын экспертүүдийг авна гэж Ерөнхий сайд хэлсэн. Үгүй гэж хэлээгүй. Энэ байр суурин дээрээ байгаа.

Хөрөнгө оруулалтын гэрээн дээр олон зүйлийг тусгана. ТЭЗҮ-г баталж байж хийнэ. “Айвенхоу Майнз” компани дээр одоо нөөц авах ажил явж байгаа.

Гар аргаар алт олборлох асуудал ганц манайд биш, дэлхийд 300, 400 жилийн өмнө байсан юм билээ. Энэ харилцааг зохицуулсан хууль гаргах хэрэгтэй байгаа. Химийн бодисыг яаж ашиглах вэ гэдэг дээр гацчихаад байна.

Нэмжхэлэхэд Монгол Улсын ногоон бүсийн хууль гаргахаар бид боловсруулж байгаа.

Ил тод байдал их чухал. Энэ тал дээр шүүмжлэл байгаа. Та бүхнийг механизмын талаар тодорхой санал хэлбэл зүгээр болов уу гэж бодож байна.

Д.Батбаяр /Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн ахлагч/:

Төсөвт мөнгө суугаагүй. Дэлхийн Банктай ярьж байгаа.

ХААЛТЫН НЭГДСЭН ХУРАЛДААН

Хурал даргалагч нар дэвшүүлэх саналынхаа тоймыг тус бүр танилцуулсны дараа оролцогчид саналаа хэллээ. Форумыг хааж ННФ-ын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал үг хэлсэн юм.

Д.Ганбат /УТБА-ийн гүйцэтгэх захирал, ННФ-ын Удирдах зөвлөлийн гишүүн “Төрийн ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчин, хэрэгжилт” хуралдааныг даргалагч/:

“Төрийн ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчин, хэрэгжилт” хуралдаанаас дараах асуудлыг дэвшүүлж байна. Нийтэд нь дөрвөн хэсэгт хувааж үзсэн байгаа. Үүнд:

- Ил тод байдлын эрх зүйн зохицуулалт,
- Мэдээллийн хүртээмж,
- Үйл ажиллагааны нээлттэй байдал,
- Иргэдийн оролцоо юм.

Ил тод байдлын эрх зүйн зохицуулалттай холбоотой асуудлаар:

- ил тод байдлын үзэл баримтлал нь хуулиудад нэгдсэн бодлого, нэгдсэн зарчмаар тусгагдах,
- үйлчилж буй хуулиудын уялдааг ил тод байдлын зарчмын дагуу эргэж хянаж сайжруулах,
- хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэж батлах, хуулийн хэрэгжилт болон бүхий л шатанд ил тод байдлын зарчмыг мөрдөж хангах тухай тусгай журмын тухай хуулийг баталж гаргах,

Мэдээллийн хүртээмжийн асуудлаар:

- мэдээллийн эрх чөлөөний хуулийг нэн даруй батлах,
- нууцтай холбоотой хуулийг олон улсын стандартад нийцүүлэн өөрчлөх,
- байгууллагын нууцын тухай болон хувийн нууцын тухай хуулийг хүчингүй болгох, зохицуулалтыг холбогдох хуулиудаар зохицуулах,
- төрөөс иргэдэд мэдээллээр үйлчлэхэд учирч буй хандлага болон биет саадыг арилгах,

- төрийн байгууллагуудад иргэдэд мэдээллээр үйлчлэх бүтцийг бий болгох, төсөв гаргаж санхүүжүүлэх, иргэдийг мэдээллээр хангахуйц сан бий болгох,
- төрийн байгууллагуудаас иргэдийг мэдээллээр хангахдаа үнэ төлбөргүй үйлчилдэг болгох,

Үйл ажиллагааны нээлттэй байдлын хүрээнд:

- үйл ажиллагааны нээлттэй байдлын зохицуулалтыг хуульд тусгах, нээлттэй байдлыг хаасан аливаа журам дүрмийг хүчингүй болгох,
- төрийн байгууллага, үүнд УИХ, ИТХ-ын үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй байх боломжийг хангаж бүрдүүлэх, үүнд биет хүчин зүйлс буюу байр танхим, хуралдаан, зарлал, мэдээллийг цаг тухайд нь хүргэх асуудал багтана.
- төрийн байгууллагуудаас гарч байгаа аливаа шийдвэрүүдийн төслийн хувилбаруудын үндэслэл, шийдвэр гаргах үйл явц нь иргэдэд нээлттэй байх,
- төрийн байгууллага нь үйл ажиллагааны ил тод байдлын зарчмыг хангасан талаарх тайланг жил бүр гаргаж олон нийтэд мэдээлдэг болох.

Иргэдийн оролцоотой холбоотой асуудлаар:

- аливаа хууль, шийдвэрийн төслийг олон нийтэд хангалттай хугацааны өмнө бүхий л хэлбэр, арга замыг ашиглан хүргэх, санал авах, эргэж иргэдэд мэдээлэх механизмыг хуульчлах,
- төрийн бүхий л шатанд шийдвэр гаргахдаа иргэдийн оролцоог нээлттэй хэлэлцүүлэг гэх мэтийн хэлбэрээр хангаж байх,
- төрийн байгууллагын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлан хэлэлцүүлэг зэрэг үйл ажиллагаанд иргэний нийгмийн төлөөллийг оруулж байх гээд дөрвөн бүлэг нь дотроо 15 санаа болж задарсан байгаа юм.

Ц.Ганболд /“Олборлох салбарын ил тод байдлын төлөө” ТББ-уудын эвслийн зохицуулагч/:

Хурал даргалагчийн зөвлөмжид “Мэдээллийн эрх чөлөөний хуулийг нэн даруй гаргах” гэж орсон байна. Нэн даруй батлах хэрэгтэй гэдгийг ярьсаар байгаад найман жил өнгөрлөө.

1998 оноос хойш авилгалын хуулийг ярьсаар байгаад сая нэг баталсан. Хууль нь гарснаас хойш ОНРТ-ийн хуулийг зургаан жил хагас болж байж баталсан. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар манай иргэний нийгмийн байгууллага маш идэвхтэй ажилласан. Би хувьдаа 10 гаруй удаа семинарт нь оролцсон юм байна. Одоо үнэхээр энэ хуулийг гаргах цаг нь болсон.

Лүндээ дарга хэлсэн шүү. Мэдээллийн эрх чөлөөний хууль олон жил яригдаж байгаа, яригдаад байх нь их зүгээр, бас хурал хийгээд байх зүгээр гэж. Ямар утгаар хэлж байгааг нь би сайн ойлгосонгүй.

Форумын хамгийн том үр дүн бол Мэдээллийн эрх чөлөөний хууль байж магадгүй. Гэхдээ одоо үүнийг ярих хэрэггүй. Миний сонссоноор 10-р сард Шадар сайд Энхсайхан “энэ хууль бол мэдээллийн аюулгүй байдал, улс орны аюулгүй байдалтай холбоотой асуудал” гээд буцаасан гэнэ. Энэ нь үнэн юм шиг байна. Яагаад гэвэл Лүндээжанцан дарга Орост очоод суверный демократ гэсэн сайхан хоршоо үг сонсож ирсэн, тэгээд үндэсний аюулгүй байдалтай холбоотой гээд энэ хуулийг дахин 15 жил хэлэлцэх юм шиг байна.

УИХ-ын гишүүд хүссэн хуулиа бол нэг хоногийн дотор л баталж байгаа шүү дээ. Ашигт малтмалын тухай хуулийг зургаан сар яриулж яриулж байгаад наадмын өмнөхөн өөрсдийн хүссэн байдлаараа нэг хоногийн дотор баталсан. Тийм учраас Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шахалтын маягаар оруулж хэрэггүй болов уу. УИХ-ын гишүүдэд төслөө хүргүүлчихээд УИХ-ын гишүүдээс хэн нь дэмжиж байгаа, хэн нь дэмжихгүй байгааг нь мэдээллийн хэрэгслээр ил тод зарлаад энэ хуулиа жаахан шахах хэрэгтэй. Хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын боловсон хүчний асуудал, санхүүжилтийн асуудал яригддаг л юм байна лээ. Бид үндэсний аюулгүй байдлын түвшинд мэдээллийг шаардахгүй нь мэдээж. Монгол Улсын иргэн Дорж Баянхонгор аймгаас ирээд Содбаатар сайдтай уулздаг ийм түвшинд хүрэхийн тулд Мэдээллийн эрх чөлөөний хуулийг батлуулах акц зохион байгуулах санааг санал болгож байна. Зөвхөн Ганбаатар биш. Ганбаатарыг л очихоор Болормаа ч найр тавиад, Содбаатар сайд ч найр тавиад байж болохгүй шүү дээ.

С.Оюун /УИХ-ын гишүүн/:

Товчхон мэдээлэл өгье. Ганболд гуайн хэлсэн нь зөв л дөө. УИХ-ын гишүүн Сү.Батболд энэ хуулийг санаачлаад Засгийн газраас санал авахаар гурван долоо хоногийн өмнө хүргүүлсэн байгаа. Энэ дээр зөв зүйтэй саналуудаа нэмэрлэж, шахаж шаардах нь зүйтэй байх аа.

ИТХ-ыг ил тод байлгах тал дээр нэмэлт нэг санал байна. Иргэдийн хуралд аймаг, орон нутгаас сонгогдож буй төлөөлөгчдийн ихэнх нь ЗДТГ-ын хэлтэс, агентлагийн дарга нар байдаг. Тэгэхээр энэ хүмүүс Иргэдийн хурлын үйл ажиллагааг мөн чанараар нь явуулж хэзээ ч чадахгүй. Энэ байгууллагын ЗДТГ-ын үйл ажиллагааг хянаж байх механизм нь алдагдсан байгаа. Тэгэхээр хуралд сонгогдож байгаа хүмүүсийн бүтцэд өөрчлөлт оруулах, эсвэл, нэр дэвшиж байгаа төлөөлөгчид нь өөрсдийн албан үүргээс чөлөөлөгдөх гэсэн заалтыг хуульд тусгуулбал яасан юм бэ.

С.Ганбаатар /“Үндэсний Соёмбо” хөдөлгөөн/:

Та нарын саналыг жаахан детальчлаад өгчихмөөр байна. Ил тод байдлын төлөө гэсэн гарын авлага хиймээр байгаа юм. Баг, сум, аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргаас ийм ийм асуултыг асууж болно гэсэн 4-5 асуулт бэлдээд гаргачихъя.

Бид ил тод байх ёстой гэж ярьчихаад төрөөсөө юуг асуух вэ гэхээр л гацчихаад байна шүү дээ. Төр маань бидний урдаас маш олон хуулиар боомилдог. Тэд бидэнд үйлчлэхгүй байгаагаа хуулиар гоё тайлбарладаг, хуулийг сайн ашигладаг болчихсон шүү дээ. Энэ гарын авлагыг ойрын үед гаргах боломж байна уу?

П.Эрдэнэжаргал /ННФ-ын гүйцэтгэх захирал/:

Өнөөдрийн асуудлуудтай холбож тусгайлсан гарын авлага гэж ойлгож болох уу. Жишээлбэл, эцэг эх нь сургуулийн захиргаанаас ямар асуулт асуух ёстой юм бэ гэх мэтээр төрөлжүүлсэн цуврал гарын авлага гэж ойлгож болох уу. Эсвэл төрийн ил тод байдлыг хангах чиглэлээр нэгдсэн гарын авлага гэж хэлээд байна уу?

С.Ганбаатар /“Үндэсний Соёмбо” хөдөлгөөн/:

Тантай санал нэг байна. Муу юмнаас сайн юм үүсдэг гэгчээр төр маань их муу юм хийж байгаа учраас бидэнд ийм сайхан гарын авлага гаргах боломж олдоод байна л даа. Тухайлбал, хүүхдүүдийн өдрийн ундны асуудал дээр бид бачуураад л байгаа болохоос төсвийн байгууллага үүнд хэдэн төгрөг, яаж зарцуулаад байгаа юм, хаанаас нийлүүлж байгаа юм бэ гэсэн асуултыг мэдүүлэх гэсэн санаа юм.

Б.Болдбаатар /“Миний Монголын газар шороо” хөдөлгөөний гүйцэтгэх захирал/:

МҮОНРТ бол биднийх шүү дээ. Энэ байгууллагыг бидний ил тод байлгах зүйлийг хариуцсан байгууллага гэж ойлгож байгаа. Өнөөдөр олон нийтийн радио, телевизэд Үндэсний зөвлөл гэж байхгүй. Бүтэн жил юу ч хийсэнгүй. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль гарсан. Гэтэл бүх юм нь цензуртэй, нэг нь нэгийгээ үгүйсгээд явчихсан хууль байгаа юм. Өнөөдөр олон нийтэд ил тодоор явуулах ёстой юм нь алдагдсан байна. Үүнийг цэгцлэх ёстой болов уу.

Бид нэвтрүүлэг хийлгэх гээд очдог юм. Тэгэхээр нэг минутад 100 мянган төгрөг төлөх ёстой болдог. Энэ нь батлагдсан юм уу гэвэл үгүй. Үндэсний зөвлөлөөс асуухаар тэр ч мэднэ, энэ ч мэднэ, гүйцэтгэх захиралтайгаа гэрээ хийж байгаа гэсэн юм хэлдэг. Үндэсний зөвлөл нь хоёр гурван хэсэгт хуваагдчихсан байдалтай. Олон нийтийн телевиз, радио байхгүй болсныг та бүхэн ч харж байгаа байх аа.

Ж.Занаа /Иргэдийн Альянс төв/:

МҮОНРТ ажиллаж байгаа. Үндэсний зөвлөлд олон нийтээс сонгогдсон 15 гишүүн ажилладаг. Бүтэн жил нэг намын, нэг засгийн хараанд байсан, нэлээн урхаг, авилгалын хүүдий болсон газрыг олон нийтийнх болгохоор зүтгэж л байгаа. Нэвтрүүлэгт нь маш их өөрчлөлт оруулах гэж үзэж байна. Гэхдээ бидэнд нэвтрүүлгийн бодлогод оролцох эрх хуулиар олгогдоогүй. Харин хяналт тавьдаг. Саяын үг хэлсэн хүний мэдээлэлд буруу зөрүү, сайн ойлгогдохгүй зүйл гарч байна. Энэ хүний араас хөөцөлдөөд явах сонирхол надад алга.

Олон нийтийн радио, телевиз бол Монголын ард түмний өмчөөр бүтсэн байгууллага. Тийм учраас төрийн ил тод байдлыг хангая гэж бодож л байгаа бол олон нийтийн радио, телевизийг ашиглах хэрэгтэй. Олон нийтийн радио, телевиз дээр тусгай сувагтай болъё гэдэг саналыг салбар хуралдаан дээр гаргасан. Энэ сувгаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлогын сайн, муу талыг олон нийтэд мэдээлдэг, тэднээр хэлэлцүүлдэг, тэдэнтэй ярилцаж санал бодлыг нь сонсдог, эрдэмтэд болон судлаачийн санаа бодлыг сонсдог байя. Манай МҮОНРТ чинь ганцхан сувагтай, түүгээрээ түмэн зүйлийн юм явуулж байгаа. Тэгэхээр олон нийтийн радио, телевиз дээр ийм суваг нээж, хамтарч ажиллая гэсэн санааг оруулмаар байна.

Чулуунбаатар /Татвар төлөгчдийн үйлдвэрчний холбооны ерөнхийлөгч/:

Төрөөс иргэдэд ямар мэдээллийг өгөх ёстой вэ гэсэн асуудлыг нухацтай авч үзмээр байна. Хэрвээ үүнийг мэдээлээгүй бол ямар хариуцлага хүлээх ёстой юм бэ. Өөрөөр хэлбэл, мэдээллийг хаасан нөхцөлд яах вэ гэдгийг тодруулмаар юм шиг.

Гэхдээ мэдээллийг хоёр талаас авч үзэх нь зүйтэй. Ил тод байдал нь төр иргэдийн харьцаагаар тодорхойлогддог учраас нэг талаас төрөөс мэдээллийг яаж авах вэ, нөгөө талаас иргэдийн гаргасан санал, гомдлын үр дүнг хэрхэн тооцох вэ гэж. Үүнийг Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд тодорхойлж оруулбал зүгээр болов уу.

Баяраа /Багануур дүүрэг/:

Хамгийн гол нь мэдээллийн мөрөөр ямар хуулийн статустай байгууллага юу хийх вэ гэдэг асуудал их чухал. Энэ талаар анхаарч бичиг баримтдаа тусгаж өгвөл зүгээр болов уу.

Ж.Уртнасан /Татвар төлөгчдийн холбооны дарга, “Улсын төсвийн ил тод байдал” салбар хуралдааныг даргалагч/:

Өнөөдрийн форум зорилтоо хэрэгжүүлээд төгсгөл рүүгээ ойртож байна. Төсөв гэдэг сэдэв өргөн цар хүрээтэй, олон талтай, эмзэг, бас сонирхолтой асуудал байдаг. Өөрөөр хэлбэл, хаантай ч бай, вантай ч бай, ерөнхийлөгчтэй ч бай, парламентын засаглалтай ч бай ямар ч оронд төсөв бол зайлшгүй байх ёстой зүйл юм. Төр оршин буй нөхцөлд төрөөс авдаг хатуу авлага, нөгөө талаасаа иргэд, татвар төлөгчдөөс цуглуулж өгдөг өршөөлгүй өглөг юм. Авлага, өглөг хоёр тэнцэж байж улс орон урагшлах, эс урагшлах нь хэмжигддэг учраас аль ч улсын амин чухал асуудал байдаг.

Энэ сэдэв дээр манай ажлын хэсгийнхэн дөрвөн багц, санаа дэвшүүлсэн. Цаашаа задалбал 23 зүйл дээр ярих болж байна.

1. Төрийн үүрэг, хариуцлага тодорхой байх. Үүнд:

- төсвийн хууль тогтоомж, захиргааны зааварт төсвийг удирдан зохион байгуулах, зарцуулах хариуцлагыг тодорхой болгох,
- бүх шатны төсөв захирагч, эрх бүхий байгууллага болон аж ахуйн нэгж, иргэдэд төсвийн төлөвлөлт, үйл явц, гүйцэтгэлийн тайлангаа тавьж хэлэлцүүлдэг журамтай байх,
- төсвийн үйл явц, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд оролцох эрхийг хуулиар баталгаажуулсан байх.

2. Мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй байх асуудал. Үүнд:

- Төсвийн үйл явцын талаар иргэдийн санал бодлыг төв орон нутгийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан авдаг арга хэлбэрийн тогтоосон журамтай болох,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг нийтэд мэдээлэх хугацаатай болох,
- Мэдээлэл хүргэх нарийвчилсан журамтай байх,
- Иргэд мэдээлэл хүсэхээр хаана, хэнд хандах нь ойлгомжтой байх,
- Төсвийн байгууллагууд тогтмол шинэчилдэг вэб хуудастай байх,
- Төсвийн төлөвлөлтийн үйл явцад олон нийтийн санал хүсэлтийг хэрхэн тусгасныг эргэж мэдээлдэг журамтай болох.

3.Төсвийг нээлттэй болгож хэрэгжүүлж тайлагнадаг байх асуудал. Үүнд зургаан асуудлыг гаргаж тавьсан байгаа. Төсвийн бие даасан байдалд хөндлөнгийн аудит хийх гэх мэт.

4. Иргэдийн оролцоог хангах асуудал гэж байна. Энэ нь бас зургаан асуудал болж задарч байгаа. Төсвийн үйл явцад оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх, төсвийн үйл явцад үнэлгээ зөвлөмж, дүгнэлт өгдөг дагнасан ТББ-ын сүлжээтэй байх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүлчид төсвийн асуудлаар дагнан ажиллаж идэвхтэй оролцдог байх, төсвийн талаар иргэдэд зориулсан гарын авлагын хүртээмж, хэвлэлтийн давтамж, хангамжтай байх зэрэг асуудлыг тавьж байна.

С.Бямбаа /НДЭХ-ий Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийн зохицуулагч/:

Нэг санал нэммээр байна. Засгийн газар, Сангийн яам, ЭМЯ, БСШУЯ-наас гаргаж байгаа тушаал шийдвэрүүдийг нэг хүнд оногдох норм нормативаар баталж байх гэсэн саналыг оруулмаар байна.

Манай байгууллага хөдөөгийн сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны зардал дээр нэг жилийн хугацаагаар мониторинг хийсэн. Тэгээд нэг хүүхэд хоногт хэдэн төгрөгийн, ямар калоритой хоол идэх ёстой вэ гэсэн өгүүлбэртэй плакат хэвлэх ёстой байлаа. Гэтэл би энэ плакатыг одоо хүртэл хэвлүүлж чадахгүй

байгаа. Хүмүүс яасан арчаагүй юм бэ гэж бодох байх. Нэг хоногт хэдэн төгрөгийн хоол идэх ёстой гэдгийг мэдвэл олон нийт хяналтаа тавьж чадна.

Сургуулийн дотуур байрны хүүхэд жилд 147000 төгрөгийн хоол идэх ёстой гэсэн Засгийн газрын тогтоол байгаа. Энэ тоог хэдэд хуваах вэ гэхээр гурван янзын тоо гарч ирдэг. 262 хоног, 260 хоног, 285 хоног гээд. Хэрвээ нэг хүнд оногдох гэдгээр нь тавьсан бол ийм асуудал үүсэхгүй шүү дээ.

Б.Батхүү /Нийгмийн хөгжил төвийн зөвлөх/:

УИХ олон улсын байгууллагын санаачилгаар л хууль гаргадаг болсон гэж би түрүүн хэлсэн. Төсөв дээр гэрээгээр ажил гүйцэтгүүлэх гэсэн хуулийн нэг заалт байгаа. Энэ хуулийн хүрээнд жаахан юм бодооч гэсэн утгаар үүнийг хэлсэн юм.

Шинжлэх ухааны байгууллагууд жил бүр зөвлөх үйлчилгээ зарлаад явуулж байгаа. Тэгвэл төрийн байгууллага нь ТББ-уудаар гүйцэтгүүлэх зөвлөх үйлчилгээний жагсаалтыг гаргаж, түүндээ мөнгө төлөвлөж гэрээгээр гүйцэтгүүлбэл иргэний нийгэм ч хөгжинө, төр ч илүү хариуцлагатай болох боломжтой юм. Энэ санааг тусгаж өгөөч.

Нямдаваа /Ховд аймгийн Засаг дарга/:

Аймгийн дарга нар нэг ч үг хэлсэнгүй гэж шүүмжлүүлж байгаа ч гэсэн та нарын мэдээллийг анхааралтай сонсож байгаа шүү гэдгийг хэлмээр байна. Орон нутгийн эрх мэдлийг өргөтгөх тухай асуудлыг ярьж байсан боловч зөвлөмжид энэ талаар орсонгүй. Ард түмэндээ тодорхой мэдээлье, тэдний саналыг тусгана гэх зэргээр ярьж байна. Орон нутаг маань мэдэлгүй байгаа тохиолдолд энэ чинь хоосон яриа болно. Орон нутгийн эрх мэдлийг өргөтгөх тухай хуульд өөрчлөлт оруулах талаар мэдээлж байсан. Цаанаа төсөвгүй бол дахиад л хоосон яриа болоод явна. Тэгэхээр зөвлөмж дээрээ орон нутгийн ард иргэдийн санал бодол дээр тулгуурласан үйл ажиллагааг зохицуулах төсвийн эрх мэдлийн асуудлыг өргөтгөх талаар тодорхой заалтыг оруулах нь зүйтэй.

Энэ жилийн төсвийн хэлэлцүүлгийн явцад гишүүд их сонин мэдээллийг гаргаж ярьж байсан. Жишээ нь, аймгийн Засаг дарга нар овооны наадамд л мөнгө зараад сууж байдаг, үүнээс өөр эрх мэдэлгүй юм шиг ярьж байх жишээтэй. Өөрөөр хэлбэл, орон нутагт эрх мэдэл өгчихвөл овооныхоо наадамд л зарцуулна, өөр юу ч хийхгүй гэсэн байдлаар хандаж байгаа нь их эвгүй сонсогдож байсан. Овооны наадмыг хандив зохион байгуулж хийдэг болохоос төсвийн мөнгөөр хийдэггүй. Төсвөөс хийчихвэл аудитын шалгалтаар төлбөр болж тавигдчихна шүү дээ. Иймэрхүү хачин ойлголтоор хандаж тойргоор төсөв хуваарилдаг нөхцөл бий болсон. Тэгээд эсэргүүцэлтэй тулгарч сайд нарын багцад хийгээд өөрчиллөө. Ийм гажиг явдлыг төсвийн явцад оруулахгүй байх талаас нь зөвлөмжид тусгах нь зөв байх аа.

Бүсчилсэн хөгжил гэж ярьдаг мөртлөө тойрог дээр очихдоо бүсийн эрх ашгийг ярьдаг нэг ч гишүүн байхгүй. Зөвхөн тойргийн асуудлаа л ярьдаг. Энэ мэтийг зөвлөмжид тусгачихвал зүгээр болов уу.

Нарантуяа /Ховд аймаг/:

Улаанбаатарт байгаа ТББ-ууд мэдээллийг ямар ч шугамаар авч болно. Алслагдсан орон нутагт цахилгаанаас болж янз янзын саатал гардаг. Тэгэхээр иргэний нийгмийн байгууллагуудад тодорхой төсөв баталж төрийн мэдээллийн үйлчилгээг хүргэж болно. Орон нутгийн төр захиргааны байгууллага иргэний нийгмийн байгууллагуудыг хуралдаа урилгаар суулгадаг. Тэр мэдээллийг нь бичгийн хэлбэрээр, эсвэл, аман хэлбэрээр багийн иргэдтэй уулзахад түгээж явах боломж байгаа. Зарим хуучин зүйлээ сэргээмээр байна. Жишээ нь, шуудангаар мэдээ мэдээлэл хүргэдэг байсан нь сүүлийн үед алга болсон.

Чулуунбаатар /Татвар төлөгчдийн үйлдвэрчний холбооны ерөнхийлөгч/:

Төсвийг батлахын өмнө нийт иргэдээр хэлэлцүүлэх нь их чухал байгаа юм. Төсөв чинь татвар төлөгчдийн хяналтаас гарчихсан байгаа шүү дээ. Гэхдээ орон нутагт юу шаардлагатай байгаа тухай иргэдийнхээ саналыг аваад орон нутгийн засаг захиргаа, Засгийн газарт оруулдаг баймаар юм.

Төсвийн зарцуулалтыг төрийн аудитын байгууллагаас гадна олон нийтийн оролцоогоор хянадаг системтэй байх нь зүйтэй юм.

Төсөв баталдаг хүн төсөв захиран зарцуулагч байж болохгүй. Үүнийг хуульд тусгаж өгмөөр байна.

Б.Чимэд /ХЗДС-ийн Төр захиргааны тэнхимийн эрхлэгч, Гавьяат хуульч/:

Төсвийнхөө хуулийг шинэчлэхгүй бол болохгүй ээ. Орон нутгийн төсвийг устгасан байгаа. Ямар төсөв яриад байгаа юм. Ужет гэдэг юмыг ярих ёстой. Аймагт бол ийм юм байхгүй. Суманд байхгүй. Смёрта гээд зардлын төсөв гэж байгаа. Тэгээд хоёр өөр юмыг хооронд нь холиод бүтэхгүй л дээ. Уг нь 1974 оноос эхлээд сумыг төсөвтэй болгох гэж оролдсон юм. Гэтэл 2003 онд устгасан. Хэрэг эрхлэх газрын дарга байсан Цогтсайхан өнөөдөр энд үг хэлж байна лээ. Шинэ Зеландын туршлага чинь найман оронд туршаад болохгүй ээ гэдэг нь тогтоогдчихсон юм шүү гэж. Тэгэхээр манайхан туршлагынхаа туулайнаас салаад төсөв, бүр хориод оны хэлээр бол улсын орлого зарлагын данс гэдэг юмтай болмоор байна. Тэр нь аймагтаа байдаг, сумандаа байдаг баймаар. Одоогийн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулиа түүндээ тохируулж хийх юм байгаа биз. Байхгүй юмыг бид, ТББ хэчнээн санал тавиад нэмэргүй л дээ. Хуулиа өөрчлөхгүй бол болохгүй. Түүний дараа хүнийхээ толгойг өөрчлөх байх.

Ховдын дарга ярьж байна. Орон нутагт эрх өгөөч гэж. Одоогийн өгөх гээд байгаа эрх нь хэдэн хүний томилолтын асуудал байгаа юм. Мөнгөгүй хүн томилоод яах юм. Цолоо дуудуулж дуудуулж уначихдаг улсын начин шиг болно шүү дээ. Мөнгө байхгүй. Мөнгийг нь баталж өгдөг хурал, мөнгийг нь төлөвлөдөг орлого зарлагын төсөвтэй болгохгүй бол орчин цагийн залуучууд урьдын юм гэж үзээд байх шиг байгаа юм. Энэ чинь урьдын юм биш, улс хоорондын юм. Тэр ч байтугай Герман, Европын социализмаас зах зээлд шилжиж буй орнууд бүгд

тийм төсөвтэй болчихлоо. Жаахан баруун зүгээ баривал яасан юм бэ. Далайн чанад яваад юу хийх юм, живэхийн нэмэр.

П.Очирбат /“Очирбат” сангийн тэргүүн, “Газар олголтын ил тод байдал” хуралдааныг даргалагч/:

Илтгэлд дэвшигдсэн санаа, 10 гаруй хүний хэлсэн үгийн гол анхаарал төвлөрсөн хэсгийг эвлүүлээд арваад зүйлтэй зөвлөмжийг санал болгож байгаа юм. Та бүхэн хэлэлцээд авахаа авч, орхихоо орхино биз ээ.

Төрийн удирдлагын ил тод, ариун тунгалаг байлгах гэсэн асуудал дээр төвлөрөөд дөрвөн чиглэлээр ярьцгаалаа. Энэ дотор газрын харилцааг ил тод байлгах, олон нийтийн хяналттай байлгах асуудал бол нийгмийн амьдралын амин чухал асуудал болчихож гэсэн дүгнэлтийг хийсэн.

Үүнд дутагдаж буй зүйл цөөнгүй байна. Хамгийн түрүүнд манай эрх зүйн зохицуулалт, хуулиуд төгс төгөлдөр биш. Хоорондоо зөрчилтэй байна. Одоо газартай холбоотой 10 гаруй хууль байгаа юм. Эдгээр хуулийг иж бүрнээр нь эргэж харж боловсронгуй болгох шаардлага байна.

Хуулиас гадна байгууллагуудын заавар, дүрэм гэж үй түмэн юм байна. Үүний зарим нь ил байна, зарим нь далд байна. Эдгээр нь хуулиас хэтэрсэн эрх хэмжээг тогтоосон байна. Уг нь хуулиар бүх харилцаа зохицуулагдаж явах ёстой. Гэтэл манайхан заавар, дүрэм гэж гаргаж ирчихээд байгаа юм. Шүүхэд очихоор хуулиа барьж ярьдаг. Зааврыг нь тоодоггүй. Ийм эрх зүйн зохицуулах чадваргүй дүрэм журмыг аль болохоор цөөлөх, чадвал бүр үгүй болгох шаардлага байгаа юм.

Нөгөө талаас хуулиа ч барьдаггүй, дүрмээ ч барьдаггүй, зөвхөн өөрсдийн дур зорго, тухайн хүний сонирхлоор асуудлыг шийддэг. Энэ сонирхол гэдэг үгийн цаана их олон утга байгаа юм. Авилгал, гар хөнгөрүүлэх, хүндрүүлэх, хээл хахууль гээд. Энэ үгүүдийн цаана нарийн утга байх шиг. Тэр бүх үйл явдлууд нь мөнгөөр хэмжигддэг. Харин зангиддаг юм нь нэг байна. Тэр нь мөнгө. Энэ системийг үндсээр нь арилгахгүй бол газрын харилцааны асуудал их зовлонтой байх янзтай. Та бид бүгд газар дээр л амьдарч, газар дээр л гишгэж байгаа.

Газрыг эдийн засгийн харилцаанд оруулах гэдэг зах зээлийн анхны суурь. Зах зээлийн харилцаанд шилжих эдийн засгийн суурь нь энд байна гэж үзээд газрыг иргэдэд өмчлүүлж болно гэж Үндсэн хуульд бичсэн. Үндсэн хуулийн зарчмыг яаж барихаа мэдэн будилсаар байгаад 2000 он гаргаж байж хийсэн шүү дээ.

Үүнээс гадна нийслэл, аймаг, сум, төв суурин газруудад ерөнхий төлөвлөгөө гэж байхгүй. Ерөнхий төлөвлөгөө гэж байхгүй учраас хотын төлөвлөлт, барилгажилтын бодлого нь хоёр сонгуулийн хооронд албан үүрэг гүйцэтгэж ирсэн хүний үзэмж, мөнгөний хэмжээгээр зохицуулагдаж ирсэн харилцаа болжээ. Тийм учраас нийтийн үйлчилгээний газруудын ихэнх нь хувьчлагдаж зам, талбай, Нийслэлийн ногоон бүс жилээс жилд хорогдоод л байгаа юм. Харин утаа, хог тоос, хүнд металл нь арвижаад байгаа. Энэ хэрээр хүний эрүүл мэнд хордож байгаа. Тийм учраас хот төлөвлөлт, газрын хуваарилалтын асуудал дээр онцгой

анхаарахгүй бол өнгөн дээрээ газрын мэт сонсогдовч мөн чанараараа хүний амьдрах орчны асуудал юм. Цаашилбал, оршин тогтнох уу, эс тогтнох уу гэдэгтээ тулаад байна. Гишгэх талбай байхгүй. Одоо хотын гудамжаар явган хүн явах зам байхгүй шахуу болж байгаа юм. Арга буюу зарим үед машин замаар машинтай зэрэгцэж явж байгаа. Тийм учраас хотын зам талбай, нийтийн хэрэгцээний газар, талбай руу гар хүрч болохгүй, харин ч өргөжүүлэх ёстой.

Гал түймэр гарч, газар хөдөлбөл тусламж үзүүлэх ямар ч арга байхгүй. Магадгүй агаараас вертолетоор дүүжигнэвэл хаашаа байдаг юм. Машинаар явж орох газар гэж ерөөсөө байхгүй.

Манай салбар хуралдаан дээр авилгалаар газрын асуудал тэргүүлж байгаа гэлээ. Газар гэдэг чинь дотроо олон янз байна аа. Дэд бүтцийн мэддэг газар, барилга хот байгуулалтын мэддэг газар, хотын газар зохион байгуулалтынхны мэддэг газар гэж байна. Их олон мэдэлтэй байдаг юм байна. Мэдэлтэй болгон нь өөрсдөө дураараа захиран зарцуулах тал руугаа орсон бололтой юм. Бид газрын харилцааны талаар иргэддээ нарийн ойлгуулах, иргэдийнхээ саналыг сонсох, иргэдийнхээ газрын харилцаанд оролцох эрхийг нь хэлж таниулах ажлыг их муу хийж байна. Тийм учраас мэддэг нь мэдэн будилж зөрчөөд, мэддэггүй нь нөгөө хүний ам дагаж буруудаад энэ асуудал их эмзэг болжээ.

Газрын харилцааны зохицуулалт манайд маш их хэцүү байна. Судалгаанаас үзвэл нэг жилийн дотор газрын харилцаатай холбоотой өргөдөл гомдол 1146 ирсэн гэнэ. Ерөнхийлөгчөөс эхлээд Засгийн газар, бүх шатны төрийн байгууллагад ирсэн тоонуудыг нийтэд нь хэлж байна. Захиргааны хэргийн шүүх дээр хэлэлцэгдэж байгаа хэргүүдийн 40 орчим хувь нь газрын маргааны асуудал гэнэ. Энэ асуудлыг яаж шийдэж байгаа вэ гэвэл механизм нь их сонин юм. Ерөнхийлөгчид өргөдөл бичихээр тэр нь Засгийн газарт цохоод, Засгийн газар нь хотын захирагчид ч юм уу цохоод, тэр нь газрынхаа албанд цохоод, буцаад анх буруу шийдсэн хүндээ очиж байна. Тэгэхээр өөрийгөө хамгаалаад л үлдэнэ биз дээ. Хариу нь тус тусдаа явдаг юм байна. Ерөнхийлөгч таны хүсэлтийг хүлээн аваад зохих байгууллагад нь шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн болохыг мэдэгдье гэж хариу явуулах жишээтэй. Эцэстээ нөгөө хүн газаргүй үлддэг бололтой юм уу даа. Энэ их ортой болж таараад байна. Эдгээрээс үүдэж 10 асуудлыг гаргаж тавилаа.

Нийслэл болон аймаг хотод газар олголтыг төлөвлөх, шийдвэр гаргах ба түүнийг хэрэгжүүлэх үйл явцыг ил тод болгох, газрын маргааныг оновчтой зохицуулахын тулд дараах асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байна.

- Улаанбаатар хот, аймаг, төв суурин газруудыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө ба хэсэгчилсэн төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилт, мөн хот байгуулалттай холбогдсон тулгамдсан асуудлуудыг төлөвлөх, уран барилга, газар зохион байгуулалтын мэргэжлийн хүмүүсийг болоод иргэний нийгмийн байгууллагыг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг 2007 оны эхээр бүх нийтээр зохион байгуулах.

- Нийслэлийн дүүрэг, аймаг, сумын ИТХ-аас газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө ба тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг

хэлэлцэж батлахын өмнө иргэдээр хэлэлцүүлдэг журмыг бий болгож, биелэлтийн явцыг чуулган бүрээр хэлэлцэж, дүгнэлт өгч байх,

- Нийслэлийн болон орон нутгийн газрын мэдээллийн санг олон нийтэд нээлттэй болгох арга хэмжээ авах, хэрвээ тодорхой мэдээллийг нууцлах, хаалттай байлгах шаардлагатай бол түүнийгээ олон нийтэд мөн ил тодоор тайлбарлаж байх,

- 1996 оноос хойш нийслэл, дүүрэг, аймагт газар олгосон Засаг дарга нарын захирамж шийдвэрүүдийг олон нийтэд ил тод болгох арга хэмжээ авах,

- 2007 оноос хойш газар олгох шийдвэр гаргахаас нэгээс гурван сарын өмнө олон нийтэд танилцуулж Нийслэл болон аймгийн иргэд, оршин суугчдын саналыг авч, ямар нэгэн маргаантай зүйл гараагүй тохиолдолд эцсийн шийдвэр гаргаж хэрэгжүүлж байх.

- Өнгөрсөн хугацаанд гарсан газрын маргааны жагсаалтыг гаргаж хэрхэн шийдвэрлэсэн талаар олон нийтэд танилцуулах ажлыг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах,

- Газар олголтыг ил тод болгоход юуны өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх,

- “Үндэсний Соёмбо” хөдөлгөөнөөс гаргасан саналын дагуу Иргэний зөвлөлийг ажиллуулж, газар олголтын зөрчил, маргаантай асуудлуудыг шийдвэрлэхэд оролцуулж байна. Иргэний зөвлөл гэдгийг хөндлөнгийн аудит гэж ойлгох юм байна лээ. Түүнээс биш Иргэдийн хурлыг орлох сайн дурын байгууллага биш шүү. Энэ бүх асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд 2007 оныг Улаанбаатар хот, аймаг, сум, хотын газар олголт, төсвийн ил тод байдлыг хангах эргэлтийн жил болгон зарлахыг удахгүй болох аймаг, нийслэлийн ИТХ-ын ээлжит хуралдаанд хандан уриална гэж бичсэн байна.

Д.Мижиддорж /31-р сургуулийн ахмад багш/:

Газар олголт нь булаан эзлэх, нууц хуйвалдааны журмаар хийгдсэн байдаг. Үүний хор уршигаар иргэд, байгууллага их хохирсон байгаа. Хэрэг хуучрахгүй гэдэг үг бий. Энэ хохирлыг барагдуулах арга хэмжээ авахыг зөвлөмжинд тусгах гэсэн санал байна.

Хууль мэдсээр байтал санаатайгаар хууль зөрчиж, газар олголтын захирамж гаргасан Нийслэл болоод дүүргийн Засаг дарга нарт, буруутай нөхдөд хариуцлага тооцож, үүнийг ил тодоор нийтэд мэдээлэх гэдгийг оруулж өгнө үү.

С.Ганбаатар /“Үндэсний Соёмбо” хөдөлгөөн/:

Дахиад л жаахан детальчилмаар байна. Ерөнхий болчихож. Бид хүчээ бодож байж довтолгооноо хийх хэрэгтэй шүү дээ. Арван жилийн сургуулиудын биеийн тамирын талбай, эмнэлэг, цэцэрлэгийн талбайг чөлөөлөх гэдгийг оруулмаар байна. Үүнийгээ дотроо детальчлах байх л даа. Ядаж ингээд оруулчихвал бусад нь болно. Дөрөвдүгээр дэлгүүрийн баруун талд Хүүхдийн урлан бүтээх төвийг том

том байшингууд нөмрөөд ороод ирсэн байгаа. Хүүхдүүд чинь эрх ашгаа хамгаалж чаддаггүй өрөвдмөөр улсууд шүү дээ. Тийм учраас цаадуул нь дээрэлхээд байна. Өнөөдөр бид тэдний хүүхдийн талбайг трактороор чирчихвэл маргааш тэд биднийг танкаар дайрч магадгүй л байгаа юм.

Сумьяа /ЗГХЭГ-ын ахлах референт/:

Зөвлөмж дээр та нарын эсрэг санал гарч байгаа бол уучлаарай. Би бодлого, үр дүнгийн талаас нь хэлмээр байна. Бодлого боловсруулахад ТББ-ын оролцоо их өндөрт тавигдаж байна. Манай ТББ-ууд энэ тал дээр анхаарлаа бага хандуулж, Засгийн газар, УИХ-аа шүүмжлэх тал чинь ихэдчихээд байгаа. Би төрийн байгууллагын ажилтан. Гэхдээ ТББ-д цалингүйгээр ажилладаг.

ТББ нь Засгийн газрын хамтын ажиллагаа руу чиглэсэн зөвлөмж байх хэрэгтэй юм. Дараа нь хамтын ажиллагааны үр дүнд хяналтаа тавих байдал руу нь чиглүүлж өгөөч ээ. Тэгэхгүйгээр газрын асуудлыг Улаанбаатарт ингэнэ гээд найман асуудал биччихээр нийслэл нь хэрэгжүүлсэн ч юм байхгүй, та бүхэн хашгичаад л дуусна. Засгийн газарт ажиллаж байгаа бид ч хяналт тавьж чадахгүй.

Тэгэхээр зөвлөмж юунд чиглэх вэ. Салбар хуралдаан болон нэгдсэн хуралдаан ямар асуудалд анхаарлаа төвлөрүүлж, саналаа нэгтгэв ээ. Та нарын тавьсан илтгэлээс гарсан дутагдал нь оролцогчдоос гарсан саналтай нэгдсэн гэж үзэх ёстой. Үүнийгээ тодорхой зааж өгөх хэрэгтэй юм.

Зөвлөмж нь санал, шүүмжлэлийн цуглуулга байж болохгүй ээ. Энэ чинь хэрэгждэггүй шүү дээ. Та нар мэдэж байгаа. Илтгэл бэлдсэн хүмүүс анализ, синтез хийж байгаад илтгэлээ оруулсан. Бид илтгэлийг хэлэлцээд анализ хийгээд дахиад задалсан байна. Одоо ажлын хэсэг сууж байгаад энэ илтгэлээ синтез болгон, сайн зөвлөгөө өгөөд зөвлөмж дээрээ ТББ-ууд ЗГ-тайгаа хамтарч оролцохоор тусгах нь зүйтэй болов уу. Ялангуяа олборлох ил тод байдлын санаачилга дээр гурван талыг хамтарч оролцуулбал форумын үр дүн гарна. Дараа жил бид ингэж санал тавилаа, төр ингэж ажиллалаа гэж гурван талаасаа хэлэлцэх юм биш үү. Би хувийн туршлагаасаа хэлж байна. Үр дүнд хүрэх талаас нь ойлгооч.

Хүмүүсийн санал, шүүмжлэл нь асуудлыг бүрэн гаргадаггүй. Эхний асуудал ямар гарна тийшээгээ хошуурах байдлаар явчихдаг юм. Тухайлбал, байгаль хамгаалал руу нэг хэсэг нь явчихвал олборлох салбарын ил тод байдал нь хаягдчихдаг, олборлох салбарын ил тод байдлын санаачилга гээд явахаар лицензийн төлбөрийн асуудал орхигдчихдог юм. Үүнийг анхаарч үзээрэй.

Б.Чимэд /ХЗДС-ийн Төр захиргааны тэнхимийн эрхлэгч, Гавьяат хуульч/:

Нэг сонин юм хэлье. Хүмүүс ерөөсөө ажиглахгүй нэг юм байгаа. Төрийн өмчийн газрыг нутгийн өөрөө удирдах байгууллагад хуваарилчихдаг. Гэтэл эзэн нь төр байдаг. Газрыг төрийн биш байгууллага хуваарилаад байдаг. Яагаад манай төр юмаа мэдэхээ больчихсон юм бэ. Уг нь улсын өмчийн хороо хийх ёстой ажил л даа. Үүнийг болиулаач. Энэ нь 329 сум, 22 аймгийн хэрэг болчихоод байна.

Төрийн мэдлийн газар байгаа шүү дээ. Үндсэн хууль зөрчсөн ийм ажиллагаа яваад байгаа юм.

Монголын иргэдэд газраа хуваарилаагүй байж дуудлага худалдаанд оруулж байна. Үүнийгээ болиоч. Хүүрийн газар, гүүрийн доорх газар л ногдож байна. Бид иргэдээ бодох ёстой шүү дээ. Эхлээд үнэ төлбөргүй хувьчилдаг газраа дуусгасны дараа үлдсэнийг нь дуудлагаар худалдаач ээ. Тэгэхээр зөвлөмждөө иргэдэд нормт газрыг нь хуваарилсны эцэст үлдсэн газрыг дуудлага худалдаанд оруулах гэж.

Нийтийн ашиглалтын газрыг хувьчилдгаа зогсоомоор байгаа юм. Одоо юу ч үгүй болсон доо. Солонгос тосгон нэг хэсгийг нь авчихлаа. Одоо төв цэцэрлэг юу болж байгаа юм. Түүний цаана Япон таун гээд Улаанбаатарт иргэдийн амьсгалах, суух газар гэж байхгүй болж байна шүү дээ. Үндсэн хуульд нийтийн өмчлөлийн газрыг хувьчилж болохгүй гээд заачихсан байгаа. Тэгээд цаашаа жижиг буюу хүүхдийн тоглоомын талбайн газар гээд явна.

Нийтийн ашиглалтын газрыг яагаад хувьчилчихав аа. Хөрөнгөтэйхөн шиг бол энэ газруудыг чинь чөлөөлмөөр байна шүү дээ. Барилгыг нь нураагаад. Их харгис юм ярьж байгаа байх. Яагаад ингэж засаг төр өөрийнхөө юмыг зохион байгуулж чадахгүй байгаа юм бэ. Батсүх, Сугар дарга нарын хэн нэг нь улсын хэмжээгээр үүнийг базаж байхгүй бол болохгүй ээ. Нэг дарга ирээд л баахан наймаа хийдэг. Юмаа худалдаж идээд дуусах юм биш байгаа. Үйлдвэрлээд мөнгө олж байгаа нь бага л болов уу.

Г.Цогтсайхан /Азийн санаачилга институтийн захирал, “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал” хуралдааныг даргалагч/:

Олборлох салбар маань манай улсын эдийн засагт их том байр суурийг эзлэх болсон, цаашид ч маш ихээр нэмэгдэх салбар байгаа юм. Хоёрхон тоо хэлье. Өнөөдрийн ДНБ-ий 20 орчим хувийг уул уурхайн салбар дангаараа үйлдвэрлэж эхэллээ. Гадагшаа гаргаж байгаа бүтээгдэхүүний 70 гаруй хувийг нь энэ салбар дангаараа гаргаж байгаа. Гаднаас орж ирж байгаа хөрөнгө оруулалтын 60 гаруй хувийг энэ салбар дангаараа хүлээж авч байна.

Монгол Улсын тусгаар тогтнолтой шууд холбогдох болсон энэ салбарын асуудлыг ярихад хоёрхон цаг хангалтгүй нь ойлгомжтой. Хуралдаанд санал хэлсэн хүмүүс тодорхой нутаг орныхоо жижиг асуудлууд дээр төвлөрлөө. Орон нутгаас ирсэн хүмүүс тодорхой нэг орон нутгийн нэг орд газар, нэг компанийн үйл ажиллагаатай холбогдсон санал, шүүмжлэлийг тавилаа.

Юуны өмнө энэ салбарыг дэлхий нийтийн жишиг гэдэг талаас нь харж товчхон хэдэн үг хэлье. Дэлхийн ихэнх орон хөдөө аж ахуй, уул уурхайгаараа дамжин хөгжиж гарч ирсэн байдаг.

Манай улс тэргүүний хөгжилтэй орноос 100-150 жилийн ард явж байна гэж бодвол бид эхлээд энэ салбарынхаа удирдлагыг маш сайн болгох хэрэгтэй. Гадны сайн муу жишээ олон бий. Дэлхийд 230 орон байлаа гэж бодоход газрын доороо баялагтай нь 20-30 хувь л байгаа шүү дээ. Бүгдэд нь бурхдын хишиг заяачихаагүй.

Тэр газрын дороо баялагтай орнуудын муу жишээ гэвэл хамгийн түрүүнд Африкийн орнуудыг оруулж болно. Газрын дороо маш их нефтийн баялагтай Африкийн олон орон тэр баялгаа зарж дуусаад, ОУВС, Дэлхийн банкнаас хэдэн миллиардаар нь зээл тусламж авсан мөртлөө ард түмэн нь биднээс дор ядуу амьдарч байна. Бид сайн жишээг харахаасаа илүү муу жишээг харж юун дээрээ алдсан юм бэ гэдгийг нь сайн ойлгох хэрэгтэй байгаа юм. Африкийн орнуудад газрын доорх баялгийг нь 60, 70-аад оны үед төрийн албанд ажиллаж байсан цөөн тооны хүмүүс ухаж аваад хуваагаад идчихсэн. Өөрөөр хэлбэл, гадны банканд мөнгөө байршуулаад, өөрсдөө дараа нь гараад явчихсан. Энэ бүхний эцэст ард түмэн хоосон үлдэж, үүнээс хувь хүртэж чадаагүй.

Сайн жишээнд Австрали, Канад, Америк зэрэг орныг оруулж болно. Энэ орнууд хуулийн хэрэгжилтээ зөв зохион байгуулж чадсан юм.

Уул уурхайн салбарын асуудлыг тусад нь дахин авч хэлэлцэх байх. Нэг бус удаа хэлэлцэх ёстой гэж би ойлгож байна. Гэхдээ хамгийн түрүүнд хуулиа сайжруулахаас ажлаа эхлэх ёстой. Мэдлэг, мэдээлэлгүйгээр маш олон хууль гарч байгаа. Дэлхийн иймэрхүү сайн муу жишээг огт судлаагүй зөвхөн тогоон дотроо ойлгосноороо төрийн олон асуудлыг шийдэж болохгүй. Хуулиа сайжруулсны дараа хуулийн хэрэгжилтийг зөв зохион байгуулах нь чухал. Манай ямар ч хууль дээр хэрэгжилтийн механизм тусгагдахгүй байгаа.

Өнөөдрийн хуралдаанаас доорх дүгнэлтийг гаргаж байна:

- Өнөөдөр уул уурхайн салбарын мэдээлэл бага, маш хангалтгүй байна. Иргэд битгий хэл орон нутгийн төрийн албан хаагчид өөрсдөө түүнийгээ мэдэхгүй байна.

- Уул уурхайн маш олон амин чухал асуудал иргэдээс далдуур, тэр бүү хэл төрийн бусад байгууллагаас нууцалсан байдлаар, хаалттай хаалганы цаана шийдэгдэж байна. Энэ талаар маш олон жишээ гарсан.

- Төр засгийн байгууллагуудын ам, ажил нь маш их зөрж байна. Тодорхой хууль гаргаж байгаа мөртлөө албан тушаалтнууд хуулийн дагуу ажиллахгүй байна. Хувь хүн, бүлэг сонирхлын эрх ашгийг харж байна гэсэн саналыг олон хүн гаргалаа.

- Уул уурхайн салбар хөгжихийн хэрээр Монгол Улсын байгаль орчин сүйдэж байна. Энэ чухал асуудлыг орон нутгаас ирсэн хүмүүс тодорхой жишээгээр ярилаа.

- Иргэний нийгмийн байгууллагууд саналаа хэллээ. Орон нутагт ажиллаж байгаа олон нийтийн байгууллагууд болон бизнесийн байгууллагын холбоо маш муу байна, харилцан мэдээлэл солилцохгүй байна.

- Орон нутагт байгаа төрийн байгууллагын албан хаагчид ажил үүргээ биелүүлэх ажлын чадвар, мэдлэг боловсрол дутмаг байна. Дээрээс гаргасан хууль тогтоомж, дүрэм журам нь орон нутгийн түвшинд очихдоо хэрэгжихгүй байна. Сум, багийн Засаг дарга нь том компанийн өмнө очоод манай сургуулийн дотуур

байрны дээврийг сольж өгөөч гэж гуйлгачин маягаар ханддаг. Ингэж хандвал хууль дүрэм чинь хэрэгжихгүй ээ.

Дээрх дүгнэлтээс үндэслэж зөвлөмжид тусгуулахаар доорх саналыг дэвшүүлж байна.

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсын Засгийн газар дэмжээд нэг жил гаруй боллоо. Үүний хэрэгжилтийн явц их удаан байна. Үүнийгээ түргэлүүлээч гэсэн саналууд гарсан. Иргэдийн үүсгэл санаачилгын байгууллагуудыг, ялангуяа орон нутгийн байгууллагуудыг үүнд илүү хамруулах хэрэгтэй гэсэн санал гарлаа.

- Төр засгаас уул уурхайн салбарын ил тод байдлыг хангах, хамгийн гол нь мэдээллийг ил тод байлгах шинэ арга механизмыг сэдэх хэрэгтэй.

- Стратегийн ач холбогдолтой, улсын хөгжилд нөлөөлөх томхон орд газруудыг ашиглах, байгаль орчны нөлөөллийг тогтоох, эдийн засаг болоод технологи, инженерийн асуудлыг шийдэхэд гадаад, дотоодын мэргэжлийн экспертүүдийг өргөн татаж оролцуулж байх,

- Ил тод байдал гэж их ярьж байгаа. Энэ нь өргөн хүрээг хамарч болно. Зарим нэг улсын нууцтай холбоотой зүйл ч бий. Ялангуяа уул уурхайн салбарт улсын нууцтай холбоотой юм зайлшгүй байдаг. Тэгэхээр юуг ил тод болгох вэ гэдэг дээрээ төвлөрч анхаарлаа хандуулаач гэсэн санал гарлаа.

Нэг жишээ хэлье. Олборлох салбарын ил тод байдлын санаачилга гаргаад дэлхийн 20 орчим орон үүнийг хэрэгжүүлж байгаа. Нэлээн хөгжсөн, ихээхэн нефть олборлодог, мөнгө нь манайх шиг ганц нэг зуун сая доллараар биш, хэдэн зуун тэрбумаар яригддаг орнууд юуг ил тод болгох вэ гэдэгт анхаарлаа маш их хандуулж байгаа. Засгийн газар, компаниуд, иргэдийн олон нийтийн байгууллагуудын хооронд бараг дайн болж байгаа гэхэд хилсдэхгүй.

- Төр, олон нийт, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг уул уурхайн салбарыг зохицуулахад ашиглая, гурван талт хамтын ажиллагааг сайжруулах механизмыг бодож олох хэрэгтэй гэсэн саналууд гарлаа.

Ц.Ганболд /“Олборлох салбарын ил тод байдлын төлөө” ТББ-уудын эвслийн зохицуулагч/:

Юуг ил тод болгох вэ гэдэгт орчихов уу. Би олж сонссонгүй. Монгол даяар хамгийн их анхаарч хүлээж байгаа зүйл бол томоохон ордуудын ашиглалттай холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ байгаа. Засгийн газраас ажлын хэсэг томилчихсон байж байна. Энэ гэрээг хэлэлцэж байгаа явцыг нь, байгуулагдсаных нь дараа гэрээ хэлэлцээрийг ил тод болгохыг би илтгэлдээ дурдсан. Энэ асуудал маань дэлхий дахины жишээнд бүдгэрээд алга болчихлоо. Оюутолгой, Таван толгойтой холбоотой гэрээг хянахгүй юм бол бид өөр юу хийх билээ. Энэ санааг тусгаж өгөөч гэж хурал даргалагчаас хүсч байна.

Баяраа /Багануур дүүрэг/:

Улс орны хөгжлийг тодорхойлох асуудал нь гадаадын хөрөнгө оруулалт юм. Тухайн хөрөнгө оруулалт нь манай орны хөгжил дэвшилд стратегийн ямар ач холбогдолтой юм гэдгийг тодорхойлох хэрэгтэй.

Гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн үйлдвэрлэлийг хэний зөвшөөрлөөр, хэдийд орж ирсэн, ямар үзүүлэлттэйг ил тодоор ард түмэндээ мэдээлээч. Ард түмэнд зөв мэдээлэл хэрэгтэй байна.

Улс эх орны хөгжлийн бодлогыг тодорхойлоход эрдэмтдийн санаа бодлыг оруулах хэрэгтэй юм.

О.Эрдэнэ-Өлзий /“Үндэсний Соёмбо” хөдөлгөөний төлөөлөгч/:

Байгаль орчны нөхөн сэргээлтийн асуудал нэлээн бүрхэг өнгөрчихлөө. Энэ талаар бодитой тусгаж, байгаль орчны нөхөн сэргээлтээр иргэний байгууллагууд яаж ажиллах ёстой вэ гэдгийг зөвлөмждөө оруулах нь зүйтэй болов уу. Засгийн газар байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлаа маш муу хийж байгаа. Үүнийг иргэний байгууллагууд байнга шүүмжилдэг.

Манай хөдөлгөөнөөс УИХ-ын Байгаль орчны байнгын хороонд саяхан хандсан. Энэ чиглэлээр ямар нэгэн ажил зохион байгуулж, иргэний байгууллагуудтай хамтарч ажиллаач гэж. Хорооноос хамтарч ажиллаж болно, харин яаж хамтарч ажиллахаа харилцан ойлголцож тохиролцох ёстой гэсэн хариу ирүүлсэн байна лээ.

Батпүрэв /“Инфорум” төв/:

Олборлох салбарын ил тод байдлыг хангах тухай хүмүүс нэлээн ярьж байсан боловч зөвлөмжид орсонгүй. Хуулиудын зохицуулалтын хоорондын уялдаа холбоог сайжруулж өгөх хэрэгтэй. Жишээ нь, Ашигт малтмалын тухай хуульд янз бүрийн мэдээллийг ил гаргах ёстой гэж заасан мөртлөө нөгөө талд нь Нууцын болон Татварын хуулиар хориглосон байдаг гэж татварынхан ярьж байсан. Үүнийг зохицуулах талын зүйлийг оруулж өгөөсэй гэж бодож байна. Гэхдээ хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох гэж улиг болсон байдлаар томъёолмооргүй байна. Тэгэхээр баахан журам гаргачихдаг.

Хэрэггүй баахан журам байгаа. Мэдээлэл авах гээд нэг яам, агентлаг дээр очихоор хуулиас давсан ямар нэг даргын тушаал, журам хэлээд ам таглачихдаг. Тэр шаардлагагүй дүрэм журмыг зөв зохицуулж зөв зохион байгуулалтад оруулан, аль болох хүнд суртал багатай болгох талаар санал хэлмээр санагдсан.

Олборлох салбарын ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх, бий болгох гэдэг дээр гурван тал оролцох хэрэгтэй гэдэг. Нэгэнт санал зөвлөмж гаргаж байгаа бол тэр талуудад хандсан зүйл байх ёстой юм шиг санагдаж байна. Жишээлбэл, үндэстэн дамжсан компаниудын хувьд олборлох салбар нь аль болох нээлттэй байх ёстой гэдэг талаас нь хараад нээлттэй байхыг уриалаад байдаг. Гэтэл илүү хаалттай, ил тод бус байдал нь дотоодын гэсэн компаниуд дээр байдаг шүү

дээ. Үнэн хэрэгтээ дотоодын компаниуд ил тод байдлын санаачилгыг ерөөсөө дэмжихгүй байгаа. Энэ талаар юу ч дуугарахгүй байна. Тэд нарыг энэ талаар ажиллаач гэдгийг санал болгох, эсвэл, зөвлөх байдлаар оруулж өгөх нь зөв болов уу.

Энхтөр /“Тосон Заамар” хөдөлгөөн/:

Экс ерөнхийлөгч Очирбат гуайг энд хүрэлцэн ирсэнд талархаж байна. Уулзах юмсан гэж бодож байлаа. Таныг “Алт” хөтөлбөрийн загалмайлсан эцэг гэж нэрлэдэг. Энэ хөтөлбөр хэрэгжсэнээс хойш 16 жил өнгөрлөө. Өнөөдөр ямар байдалд хүрснийг хэнээр ч хэлүүлэлтгүй мэдэж байгаа байх. Энэ байдлыг та хувь хүн гэдэг талаасаа өнгийгөөд харвал яасан юм бэ. Та хойтох, урдах насаа бодоод цаашид яах вэ гэдэг талаар бодмоор юм биш үү.

Нэгэнтээ авахын төлөөх асуудлыг хөтөлбөр боловсруулж шийдэж чадсан юм чинь нөхөн сэргээлт болон байгаль орчны асуудлыг санаачилга болгон оруулж, та үүний магнайд нь явбал яасан юм бэ. Тэгээд цөмөөрөө хамтарч ажиллая.

Авилгал авснаар нь хэмжихгүй байх аа. Хүн болгон эх дэлхийдээ буцахдаа хоёр метр цагаан давуутай л буцна шүү дээ...

Д.Жаргалсайхан /ННФ-ын Удирдах зөвлөлийн гишүүн/:

Саналын 4-рт нэг тодорхой зүйлийг оруулъя. Хөгжлийн санг ил тод болгооч гэж. Хөгжлийн сангийн анхны санаа Норвегид гарахдаа зах зээлийн үнийг төдөөс дээш болохоор нь улсыг хөгжүүлэх санд авна, үүнийг Засгийн газар хариуцахгүй гэж анх гаргасан юм. Казакстан 27 мянган доллараас дээших нефтийн үнийг нийлүүлэн хуримтлуулж хот барина гэсэн. Одоо барьж байгаа. Орос бас ингэж байна.

Одоо энэ хүмүүс чинь хуваагаад авчихлаа шүү дээ. Хаана энэ мөнгийг хадгалах вэ гэсэн асуудал байгаа. Өнөөдөр 250 сая төгрөгийг хуваах юм бол манайд инфляци бий болно гэж бодож байна. Оросууд мөнгөнийхөө 40 хувийг доллараар, 40 хувийг еврогоор, 20 хувийг пункт стерлингээр хадгалаад энэ жил 6 хувийн хүүтэй, 70 орчим миллиард доллартай болоод байж байна. Манайд яаж ашиглах вэ гэдгийг ил тод болгох санал оруулаач. Ер нь хөгжлийн сан хаана, юу болж байгааг нь мэдэж баймаар байна.

П.Очирбат /“Очирбат” сангийн тэргүүн/:

Надтай холбоотой нэг юм яриад байна аа. Авилгал энэ тэр гээд. Ах нь нэг ч төгрөгийн авилгал аваагүй. Тэгж буяндаа бузар хийхгүй. Тийм учраас наад авилгал гэдгээ надаас зайдуу барьж яриарай.

Алт хөтөлбөрөөр 12 жил Монгол Улс амьдарч байгаа. Орост төлөх өрөө ч түүгээр төлсөн. 7 хоногийн улсын валютын нөөцтэй байсан нь одоо арван есөн долоо хоногийн нөөцтэй болж байгаа. Алтаар амьдарч байгаа.

Байгаль дэлхийг сүйтгэж байгаагийн хувьд үнэхээр тийм. 40 метрийн гүнээс шороо гаргаж тэр 40 метрийн шороог нь зайлшгүй зайлуулж байгаа юм. Овоолж байгаа юм. Ерөөсөө уул уурхай өөрөө тийм. Ухдаг, овоолдог. Дууссаны дараа буцаад булдаг, янз бүрийн усан цөөрөм байгуулдаг. Тэр бол явдаг жамтай юм. Анх Монголд ухаж байгаа юм биш. Олон зуун жил дэлхий ухаж байгаа юм. Ийм л замаар явдаг.

Одоо хоёр шаардлага тавигдаж байгаа. Эхний шаардлага бол ухсан юмаа өмнө байсан байранд нь оруул. Нөгөө шаардлага нь үүнд зарцуулах зардлын 50 хувийг орон нутагт өг, 50 хувьд нь байгалийг сэргээж өг гэдэг. Тэгэхээр бид нарийг нь хийх вэ.

Одоо 150 мянган нинжа байгаа гэдэг. Амьдрахын тулд явж байгаа тийм тооны, улирлын чанартай хүмүүс байгаа юм. Одоо үүнийг байлгах уу, үгүй юү гэдгээ төр шийдэх хэрэгтэй. Эд бүгд хууль зөрчиж байгаа юм. Яагаад гэвэл газрын баялгийг ашиглахын тулд зөвшөөрөл авах ёстой. Эд нарт зөвшөөрөл байдаггүй юм. Үүнийг хуулиар зохицуулах хэрэгтэй, эсвэл тас хориглох хэрэгтэй.

Монгол Улсад хайгуулын лиценз олгох уу, үгүй юү. Олгохгүй бол бүр зогсоочих хэрэгтэй. Эдгээр асуудлыг нэн түрүүнд төрөөс шийдэх хэрэгтэй байгаа юм. Одоо төр Налайхын уурхайг 70 жил ухчихаад нэг ч куб метр газар тэгшлээгүй. Төр одоо үүнийгээ тэгшилж өгөх хэрэгтэй. Бид ийм шаардлагыг тавих хэрэгтэй. Яг ийм шаардлагыг хувийнханд тавих хэрэгтэй байгаа юм.

Би сүүлийн найман жил экологи, байгаль хамгааллын чиглэлээр судалгаа хийж байгаа. Тийм болохоор энэ асуудал дээр өөрийн чинь сэтгэл зовж байгааг хуваалцаж болох юм. Гэхдээ би санаачлагч болоод чамтай хөтлөлцөөд манаргаж явахгүй ээ. Чи санаачил, би бүх талаар дэмжье. Судалгаа болон онол, практикийн талаас нь, яаж хэрэгжүүлэх талаас нь хамтарч ажиллаж болно.

“ТӨРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ:НИЙГМИЙН БАЯЛАГ ХУВААРИЛАЛТ” ФОРУМААС ГАРГАСАН САНАЛ ЗӨВЛӨМЖ

Улаанбаатар хот

Ил тод байдлыг хангах чиглэлээр Монголын төр, иргэний нийгмийн зүгээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааг хэлэлцэж, оршиж буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх арга замыг хэлэлцэх зорилгоор Нээлттэй Нийгэм Форумаас “Төрийн ил тод байдал: нийгмийн баялаг хуваарилалт” сэдэвт форумыг 2006 оны 12 дугаар сарын 7-нд зохион байгууллаа. Энэхүү форумд Монголын төр засаг, иргэний нийгэм, бизнесийн төлөөлөгч 200 гаруй хүн оролцож, ардчиллын тулгуур зарчим болох ил тод байдлын асуудлыг Төрийн ил тод байдлыг хангах хууль, эрх зүйн орчин, Улсын төсөв болон тендерийн үйл явц, Газар олголт, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал зэрэг дөрвөн үндсэн сэдвийн хүрээнд хэлэлцэж, асуудал тус бүрээр цаашид хэрэгжүүлбэл зохих бодлого, үйл ажиллагааны талаар санал зөвлөмж гаргалаа. ҮҮНД:

ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР:

Хуралдаанаар төрийн ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчин, мэдээллээр үйлчлэх төрийн үүрэг, хууль тогтоох үйл ажиллагааны ил тод байдал зэрэг асуудлаар илтгэл тавьж, санал шүүмжлэл өрнүүллээ. Төрийн ил тод байдлын эрх зүйн зохицуулалт тунхагийн шинжтэй, хэрэгжүүлэх механизм нь тодорхой бус байгаагийн зэрэгцээ төрийн байгууллагууд иргэдэд хэрэгцээтэй мэдээллийг нь хүргэхээс илүүтэй өөрийн сурталчилгааг анхаардаг талаар оролцогчид тодорхой жишээ баримтаар дурдав.

Хэлэлцүүлгийн илтгэл, санал шүүмжлэлд үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна:

1. Ил тод байдлын эрх зүйн зохицуулалтын хувьд :

1.1 Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа ил тод байх үзэл баримтлалыг шинээр батлагдан гарах бүх хууль тогтоомжид нийтлэг зарчим болгон тусгахын зэрэгцээ одоо үйлчилж буй хууль тогтоомжийг энэхүү зарчимд нийцүүлэн өөрчлөх. Тухайлбал, хэрэгжүүлэх механизм, хариуцах эзэн, төсөвтэй болгох.

1.2 Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэж батлах болон хуулийг хэрэгжүүлэх шатанд ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоог бодитой болгоход чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг нэн даруй боловсруулж батлан мөрдөх.

2. Мэдээллийн хүртээмжийг сайжруулахын тулд :

2.1 Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг нэн даруй баталж, нууцтай холбоотой хууль тогтоомжийг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх. Иргэний нийгмийн зүгээс УИХ-ын гишүүдэд ил захидал илгээн, байр суурийг нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх зэргээр нөлөөлөх.

2.2 Байгууллагын нууцын тухай, Хувийн нууцын тухай хуулийг хүчингүй болгох, холбогдох харилцааг Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар зохицуулах.

2.3 Төрийн байгууллагуудад иргэдэд мэдээллээр үйлчлэх бүтэц бий болгох, төсөвлөж санхүүжүүлэх, иргэний хэрэгцээг хангахуйц мэдээллийн сан бүрдүүлэх.

2.4 Төрийн байгууллага иргэнд мэдээлэл хүргэхдээ цахим сүлжээний зэрэгцээ хэвлэмэл хэлбэрээр хүргэх. Мэдээлэл нь иргэдийн хэрэгцээнд тулгуурласан байх шаардлагатай ба тухайн байгууллагын төсвийн зарцуулалт, шийдвэрийн төсөл, хуралдааны бүрэн тэмдэглэл, гаргасан шийдвэр зэргийг тогтмол шинэчлэн мэдээлж байх.

2.5 Төрийн байгууллага иргэдэд мэдээллээр үнэ төлбөргүй үйлчилдэг болох.

2.6 Төрийн байгууллага, албан тушаалтан иргэнд мэдээлэл өгөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох.

2.7 Төрөөс иргэнд мэдээллээр үйлчлэх болон иргэн нь төрийн байгууллагаас тодорхой мэдээлэл авахад зориулсан арга зүйн зөвлөгөө бүхий гарын авлага, зурагт хуудас зэргийг гарган түгээх.

3. Үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд :

3.1 Үйл ажиллагааны нээлттэй байдлын зохицуулалтуудыг хуулинд тусгах, нээлттэй байдлыг хаасан журам, дүрмийг хүчингүй болгох.

3.2 Төрийн байгууллагын үйл ажиллагаа иргэнд нээлттэй байх боломжийг хангах, ялангуяа УИХ, ИТХ-ын хуралдааны үеэр иргэд чөлөөтэй орж, ажиглах боломжийг бүрдүүлэх. Иргэд хуралдааныг хөндлөнгөөс ажиглах боломжтойгоор танхимыг зохион байгуулах, болох гэж буй хуралдааны талаарх мэдээлэл / ямар асуудал, хэдийд хэлэлцэгдэх гэх мэт/ болон хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг цаг тухайд нь иргэдэд мэдээлэх зэрэг арга хэмжээ авах.

3.3 Төрийн байгууллага, албан тушаалтны аливаа шийдвэрийн үндэслэлийн талаарх мэдээлэл иргэдэд нээлттэй байх.

3.4 Төрийн байгууллага, албан тушаалтан үйл ажиллагаандаа ил тод байдлыг хэрхэн хангасан талаар жил бүр тайлан гаргаж нийтэд мэдээлэх.

4. Иргэдийн оролцоог хангахын тулд:

4.1 Аливаа хууль, шийдвэрийн төслийг олон нийтэд хангалттай хугацааны өмнө бүхий л арга, хэлбэрээр түгээх, санал авах, иргэний саналыг тухайн хууль, шийдвэрт тусгасан эсэх талаар мэдээлэх механизмыг хуульчлах.

4.2 Бүхий л шатны шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нээлттэй хэлэлцүүлгийн хэлбэрээр хангах.

4.3 УИХ-ын хууль хэлэлцэх шатанд иргэний нийгмийн төлөөлөл, иргэнийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, санал авах журмыг “Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай”, “УИХ-ын тухай” зэрэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр тусгах.

4.4 Төрийн байгууллагын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих бүтцэд иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах, тайлан, хэлэлцүүлэг зэрэг хяналт тавих үйл ажиллагааг тэдний оролцоотойгоор явуулдаг болгох.

УЛСЫН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЛААР:

Хуралдаанаар төсвийн ил тод байдлын ерөнхий асуудлуудаас гадна иргэдийг төсвийн мэдээллээр хангахад төрийн хүлээх үүрэг хариуцлага, төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны тухай мэдээллийн олдоц, хэрэгцээ зэрэг асуудлыг хэлэлцэж, санал бодлоо солилцлоо. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд оролцох, хяналт тавих иргэдийн эрх хэрэгжихгүй, түүнчлэн төсвийн гүйцэтгэлийг олон нийтэд тайлагнах, хариуцлага хүлээх тогтолцоо огт байхгүй талаар оролцогчид шүүмжлэн ярилцлаа. Мэдээлэл эрх тэгш, тэнцвэртэй хүрдэггүйгээс төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явц шударга бус явагдах, төсвийн зарцуулалтын үр ашиг муу байх, авилгал бий болох нөхцлийг бүрдүүлж байгааг онцлов.

Эдгээр санал шүүмжлэлд тулгуурлан доорх зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

1. Төсвийн хууль тогтоомжид төсвийн төсөл, батлагдсан төсөв, гүйцэтгэлийг олон нийтэд нээлттэй мэдээлэх, иргэдэд шаардлагатай мэдээллийг өгөөгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тусгах.
2. Төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоог дэмжих үүднээс төсвийн мэдээллийг иргэдэд энгийн ойлгомжтой хэлбэрээр хүргэх.
3. Төсвийн тогтвортой байдлыг хангах, улс төрийн амлалт, төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх механизмыг бүрдүүлэх.
4. Төсвийн байгууллагын үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг төсөвтэй уялдуулан тодорхой болгож төсвийг зохиох, хэрэгжүүлэхэд ашиглаж

буй үзүүлэлтүүдийн бүртгэл, тооцоо хийж буй аргачлалыг ил тод болгон нийтэд мэдээлдэг байх.

5. Аудитын дэлгэрэнгүй тайланг ил тод байлгах, олон нийтээр хэлэлцүүлж, түүний дагуу авсан арга хэмжээг мэдээлэх.
6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны талаарх мэдээллийг шалгаруулалт явуулахын өмнө болон тендер явагдсаны дараа олон нийтэд нээлттэй болгон, мэдээллийн санд тавих. Тендерээр гүйцэтгэсэн ажлын үр дүнг олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлдэг байх.
7. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд өөрчлөлт оруулахдаа Үндсэн хууль, Нэгдсэн төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Татварын багц хуулиуд, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хууль зэрэг холбогдох хуулиудтай уялдуулж, орон нутгийн төсвийн эрх мэдлийг баталгаажуулан иргэдийн оролцоог хангахуйц эрх зүйн үндсийг бүрдүүлэх.
8. Төсвийн үйл явцад оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авдаг, энэ талаарх саналыг дэмждэг байх.
9. Төсвийн асуудлыг УИХ, ИТХ-аар хэлэлцэхдээ зөвхөн экспертүүдээс гадна иргэдэд зориулсан нээлттэй хэлэлцүүлгийг хийж хэвшүүлэх.

ГАЗАР ОЛГОЛТЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЛААР:

Хуралдаанаар газар олголтын ил тод байдлын талаар төр засаг, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид байр сууриа илэрхийлж, бусад оролцогч өөрсдийн санал шүүмжийг танилцууллаа. Үүнд, газрын зөрчил маргаан, газар авч буй гол шалтгаан нь газар олгох үйл явц өөрөө ил тод бус байгаа явдал гэж оролцогчид дүгнэлээ. Нийслэл, аймаг, төв суурин газрын ерөнхий төлөвлөгөө боловсронгуй бус, байнга өөрчлөгддөг, чанд хэрэгждэггүй, нийтийн хэрэгцээний газрыг оршин суугч, олон нийтийн эрх ашгийг үл харгалзан дураар олгодог, газар олгох шийдвэрээ иргэдэд ил тод мэдээлдэггүй нь анхаарал татсан асуудал болж байна. Түүнчлэн газрын зөрчил, маргааныг оновчтой хэлбэрээр шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт, механизм дутагдаж байна.

Энэ байдалд үндэслэн форумд оролцогчид дараах зөвлөмжийг гаргалаа. Үүнд:

1. Улаанбаатар хот, аймгийн төв, суурин газруудыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал, тулгамдсан асуудлын талаар хот төлөвлөлт, уран барилга, газар зохион байгуулалтын мэргэжлийн хүмүүс болон иргэний нийгмийн байгууллагыг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг 2007 оны эхээр зохион байгуулах, төлөвлөгөөг мэргэжлийн өндөр түвшинд боловсруулсан байх явдлыг хангах.
2. Нийслэл, дүүрэг, аймаг, сумдын ИТХ-аас газар зохион байгуулалтын

ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөг хэлэлцэж батлахын өмнө иргэдээр хэлэлцүүлдэг журмыг бий болгох, биелэлтийн явцыг чуулган бүрээр хэлэлцэн дүгнэдэг байх.

3. Газартай холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тухайлбал газар эзэмших гэрээг цөөн жилээр хийн, гэрчилгээг богино хугацаагаар олгож иргэдийн эдийн засгийн эрхэнд халдаж байгааг таслан зогсоох.
4. Нийслэлийн болон орон нутгийн газрын мэдээллийн санг олон нийтэд нээлттэй болгох арга хэмжээ авах, хэрвээ тодорхой мэдээллийг нууцлах, хаалттай байлгах шаардлагатай бол үүнийгээ олон нийтэд ил тод тайлбарлах.
5. 1996 оноос хойш нийслэл, дүүрэг, аймагт газар олгосон нийслэл, дүүрэг, аймгийн Засаг дарга нарын захирамж, шийдвэрийг олон нийтэд ил тод болгох.
6. 2007 оноос хойш газар олгох шийдвэр гаргахдаа 1-3 сарын өмнө олон нийтэд танилцуулж нийслэлийн иргэд, оршин суугчдын саналыг авч, ямар нэгэн эсэргүүцэл маргаан гараагүй тохиолдолд гарын үсэг зурдаг журам тогтоох.
7. Газрын маргаантай асуудлуудын жагсаалтыг гаргаж учирсан хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар олон нийтэд танилцуулах ажлыг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.
8. Газар олголтыг ил тод болгох, газрын харилцааны талаар сурталчилгаа явуулахад юуны өмнө нийслэл, аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, тухайлбал UBS телевизийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх.
9. Хөндлөнгийн аудит хийх иргэдийн зөвлөлийг ажиллуулж, газар олголтын зөрчил, маргаантай асуудлуудыг шийдвэрлэхэд оролцуулах.
10. Хүүхдийн тоглоом, эмнэлэг, сургуулийн талбайг чөлөөлж, эргүүлж холбогдох газруудын мэдэлд өгөх.
11. Нийтийн ашиглалтын газрыг хувьчлахыг нэн даруй зогсоох.

Энэ бүх асуудлыг шийдэхийн тулд 2007 оныг Улаанбаатар хот, аймаг сумын газар олголт, мөн төсвийн ил тод байдлыг хангах эргэлтийн жил болгон зарлаж ажиллахыг аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит хуралдаанд хандан уриалж байна.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЛААР:

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын талаарх хуралдаанд төр, олон нийт, бизнесийн байгуулагын төлөөлөгчид оролцож, өөрсдийн байр суурийг илэрхийлсэн дөрвөн илтгэл тавьж, оролцогчид үг хэлж, санал шүүмж өрнүүлэв.

Уул уурхайн салбарын зохистой хөгжлийг хангахад салбарын бодлого, хэрэгжилтийг иргэдэд ойлгуулах, бодлого боловсруулахад зөвлөлдөх механизм бүрдүүлэх явдал чухал болохыг сүүлийн үеийн үйл явдлууд улам бүр нотолж байна.

Ялангуяа ард түмний өмч болох байгалийн баялгийн үр шимийг иргэд жигд хүртэх, тэдний эрх ашигт учруулах хохирол, байгаль орчны доройтол зэрэг сөрөг үзэгдлийг зөв зүйтэй шийдвэрлэхэд иргэдийн оролцоо зайлшгүй шаардлагатай оролцогчид тэмдэглэж байв. Түүнчлэн лиценз, гэрээ хэлэлцээр, татвар төлбөртэй холбоотой мэдээлэл ил тод бус байгаа нь авилгал үүсэх нөхцлийг бүрдүүлж, улмаар хөрөнгө оруулалтын орчинд сөрөг нөлөө үзүүлж болохыг оролцогчид сэрэмжлүүлэв.

Хэлэлцүүлгийн үр дүнд дараах зөвлөмжийг гаргав. Үүнд:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хэрэгжилтийг олон улсын зарчим, шалгууруудад нийцүүлэн сонирхогч бүх талын оролцоотой зохион байгуулж шахуу хугацаанд бодит үр дүнд хүргэх.
2. Стратегийн ач холбогдолтой томоохон ордуудыг ашиглах хөрөнгө оруулалтын болон гадаадын хөрөнгө оруулагчтай байгуулж байгаа бусад бүх гэрээ хэлэлцээр, тэдгээрийн хэлэлцэн тохирох үйл явцыг нийтэд ил тод болгож, эрх ашиг нь хөндөгдөх олон нийтийн санаа бодлыг тусгаж байх.
3. Эдгээр чухал ач холбогдолтой ордуудыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хянан үзэх, инженерийн болон ашиглалтын тооцоог хийхэд гадаад, дотоодын мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийг өргөн оролцуулах замаар том орд газруудыг ашиглахад мэргэжлийн бус улстөрчдийн явцуу ашиг сонирхлын дагуу, улс төрийн шийдвэр давамгайл гаргадаг өнөөгийн арга ажиллагааг таслан зогсоох.
4. Стратегийн чанартай томоохон орд газруудад хөрөнгө оруулах гадаад, дотоодын компаниудыг сонгон шалгаруулах, тэдэнтэй гэрээ хэлэлцээр байгуулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэн тохирох зэргийг олон нийтийн хараа хяналтын дор нээлттэй хийдэг журамтай болох.
5. Уул уурхайн салбарын ил тод байдлыг хангах ажлын хүрээнд энэ салбараас орж байгаа, орж ирэх мөнгөний урсгалыг ил тод болгох, ялангуяа хөгжлийн санд хуримтлуулж буй орлого, түүний зарцуулалтыг ил болгох, энэ талаар дэлхий нийтэд хэрэглэдэг шилдэг тэргүүний арга хэрэгсэл, тухайлбал эрдсийн сан, хадгаламжийн сангуудыг бий болгох асуудлыг төр, засгийн байгууллагууд судалж хэрэгжүүлэх.
6. Уул уурхайн салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож хоорондоо зөрчилтэй дүрэм, журмуудыг хянан цэгцлэх.
7. Уул уурхайн компаниуд байгаль орчны нөхөн сэргээлт хийх талаар хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад төр, олон нийтийн зүгээс тавих хяналтыг чангатгаж, хүлээлгэх хариуцлагыг дээшлүүлэх үр дүнтэй механизмыг төр засгаас төлөвлөн хэрэгжүүлэх.
8. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа, ялангуяа байгаль орчныг хамгаалах, газрын нөхөн сэргээлт хийх зэрэгтэй холбогдсон асуудлуудаар төр, олон нийт, иргэний нийгмийн болон бизнесийн байгууллагуудын хоорондох

мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг сайжруулж үр дүнтэй болгох арга замыг олоход эдгээр байгууллага хамтран ажиллах.

9. Уул уурхайн салбарын ил тод байдлыг чухам ямар хүрээнд авч үзэх, юуг ил тод болгох талаар сонирхогч бүх тал нэгдмэл ойлголцолд хүрэх шаардлагатай гэж салбар хуралдаанд оролцогчид санал нэгдлээ. Тухайлбал, орон нутгийн хөгжил, тэнд байгаа иргэдэд тухайн ордыг олборлосноос ямар ашиг тустай байх вэ гэдгийг юуны түрүүнд тодотгож ил тод болгох ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөв.

2006 оны 12 дугаар сарын 7-ны өдөр.

ОРОЛЦОГЧДЫН НЭРС

Нэр	Байгууллага, албан тушаал
Д.Лүндээжанцан	УИХ-ын дэд дарга
Д.Дондог	Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, УИХ-ын гишүүн
Ч.Улаан	Төсвийн байнгын хорооны дарга, УИХ-ын гишүүн
Ц.Мөнх-Оргил	Хууль зүйн байнгын хорооны дарга, УИХ-ын гишүүн
Л.Гантөмөр	Эдийн засгийн байнгын хорооны дарга УИХ-ын гишүүн
Г.Занданшатар	Төсвийн хяналтын дэд хорооны дарга, УИХ-ын гишүүн
Р.Амаржаргал	УИХ-ын гишүүн
Р.Бадамдамдин	УИХ-ын гишүүн
Ц.Дамиран	УИХ-ын гишүүн
Д.Дэмбэрэл	УИХ-ын гишүүн
З.Энхболд	УИХ-ын гишүүн
Э.Бат-Үүл	УИХ-ын гишүүн
С.Оюун	УИХ-ын гишүүн
Р.Эрдэнэбүрэн	Ёс зүйн байнгын хорооны дарга, УИХ-ын гишүүн
Ж.Лувсанжав	УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга
М.Энхсайхан	МУ-ын шадар сайд, УИХ-ын гишүүн
Б.Энхмандах	Байгаль орчны дэд сайд
Д.Одбаяр	Хууль зүйн сайд
Д.Сүхбаатар	Хууль зүйн дэд сайд
Г.Баясгалан	Хууль зүйн яам, Төрийн нарийн бичгийн дарга
Ц.Цолмон	Хууль зүйн яам, Хуулийн бодлогын газрын дарга
Д.Сугар	Төрийн өмчийн хорооны дарга
С.Цэрэндорж	Хүний Эрхийн Үндэсний Комиссын дарга
Э.Сумъяа	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын ахлах референт
М.Тунгалаг	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга
Ш.Батсүх	Газрын харилцаа, геодези зураг зүйн газар дарга
Л.Лхагва	МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газар, Нийгмийн бодлогын зөвлөх
Зүмбэрэлхам	МУ-ын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх
Батбаяр	Ерөнхий сайдын ахлах зөвлөх
Н.Энхбаяр	Ерөнхий сайдын эдийн засгийн зөвлөх
Н.Болормаа	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
Б.Төмөрхуяг	Нийслэлийн газрын албаны дарга
Н.Нацагдорж	Нийслэлийн засаг даргын зөвлөх, Улаанбаатар хотын ерөнхий архитектор

Нэр	Байгууллага, албан тушаал
Г.Галсанпунцаг	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дарга
Д. Баярсайхан	Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
Д. Совдоо	Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
Ц. Тунгалаг	Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
Д. Дэмбэрэлдаш	Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
Б.Төмөрбаатар	Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
П.Цогтбаатар	Баянгол дүүргийн Засаг дарга
Э.Мөнх-Очир	Баянзүрх дүүргийн Засаг дарга
Л.Найдан	Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга
А.Амарсайхан	Сүхбаатар дүүргийн Засаг дарга
П.Очирбат	Чингэлтэй дүүргийн Засаг дарга
Х.Баттулга	Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч
Г. Цэрэндулам	Сонгинохайрхан дүүргийн 3-р хорооны засаг дарга
Г.Болд	Нийслэлийн Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хврээлэнгийн захирал
Ж.Наранцацралт	Барилга хот байгуулалтын сайд
Д.Мөнхбаатар	Барилга хот байгуулалтын яам, газрын дарга
Б.Батболд	Барилга, хот байгуулалтын яам, Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга
Жаргалсайхан	Сангийн яам, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга
Батхүү	Сангийн яам, Хуулийн хэлтэс
Борчулуун	Үйлдвэр, худалдааны яам, ахлах мэргэжилтэн
Я.Содбаатар	Үйлдвэр, худалдааны яамны дэд сайд
Зоригт	Үйлдвэр, худалдааны яам, Нэгдсэн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга
Даваасүрэн	БСШУ-ны яам, Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга
Ю.Эрдэнэтуяа	УИХ-ын мэдээллийн лавлагааны ажилтан
Л.Отгонтуяа	Удирдлагын академи, Төрийн удирдлагын тэнхимийн ахлах багш
С.Оюунтуяа	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөний менежер
Т.Амгалан	Тогтвортой хөгжил жендер төвийн гүйцэтгэх захирал
О.Мөнхбат	МУИС-ийн Социологийн тэнхимийн багш
Х.Март	Сангийн яам
Уртнасан	Татвар төлөгчдийн холбооны захирал
Р. Бурмаа	Сонгогчдын боловсролын төв
Х.Наранжаргал	Глоб интернэшнэлийн тэргүүн
Д. Ламжав	иргэн
Б.Эрдэнэбат	Нээлттэй академийн судлаач, профессор
М.Батсуурь	Нээлттэй академийн судлаач, профессор

Нэр	Байгууллага, албан тушаал
Т.Оюунчимэг	УИХ-ын тамгын газар
О.Эрдэнэ-Өлзий	“Үндэсний соёмбо” хөдөлгөөний иргэний хяналтын зөвлөлийн дарга
Д.Цэрэнжав	Шинэ бодлого хүрээлэн
Ганхуяг	Газрын харилцаа, геодиз зураг зүйн газрын дарга
Ц.Ганболд	Ил тод байдал сан, ажлын хэсгийн ахлагч
Батпүрэв	Мэдээлэл олон нийтийн харилцааны “Инфорум” төв
Эрдэнэбилэг	УИХ-ын гишүүн асан
А. Энхбат	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
Б. Батмөнх	Үндэсний Хөгжлийн Хүрээлэнгийн Нийгэм Эдийг Засгийг мэдээллийн төвийг эрхлэгч
Б. Бат	МУИС-ийн Эдийн засгийн сургууль
Т. Мөнх-Очир	
Ч.Тамир	МУИС-ийн Социологийн тэнхимийн багш
З.Батболд	Шинэ бодлого хүрээлэн
Ц.Нямхүү	Мэдээлэл харилцаа холбооны технологийн газар
А.Алтантуяа	“Ардын эрх” сонины тоймч
С.Ононтуул	“Зууны мэдээ” сонины тоймч
Л.Болормаа	“Өнөөдөр” сонины орлогч эрхлэгч, эдийн засгийн албаны дарга
Ж.Гангаа	“Өдрийн сонин”-ы албаны дарга
Энхжавхлан	“Үг” сонины орлогч эрхлэгч
Лутаа	Би Эйч Пи Биллитон компанийн хэвлэл мэдээллийн зөвлөх
Ж.Мягмарсүрэн	“Өдрийн сонин”
Б.Ганболд	“Зууны мэдээ” сонины тоймч
Ц.Балдорж	“Өнөөдөр” сонин
Д.Сандагсүрэн	“Монголын мэдээ” сонин
Б.Тэмүүлэн	“Ардын эрх” сонин
Ц.Ганбат	“Үнэн” сонин
До.Цэнджав	“Өнөөдрийн монгол” сонин
Г.Уянга	“Улс төрийн сонин”
Б.Индра	“Mongol messenger” сонин
Р.Оюунцэцэг	Монголын хэвлэлийн хүрээлэн
И.Амараа	Just, Хүний нөөцийн газрын захирал захирал
Р.Энхбат	“Эдмон, захирал
Л.Даваасүрэн	Эх газар, гүйцэтгэх захирал
П.Түмэнжаргал	АПУ, Захиргаа хүний нөөцийн газрын дарга
Ц.Хэнмэдэх	Баянгол зочид буудал, захирал
П.Туул	Бодь Интернэшнл, Маркетингийн хэлтсийн захирал
А.Ариунболд	Бишрэлт Холдинг, захирал
Ж.Саруултуяа	Датаком, Маркетингийн хэлтсийн дарга
Mr. Barry Maddems	КНААН bank Deputy CEO
Ч.Батаа	Мэжикнэт ХХК
Нарантуяа	Мобиком. Худалдаа, үйлчилгээний хэлтсийн захирал

Нэр	Байгууллага, албан тушаал
Ш.Баярсайхан	Номин Холдинг, ерөнхийлөгч
Д.Цолмон	Кредит Монгол ББСБ, захирал
С.Гонгор	“Жуулчин” ХХК
Mr Leyton Croft	Ivanhoe Mines, Vice President for Public Relations
М.Отгонцэцэг	Говь, Борлуулалт санхүүгийн хэлтсийн захирал
С.Оюунсүрэн	MCS групп, Хүний нөөцийн хэлтэс
Цоодол	МИАТ, Маркетингийн хэлтсийн ерөнхий менежер
Булган	Скайтел, Борлуулалт, үйлчилгээний хэлтсийн захирал
Steve Carty	Centerragold, Senior Geologist
Ч.Ганхуяг	ХАС Банк, Гүйцэтгэх захирал
О.Шаалуу	Монголын шуудан холбоо, захирал
Ц.Болдбаатар	Ньюком, ТУЗ-ын дарга
Л.Даваажаргал	Bridge групп, захирал
Энхтуяа	Монполимет компани, захирал
Цэнд-Аюуш	Баялаг газар компани, захирал
Б.Энхболд	Сонор трейд компани, захирал
Б. Эрдэнэбат	Глобус ХХК, захирал
О.Рагчаа	Арьс ширний үйлдвэрийн холбооны ерөнхийлөгч
Цогт	Үндэсний татварын ерөнхий газар, Татвар хураалтын хэлтсийн дарга
Шагар	Үндэсний татварын ерөнхий газар, Татвар хураалт, үйлчилгээний хэлтсийн байцаагч
Лу.Болд	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга
Ж.Билэгсайхан	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, Уул уурхайн албаны дарга
Л.Жавзмаа	Монгол Улсын Үндэсний Аудитын газрын дарга
Р.Олонбаяр	Нийгмийн халамжийн хамтын ажиллагааны сан
С.Баяр	МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга
Ц.Элбэгдорж	Ардчилсан намын дарга
Г.Ундрал	Ардчиллын Боловсролын төвийн захирал
Д.Одончимэг	ЛЭОС гүйцэтгэх захирал
Ж.Эрдэнэчимэг	Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны Ерөнхийлөгч
Д.Энхжаргал	Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвийн захирал
Б.Отгонбаяр	Хөдөөгийн эмэгтэйчүүдийг дэмжих сангийн гүйцэтгэх захирал
Х.Оюунцэцэг	Хуульч эмэгтэйчүүдийн холбооны захирал
Ц.Ариунаа	Эрх чөлөө төвийн захирал
Ж.Осоржамаа	Байгаль 21 ТББ, тэргүүн
Б.Оюун	Бэрцэцэг холбоо
П.Цагаан	Дельта сан
О. Цэрэннадмид	Зориг сан
Ж. Занаа	Иргэдийн Альянс төв
Р.Нарангэрэл	Иргэний боловсрол төв
Д.Алтай	МАСЭХ-ны тэргүүн

Нэр	Байгууллага, албан тушаал
Баярбаатар	“Миний монголын газар шороо” хөдөлгөөн
Б.Болдбаатар	“Миний Монголын газар шороо” хөдөлгөөний гүйцэтгэх захирал
Гомбо	Монгол менежмент төв
Б.Батжав	Монголын Архитекторуудын Эвлэлийн ерөнхийлөгч
Ц.Чүлтэмнамдаг	Монголын байгаль орчныг хамгаалах холбоо
Г.Тунгалаг	Монголын жижиг дунд уурхайнуудын Монмин нийгэмлэг
Батболд	Монголын ногоонтны хөдөлгөөний сүлжээ - Сэлэнгэ аймгийн зөвлөл, Ойн менежментийн холбоо
Бат-Эрдэнэ	Монголын нутгийн удирдлагын холбоо
Х.Дашзэвэг	Монголын тул хамгаалах нийгэмлэг
Г.Мянганбаяр	Монголын худалдаа, эд хэрэглэгчдийн хоршооллын төв холбооны дарга
Г.Лхагвасүрэн	Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, менежер
Золзаяа	Нутгийн удирдлагын холбоо
Б.Баттүвшин	Нутгийн удирдлагын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, КАС-ын ажилтан
Товуудорж	Олон улсын мэдээлэл аудит компанийн захирал; Татвар төлөгчдийн холбооны гишүүн
Д. Мөнхбаяр	“Онги гол” хөдөлгөөний тэргүүн
Л.Сумати	Сант марал сан
Ж. Халзанбанди	Татвар төлөгчдийн холбооны захирал
П.Төмөрбаатар	Төмөр сан
Б.Чимид	ХЗДС-ийн Төр захиргааны тэнхимийн эрхлэгч
С.Дэмбэрэл	Худалдаа аж үйлдвэрийн танхим
Н.Отгонжаргал	Худалдан авах үйл ажиллагааны хөгжлийн төв
Б.Уранцоож	Хүний эрх хөгжил төв
Д.Энхбат	Шинэ бодлогын хүрээлэн
М.Ичинноров	Эмэгтэйчүүд манлайлал сан
Н. Чинчулуун	Эмэгтэйчүүдийн сангийн тэргүүн
С.Ганбаатар	“Эрс шинэчлэл” хөдөлгөөний тэргүүн
Зоригт	Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхий менежер
Б.Батхүү	Нийгмийн хөгжлийн төвийн зөвлөл
Энхтуяа	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, гүйцэтгэх захирал
Машбадрах	МНЭММН, гүйцэтгэх захирал
Д.Бямбасүрэн	Ерөнхий сайд асан
Н.Алтанхуяг	Сангийн сайд асан
Б.Батбаяр	улстөрч
Х.Хулан	улстөрч
Р.Болд	эдийн засагч
П.Мягмарцэрэн	МУИС ГЗГФ, багш
М.Батсуурь	МУИС-ийн багш, хуульч
Д.Цэрэнпил	МУИС-ийн санхүүгийн тэнхим
С.Нарангэрэл	МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн захирал

Нэр	Байгууллага, албан тушаал
Я.Гомбосүрэн	ШУТИС-ийн Уул уурхайн сургуулийн тэнхимийн эрхлэгч
Л.Шарав	гавьяат эдийн засагч
Tilman Jaeger	Technical Advisor, Conservation and Sustainable management of Natural Resources, gtz
Ц. Монгол	ХААН банкны Хуулийн газрын дарга
Т.Төрбат	Орон сууцанд оршин суугчдын эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн
О.Пунцагдэлгэр	СӨХДЗ-ийн дэргэдэх Газрын маргаан таслах комиссын дарга
Д.Жаргалсайхан	Сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлийн дарга, (Жаргалсайханаар дамжуулан газрын маргаанд орсон СӨХ-ийн дарга нарыг олж болно)
Шагдарсүрэн	Зүүн бүсийн Цахилгаан шугам сүлжээний дарга
Д.Баасанжав	“Оргил” рашаан сувиллын захирал
Д.Мижиддорж	31-р сургуулийн ахмад багш
Б.Чимэдбат	бизнес эрхлэгч
С.Ганхуяг	“Үг” сонины тоймч
С.Авирмэд	
Цэвээндорж	“Үндэсний соёмбо” хөдөлгөөний газар хариуцсан иргэний зөвлөлийн гишүүн
Сансармаа	“Үндэсний соёмбо” хөдөлгөөний газар хариуцсан иргэний зөвлөлийн гишүүн
Чагнаадорж	“Ариун суварга” хөдөлгөөн
Молотов	Монголын хувьцаа эзэмшигчдийн холбоо
Б.Ихбаяр	Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо
О.Нарангэрэл	Бүс нутгийн байгаль хамгааллын Хангай хан сүлжээ
Ж.Отгонцэцэг	“Онон - Улз голынхон” хөдөлгөөн
Д.Ганболд	Тул хамгаалах нийгэмлэг
Б.Дэжид	“Уугуул” хөдөлгөөн
Л.Ариунчимэг	Хүний эрх хөгжил төв
До.Ганболд	Монголын үндэсний уул уурхайн ассоциаци
Doug McGay	Эрдэс уул уурхайн салбарын хөгжлийн сан
Д.Лхагвадорж	“Тунгаа” төв ТББ-ийн тэргүүн
Д. Батмөнх	“Газрыг шударгаар хувьчлахын төлөө” хөдөлгөөн
Д.Гангабаатар	МУИС дахь Нагоя их сургуулийн төсөл
С.Алтанцэцэг	Нийслэлийн хүүхэд залуучуудын хөгжлийн газар
Чулуунбаатар	Хүүхдийн амьдрах ухаан төв
М.Төгсбүрэн	Монголын хүүхдийн эрхийн төв
Гантөмөр	Монголын радиогийн хүүхдийн танин мэдэхүйн редакц
Долгорсүрэн	МОНРТ хүүхдийн танин мэдэхүйн редакц
Ганболд	Оюунтүлхүүр сан
Ц.Ишдорж	Гэгээ СӨХ-ийн захирал, “Үндэсний соёмбо” хөдөлгөөний газар хариуцсан иргэний зөвлөлийн гишүүн
Эрдэнэбилиг	“Үндэсний Соёмбо” хөдөлгөөний газар хариуцсан иргэний зөвлөлийн гишүүн

Нэр	Байгууллага, албан тушаал
Н.Алтай	“Үндэсний Соёмбо” хөдөлгөөний газар хариуцсан иргэний зөвлөлийн гишүүн
Эрдэнэмөнх	“Кадастрын зураглал ба газрын бүртгэл” төсөл, төслийн удирдагч
Adrian Ruthenberg	Азийн Хөгжлийн Банк
Arshad Sayed	Дэлхийн Банк
Pratibha Mehta	НҮБХХ
Agni.B	Шударга ёсны тогтолцоог сайжруулах НҮБ-ын төсөл
Moriya Tsutomu	ЛСА
William Foerderer	Азийн сан
Barrytrimm	АНУ-ын хөгжлийн агентлаг
John Chonel Doe	Европын сэргээн босголт хөгжлийн банк
Martin Marschke	GTZ
Byung Kyoon Jang	Олон улсын валютын сан
Markus Dubach	Швейцарийн хөгжил хамтын ажиллагааны агентлаг
Thomas Schrapel	Конрад Аденаурын сан
Mark Minton	АНУ-ын Элчин сайдын яам
Ulrich Dreesen	ХБНГУ-ын Элчин сайдын яам
Christopher Osborne	Английн Элчин сайдын яам
Ichihashi Yasuyoshi	Япон улсын Элчин сайдын яам
Ж.Хүрэлсүх	Архангай аймгийн Засаг дарга
О.Хабсатор	Баян-Өлгий аймгийн Засаг дарга
Д.Юндэнбазар	Баянхонгор аймгийн Нийгмийн бодлого зохицуулалтын газрын дарга
Г.Буянжаргал	Булган аймаг
В.Сүррагчаа	Говь-Алтай аймгийн ТЗУ-ын хэлтсийн дарга
Р.Батжаргал	Дархан-Уул аймгийн НБЗ-ын хэлтсийн дарга
Ц.Ганбаатар	Дорноговь аймгийн Засаг даргын орлогч
Д.Мөнгөнцэцэг	Дорнод аймгийн Хууль зүйн хэлтсийн дарга
Ш.Төрбат	Дундговь аймгийн Засаг дарга
Н.Ганбаатар	Завхан аймгийн Хуулийн хэлтсийн дарга
Х.Ганболд	Орхон аймгийн ТГ-ын дарга
И.Доржсүрэн	Өвөрхангай аймгийн Хууль зүйн хэлтсийн дарга
Б.Бадраа	Өмнөговь аймгийн ЗД-ын орлогч
Б.Сүхбаатар	Сүхбаатар аймгийн ТЗУ-ын хэлтсийн дарга
Р.Болд	Төв аймгийн Тамгын газрын дарга
Л.Батнасан	Увс аймгийн ТЗУ-ын хэлтсийн дарга
Г.Нямдаваа	Ховд аймгийн Засаг дарга
Б.Батхүү	Хөвсгөл аймгийн Засаг дарга
Б.Эрдэнэнамжилмаа	Хэнтий аймгийн ТГ-ын дарга
Ж.Ариунаа	Баянхонгор аймгийн Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн Орон нутгийн салбар
Б.Ариунаа	Завхан аймгийн Хуульч эмэгтэйчүүдийн холбоо
Э.Дэлгэрсуурь	Өмнөговь аймгийн Амжилтын томъёо

Нэр	Байгууллага, албан тушаал
Хишигсүрэн	Дархан-Уул аймгийн Орхон-21
Т.Алмагуль	Баян-Өлгий аймгийн ЛЭОС
Нарантуяа	Ховд аймгийн Монголын Мэдээллийн Сүлжээ
Энхтуяа	Увс аймгийн Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо
Мөнхцэцэг	Хөвсгөл аймгийн Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөний салбар зөвлөл
Энхтөр	Төв аймгийн “Тосон заамар” хөдөлгөөн
Бор	Сүхбаатар аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдийн холбоо
Ганцогт	Дорнод аймгийн УТБА
Нямхүү	Дорноговь аймгийн Хөдөөгийн Эмэгтэйчүүдийн Хөгжлийг дэмжих сан
Отгон-Эрдэнэ	Говьсүмбэр аймгийн Монголын эм найруулагчдын холбоо
Оюунчимэг	Орхон аймгийн Хуульч эмэгтэйчүүдийн холбоо
Ё Туул	Багануур аймгийн CEDAW